

Хөгжлийн бэрхшээлтэй хүмүүсийн эрхийн тухай НҮБ-ын конвенц

Хянан тохиолдуулсан: Дарамжавын СОЛОНГО

Боловсруулсан: Ганбатын НАРАНТУЯА

2008 он

ХӨГЖЛИЙН БЭРХШЭЭЛТЭЙ ХҮМҮҮСИЙН ЭРХИЙН ТУХАЙ НҮБ-ЫН КОНВЕНЦ

ГАРЫН АВЛАГА

Энэхүү гарын авлагыг Европын холбоо, Италийн засгийн газрын бус Раул Фалерогийн анд нөхдийн холбоо байгууллагын дэмжлэгтэйгээр Монгол Улсын Хүний эрхийн үндэсний комиссоос эрхлэн гаргав. Гарын авлагад НҮБ-ын Хөгжлийн бэрхшээлтэй хүмүүсийн эрхийн тухай конвенцийн нарийн бичгийн даргын газрын зөвшөөрлөөр НҮБ, НҮБ-ын Хүний эрхийн дээд комиссарын газар, Парламентын хоорондын холбооноос боловсруулж гаргасан “Алагчлалаас адил тэгш байдалд: Хөгжлийн бэрхшээлтэй хүмүүсийн эрхийг хэрэгжүүлэх нь” гарын авлагын зарим илэрхийлэл, дүрслэлийг ашиглав.



Монгол Улсын Хүний эрхийн үндэсний комисс



Раул Фолерогийн анд нөхдийн холбоо байгууллагын
Монгол дахь суурин төлөөлөгчийн газар



Европын Холбоо

Гарын авлагыг худалдан борлуулахгүй. Зохиогчийн эрх Хүний эрхийн үндэсний комисст хадгалагдана. Гарын авлагыг дахин хэвлэх, хэсэгчлэн ашиглахдаа Хүний эрхийн үндэсний комиссоос зөвшөөрөл авна.

ӨМНӨХ ҮГ

Эрхэм танд “Хөгжлийн бэрхшээлтэй хүмүүсийн эрхийн тухай НҮБ-ын конвенци” гарын авлагыг өргөн барьж байна.

Дэлхийн аль ч улсад, өндөр хөгжилтэй, хөгжиж буй аль ч нийгэмд эрх, эрх чөлөө нь ноцтой зөрчигдсөөр ирсэн бүлэг бол хөгжлийн бэрхшээлтэй хүмүүс юм. Тэдэнд хийж бүтээх, сурч боловсрох, “хүний дайтай амьдрах” эрмэлзлэл дүүрэн боловч хүнээ гадуурхах нийгмийн орчин, чадвар, чадавхыг нь үл тоомсорлох хандлагын улмаас хүсэл мөрөөдлөө биелүүлэх боломж хомс байна. Иймд хөгжлийн бэрхшээлтэй хүмүүст тэгш боломж олгох, тэдний “хүн” хэмээх эрхэм чанар, эрх, эрх чөлөөг баталгаажуулах зорилгоор НҮБ-ын Ерөнхий Ассамблей Хөгжлийн бэрхшээлтэй хүмүүсийн эрхийн тухай конвенци, түүний ннэмэлт протоколыг батлан гаргасан билээ.

Энэхүү гарын авлагад Хөгжлийн бэрхшээлтэй хүмүүсийн эрхийн тухай конвенци болон түүний нэмэлт протоколын зүйл заалтыг тайлбарлахын сацуу конвенцийг хэрэгжүүлэхтэй холбоотой анхаарах асуудлыг тоймлон оруулав. Ингэхдээ хэн бүхэнд ойлгомжтой үг хэллэгтэй, товч боловч тодорхой бичихийг хичээж ажиллалаа.

Гарын авлагаа “шийдвэр гаргагчдад зориулах” болсон нь учиртай. Аливаа олон улсын гэрээг дагаж мөрдөх зөвшөөрлөө илэрхийлэх эсэх нь иргэдийн ашиг сонирхол, хэрэгцээ, шаардлагаас гадна улс төрийн хүсэл зоригоос ихээхэн хамааралтай. Шийдвэр гаргагч гэрээний талаар тодорхой мэдээлэлтэй байх нь түүнийг соёрхон батлахад чухал билээ. Иймээс Хөгжлийн бэрхшээлтэй хүмүүсийн эрхийн тухай конвенцийг соёрхон батлахад төрийн түшээ таны дэмжлэгийг хүсэж, гэрээний ач холбогдол, түүнээс үүдэн гарах үр дагаврыг учирлан өгүүлэхийн хамт гарын авлагаа “таны нэр дээр” хаяглалаа.

Гэхдээ энэхүү цомог хүний эрх, хөгжлийн бэрхшээлтэй хүмүүсийн эрхийн чиглэлээр ажилладаг төрийн болон төрийн бус байгууллагууд, сонирхогч хэн бүхэнд хэрэгцээтэй байна гэдэгт итгэж байна.

Гарын авлагыг нийтийн хүртээл болгоход дэмжлэг үзүүлж, хамтран ажилласан Европын холбоо, Италийн “Раул Фолерогийн анд нөхдийн холбоо” байгууллага, түүний Монгол дахь суурин төлөөлөгчийн газарт талархал илэрхийлье.

ХҮНИЙ ЭРХИЙН ҮНДЭСНИЙ КОМИСС

НЭГДҮГЭЭР ХЭСЭГ: КОНВЕНЦ ХҮРТЭЛ...

1.1 Хөгжлийн бэрхшээлийн асуудалд хүний эрхийн үүднээс хандах нь

Дэлхийн хүн амын 10 хувь орчим нь буюу 650 сая хүн хөгжлийн бэрхшээлтэй амьдардаг гэсэн тооцоог Дэлхийн эрүүл мэндийн байгууллагаас гаргасан. Энэ тоон дээр хөгжлийн бэрхшээлтэй хэн нэгэн дотны хүнээ харж хандахын тулд суралцаж, хөдөлмөрлөж, нийгмийн амьдралд бүрэн дүүрэн оролцож чадахгүй байгаа гэр бүлийн гишүүд, асран хамгаалагчдын тоог нэмбэл ойролцоогоор 2 сая хүн хөгжлийн бэрхшээлээс үүдсэн асуудалтай амьдарч байна.

Дэлхийн хүн ам өсөхийн хирээр хөгжлийн бэрхшээлтэй хүний тоо ч улам бүр нэмэгдэж байгаа юм. Нөгөө талаас, ядуурал, байгалийн гамшиг, тогтворгүй байдал, осол гэмтэл, эмнэлгийн байгууллагын үйл ажиллагаанд гарсан алдаа дутагдлаас хүн хөгжлийн бэрхшээлтэй болох тохиолдол өссөөр байгааг Дэлхийн эрүүл мэндийн байгууллагын мэдээ, тайлан харуулж байна. Ялангуяа, ийм байдал хөгжлөөр буурай болон хөгжиж байгаа улс орнуудад харьцангуй өндөр хувьтай байдаг. Хэнд ч, хэдийд ч тохиолдож болох учраас хөгжлийн бэрхшээлийн асуудал хүн бүрийн асуудал мөн билээ.

Дэлхийн аль ч улс оронд хөгжлийн бэрхшээлтэй хүмүүс нийгмээс тусгаарлагдсан, хязгаарлагдмал орчинд амьдарч байна. Тэд бусдын л адил амьдрах, хийж бүтээх хүсэл, тэмүүлээр дүүрэн байдаг боловч сурах, хөдөлмөрлөх, нийгмийн үйл хэрэгт оролцох, найзалж нөхөрлөх, гэр бүл зохиох, үр хүүхдээ өсгөх итгэл найдвар бага, эмнэлэг, сургууль, дэлгүүрээр үйлчлүүлэх, тээврийн хэрэгслээр зорчих, хэрэгцээтэй мэдээллээ бүрэн дүүрэн хүлээж авах боломж хязгаарлагдмал амьдарч байна.

Хөгжлийн бэрхшээлийг ядуурал, ядуурлыг хөгжлийн бэрхшээл сүүдэр мэт дагах нь олонтаа. Амьдралын хүнд хэцүү нөхцөл, хоол хүнсний дутагдал, эмнэлгийн үйлчилгээнд хамрагдаж чадахгүйгээс ядуу хүн хөгжлийн бэрхшээлтэй болох нь элбэг байхад сурч боловсрох, ажиллаж хөдөлмөрлөх боломж, орчин хязгаарлагдмал учраас хөгжлийн бэрхшээлтэй хүмүүсийн олонх нь ядуу амьдарч байна. Ядуурал хүний эдийн засаг, нийгэм, соёлын эрх зөрчигдөхөд хүргэдэг гол шалтгаан билээ.

ТООН ХЭЛЭЭР...

👤 Дэлхийн хүн амын 10 хувь нь хөгжлийн бэрхшээлтэй байгаа бөгөөд хүн амын өсөлт, насжилттай холбоотойгоор энэ тоо улам өсөн нэмэгдэх хандлагатай байна. (Дэлхийн эрүүл мэндийн байгууллага)

᠘ Дэлхий дээр амьдарч буй хөгжлийн бэрхшээлтэй хүмүүсийн 80 хувь нь хөгжиж буй орнуудад амьдарч байна. (НҮБ-ын Хөгжлийн хөтөлбөр)

᠘ Монгол Улсын хувьд хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн талаарх нэгдсэн тоо байхгүй. 2004 онд Үндэсний статистикийн газраас 67 мянга орчим хөгжлийн бэрхшээлтэй иргэн бий гэсэн тоо гаргасан байхад 2002 онд Эрүүл мэндийн яам 115 мянган хөгжлийн бэрхшээлтэй иргэн байна гэсэн тоо гаргажээ. (Монгол Улсын Хүний эрхийн үндэсний комисс)

᠘ Хүн амын дундаж наслалт 70-аас илүү гарсан улс орны иргэд дунджаар амьдралынхаа 8 жилийг буюу 11.5 хувийг хөгжлийн бэрхшээлтэй өнгөрүүлж байна. (Дэлхийн эрүүл мэндийн байгууллага)

᠘ Дэлхий дээр хөдөлмөрийн насны 386 сая хүн хөгжлийн бэрхшээлтэй амьдарч байгаа ба зарим улс оронд тэдгээр хүмүүсийн 80 орчим хувь нь хөдөлмөр эрхлэхгүй байна. (Олон улсын хөдөлмөрийн байгууллага)

᠘ Дэлхийн нэн ядуу хүмүүсийн 20 хувь нь хөгжлийн бэрхшээлтэй байгаа бөгөөд амьдралын нөхцөл, хөгжлийн бэрхшээлийнхээ улмаас хамгийн хүнд нөхцөлд амьдарч байна. (Дэлхийн банк)

᠘ Хөгжиж буй орнуудад амьдарч буй хөгжлийн бэрхшээлтэй хүүхдүүдийн 90 орчим хувь нь сургуульд хамрагдаж чаддаггүй ба орон гэргүй, тэнүүчилж амьдардаг хүүхдүүдийн 30 хувь нь хөгжлийн бэрхшээлтэй байна. (НҮБ-ын Хүүхдийн сан)

᠘ Насанд хүрсэн хөгжлийн бэрхшээлтэй хүмүүсийн 3 хүрэхгүй хувь нь бичиг үсэг тайлагдсан байгаа бөгөөд зарим улсад хөгжлийн бэрхшээлтэй эмэгтэйчүүдийн 1 хүрэхгүй хувь нь бичиг үсэг мэдэж байна. (НҮБ-ын Хүний эрхийн дээд комиссарын газар)

᠘ 5-аас доош настай хүүхдийн эндэгдлийг 20 хүртэлх хувиар бууруулж чадсан орнуудад ч хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийн нас баралт 80 орчим хувьтай байна. (Олон улсын хөгжлийн газар, Их Британи, Умард Ирландын нэгдсэн вант улс)

᠘ 2004 онд Энэтхэгийн Орисса мужид хийгдсэн судалгаагаар тухайн бүс нутагт амьдардаг хөгжлийн бэрхшээлтэй эмэгтэйчүүд, охид бүгд орон гэртээ зодуулдаг бөгөөд тэдний 6 хувийг албадан үргүй болгосон байв. Түүнчлэн, сэтгэцийн эмгэгтэй эмэгтэйчүүдийн 25 хувь нь бэлгийн хүчирхийлэлд өртөж байжээ.

᠘ Хөгжлийн бэрхшээлтэй хүмүүсийн эрх ийнхүү ноцтой зөрчигдөж, алагчлагдаж байхад дэлхийн 45 улс нь хөгжлийн бэрхшээлтэй хүмүүсийг алагчлахыг эсрэг буюу түүнтэй ижил төстэй хууль тогтоомжтой байна.

᠘ 2004 онд АНУ-д хийсэн судалгаагаар хөдөлмөрийн насны хөгжлийн бэрхшээлтэй хүмүүсийн 35 орчим хувь нь хөдөлмөр эрхэлж байхад эрүүл хүмүүсийн 78 хувь нь хөдөлмөр эрхэлж байв. Судалгааны санал асуулгад оролцсон хөгжлийн бэрхшээлтэй хүмүүсийн гуравны хоёр нь ажил хөдөлмөр эрхлэх хүсэлтэй боловч ажил олддоггүй гэсэн байна.

᠘ Мөн судалгаагаар хөгжлийн бэрхшээлтэй ажилтанд зориулж ажлын байрыг тохирох хэрэглэгдэхүүнээр тоноглоход 500, түүнээс ч бага доллар шаардагдаж байсан бөгөөд санал асуулгад хамрагдсан ажил олгогчдын 73 хувь нь хөгжлийн бэрхшээлтэй ажилтанд ямар нэг нэмэлт зардал шаардлагагүй байсан гэжээ.

᠘ Мөн судалгаагаар хөгжлийн бэрхшээлтэй хүмүүс хамгийн тогтвортой ажилтнууд байдгийг тогтоожээ.

᠘ Лондонгийн хөрөнгийн биржид бүртгэлтэй топ 100 аж ахуйн нэгжийн 75 хувь нь цахим хуудсаа хөгжлийн бэрхшээлтэй хүмүүст хүртээмжтэй болгож чадаагүйгээс 147 сая америк долларын ашгаа алдаж байгааг судалгаагаар тогтоосон байна.

Нийгмийн бусад гишүүдийн үл тоомсорлол, боломж, чадавхыг нь үгүйсгэх хандлагын улмаас хөгжлийн бэрхшээлтэй хүмүүсийн эрх зөрчигдөхөд хүрч байна. Өнгөрсөн түүхийн ихэнх хугацаанд, дэлхийн улс орнуудад хөгжлийн бэрхшээлтэй хүмүүсийг нийгмийн харилцаанд эрүүл иргэдийн нэгэн адил оролцох эрхтэй болохыг нь үл хүлээн зөвшөөрч, тэднийг гагцхүү “төрийн тусламж, дэмжлэгийг хүртэгч”, “эмнэлэг, нийгмийн халамжийн үйлчилгээний объект” мэтээр хандаж ирсэн. Ийм ч учраас утга зохиол, соёл урлаг, нийгмийн шинжтэй сурталчилгаанд хөгжлийн бэрхшээлтэй хүнийг өрөвдөж энэрэх, туслахыг уриалсан өнгө аяс зонхилж, харин сурч боловсрох, хөдөлмөрлөх, нийгмийн амьдрал оролцохыг нь дэмжих, тэгш боломжийг бий болгох утга агуулга төдийлөн хөндөгддөггүй байв. Хөгжлийн бэрхшээлтэй хүнийг тохуурхах, нэр төрийг нь доромжлох, элдэв нэр хоч өгөх, цэрвэх, цээрлэх хандлага ч нийгэмд байдгийг үгүйсгэх аргагүй. Хөгжлийн бэрхшээлтэй гэр бүлийн гишүүнээсээ ичиж зовох, ил гаргахаас нуух нь бидний эргэн тойрон байдаг асуудал боловч ингэснээрээ тэдгээр дотны хүмүүсийнхээ “хүн хэмээх” эрхэм чанарыг үгүйсгэж байгаа болохоо хүмүүс тэр бүр анзаардаггүй. Тэргэнцэртэй, таягтай гэх зэргээр хүнийг нь биш, тусгай хэрэглэгдэхүүн, согоогоор онцлон нэрлэж, тахир дутуу гэх мэтээр өөрсдөө ч хэлэхээс эвгүйцэм нэр томъёогоор дуудах нь ч мөн хүнлэг бус харьцаа болно.

Хүн зөвхөн согог, гэмтлийнхээ улмаас хөгжлийн бэрхшээлтэй болдоггүй бөгөөд бие эрхтний согог, гэмтэл нийгмийн орчин, хязгаарлалттай нэгдэн нийлж хөгжлийн бэрхшээлийг үүсгэдэг. Өөрөөр хэлбэл, тэргэнцэр ашигладаг хүн ямар нэг ажил хийх чадваргүйдээ биш, гагцхүү түүний ажлын байр тэргэнцэртэйгээ орох, гарах, ажиллах нөхцөлийг бий болгож чадаагүй учраас тэдний ихэнх нь хөдөлмөр эрхэлж чадахгүй байна. Үүний нэгэн адилаар сонсголын бэрхшээлтэй хүүхдүүд эрүүл хүүхдүүдийн нэгэн адил суралцах оюуны чадавхгүйдээ биш, харин тэдний хэрэгцээг хангахуйц сургалтын орчин, гарын авлага, багш байхгүйгээс, сургууль тэдэнд хүртээмжтэй бишээс тэр бүр амжилттай суралцаж чаддаггүй юм.

Хөгжлийн бэрхшээл нь нийгмийн орчин, хөгжлийн түвшингээс хамаарч үргэлж өөрчлөгдөн хувьсаж байдаг ойлголт юм. Шинжлэх ухаан, технологийн хөгжлийг дагаад хөгжлийн бэрхшээлтэй хүний тусгай хэрэгцээг хангах тоноглол, хэрэглэгдэхүүн улам бүр боловсронгуй болж байна. Жишээлбэл, сул харааг /хурц миофиа буюу зөвхөн мөрөө л хардаг/ нөхөх линзийг хэрэглээнд нэвтрүүлсэн хөгжингүй улс оронд сул хараатай хүнийг хөгжлийн бэрхшээлтэйд тооцохооргүй болж байгаа нь хөгжлийн бэрхшээл орчин нөхцөл, улс орны хөгжлийн түвшнээс хамааралтай болохыг харуулж байна.

Хөгжлийн бэрхшээлтэй хүний нэр төр, эрхэм чанарыг хүндэтгэн харьцаж, бусадтай адил тэгш эрх эдлэх боломжийг бий болгох нь хүний эрхийн зарчим юм. Чухам энэ л зарчмын үүднээс хөгжлийн бэрхшээлийн асуудалд хандахыг хүний эрхийг хамгаалагчид чухалчилдаг. Азгүй тохиолдлоор хэн нэгэн хөгжлийн бэрхшээлтэй болж болох ч түүнийг золгүй хувь тавилан угтах ёсгүй билээ.

*Хүний эрхийн төлөө тэмцэгч эмэгтэйн захидлын хэсгээс
та нэгийг эрэгцүүлэн бодох биз ээ.*

МИНИЙ АМЬДРАЛ

Би амьдралынхаа эхний долоо хоногийг Германы Бремерхафен хот дахь АНУ-ын цэргийн баазын нярай хүүхдийн эрчимт эмчилгээний тасагт өнгөрүүлсэн юм. Намайг хорвоод мэндэлсний дараахан нэг залуу ахмад аавд маань “Олон хүн танай охин шиг ийм өвчтэй хүүхдийг өндөр ууланд аваачаад орхих байсан” гэж хэлсэн юм гэнэ лээ. Би дэлхийн хүн амын дөнгөж 0,008 хувь тусдаг ясны төрөлхийн өвчтэй. Энэ өвчний улмаас яс хэврэг, хугарамхай болдог бөгөөд миний яс 55 удаа хугарсан юм. Би чөмгөндөө 12 удаа, нуруундаа 1 удаа төмөр саваа суулгах мэс засал хийлгэж байсан.

Би багадаа өөрийгөө биеийн хувьд зарим нэг дутагдалтай ч жирийн л хүүхэд гэж бодож байсан болохоор хөгжлийн бэрхшээлтэй хүнийг амьдралд чухам юу угтдагийг мэддэггүй байжээ. Яс маань санамсаргүй хугарах вий гэж ээж бид хоёр байнга түгшдэг байв. Тоглож байгаад ясаа хугална гэж болгоомжлохдоо ээж маань намайг хүүхдүүдтэй нийлүүлдэггүй байсан. Би бага насны амьдралынхаа бараг 7 жилийг бэртлээ эмчлүүлэх гэж өнгөрүүлсэн билээ.

3 хүрээд би АНУ-ын Колорадо мужийн хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийн тусгай цэцэрлэгт явж эхэлсэн. Тэнд би хүүхдүүдтэй хамт байхыг хүсэж байсан боловч цэцэрлэгийн найзуудын маань маш хүнд согог гэмтэл чөлөөтэй харьцахад саадтай байлаа. Хэдэн жилийн дараа манайх Калифорни шилжиж, би тэндхийн ерөнхий боловсролын ердийн сургуульд орсон юм. Сургуулийнхаа эрүүл сурагчдын дотор би ганцаараа хөгжлийн бэрхшээлтэй байсан боловч

хүмүүстэй харьцахын баяр жаргалыг эдлүүлдэг сургуульдаа би хайртай байлаа. Гэвч хичээлийн бус цагаар урьдын л адил нийгмээс тусгаарлагдсанаа мэдэрдэг байв.

Хөлдөө төмөр саваа суулгасны дараа надад сувилгаа шаардлагатай байсан тул би 8 настайдаа тусгай сургуульд шилжсэн юм. Хэдийгээр тэндхийн нөхөн сэргээх үйлчилгээ гайхалтай сайн байсан боловч сургалт нь наад захын зүйлээс хязгаарлагдаж, хуучин сургуулийн маань 1 дүгээр ангид үзсэнийг л дахин зааж байв. Миний хувьд энэ үе оюун ухаанаа дайчлахгүй байх аятайхан цаг байсан боловч тэнд ганцхан жилийг өнгөрүүлсэндээ баярладаг юм.

Үүний дараа би хуучин сургуульдаа эргэн ирж, оюун ухааны чадвараар өөртэйгөө эн зэрэгцэх хүмүүстэй харилцах болов. Арай гэж дотны нөхөдтэй болж, орчиндоо дасаж байтал дахиад л нуруу бэхжүүлэх эмчилгээ хийлгэх болж, сургуулиа жил орчим хугацаанд орхих боллоо. Эмчилгээний дараа гэрийн багш надад өдөр бүр нэг цагийн хичээл заах болсон бөгөөд ийнхүү дахиад л оюун ухааны минь хөгжилд түлхэц өгөх юмгүй болов.

1990-ээд он бол миний хувьд эмчилгээний ямар нэгэн ноцтой асуудалгүй, тайван суралцах боломж бүрдсэн үе байлаа. Өсвөр насны бүх хүүхдүүдийн адил биед маань өөрчлөлт гарч байв. Тун удалгүй би нэгэн хүүд сэтгэл татагдах болж, үүний улмаас миний хувьд хамаг юм уруудах тийшээ хандлаа. Миний биеийн хөгжил үе тэнгийн охидын адил байж, түүнийг хүсэл

мөрөөдөл дүүрэн байсан боловч мэдрэмж хийгээд түүнийгээ илэрхийлэх боломжийн хооронд асар их зөрүү байдгийг би мэдэрсэн. Энэ үед би сэтгэлээр маш их унаж, өөртөө бухимдаж байв. Толинд өөрийгөө хараад ой гутах шиг болдогсон. Олон нийтийн мэдээллийн хэрэгслээр сурталчилж, нийтээр хүлээн зөвшөөрсөн гоо сайхны хэвшмэл дүр төрх ухаан санаанд минь шингэснээс тийнхүү зөрчилдөн, хямарч байснаа би эргэн дурсдаг. Би хөгжлийн бэрхшээлтэй хүний сайхан чанар, гоо байдлыг харуулсан дүрийг огт олж хараагүй, гагцхүү биднийг хөөрхийлөлтэй хүмүүс болох тухай үзүүлж байхыг л харж байсан. Тэр үед би өөрийгөө хүндэтгэхээ больж, энэ цөхрөлөөсөө хэзээ ч салахгүй юм шиг санагдаж байлаа.

Флоридын их сургуулийн хуулийн факультетад орсны дараа амьдралын маань зорилго надад тодорхой болов. Би хүч чадлаа мэдэрч, эрхээ хамгаалан тэмцэх асар их хүсэл төрөх болов. Тэр л үеэс тэгш эрх, гоо үзэсгэлэн, өөрийгөө хүндэтгэх сэтгэлийн тухай эргэцүүлэн бодож, нийгмийн хандлагыг өөрчилж болно гэж гүнээ итгэх боллоо. Би гадаад оронд зохион байгуулагдсан хөгжлийн бэрхшээлтэй хүмүүсийн асуудлаарх олон улсын арга хэмжээнүүдэд эх орноо төлөөлөн оролцож, НҮБ, “Rehabilitation International” байгууллагын туслалцаатайгаар илтгэлүүдээ нийтлүүлэх болсон юм.

Энэ үеэс л дэлхий аль ч улс оронд ялгаагүй хөгжлийн бэрхшээлтэй хүмүүсийг алагчилагдаж байгаа нь тэднийг хязгаарлагдмал байдалд хүргэж байгааг ойлголоо. Бодит байдал дээр ихэнх хүн амьдралынхаа аль нэг үед хөгжлийн бэрхшээлтэй болдог бөгөөд зөвхөн манай улсад л гэхэд нийт хүн амын 80 орчим хувь нь амьдралдаа түр буюу удаан хугацаагаар, эсвэл байнгын хөгжлийн бэрхшээлтэй болж байдаг ажээ.

Миний өнгөрүүлсэн амьдралын минь туршид надаас салж өгөхгүй байсан өөрийгөө хүнээс дутуу гэх сэтгэл, ичгүүр, зовиураа дарахыг хичээн зүтгэсний эцэст одоо би хөгжлийн бэрхшээлтэй байдал минь надад асар их бололцоо олгосныг мэдрэх болов. Хэрэв үүнийг ухаараагүй бол одоо надад байгаа олон сайхан боломж гарч ирэхгүй байсан биз ээ.

16 настайдаа аавынхаа ирж амьдрах болсноос хойш энэ бүхэн нээгдсэн гэж хэлж болно. Аав маань миний хүн хэмээх эрхэм чанарыг олж харан, түүнийг хөгжүүлэхийг бүх талаар дэмжиж байлаа. Машин жолоодохыг зааж, ажил олоход минь тусалж, нэг үгээр хэлбэл аав маань надад хүссэнээ хийх эрх чөлөө олгосон. Энэ бол миний амьдралд гарсан эргэлт байлаа. Харин ээж маань хэзээ ч ингэж зүрхлэхгүй байсандаа. Гэхдээ би ээжийнхээ ачаар хувь хүн болж төлөвшиж, өөрийгөө хайрлах үзэлтэй болсон. Эцсийн эцэст өөрийгөө хайрлана гэдэг эрхэм чанар билээ.

Хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийн эцэг эх тэднийг өөрийгөө хайрлах, хүндэтгэх, бие даасан үзэл хандлагатай болоход нь дэмжлэг үзүүлэх ёстой. Аав, ээжийнхээ ийм дэмжлэгийн үрээр би өөртөө итгэлтэй болж, бусад хөгжлийн бэрхшээлтэй хүмүүст туслах боломжтой боллоо.

Бетани Стивенс

Флоридын их сургуулийн хуулийн факультетын оюутан,

Оюутны “Делта сигма омикрон” нийгэмлэгийг үүсгэн байгуулагч

(НҮБ-ын Хүүхдийн сангийн 2006 оны дэлхийн хүүхдийн байдал илтгэлээс хэсэгчлэн авав...)

2000 онд дэлхийн 189 орны төр засгийн тэргүүнүүд оролцсон НҮБ-ын дээд хэмжээний уулзалтаар “Мянганы тунхаглал”-ыг баталж, 2015 он гэхэд дараах зорилгуудад хүрэхийг санал нэгтэй хүлээн зөвшөөрсөн. Монгол Улсын Их Хурлын 2005 оны 25 дугаар тогтоолоор хүний эрхийг баталгаажуулах, ардчилсан засаглалыг хөгжүүлэх зорилгыг нэмж, улсынхаа мянганы зорилтуудыг тодорхойлсон билээ.

Зорилго 1: Ядуурал, өлсгөлөнг бууруулах

✎ Ядуурал хөгжлийн бэрхшээлийг, хөгжлийн бэрхшээл ядуу байдлыг бий болгодог бөгөөд ойролцоогоор хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн 85 орчим хувь нь ядуу, нэн ядуу амьдарч байна.

Зорилго 2: Бүх нийтээр анхан шатны боловсрол эзэмших

✎ Хөгжиж буй орнуудад амьдарч буй хөгжлийн бэрхшээлтэй хүүхдүүдийн 98 орчим хувь нь сургуульд суралцаж чадахгүй байгаа тухай тооцоо бий.

Зорилго 3: Хүйсийн тэгш байдлыг дэмжих, эмэгтэйчүүдийн эрхийг хангах

✎ Хөгжлийн бэрхшээлтэй эмэгтэйчүүд нь давхар алагчлалд өртөх эрсдэлтэй нийгмийн эмзэг хэсэг билээ. Тэд нэг талаас эмэгтэй хүнийхээ хувьд нөгөө талаас хөгжлийн бэрхшээлийнхээ улмаас эрх нь зөрчигдөх эрсдэлтэй байдаг.

✎ Хөгжлийн бэрхшээлтэй эмэгтэйчүүд биеийн болон бэлгийн хүчирхийлэлд өртөх нь эрүүл эмэгтэйчүүдтэй харьцуулахад 2-3 дахин их байдаг тухай олон улсын байгууллагын судалгаа бий. Хөгжлийн бэрхшээлтэй эмэгтэйчүүд хүчирхийлэлд өртсөн ч хуулийн байгууллагад хандах нь ховор байдаг.

Зорилго 4: Хүүхдийн эндэгдлийг бууруулах

✎ Эрүүл хүүхдийн эндэгдлийг 20 хувь хүртэл бууруулж чадсан улс оронд ч хөгжлийн

бэрхшээлтэй хүүхдийн эндэгдэл өндөр хувьтай байна.

Зорилго 5: Эхчүүдийн эрүүл мэндийг сайжруулах

✎ Жилд ойролцоогоор 20 орчим сая эмэгтэйчүүд жирэмслэлт, төрөлттэй холбоотой шалтгаанаар хөгжлийн бэрхшээлтэй болж байна.

✎ Эхийн төрөлтөөс өмнөх хэвийн бус үйл ажиллагаа нь хөгжиж буй орнуудад хүүхэд хөгжлийн бэрхшээлтэй болох түгээмэл шалтгаан болдог ажээ.

Зорилго 6: Бэлгийн замын халдварт өвчин, ХДХВ/ДОХ, сүрьеэтэй тэмцэх, бусад өвчнийг бууруулах

✎ Өвчнөөс урьдчилан сэргийлэх мэдлэг, мэдээлэл дутмагаас, эмнэлгийн үйлчилгээ хүртээмжгүйгээс хөгжлийн бэрхшээлтэй хүмүүс аливаа өвчнөөр өвдөх нь элбэг байдаг.

Зорилго 7: Байгаль орчны тогтвортой байдлыг хангах

✎ Хүрээлэн буй орчны бохирдол, байгалийн тэнцвэртэй байдал алдагдах нь хүн хөгжлийн бэрхшээлтэй болох томоохон хүчин зүйл.

Зорилго 8: Хөгжлийн төлөө дэлхийн түншлэлийг хөгжүүлэх

✎ Хурдаараа дэлхийг гайхашруулж байгаа мэдээллийн технологийн хөгжлөөс хөгжлийн бэрхшээлтэй хүмүүс хоцрогдсон хэвээр байна.

Зорилго 9: Хүний эрхийг баталгаажуулах, ардчилсан засаглалыг хөгжүүлэх

᠘ Монгол Улсын нийт хүн амын 8 орчим хувь болох хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн эрх ноцтой зөрчигдөж байна.

᠘ Хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн 70 гаруй хувь нь төрийн үйл хэрэг, нийгмийн амьдралд оролцож чадахгүй байна.

Хөгжлийн бэрхшээлтэй хүмүүст тулгамдаж байгаа асуудлуудыг шийдвэрлэхгүйгээр мянганы зорилтуудад хүрэх боломжгүй...

ЯАГААД ШИЙДВЭР ГАРГАГЧ ХӨГЖЛИЙН БЭРХШЭЭЛТЭЙ ХҮНИЙ ЭРХИЙН АСУУДЛЫГ АНХААРАХ ЁСТОЙ ВЭ?

᠘ Хүн бүр угаас заяасан нэр төр, эрхэм чанар, эрхийнхээ хувьд тэгш учраас хөгжлийн бэрхшээлийн асуудалд хүний эрхийн үүднээс хандах ёстой. Иргэдийнхээ нэлээдгүй хэсгийг алагчилж, орхигдуулсан улс орон хүмүүнлэг, иргэний, ардчилсан нийгмийг цогцлуулан хөгжүүлж чадахгүй.

᠘ Хөгжлийн бэрхшээлтэй хүмүүс бусдын нэгэн адил сонгогч, татвар төлөгч, иргэн юм.

᠘ Хөгжлийн бэрхшээлтэй хүмүүсийг нийгмээс тусгаарлаж, тусгай халамж, үйлчилгээ үзүүлэх нь өндөр өртөгтэйн дээр эцэс төгсгөлгүй үргэлжлэх ажиллагаа билээ. Харин тэдэнд хараат бусаар бие даан амьдрах орчныг бүрдүүлэх нь нийгэм, эдийн засгийн хувьд ашигтай шийдэл болно.

᠘ Хөгжлийн бэрхшээл хэнд ч, хэдийд ч тохиолдож болох учраас хүн бүрийн асуудал болно.

1.2 Хөгжлийн бэрхшээлтэй хүний эрхийн талаарх олон улсын эрх зүйн бусад баримт бичгүүд

Конвенци батлагдахаас өмнө хүний эрхийн олон улсын баримт бичгүүдэд хөгжлийн бэрхшээлтэй хүний эрхийн асуудал дараах байдлаар тусгагдсан байв.

᠘ *Хүний эрхийн тцгээмэл тунхаглал (1948)*

Тодорхой зарчмуудыг уриалсан чанартай баримт бичиг хэдий ч хүний эрхийн олон улсын эрх зүйн бусад баримт бичгийн суурь хэм хэмжээ юм. Тунхаглалын 7 дугаар зүйлд хүн бүрийн хуулийн өмнө адил тэгш байх болон алагчлалд өртөхгүй байх, 25 дугаар зүйлд хөгжлийн бэрхшээлтэй болох тохиолдолд тэтгэмж авах эрхтэй болохыг баталгаажуулсан.

᠘ *Иргэний болон улс төрийн эрхийн тухай олон улсын пакт (1966)*

ИУТЭОУП-ын 2 дугаар зүйлд Пактаар хүлээн зөвшөөрсөн эрхийг арьс үндэс, арьсны өнгө, хүйс, хэл, шашин шүтлэг, улс төрийн болон бусад үзэл бодол, үндэсний буюу нийгмийн гарал, хөрөнгө чинээ, **төрсөн буюу бусад байдлаар** ялгаварлахгүйгээр хүндэтгэн хангахаар заасан. Пактад хөгжлийн бэрхшээлтэй хүмүүсийн талаар тусгайлсан заалт байхгүй ч дээрх зүйлийн төрсөн буюу бусад байдлаар гэдэгт хөгжлийн бэрхшээлтэй хүмүүсийг хамруулж ойлгоно.

🕒 *Эдийн засаг, нийгэм, соёлын эрхийн олон улсын пакт (1966)*

ЭЗНСЭОУП-д ч мөн дээрхийн нэгэн ижил заалт бий. 1994 онд энэ Пактын хэрэгжилтэд хяналт тавих, хэрэгжилтийг хангуулах үүрэг бүхий Эдийн засаг, нийгэм, соёлын эрхийн Хорооны 5 дугаар ерөнхий зөвлөмж гаргаж, хөгжлийн бэрхшээлтэй хүнийг хүйсийн хувьд алагчлах болон хөдөлмөр эрхлэх, гэр бүлийг хамгаалах, хүрэлцэхүйц амьжиргаатай байх, бие бялдар, сэтгэхүйн хувьд эрүүл байх, сурч боловсрох, соёлын амьдралд оролцох, шинжлэх ухааны хөгжил дэвшлийн үр шимийг хүртэх эрхээ эдлэхэд алагчлах явдлыг устгахыг оролцогч улсуудад зөвлөжээ.

🕒 *Эмэгтэйчүүдийг алагчлах бүх хэлбэрийг устгах тухай конвенци (1979)*

Конвенцууд хөгжлийн бэрхшээлтэй эмэгтэйчүүдэд чиглэгдсэн тусгай заалт байхгүй. Харин Эмэгтэйчүүдийг алагчлах явдлыг устгах хорооны 18 дугаар ерөнхий зөвлөмжид хөгжлийн бэрхшээлтэй эмэгтэйчүүд нь давхар алагчлалд өртөж буй нэн эмзэг бүлэгт учраас оролцогч улсууд тайлан илтгэлдээ тэдний асуудлыг заавал оруулах, ялангуяа хөгжлийн бэрхшээлтэй эмэгтэйчүүдийн боловсрол, хөдөлмөр эрхлэлт, эрүүл мэндийн үйлчилгээ, нийгмийн хамгааллын арга хэмжээ ижил тэгш хамрагдах боломж олгох, нийгэм, соёлын амьдралд бүрэн дүүрэн оролцуулах нөхцөлийг бий болгохыг зөвлөсөн.

🕒 *Хүүхдийн эрхийн тухай конвенци (1989)*

НҮБ-ын хүний эрхийн суурь гэрээнүүдээс хөгжлийн бэрхшээлтэй хүний асуудлыг тусгасан анхны гэрээ нь Хүүхдийн эрхийн тухай конвенци юм. Конвенцийн 2 дугаар зүйлд хүүхдийг хөгжлийн бэрхшээлээс нь шалтгаалан алагчлах явдлыг хориглож, хүүхэд бүр хөгжлийн бэрхшээлтэй эсэхээсээ үл хамаарч Конвенцид заагдсан эрхийг бүрэн дүүрэн эдлэх ёстой болохыг заажээ. Түүнчлэн Конвенцийн 23 дугаар зүйлд “Оролцогч улсууд өөрийнхөө боломжид түшиглэн хөгжлийн бэрхшээлтэй болон оюуны хомсдолтой хүүхдийн нэр төрийг хүндэтгэн нийгмийн амьдралд идэвхтэй оролцох боломжтой орчинд бүрэн дүүрэн, зохистой амьдрах нөхцөлийг бүрдүүлэх, хөгжлийн бэрхшээлтэй болон оюуны хомсдолтой хүүхдийг асран хамгаалахад бололцооныхоо хэрээр туслалцаа үзүүлэх, онцгой анхаарал халамж тавих үүрэгтэй” болохыг заасан.

🕒 *Хөгжлийн бэрхшээлтэй хүний мэргэжлийн нөхөн сэргээлт ба хөдөлмөр эрхлэлтийн тухай Олон улсын хөдөлмөрийн байгууллагын 159 дүгээр конвенци (1983)*

Конвенцийн 2 дугаар зүйлд “Оролцогч улсууд хөгжлийн бэрхшээлтэй хүмүүсийн мэргэжлийн нөхөн сэргээлт, хөдөлмөр эрхлэлтийн талаар үндэсний бодлого боловсруулан хэрэгжүүлж, тухай бүр эргэн авч үзэж байх үүрэгтэй” болохыг заажээ. Үндэсний бодлого нь хөгжлийн бэрхшээлтэй бүх хүнийг зохих мэргэжлийн нөхөн сэргээх арга хэмжээнд хамруулах, хөгжлийн бэрхшээлтэй хүмүүс хөдөлмөрийн нээлттэй зах зээлээс ажил олох боломжийг нэмэгдүүлэхэд чиглэгдэх ёстой бөгөөд түүнийг боловсруулахдаа эрэгтэй, эмэгтэй хүмүүсийн адил тэгш байдлыг баталгаажуулах, хөгжлийн бэрхшээлтэй хүний эрхийн талаар мэргэшсэн байгууллагуудыг оролцуулахыг гэрээнд оролцогч улсуудад үүрэг болгосон.

 Оюуны хомсдолтой хүний эрхийн тухай тунхаглал (1971)

Оюуны хомсдолтой хүмүүс бусад хүний эдэлдэг эрхийг дээд хэмжээгээр эдлэх ёстойг тунхагласан.

 Хөгжлийн бэрхшээлтэй хүний эрхийн тунхаглал (1975)

Тунхаглал нь “хөгжлийн бэрхшээл” гэсэн ойлголтыг тайлбарласан анхны олон улсын баримт бичиг юм. Хөгжлийн бэрхшээлтэй хүн иргэний, улс төрийн, нийгмийн болон соёлын бүхий л эрхийг бусдын нэгэн адил эдлэх ёстой болохыг тунхаглан зарлажээ.

 Харааны болон сонсголын бэрхшээлтэй хүний эрхийн тунхаглал (1979)

Харааны болон сонсголын бэрхшээлтэй хүн бүр олон улсын хүний эрхийн баримт бичгүүдэд заасан бүх эрхийг эдлэх ёстой болохыг тунхагласан.

 Сэтгэцийн өвчтэй хүнийг хамгаалах, сэтгэцийн эмчилгээ сувилгааг сайжруулах зарчмууд (1991)

Зарчмуудын зорилго нь оюуны хомсдолтой хүмүүсийг хамгаалахад чиглэгдсэн нийтлэг стандарт тогтоох явдал юм. Хүн бүр хамгийн дээд зэргийн сэтгэцийн эмчилгээ, үйлчилгээг хүртэх эрхтэй ба сэтгэцийн өвчтэй хүмүүс нь хүн ёсоор, нэр төрөө хүндэтгүүлэн харьцах эрхтэй болохыг зарчмуудад заасан. Мөн сэтгэцийн өвчтэй хүмүүс эдийн засгийн, бэлгийн болон бусад хэлбэрийн мөлжлөг, бие махбодийн хүчирхийлэл, хүнлэг бус хэрцгий хандахаас хамгаалуулах эрхтэй болохыг баталгаажуулсан. Сэтгэцийн өвчтэй хүн иргэний, улс төрийн эрхээ бусдын нэгэн адил эдэлж, алагчлалаас ангид байх эрхтэй бөгөөд сэтгэцийн өвчин хүнийг эрх зүйн чадамжгүй байдалд хүргэж байгаа бол энэ талаар хараат бус шүүхийн хүчин төгөлдөр шийдвэр гарсан байх ёстойг дэлхий нийтийн зарчим болгожээ.

 Хөгжлийн бэрхшээлтэй хүний талаарх дэлхийн үйл ажиллагааны мөрийн хөтөлбөр (1982)

1981 онд зарлагдсан Хөгжлийн бэрхшээлтэй хүний олон улсын жилийн үр дүнд энэхүү баримт бичиг боловсруулагджээ. Мөрийн хөтөлбөр нь хөгжлийн бэрхшээлээс урьдчилан сэргийлэх, хөгжлийн бэрхшээлтэй хүнийг сэргээх, нөхөн сэргээх дэлхий нийтийн цогц стратегийг тодорхойлсон юм. Түүнчлэн хөгжлийн бэрхшээлтэй хүний асуудалд хүний эрхийн үүднээс хандахыг чухалчилсан анхны баримт бичиг байв.

Хөгжлийн бэрхшээлтэй хүмүүст тэгш боломж олгох стандарт дүрмүүд (1993)

Энэ баримт бичиг улс орон бүрийн ёс суртахууны хүчин зүтгэлийн үр дүнд хэрэгжих ёстойг Стандарт дүрмүүдэд заасан байдаг. Тэгш оролцоо, тэгш оролцооны зорилтот хүрээнүүдийг тодорхойлж, авах арга хэмжээ, хэрэгжилтийг хянах механизмыг цогц байдлаар тогтоож, хэрэгжилтэд нь хяналт тавих тусгай субъектийг бий болгосноороо Стандарт дүрмүүд онцлогтой. Хөгжлийн бэрхшээлтэй хүмүүст тэгш боломж олгох стандарт дүрмүүдийн хэрэгжилтэд НҮБ-ын тусгай илтгэгч хяналт тавьдаг.

Хөгжлийн бэрхшээлтэй хүний эрхийн талаарх Бээжингийн тунхаглал (2000)

2000 онд БНХАУ-ын Бээжин хотноо зохион байгуулагдсан Төрийн бус байгууллагуудын Дэлхийн Бага Хурлаас батлан гаргасан энэ тунхаглалаар хөгжлийн бэрхшээлтэй хүний хүрэлцэхүйц амьжиргаатай байх эрх, тэгш оролцоог баталгаажуулахад чиглэгдсэн арга хэмжээг тодорхойлсон.

Бивакогийн мянганы хөтөлбөр (2003)

Ази Номхон далайн бүсийн эдийн засаг, нийгмийн комиссын 2002 оны 54/2 дугаар тогтоолоор 2003-2012 оныг Ази Номхон далайн бүсийн хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн аж байдлыг сайжруулах, тэдний оролцоог хангасан, саад тотгоргүй, эрхэд тулгуурласан үйл ажиллагааг хэрэгжүүлэх зорилго бүхий “Ази, номхон далайн бүсийн хөгжлийн бэрхшээлтэй иргэдийг дэмжих арван жил” болгон зарлаж, арван жилийн үйл ажиллагааны хөтөлбөрийг хэрэгжүүлэх гол механизм болох Бивакогийн мянганы хөтөлбөрийг баталсан. Хөтөлбөрт 2012 он гэхэд хөгжлийн бэрхшээлтэй хүний оролцоог хангасан, саад тотгоргүй, эрхэд тулгуурласан нийгмийг цогцлоон бүрдүүлэхэд чиглэгдсэн 21 зорилт, зорилтуудад хүрэх 17 стратегийг тодорхойлсон байна.

1.3 Хөгжлийн бэрхшээлтэй хүмүүсийн эрхийн тухай конвенцийн хэрэгцээ, шаардлага

...Түүхийн өнгөрсөн хугацаанд хөгжлийн хүний эрхийн суурь гэрээ, конвенцуудад тусгалаа бэрхшээлтэй хүмүүсийн эрхийн асуудал олсон нь үнэн боловч энэ асуудлыг хариуцан хүүхдүүд, эмэгтэйчүүд, дүрвэгсэд, цагаач ажилчид ажилладаг НҮБ-ын бүтэц байхгүй нь ч мөн зэрэг бусад эмзэг бүлгийн хүмүүстэй бодитой зүйл билээ.

харьцуулахад олон улсын эрх зүйн зохицуулалтын гадна үлдсээр байжээ. Хөгжлийг бэрхшээлтэй хүмүүсийг үл алагчлах нь НҮБ-ын

НҮБ-ын Хөгжлийн бэрхшээлийн талаарх тусгай илтгэгч Леандро Депю...

НҮБ-ын Ерөнхий Ассамблейн 1982 оны 12 сарын 3-ны өдрийн 37/52 дугаар тогтоолоор 1983-1992 оныг Хөгжлийн бэрхшээлтэй хүний 10 жил болгон зарлахын хамт энэ арван жилд хэрэгжүүлэх “Үйл ажиллагааны мөрийн хөтөлбөр”-ийг батлан гаргасан. Уг 10 жилийн үйл явц, үр дүн болон хөтөлбөрийн хэрэгжилтэд үнэлэлт өгөх зорилготой шинжээчдийн уулзалт 1987 оны 11 сард зохион байгуулагдсан бөгөөд энэхүү уулзалтаар хөгжлийн бэрхшээлтэй хүний эрхийн талаарх олон улсын тусгай гэрээ байгуулах анхны санаачилга гарсан юм. Энэ санаачилгыг дэмжиж зарим улс орноос хөгжлийн бэрхшээлтэй хүний эрхийн тухай олон улсын гэрээний эх бичвэрийг боловсруулах ажлыг эхлүүлж байлаа. Тухайлбал, 1987 онд Итали улс, 1988 онд Швед улс хөгжлийн бэрхшээлтэй хүний эрхийн талаарх олон улсын тусгай гэрээгээр зохицуулах асуудлыг тодорхойлж, НҮБ-д хүргүүлж байсан юм. Харин тэдгээр улсуудын санаачилга НҮБ-ын гишүүн улсуудын хангалттай дэмжлэгийг авч чадаагүй билээ. Гэсэн хэдий ч Швед улсын боловсруулсан эх бичвэр хожмоо Хөгжлийн бэрхшээлтэй хүнд тэгш боломж олгох стандарт дүрмийн үндэс суурь болжээ.

1987 оноос хойш 2000 оныг хүртэл хөгжлийн бэрхшээлтэй хүний эрхийн талаар тусгай гэрээ байгуулах шаардлагатай эсэх тухай маргаан НҮБ-ын хүрээнд хүчтэй өрнөж байв. Эхэн үедээ хөгжлийн бэрхшээлтэй хүний эрхийн асуудал НҮБ-ын хүний эрхийн суурь гэрээ, конвенцид хэдийнэ тусгагдсан учраас тусгай гэрээ шаардлагагүй гэсэн үзэл давамгайлж байлаа. Энэ хандлагыг дэмжигчид олон улсын хүний эрхийн гэрээ, конвенцуудын “...арьс үндэс, арьс өнгө, хүйс, хэл, шашин шүтлэг, улс төрийн буюу бусад үзэл бодол, үндэсний буюу нийгмийн гарал, эд хөрөнгийн байдал, төрсөн байдал буюу бусад нөхцөл байдлаар ялгаварлахгүйгээр...” гэсэн заалтын бусад нөхцөл байдлаар гэсэн хэсэгт хөгжлийн бэрхшээлтэй хүний эрхийн асуудал багтаж байгаа гэсэн үндэслэлийг гаргаж байсан.

Хүүхдийн эрхийн тухай конвенцийн 23 дугаар зүйлийг эс тооцвол өөр ямар ч хүний эрхийн гэрээ, конвенцийн зүйл заалтад хөгжлийн бэрхшээлтэй хүний эрхийг хангах талаар тусгайлсан зохицуулалт байхгүй байв. Түүнчлэн Эдийн засаг, нийгэм, соёлын эрхийн хорооны 6 дугаар ерөнхий зөвлөмж, Эмэгтэйчүүдийн эрхийн хорооны 18 дугаар Ерөнхий зөвлөмжөөс өөр НҮБ-ын хүний эрхийн үндсэн гэрээ, конвенцийн заалтыг хөгжлийн бэрхшээлтэй хүний эрхийн асуудалтай уялдуулж тайлбарласан Конвенцийн хорооны тайлбар байхгүй байлаа. Хэдийгээр олон улсын хүний эрхийн гэрээ, конвенциор хүн бүрт хамааралтай эрхийг баталгаажуулсан ч хөгжлийн бэрхшээлээс үүдэн бий болдог нийгмийн амьдралд оролцох тэгш оролцоо, барилга байгууламж, нийгмийн орчин, мэдээллийн хүртээмжтэй байдал, хараат бус амьдрах эрхийн асуудал тусгагдаж чадаагүй билээ.

Хөгжлийн бэрхшээлтэй хүмүүсийн эрхийг хангах талаар урьд өмнө нь гарч байсан олон улсын олон талт баримт бичгүүдийн ихэнх нь заавал биелэгдэх хууль зүйн хүчин чадамжтай бус, тунхаглал, зөвлөмжийн шинж чанартай байсан нь хөгжлийн бэрхшээлтэй хүмүүсийн эрхийн тухай тусгай гэрээ бий болгох нэг шаардлага байлаа.

Хөгжлийн бэрхшээлтэй хүний эрхийн тухай олон улсын конвенцийг дэмжигчдийн гаргаж байсан гол үндэслэлүүдийг нэг нь шинээр батлагдах конвенцийн дагуу НҮБ-ын бүтцэд бий болгох

Хөгжлийн бэрхшээлтэй хүмүүсийн эрхийн хорооны ач холбогдлын талаарх асуудал байв. Шинээр батлагдсан гэрээний хэрэгжилтийг хянах, хувь хүний гомдлыг шийдвэрлэх төдийгүй НҮБ-ын бодлого, хөтөлбөрүүд, эрх зүйн баримт бичигт хөгжлийн бэрхшээлтэй хүний эрхийн асуудлыг тусгахад конвенцийн дагуу байгуулагдах Хорооны үүрэг нэн чухлыг тэд онцолж байлаа.

2001 оны 12 сарын 19-ны өдөр НҮБ-ын Ерөнхий Ассамблейн 56/168 дугаар тогтоолоор хөгжлийн бэрхшээлтэй хүмүүсийн эрхийн талаарх тусгай конвенцийн эх бичвэрийг боловсруулах эсэх асуудлыг шийдвэрлэх Түр хороог байгуулсан бөгөөд 2003 оны 6 сард зохион байгуулагдсан Түр хорооны 3 дугаар чуулганаар конвенци боловсруулахыг дэмжиж, 2004 оны 2 сард ажлын хэсгийг томилжээ. Ажлын хэсэг 2 жил гаруй хугацаанд ажилласны эцэст 2006 оны 8 сарын 25-ны өдөр Хөгжлийн бэрхшээлтэй хүний эрхийн тухай олон улсын конвенцийн эх бичвэрийг боловсруулж дууссан. Хөгжлийн бэрхшээлтэй хүмүүсийн эрхийн тухай конвенци нь богино хугацаанд, иргэний нийгмийн байгууллагуудын өргөн оролцоотойгоор боловсруулагдаж, хамгийн хурдан хүчин төгөлдөр болж байгаагаараа НҮБ-ын бусад хүний эрхийн гэрээнүүдээс онцлогтой юм.

2006 оны 12 сарын 13-ны өдөр НҮБ-ын Ерөнхий Ассамблейн 61/106 дугаар тогтоолоор Хөгжлийн бэрхшээлтэй хүмүүсийн эрхийн тухай конвенцийг баталж, конвенцид гарын үсэг зурах хугацаа 2007 оны 3 сарын 30-ны өдрөөс нээгдсэн. 2008 оны 4 сарын 3-ны өдрийн байдлаар конвенцийг 20 дахь улс соёрхон баталж, конвенцийн 45 дугаар зүйлд заасны дагуу 2008 оны 5 сарын 3-ны өдрөөс хүчин төгөлдөр болсон билээ.

КОНВЕНЦИЙН ТҮҮХЭН ТОВЧООН

🕒 **2001 оны 12 дугаар сар:** Мексикийн Засгийн газраас хөгжлийн бэрхшээлтэй хүний эрхийн талаар тусгай гэрээ байгуулах саналыг НҮБ-ын Ерөнхий Ассамблейд гаргав.

🕒 **2002 оны 8 дугаар сар:** Түр хорооны анхны хуралдаан зохион байгуулагдаж, шинэ конвенцийн хэрэглээ, шаардлага, конвенцийн эх бичвэрийг боловсруулахад иргэний нийгмийн байгууллагын оролцооны асуудлыг хэлэлцэв.

🕒 **2006 оны 8 дугаар сар:** Конвенцийн эх бичвэрийг эцэслэв.

🕒 **2006 оны 12 дугаар сар:** Конвенци, түүний нэмэлт протокол НҮБ-ын Ерөнхий Ассамблейгаас батлагдав.

🕒 **2007 оны 3 дугаар сар:** Конвенци, түүний нэмэлт протоколд гарын үсэг зурахад нээлттэй болов.

🕒 **2008 оны 5 дугаар сар:** Конвенци, нэмэлт протоколын хамт хүчин төгөлдөр болов.

**ХӨГЖЛИЙН БЭРХШЭЭЛТЭЙ ХҮНИЙ ЭРХИЙН ТУХАЙ КОНВЕНЦИЙГ
ДЭМЖИХИЙН ТУЛД ШИЙДВЭР ГАРГАГЧ ЮУ ХИЙЖ БОЛОХ ВЭ?**

☞ Конвенцитай холбоотой хэлэлцүүлгийг Улсын Их Хурлын гишүүдийн хэмжээнд өрнүүлэх;

☞ Хэлэлцэгдэж буй хуулийн төслүүдийг конвенцийн агуулга, зарчимд нийцсэн эсэхийг нь хянан үзэх

☞ Хөгжлийн бэрхшээлтэй хүмүүсийн байгууллагууд, хүний эрхийн чиглэлээр ажилладаг байгууллагуудтай харилцаа холбоо тогтоох

☞ Сонгогч, дэмжигчидтэй хийх уулзалтаараа конвенцийн талаар мэдээлэл хийх, санал солилцох

☞ Хөгжлийн бэрхшээлтэй хүний эрхийн дэлхийн өдөр болох 12 сарын 3-ны өдөр зэрэг нийтийн тэмдэглэлт өдрийг тохиолдуулан конвенцийн талаар олон нийтэд хандаж үг хэлэх

☞ Конвенцийн талаарх ярилцлагыг хэвлэл, мэдээллийн байгууллагуудад өгөх, өгүүлэл, нийтлэл хэвлүүлэх

☞ Сонгуулийн мөрийн хөтөлбөртөө конвенцийг соёрхон батлуулах болон хэрэгжүүлэхтэй холбоотой асуудлыг тусгах

☞ Улс төрийн үйл ажиллагаа, үзэл баримтлалдаа хөгжлийн бэрхшээлтэй хүний эрхийн асуудлыг тусгаж, олон нийтийн дэмжлэгийг авах

ХОЁРДУГААР ХЭСЭГ: КОНВЕНЦИЙГ ОЙЛГОХ НЬ

Хөгжлийн бэрхшээлтэй хүмүүсийн эрхийн тухай конвенци нь хөгжлийн бэрхшээлтэй хүмүүст тэгш боломж олгох явдлыг гэрээний талуудад хууль зүйн үүрэг оногдуулхуйц түвшинд гаргаж тавьсан юм. Конвенци урьд өмнө нь батлагдсан НҮБ-ын хүний эрхийн суурь гэрээнүүдэд нэмэлт болох баримт бичиг юм. Өөрөөр хэлбэл, уг конвенциор ямар нэг шинэ эрх, эрх чөлөөний төрлийг бий болгож, баталгаажуулаагүй бөгөөд гагцхүү, хөгжлийн бэрхшээлтэй хүмүүсийн эдлэх наад захын эрх, эрх чөлөө, тэдгээрийг хэрэгжүүлэх талаар гэрээнд оролцогч улс, бусад этгээдийн хүлээх үүргийг нарийвчлан тодорхойлжээ.

Хөгжлийн бэрхшээлтэй хүмүүсийн эрхийн тухай конвенци нь бүтцийн хувьд оршил хэсэг, 50 зүйл, нэмэлт протоколоос бүрдэж байна.

2.1 Конвенцийн зорилго, зарчим, оролцогч улсын хүлээх нийтлэг үүрэг

Конвенцийн зорилго нь хөгжлийн бэрхшээлтэй хүн бүр хүний бүх эрх, үндсэн эрх чөлөөг бүрэн дүүрэн эдлэх явдлыг хангах, хамгаалах, хөхиүлэн дэмжих, тэдний салшгүй нэр төр, эрхэм чанарыг хүндэтгэн дэмжих явдал юм. Конвенци *хөгжлийн бэрхшээлтэй хүний эрхийг* эдийн засаг, нийгэм, улс төр, хууль, соёлын амьдралын бүхий л хүрээнд *хамгаалах, үл алагчлах харьцаа, тэгш хандлагыг* боловсрол, эрүүл мэнд, хуулийн байгууллагууд, соёл, биеийн тамир, спортын үйл ажиллагаанд, ажлын байр, гэр бүлийн амьдралд *төлөвшүүлэхэд* чиглэгдсэн. Түүнчлэн, хөгжлийн бэрхшээлтэй хүн бүр эрх зүйн этгээд болохыг нь хүлээн зөвшөөрч, эрүү шүүлт, мөлжлөг, хүчирхийллээс ангид байх явдлыг баталгаажуулан, тэдний амь нас, халдашгүй чөлөөтэй байдал, үзэл бодлоо илэрхийлэх, чөлөөтэй зорчих эрх чөлөө, хувийн амьдралын халдашгүй байдлыг хамгаалах нь зорилготой.

Конвенцид “Хөгжлийн бэрхшээлтэй хүн гэдэгт бие махбодь, оюун санаа, сэтгэл мэдрэл, мэдрэхүйн байнгын согогтой бөгөөд уг согог нь орчны бусад төрлийн бэрхшээлтэй нэгдэн нийлсний улмаас бусдын нэгэн адил нийгмийн амьдралд бүрэн дүүрэн, үр дүнтэй оролцоход нь саад учруулхуйц болсон этгээдийг хэлнэ” гэж тодорхойлсон боловч энэ нь хөгжлийн бэрхшээлтэй хүний талаарх “туйлын” тодорхойлолт биш юм. Учир нь конвенцийн оршил хэсэгт хөгжлийн бэрхшээл нь байнга өөрчлөгдөн хувьсаж байдаг ойлголт бөгөөд хувь хүний бие эрхтний согог, нийгмийн хандлагын болон орчны хязгаарлалтаас үүдэн бий болдгийг хүлээн зөвшөөрсөн.

...Бие махбодь, оюун санаа, сэтгэл мэдрэл, мэдрэхүйн согогийн улмаас бусдын адил нийгмийн харилцаанд оролцох чадвар нь бүрэн болон 12 сараас дээш хугацаагаар хязгаарлагдсан хүнийг “хөгжлийн бэрхшээлтэй” гэж ойлгоно.

Хөгжлийн бэрхшээлтэй иргэний нийгмийн хамгааллын тухай Монгол Улсын хуулийн 3 дугаар зүйлийн 3.1

Өөрөөр хэлбэл, конвенцид хөгжлийн бэрхшээлтэй хүн гэдэг ойлголтыг томъёолхоосоо илүүтэйгээр ийм бүлэгт нэн тэргүүнд хамрагдах ёстой хүмүүсийн шинж байдлыг тодорхойлсон юм. Конвенцийн тодорхойлолт нь аливаа улс орон үндэсний хууль тогтоомжийнхоо хүрээнд түр зуурын хөгжлийн бэрхшээлтэй болсон хүмүүсийг хөгжлийн бэрхшээлтэй хүн гэсэн ангилалд хамруулж, эрхийг нь хангах, хамгаалах явдлыг хязгаарлахгүй.

Конвенцийн зүйл заалтыг тайлбарлах, түүнийг амьдралд хэрэгжүүлэхэд гэрээнд оролцогч улсуудад чиглэмж болох ерөнхий зарчмуудыг 3 дугаар зүйлд тодорхойлсон.

КОНВЕНЦИЙН ЗАРЧМУУД

᠘ Сонголт хийх эрх чөлөө болон хүний бие даасан байдлыг оролцуулан хүний нэр төр, эрхэм чанар, хувийн хараат бус байдлыг хүндэтгэх;

᠘ Алагчлахгүй байх;

᠘ Нийгэмд бүрэн дүүрэн, үр дүнтэй оролцох болон хамрагдах;

᠘ Хөгжлийн бэрхшээлтэй хүмүүсийн онцлог байдлыг хүндэтгэх, тэднийг хүний ялгаатай байдал, хүн төрөлхтний нэг хэсэг гэж хүлээн авах;

᠘ Тэгш боломж олгох;

᠘ Хүртээмжтэй байх;

᠘ Эрэгтэй, эмэгтэйчүүд тэгш эрхтэй байх;

᠘ Хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийн хувьсаж өөрчлөгдөх чадамжийг хүндэтгэх болон хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийн өөрийн онцлог байдлаа хадгалах эрхийг хүндэтгэн хандах;

Нэр төр, эрхэм чанар, хувийн хараат бус байдал: Хүн болж төрсөн хэн боловч угаас заяасан нэр төр, эрхэм чанартай бөгөөд тэрхүү нандин чанарыг хүлээн зөвшөөрч, баталгаажуулах нь хүний эрхийн бүх баримт бичгийн зорилго байдаг. Хөгжлийн бэрхшээлтэй хүмүүс бие эрхтний согог гэмтлийнхээ улмаас ихэвчлэн хэн нэгний хараат байдалд орсон, өөрт хамаарах асуудлаараа шийдвэр гаргах боломж хомс байдаг тул тэдний хараат бус байдлыг баталгаажуулах нь эрхэм чанарыг нь хүлээн зөвшөөрч байгаа хэрэг юм.

Алагчлахгүй байх нь хүний эрхийн үндсэн зарчим юм. Конвенцид “Хөгжлийн бэрхшээлийн улмаас алагчлах гэж улс төр, эдийн засаг, нийгэм, соёл, иргэний болон бусад салбарт хүний эрх, эрх чөлөөг бусадтай адил тэгш эдлэх явдлыг хөгжлийн бэрхшээлээс нь шалтгаалан сулруулах

буюу ийм эрхийг хүлээн зөвшөөрөхийг үгүйсгэх зорилго агуулсан, эсхүл тийм үр дүнд хүргэсэн бүх төрлийн алагчлал, гадуурхалт, хязгаарлалтыг хэлнэ. Энэ нь алагчлалын бүх хэлбэр, түүний дотор тохирох хэрэглэгдэхүүнээс татгалзах явдал мөн хамаарна” гэж тодорхойлсон. Гэрээнд оролцогч улсууд хөгжлийн бэрхшээлтэй хүмүүсийг алагчлахад хүргэж байгаа хууль тогтоомж, нөхцөл байдлыг өөрчлөх, устгах үүрэгтэй. Гэхдээ хөгжлийн бэрхшээлтэй хүмүүст бусад эрүүл хүмүүсийн нэгэн адил боломж олгох үүднээс тэдэнд давуу боломж олгоход чиглэгдсэн, зайлшгүй шаардлагатай тусгай арга хэмжээг алагчлах гэж үзэхгүй тухай конвенцийн 5 дугаар зүйлийн 5.4 дэх хэсэгт заасан байна.

Тохирох хэрэглэгдэхүүнээс татгалзахыг хөгжлийн бэрхшээлтэй хүний эсрэг алагчлал болно. Конвенцийн 2 дугаар зүйлд “Тохирох хэрэглэгдэхүүн гэж хөгжлийн бэрхшээлтэй хүн бусдын нэгэн адил хүний бүх эрх, үндсэн эрх чөлөөг эдлэх явдлыг хангах үүднээс зохицоогүй, эсхүл үндэслэлгүй саад тотгорыг арилгах, багасгахад чиглэгдсэн нэн хэрэг бөгөөд шаардлагатай тохируулга, засвар өөрчлөлтийг хэлнэ” гэж тодорхойлжээ. Энэ зарчмын дагуу ажлын байрыг хөгжлийн бэрхшээлтэй ажилтныхаа өвөрмөц байдалд тохируулаагүй ажил олгогчид хариуцлага тооцох үндэслэлтэй. Гэхдээ конвенцид дурдсан орчин нөхцөлийг хөгжлийн бэрхшээлтэй хүний тусгай хэрэгцээнд нийцүүлэх засвар өөрчлөлт буюу тохирох хэрэглэгдэхүүн нь хөгжлийн бэрхшээлтэй хүмүүст “нэн хэрэгцээтэй” орчны байгууламжид хийгдэх бөгөөд ямар ч хязгааргүй шаардлага биш юм.

Алагчлал нь шууд ба шууд бус хэлбэртэй байж болно. Ижил нөхцөл байдалд хөгжлийн бэрхшээлтэй хүн, эрүүл хүнтэй ялгаатай харьцах нь шууд алагчлал мөн. Хэдийгээр өнгөц байдлаар харахад хүмүүст ижил тэгш хандаж байгаа мэт авч түүний үр дагавар нь ялгаатай нөхцөл байдлыг үүсгэж байвал шууд бус алагчлал болно.

Оролцооны зарчим: Хөгжлийн бэрхшээлтэй хүмүүсийг нийгмийн амьдралд, ялангуяа тэдний амьдралд нөлөөлөх шийдвэр гаргахад оролцуулахыг конвенци чухалчлан үздэг. Хөгжлийн бэрхшээлтэй хүн нийгмийн амьдралд оролцуулах нь хоёр талтай үйл явц юм. Нэг талаас хөгжлийн бэрхшээлтэй хүн өөрөө нийгмийн амьдрал оролцох идэвх санаачилга гаргах ёстой бол нөгөө талаас нийгмийн бусад гишүүд хөгжлийн бэрхшээлтэй хүнд нээлттэй байж, оролцоог нь хангах боломж олгосны үндсэн дээр хөгжлийн бэрхшээлтэй хүн нийгмийн амьдралд оролцох боломжтой болно. Конвенцид хөгжлийн бэрхшээлтэй хүн сонгууль зэрэг төрийн үйл хэрэгт оролцох, соёл урлаг, спорт, чөлөөт цагаа өнгөрүүлэх бусад арга хэмжээнд туслалцах замаар соёлын амьдралд оролцох эрхийг баталгаажуулсан.

Хөгжлийн бэрхшээлтэй хүний онцлог байдлыг хүндэтгэх: Түгээмэл тохиолддог хөгжлийн бэрхшээлтэй хүнийг дорд үзэх, биеийн согог гэмтлийг хачирхах, эвгүйцэх, дургүйцэх хандлагын улмаас тэдний эрх, эрх чөлөө зөрчигдөхөд хүрдэг. Бие эрхтэн согог гэмтлийг хэнд ч тохиолдож болох ердийн нөхцөл байдал гэж хүлээн авах, бүх төрөл хэлбэрийн хөгжлийн бэрхшээлтэй хүмүүсийг хүн төрөлхтний хэсэг болохыг хүлээн зөвшөөрөх хандлагыг нийгмийн бүх гишүүдэд төлөвшүүлэхэд конвенци чиглэгддэг.

Тэгш боломж олгох зарчим нь алагчлахгүй байх зарчимтай нягт холбоотой. Гагцхүү нийгмийн орчин байгууламжаас гадна сурч боловсрох, хөдөлмөрлөх, зохистой орон байраар хангагдах, аж амьдралаа дээшлүүлэх улмаар хүсэл мөрөөдөлдөө хүрэхэд олгогдож буй боломж хүн бүр тэгш байхыг илэрхийлсэн агуулгатайгаараа алагчлахгүй байх зарчмаас тэгш боломж олгох зарчим ялгагдаж байна.

Хүртээмжтэй байх: Энэ зарчим нь хөгжлийн бэрхшээлтэй хүмүүс эрхээ эдлэхэд учирч буй саад тотгорыг арилгахад чиглэгддэг. Гэхдээ зөвхөн бодит орчин нөхцөлийг хүртээмжтэй байлгахаас гадна интернэт, харилцаа холбоо зэрэг мэдээллийн технологи, эдийн засаг, соёлын амьдрал ч хөгжлийн бэрхшээлтэй хүмүүст хүртээмжтэй байхыг ойлгоно. Налуу зам, өргөн хонгил, хөгжлийн бэрхшээлтэй хүн ашиглах боломжтой өндөрт байрласан хаалганы бариул, брайль үсгээр буюу хялбар уншигдах хэвээр бичигдсэн мэдээлэл, дохионы хэлний орчуулагч байж гэмээ нь ажлын байр, урлаг соёлын газар, сонгуулийн санал өгөх бүхээг, тээврийн хэрэгсэл, шүүх хуралдааны танхим хөгжлийн бэрхшээлтэй хүнд хүртээмжтэй байж, тэдний бусадтай тэгш байх нөхцөл хангагдана.

Эрэгтэй, эмэгтэйчүүдийн тэгш байдал: Хөгжлийн бэрхшээлтэй эмэгтэйчүүд нэг талаас хөгжлийн бэрхшээлийнхээ улмаас нөгөө талаас “сул дорой” үзэгдсээр ирсэн хүйсийнхээ үндсэн дээр давхар алагчлалд өртдөг. Энэ зарчим нь гэрээнд оролцогч улсууд хөгжлийн бэрхшээлтэй хүний эрхийг хангах, хамгаалах арга хэмжээ авахдаа хөгжлийн бэрхшээлтэй эмэгтэйчүүдийн асуудалд тусгайлан анхаарал хандуулахыг шаарддаг. Эрэгтэй, эмэгтэй хүмүүсийн тэгш байдлыг хангах нь НҮБ-ын тулгуур зарчмаас гадна хүний эдлэх ёстой эрх юм.

Хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийн эрхийг хүндэтгэх: Хөгжлийн бэрхшээлтэй эмэгтэйчүүдийн нэгэн адил бие бялдрын өсөлт, хөгжлийн хувьд өөрийгөө илэрхийлэх насанд хүрээгүй хөгжлийн бэрхшээлтэй хүүхдүүд давхар алагчлалд өртөх эрсдэлтэй байдаг.

Конвенцийн 4 дүгээр зүйлд заасны дагуу гэрээний оролцогч улсууд хөгжлийн бэрхшээлтэй хүмүүс ямар нэг алагчлалгүйгээр хүний бүх үндсэн эрх, эрх чөлөөг бүрэн дүүрэн эдлэх явдлыг хүлээн зөвшөөрч, баталгаажуулах үүрэгтэй бөгөөд үүргээ биелүүлэх үүднээс дараах арга хэмжээг нэн даруй авах ёстой.

ГЭРЭЭНД ОРОЛЦОГЧ УЛСЫН НЭН ДАРУЙ АВАХ АРГА ХЭМЖЭЭ

🔗 Хөгжлийн бэрхшээлтэй хүний эрхийг хөхиүлэн дэмжсэн хууль тогтоомж батлан гаргах, үндэсний хууль тогтоомжийг Конвенцийн заалтад нийцүүлэх;

🔗 Алагчлалыг устгах үүднээс хууль тогтоох болон захиргааны арга хэмжээ авах;

ᠤ Төрийн бүх бодлого, хөтөлбөрт хөгжлийн бэрхшээлтэй хүний эрхийг хамгаалах, хөхиүлэн дэмжих явдлыг тусгах;

ᠤ Хөгжлийн бэрхшээлтэй хүний эрхийг зөрчсөн дадал, зуршлыг зогсоох;

ᠤ Төрийн захиргааны болон үйлчилгээний байгууллагууд хөгжлийн бэрхшээлтэй хүний эрх ийг хүндэтгэн сахих явдлыг хангах;

ᠤ Хувийн хэвшлийн байгууллага, хувь хүмүүс хөгжлийн бэрхшээлтэй хүний эрхийг хүндэтгэн сахих явдлыг хангах;

ᠤ Хөгжлийн бэрхшээлтэй хүмүүст хүртээмжтэй бараа бүтээгдэхүүн, үйлчилгээ, мэдээллийн технологийг зохион бүтээх, судалгаа шинжилгээ хийх, бусдын энэ талаарх үйл ажиллагааг дэмжих;

ᠤ Бие эрхтний согогийг нөхөх, тэдэнд туслах технологийн талаарх боломжит бүхий л мэдээллээр хөгжлийн бэрхшээлтэй хүмүүсийг хангах;

ᠤ Хөгжлийн бэрхшээлтэй хүмүүстэй ажилладаг албан хаагчдын конвенцийн талаарх мэдлэгийг нэмэгдүүлэх, сургалт зохион байгуулах

ᠤ Хөгжлийн бэрхшээлтэй хүмүүст хамааралтай хууль тогтоомж, бодлого хөтөлбөр, бусад шийдвэрийг боловсруулах, хэрэгжүүлэхдээ хөгжлийн бэрхшээлтэй иргэдтэй зөвшилцөж байх;

Хөгжлийн бэрхшээлтэй хүмүүсийн эрхийн тухай конвенцийн 4 дүгээр зүйлийн 4.2-т “Эдийн засаг, нийгэм, соёлын эрхийн тухайд эдгээр эрхийг бүрэн дүүрэн эдлүүлэх нөхцөл байдлыг аажмаар бий болгох үүднээс оролцогч улс бүр олон улсын эрх зүйн дагуу нэн даруй үүсэх энэхүү конвенциор хүлээлгэсэн үүрэгтэй үл харшлах байдлаар өөрийн боломжит нөөцийг дээд хэмжээгээр ашиглах бөгөөд шаардлагатай тохиолдолд олон улсын хамтын ажиллагаанд түшиглэнэ.” гэж заасан. Энэ заалт нь гэрээнд оролцогч улсуудад хөгжлийн бэрхшээлтэй хүмүүсийн эдийн засаг, нийгэм, соёлын эрхийг хэрэгжүүлэх нөхцөлийг аажмаар, шат дараатай бий болгох, ингэхдээ өөрийн боломжит нөөцөө дээд хэмжээгээр ашиглах үүрэг хүлээлгэж байна. Иргэдийнхээ эдийн засаг, нийгэм, соёлын эрхийг хангах үүднээс төр хангалттай арга хэмжээ авсан эсэхийг нөөц бололцоогоо хэр үр дүнтэй, хүртээмжтэй байдлаар ашигласныг үндэслэн тодорхойлдог. “Боломжит нөөц бололцоо” гэдэг нь тухайн улсын дотоодын нөөц, гадаад эх үүсвэрээс авсан тусламж дэмжлэгийг хамтад нь ойлгоно. Эдийн засаг, нийгэм, соёлын эрхийг хэрэгжүүлэх нөхцөлийг бий болгоход цаг хугацаа, хөрөнгө төсөв шаардлагатай учраас ийм нөхцөлийг аажмаар ахиц гаргах замаар бий болгохыг гэрээнд оролцогч улсуудад зөвшөөрдөг. Гэсэн хэдий боловч иргэдийнхээ эдийн засаг, нийгэм, соёлын эрхээ эдлэх нөхцөлийг гэрээнд оролцогч улс аль болох шуурхай бий болгох ёстой.

Эдийн засаг, нийгэм, соёлын эрхээс ялгаатай нь иргэний болон улс төрийн эрхүүдийг аажмаар ахиц гаргах замаар хэрэгжүүлэх боломжгүй бөгөөд эдгээр эрхүүдийг хангах, хамгаалах, хөхиүлэн дэмжих үүрэг олон улсын эрх зүйн дагуу гэрээг хүлээн зөвшөөрсөн улс орнуудад нэн даруй үүсдэг. Өөрөөр хэлбэл, Хөгжлийн бэрхшээлтэй хүмүүсийн эрхийн тухай конвенцоор баталгаажуулсан иргэний болон улс төрийн эрх, эрх чөлөөг аливаа улсын хувьд гэрээ хүчин төгөлдөр болмогц тухайн улс ямар ч тайлбаргүйгээр, нэн даруй хэрэгжүүлэх үүрэгтэй юм.

Конвенцийг хүлээн зөвшөөрсөн улсууд хөгжлийн бэрхшээлтэй хүмүүсийн талаар аливаа шийдвэр гаргахдаа тэдний төлөөллийг оролцуулах ёстой. Конвенцийн 4 дүгээр зүйлийн 4.3-т “Энэхүү Конвенцийг хэрэгжүүлэх чиглэгдсэн хууль тогтоомж, бодлого хөтөлбөрийг бий болгох, сайжруулах явцад болон хөгжлийн бэрхшээлтэй хүмүүстэй холбоотой бусад шийдвэрийг гаргахдаа Оролцогч улсууд хөгжлийн бэрхшээлтэй хүүхдүүд, тэднийг төлөөлөх байгууллагыг оролцуулан хөгжлийн бэрхшээлтэй хүмүүстэй сайтар зөвшилцож, оролцоог хангана.” гэж заасан. Түүнчлэн, хөгжлийн бэрхшээлтэй хүмүүстэй холбоотой шийдвэр гаргах төдийгүй конвенцийн хэрэгжилтийг хянах хороо байгуулах, конвенцийн хэрэгжилтийн тухай Засгийн газрын илтгэл тайлан боловсруулахад ч хөгжлийн бэрхшээлтэй хүмүүсийг оролцоог хангах тухай заалт Конвенцид бий.

Конвенцоор баталгаажуулсан эрхүүдийн тухайд гэрээг хүлээн зөвшөөрсөн улс орнууд тэдгээрийг хүндэтгэн сахих, хамгаалах, хангах үндсэн гурван үүрэг хүлээж байна.

☺ Хүндэтгэн сахих гэдэг нь гэрээг хүлээн зөвшөөрсөн улсын зүгээс иргэдээ гэрээгээр баталгаажуулсан эрхийг эдлэхэд нь хөндлөнгөөс оролцохгүй, зөрчихгүй байхыг хэлнэ. Тухайлбал, хөгжлийн бэрхшээлтэй хүний зөвшөөрөлгүйгээр биед нь эмнэлгийн туршилт хийхгүй байх, хөгжлийн бэрхшээлийнх нь улмаас хэн нэгний сургуульд сурах боломжийг хязгаарласан хууль тогтоомж гаргахгүй байх зэргээр төр гэрээгээр баталгаажуулсан эрхийг зөрчихгүй байх ёстой.

☺ Хамгаалах гэдэг нь оролцогч улс аливаа гуравдагч этгээд гэрээгээр баталгаажуулсан эрх, эрх чөлөөг зөрчихөөс төр хамгаалах үүрэгтэй болохыг ойлгоно. Тухайлбал, конвенцоор баталгаажуулсан эрхийг зөрчсөн этгээдэд оногдуулах хариуцлагыг хуульчлах, гэм буруутай этгээдэд хариуцлага хүлээлгэх замаар төр хүний эрх, эрх чөлөөг хамгаалах үүргээ хэрэгжүүлдэг. Мөн Засгийн газар хөгжлийн бэрхшээлтэй хүний хөдөлмөрлөх эрхийг хангах үүднээс тэдний ажлыг байрыг тохирох хэрэглэгдэхүүнээр тоноглох шаардлагыг ажил олгогчид тавих нь конвенцоор хүлээсэн хөдөлмөрлөх эрхийг хамгаалах үүргээ хэрэгжүүлж буй хэрэг юм.

☺ Хангах гэдэг нь гэрээг хүлээн зөвшөөрсөн улс хууль тогтоох, захиргааны, төсвийн, шүүхийн болон бусад арга замаар тэдгээр эрхийг хэрэгжүүлэх нөхцөл бололцоог бий болгохыг хэлнэ. Тухайлбал, хөгжлийн бэрхшээлтэй хүнд хүртээмжтэй сургууль, эмнэлэг байгуулах, мэдээллийг дохионы хэл, брайль үсгээр дамжуулан түгээх, төрийн албан хаагчдад дохионы хэл сургах зэргээр хөгжлийн бэрхшээлтэй хүний эрхээ эдлэх боломж нөхцөлийг бүрдүүлэх нь энэ үүргээ биелүүлж буй хэрэг юм.

Хүний эрхийн гэрээний дагуу олон улсын эрх зүйн субъектүүд дээр дурдсан үндсэн гурван үүргээс гадна хүний эрх, эрх чөлөөг хөхиүлэн дэмжих үүрэг хүлээдэг. Хөхиүлэн дэмжих гэдэг нь хүний эрх, эрх чөлөөний талаарх мэдлэг, ойлголтыг түгээн дэлгэрүүлэх, иргэдийнхээ мэдлэгийг нэмэгдүүлэхийг хэлэх бөгөөд гэрээгээр баталгаажуулсан эрхийг олон нийтэд таниулах, ойлгуулах нь төрийн бас нэгэн үүрэг болно.

Конвенцид заасан тодорхой эрхийн талаар гэрээнд оролцогч улсын хүлээх үүргийг жишээгээр тайлбарлая.

ТӨРИЙН ҮҮРГИЙГ ҮЙЛДЭЛД ХӨРВҮҮЛЭХҮЙ

Эрүү шүүлтээс ангид байх эрх

✎ Хүндэтгэн сахих - Төрийн мэдлийн хорих анги, цагдан хорих төвүүдэд хөгжлийн бэрхшээлтэй хүнийг эрүүдэн шүүхгүй байх.

✎ Хамгаалах - Хувийн хэвшлийн сэтгэцийн эмнэлэг, асрамжийн газрууд, бусад байгууллагууд хөгжлийн бэрхшээлтэй хүнийг эрүүдэн шүүхээс хамгаалах.

✎ Хангах - Төр хорих байгууллагын ажилтнууд, эмч нарыг сургалтад хамруулах, мэдээллээр хангах, ангийн барилга, байгууламж, байрны материаллаг орчин нөхцөлийг хүний наад захын хэрэгцээ, шаардлагад нийцүүлэх замаар хөгжлийн бэрхшээлтэй хүн эрүү шүүлтээс ангид байх эрх нөхцөлийг бий болгох.

Үзэл бодлоо илэрхийлэх эрх чөлөө

✎ Хүндэтгэн сахих – Хөгжлийн бэрхшээлтэй хүн бүх төрлийн мэдээллийг хүлээн авах, мэдээллийн үндсэн дээр үзэл бодлоо чөлөөтэй илэрхийлэхэд нь саад учруулахгүй байх

✎ Хамгаалах - Хувийн хэвшлийн байгууллагууд, аливаа гуравдагч этгээд хөгжлийн бэрхшээлтэй хүнийг үзэл бодлоо чөлөөтэй илэрхийлэхэд нь саад учруулахаас хамгаалах.

✎ Хангах – Дохионы хэл, брайль үсэг, өөр бусад харилцааны тохиромжтой хэрэглэгдэхүүнийг ашиглах явдлыг дэмжих замаар хөгжлийн бэрхшээлтэй хүн үзэл бодлоо чөлөөтэй илэрхийлэх боломжийг бүрдүүлэх

Сурч боловсрох эрх

✎ Хүндэтгэн сахих - Төрийн өмчийн сургуулийн удирдлагууд сурагчийг хөгжлийн бэрхшээлийнх нь улмаас алагчлахгүй, сургахаас татгалзахгүй байх

🕒 Хамгаалах - Хувийн хэвшлийн боловсролын байгууллагууд хөгжлийн бэрхшээлтэй сурагчийг ялгаварлан гадуурхаж, эрхийг нь зөрчихөөс хамгаалах.

🕒 Хангах - Хөгжлийн бэрхшээлтэй сурагчдыг тэгш хамран сургаж чадах сургуулиудыг байгуулах, зохистой сургалтын хөтөлбөр, чадварлаг багшаар хангах зэргээр тэдэнд сурч боловсрох эрхээ эдлэх нөхцөлийг бий болгох

Хөдөлмөрлөх эрх

🕒 Хүндэтгэн сахиx - Төр хөгжлийн бэрхшээлтэй хүмүүсийн хөдөлмөрлөхтэй холбоотой бүхий л эрх, түүний дотор үйлдвэрчний эвлэл байгуулж, эрх ашгаа хамгаалахыг хориглохгүй байх

🕒 Хамгаалах - Хувийн хэвшлийн байгууллагууд, ажил олгогчид хөгжлийн бэрхшээлтэй хүний ажил амралтын цагийг үндэслэлгүйгээр хязгаарлах, цалин хөлсийг олгохгүй байх, эвлэлдэн нэгдэж, хөдөлмөрлөх эрхээ хамгаалахад нь саад учруулах зэргээр хөдөлмөрлөх эрхийг нь зөрчихгүй байх нөхцөлийг бий болгох.

🕒 Хангах - Хөгжлийн бэрхшээлтэй ажилтнуудыг сургах, давтан сургах, мэргэшүүлэх, тэдэнд хүртээмжтэй ажлын байр бий болгох замаар хөдөлмөрлөх эрхээ эдлэх нөхцөлийг бий болгох

2.2 Конвенцоор баталгаажуулсан хүний эрх, эрх чөлөө

Хөгжлийн бэрхшээлтэй хүмүүсийн эрхийн тухай конвенци ямар нэг шинэ эрх, эрх чөлөөний төрлийг бий болгож, баталгаажуулаагүй бөгөөд НҮБ-ын өмнөх гэрээ, конвенцийн заалтыг хөгжлийн бэрхшээлтэй хүний онцлогт нийцүүлэн олон улсын эрх зүйн үүднээс системчилж, нэг мөр болгосон болохыг өмнө нь өгүүлсэн. Гэхдээ хүртээмж, хувийн нэгдмэл байдлыг хамгаалах, оршин суугаа орчиндоо бие даан амьдрах, хувийн хөдөлгөөн, сэргээлт, нөхөн сэргээлт зэрэг хөгжлийн бэрхшээлтэй хүн эрх, эрх чөлөөгөө эдлэхэд зайлшгүй хангагдах ёстой нөхцөлүүдийг шинээр томъёолж, эдгээр нөхцөлийг бүрдүүлэхэд гэрээнд оролцогч улсаас авах арга хэмжээг тодорхойлжээ.

ХҮНИЙ ЭРХИЙН СУУРЬ ГЭРЭЭНИЙ ЗААЛТЫГ ХӨГЖЛИЙН БЭРХШЭЭЛТЭЙ ХҮМҮҮСИЙН ОНЦЛОГИЙГ ТУСГАН ДЭЛГЭРҮҮЛСЭН:

🕒 Иргэний болон улс төрийн эрх тухай олон улсын пактын 16 дугаар зүйл

Хүн бүр хаана ч байсан эрх зүйн этгээд байх эрхээ хүлээн зөвшөөрүүлэх эрхтэй.

🔗 Хөгжлийн бэрхшээлтэй хүмүүсийн эрхийн тухай конвенцийн 12 дугаар зүйл

1. Оролцогч улсууд нь хөгжлийн бэрхшээлтэй хүмүүс нь бусад хүний нэгэн адил хуулийн өмнө адил тэгш байх эрхтэйг дахин нотолж байна.

2. Оролцогч улсууд нь хөгжлийн бэрхшээлтэй хүмүүс нь амьдралын бүхий л хүрээнд бусадтай адил тэгш байх үндсэн дээр эрх зүйн чадамжтай байх явдлыг хүлээн зөвшөөрнө.

3. Оролцогч улсууд нь хөгжлийн бэрхшээлтэй хүмүүс эрх зүйн чадамжа хэрэгжүүлэх нь шаардагдах дэмжлэг туслалцааг хүртээмжтэй байлгах үүднээс арга хэмжээ авна.

4. Оролцогч улсууд нь эрх нь зөрчигдөхөөс урьдчилан сэргийлэх үр нөлөөтэй, зохистой хамгаалалтыг бий болгохуйц эрх зүйн чадамжаа хэрэгжүүлэхтэй холбогдсон бүх арга хэмжээг олон улсын хүний эрхийн хэм хэмжээний дагуу авна. Эрх зүйн чадамжийг хэрэгжүүлэхтэй холбогдсон ийм хамгаалалт нь туайн хүний сонголт, хүсэл зоригт нийцсэн, эрхийг хүндэтгэсэн, сонирхлын зөрчилгүй, сөрөг нөлөөгүй, хувийн нөхцөл байдалд нь тохирсон, байж болох хамгийн богино хугацаанд байх бөгөөд бүрэн эрхт, хараат бус, бие даасан байгууллага, эсхүл шүүхийн зохих шатны байгууллага түүнийг тогтмол хянаж байна.

5. Энэ зүйлийн заалтуудын дагуу оролцогч улсууд нь хөгжлийн бэрхшээлтэй хүмүүсийн эд хөрөнгө эзэмших, түүнийг өвлөх, санхүүгийн үйл ажиллагаа эрхлэх болон банкны зээд, үл хөдлөх хөрөнгийн барьцаат зээл болон бусад төрлийн санхүүгийн үйлчилгээг тэгш хүртэх эрхийг баталгаажуулах зорилгоор шаардлагатай, үр дүнтэй арга хэмжээг авах бөгөөд хөгжлийн бэрхшээлтэй хүний эд хөрөнгийг үндэслэлгүйгээр хураахгүй байх явдлыг баталгаажуулна.

Хөгжлийн бэрхшээлтэй хүмүүсийн эрхийн тухай конвенцоор баталгаажуулсан хүний эрх, эрх чөлөөний агуулгыг тайлбарлах, ойлгохдоо хүний эрхийн бусад гэрээний агуулга, зарчимд шүтэлцээтэй байдлаар авч үзэх ёстой юм. Түүнчлэн, конвенцоор зөвхөн хөгжлийн бэрхшээлээс үүдэлтэй ялгаварлан гадуурхалтыг хориглоогүй бөгөөд хүнийг нас, хүйсийнх нь улмаас алагчлах асуудлыг ч мөн тусгасан юм. Энэ нь тус Конвенцийн 6, 7 дугаар зүйлүүдийн хөгжлийн бэрхшээлтэй эмэгтэйчүүд, хүүхдүүдийн талаарх заалтаас харагдаж байна.

Конвенцид хөгжлийн бэрхшээлтэй хүмүүсийн бусадтай адил тэгш эрхийн үндсэн дээр эдлэх дараах эрхийг баталгаажуулсан байна. Үүнд:

😊 Амьд явах эрх (10 дугаар зүйл)

Хүний эрхийн эхлэх цэг, тулгуур сурвалж нь амьд явах эрх юм. (Г.Совд, Монгол Улсын Үндсэн хууль, хүний эрх, 1999 он, 42 дахь тал) Хөгжлийн бэрхшээлтэй хүмүүсийн эрхийн тухай Конвенцид тэдгээр хүмүүс амьд явах эрхээ бусадтай адил тэгш эдлэх ёстойг баталгаажуулсан.

Амьд явах эрхийг хуулиар баталгаажуулах бөгөөд нийтийг хамарсан онц байдал тогтоогдсон үед ч энэ эрхийг хязгаарлаж, хэн нэгний амь насыг дур мэдэн бусниулж болохгүй. Хүний эрхийн онолын хүрээнд амьд явах эрхтэй холбоотой маргаантай асуудлууд цөөнгүй бий. Тухайлбал, амьд явах эрх хэдийнээс үүсдэг хийгээд хараахан мэндэлж амжаагүй хүүхдийн амьд явах эрхийг хүний эрхийн гэрээ, конвенцоор баталгаажуулсан эсэх нь энэ эрхтэй холбоотой нэг мөр шийдвэрлэгдээгүй асуудал юм. Төрөлхийн хөгжлийн бэрхшээлтэй ургийг хөндөх тохиолдол эмнэлгийн үйл ажиллагаанд түгээмэл гардаг учраас Хөгжлийн бэрхшээлтэй хүмүүсийн эрхийн тухай конвенцийн эх бичвэрийг боловсруулах явцад амьд явах эрхийг хэдий үеэс баталгаажуулах эсэх асуудлыг анхааралтай хэлэлцсэн. Хэдийгээр зарим улсын дотоодын хууль тогтоомжоор төрөөгүй хүүхдийн өв залгамжлах зэрэг эрхийг хүлээн зөвшөөрч, баталгаажуулсан байдаг боловч хүний эрхийн гэрээ, Конвенцид энэ асуудал тодорхой тусгагдаагүй. Харин НҮБ-ын Хүний эрхийн хороо, бүс нутгийн хүний эрхийн шүүхээс Иргэний болон улс төрийн эрхийн тухай олон улсын пактын “Хүн бүр амьд явах эрхтэй. Хэний ч амь насыг дур мэдэн бусниулж болохгүй.” гэсэн заалтын агуулгыг холбож, “хэний ч амь насыг...” гэж томъёолсон нь ургийг биш, тодорхой бие хүнийг хэлж байна гэж тайлбарласан байдаг. Амьд явах эрхтэй холбоотой дараагийн маргаантай асуудал нь цаазаар авах ял юм. Дэлхий нийтийн практикт цаазаар авах ялаас аль болох татгалзах, улмаар түүнийг халах чиг хандлага зонхилж байгаа бөгөөд цаазаар авах ялыг хэрэглэдэг улс орнуудын тоонд Монгол улс багтдаг. Цаазаар авах ялыг тухайн үед үйлчилж байгаа эрүүгийн хууль тогтоомжийн дагуу онц хүнд гэмт хэрэг үйлдсэн хүмүүст төрийн нэрийн өмнөөс шүүхийн хүчин төгөлдөр тогтоолоор оногдуулдаг. Төрөөс хүний амьд явах эрхийг урьдчилан төлөвлөж, санаатайгаар зөрчихөд хүргэдэг, шүүхээс алдаатай шийдвэр гаргасан тохиолдолд түүнийг залруулах боломжгүй төдийгүй гэм буруутай этгээдийг хүмүүжүүлэх, дахин гэмт хэрэг үйлдэхээс нь урьдчилан сэргийлэх ялын зорилгод нийцдэггүй тул цаазаар авах ялыг хүний эрхийг хамгаалагчид эсэргүүцдэг юм.

☺ Хуулийн өмнө тэгш байх эрх (12 дугаар зүйл)

Англи хэл дээр the right to equal recognition as a person before the law буюу утгачилбал, эрх зүйн этгээд байх эрхийг конвенцийн орчуулгад хуулийн өмнө тэгш байх эрх гэж буулгажээ. Эрх зүйн этгээд байна гэдэг нь хүн бүр эрхээ хэрэгжүүлэх, гэрээ байгуулах, гэрээнээс үүдэн гарах үүрэг хүлээхдээ ижил чадамжтай байхыг хэлнэ. Өөрөөр хэлбэл, уг эрх нь аливаа хүний эрх зүйн харилцааны объект биш, субъект болох шинжийг нь баталгаажуулдаг. Хүний эрх зүйн байдлын батламж нь иргэний бичиг баримт юм. Эрх зүйн этгээд байх эрхийг тухайн хүний насны буюу сэтгэцийн байдлаас нь хамаарч хязгаарлаж болдог. Конвенцид хөгжлийн бэрхшээлтэй хүмүүсийн эрх зүйн этгээд байх эрхийг хүлээн зөвшөөрч, баталгаажуулсан бөгөөд төр энэ эрхээ эдлэхэд нь шаардлагатай тусламж, дэмжлэгийг хүртээмжтэй хэлбэр, арга замаар үзүүлэх үүрэгтэй. Өөрөөр хэлбэл, хөгжлийн бэрхшээлтэй хүмүүс тэр бүр бие даан гүйцэтгэж чаддаггүй эд хөрөнгө эзэмших, өв залгамжлах, зээл авах, үл хөдлөх эд хөрөнгийг барьцаалах зэрэг эдийн засгийн зарим харилцаанд бусадтай адил тэгш оролцох боломж бүрдүүлэх нь төрийн үүрэг болно.

☺ Шүүх ажиллагаанд хүртээмжтэй оролцох эрх (13 дугаар зүйл)

НҮБ-ын хүний эрхийн үндсэн гэрээ, конвенцуудад хэргээ шударгаар шүүлгэх эрхийг баталгаажуулсан байдаг. Хэргээ шударгаар шүүлгэх эрх нь бусад эрх, эрх чөлөөний баталгаа юм. Гэсэн хэдий боловч шүүхийн барилга байгууламж, шүүх ажиллагаа бүхэлдээ хөгжлийн бэрхшээлтэй хүмүүст хүртээмжтэй байдаггүйгээс тэдний ихэнх нь зөрчигдсөн эрх, эрх чөлөөгөө хамгаалж, бусдын хууль бусаар учруулсан хохирлыг нөхөн төлүүлэх боломжгүй байдаг. Ийм учраас хөгжлийн бэрхшээлтэй хүмүүс өөртэй нь холбогдох эрүү, иргэн, захиргааны хэргийг шүүх аль ч шатны шүүх ажиллагаанд биеэр оролцох, шүүх ажиллагаанд холбогдох тогтоол, шийдвэр, бусад баримт бичигтэй танилцах, тэдгээрийг хүндрэл, бэрхшээлгүй ойлгох нөхцөлийг бий болгох нь тэдний хэргээ шударгаар шүүлгэх эрхийг хангахад чухал ач холбогдолтой юм. Гэхдээ НҮБ-ын хүний эрхийн бусад гэрээнээс ялгаатай нь хэргээ шударгаар шүүлгэх эрх хангагдах гол нөхцөл болох шүүх ажиллагааны хүртээмжтэй байдлыг Хөгжлийн бэрхшээлтэй хүмүүсийн эрхийн тухай конвенцид чухалчлан үзэж, тухайлан заажээ. Энэ нь дээр дурдсан нөхцөл байдалтай холбоотой юм. Төр бүх шатны шүүх ажиллагааны явцад хөгжлийн бэрхшээлтэй хүн гэрч, хохирогч, хариуцагчийн алинаар нь ч оролцсон түүнд тохирох хэрэглэгдэхүүнийг ашиглах замаар шүүх ажиллагааг хүртээмжтэй явуулах үүрэгтэй. Үүний зэрэгцээ шүүх ажиллагаанд оролцох эрх бүхий төрийн албан хаагчдад хөгжлийн бэрхшээлтэй хүмүүстэй харилцах дадал чадвар эзэмшүүлэх, сургахыг *конвенци* чухалчилжээ.

Эрх чөлөө, хувийн халдашгүй эрх (14 дүгээр зүйл)

Хүний эрхийн онолын ном зохиолуудад эрх чөлөө, халдашгүй байх эрхийг ардчилсан нийгэм дэх хүний эрх чөлөөний тулгын чулуу гэж нэрлэсэн байх нь олонтаа. Энэ эрх эрх чөлөөтэй байх (right to liberty), болон халдашгүй байх (right to security) гэсэн үндсэн хоёр агуулгатай. Сонгодог утгаараа эрх чөлөөтэй байх гэдэг нь хувь хүн бие махбодийн хувьд эрх чөлөөтэй байж, энэ эрх чөлөөнд нь хэн нэгэн дур мэдэн халдахгүй байхыг хэлж байна. Харин халдашгүй байх гэдэг нь (right to security буюу үгчилбэл Англи хэл дээр хамгаалагдах эрх гэсэн агуулгатай энэхүү томъёоллыг Монгол хэлнээ халдашгүй байх гэж орчуулж заншжээ.) хувь хүний эрх чөлөө хуулиар хамгаалагдсан байхыг ойлгоно. Монгол Улсын Үндсэн хуулийн 16 дугаар зүйлийн 13-т иргэн “халдашгүй, чөлөөтэй байх эрхтэй. Хуульд заасан үндэслэл, журмаас гадуур дур мэдэн хэнийг ч нэгжих, баривчлах, хорих, мөрдөн мөшгих, эрх чөлөөг нь хязгаарлахыг хориглоно. Хэнд боловч эрүү шүүлт тулгаж, хүнлэг бус, хэрцгий хандаж, нэр төрийг нь доромжилж болохгүй. Баривчилсан шалтгаан, үндэслэлийг баривчлагдсан хүн, түүний гэр бүлийнхэн, өмгөөлөгчид нь хуульд заасан хугацаанд мэдэгдэнэ. Иргэний хувийн ба гэр бүл, захидал харилцааны нууц, орон байрны халдашгүй байдлыг хуулиар хамгаална” гэж заасан. Халдашгүй дархан байх эрх хангагдахын тулд хүний нэр төр, алдар хүнд, бие сэтгэл, эд хөрөнгө болон гэр бүлийн нууц, захидал харилцаа, орон байрны халдашгүй байдал хангагдсан байх ёстой нь Үндсэн хуулийн дээрх заалтаас харагдаж байна. Халдашгүй эрхийг нийтийн дэг журам, аюулгүй байдал, бусад хүний эрхийг хамгаалах зорилгоор хуулиар эрх олгосон этгээд, хуулиар тогтоосон журмын дагуу хязгаарлаж болдог. Гэхдээ энэ эрхэд гэмт хэрэг үйлдсэн, зөрчил гаргасан нь хангалттай нотлогдсон, албадан эмчилгээ хийлгэх шаардлагатай нь шүүхийн шийдвэр, эрх бүхий эмнэлгийн байгууллагын дүгнэлтээр нотлогдсон, хууль бусаар улсын хил зөрчсөнөөс бусад тохиолдолд халдаж болохгүй. Шүүгч, прокурор, хэрэг бүртгэгч, мөрдөн байцаагч, эмч, хилийн албаны эрх бүхий ажилтан зэрэг хуулиар эрх олгогдсон субъектүүд хүний

эрх чөлөөнд халдахдаа хуульд заасан журмыг чанд мөрдөх үүрэгтэй. Нэгжих, баривчлах, албадан саатуулах, урьдчилан хорих, баривчлах шийтгэл оногдуулах, хорих, албадан эмчилгээ хийх зэрэг нь хүний халдашгүй эрхийг хөндөж буй үйлдэл бөгөөд эдгээр үйлдлүүдийг хуулиар зохицуулсан байдаг. Хөгжлийн бэрхшээлтэй хүний эрх чөлөөнд хууль бусаар халдахгүй байх баталгаа бүрдүүлэхийг Конвенцид оролцогч улс орнуудад үүрэг болгожээ.

☺ Эрүү шүүлт, хэрцгий, хүнлэг бус, нэр төрийг доромжлон харьцах, шийтгэхээс ангид байх эрх (15 дугаар зүйл)

Эрүү шүүлтийг хориглох нь ардчилсан нийгмийн үнэт зүйлсийн нэг билээ. Эрүүдэн шүүх явдал нь дэлхийн аль ч улс оронд хамгийн түгээмэл гардаг, хүний эрхийн ноцтой зөрчил байсан тул 1984 онд НҮБ-аас Эрүүдэн шүүх болон бусад хэлбэрээр хэрцгий хүнлэг бусаар буюу хүний нэр төрийг доромжлон харьцаж, шийтгэхийн эсрэг конвенцийг батлан гаргасан юм. Уг конвенцид төрийн албан тушаалтан, түүний ил далд зөвшөөрлөөр мэдүүлэг авах, хилс хэрэгт шийтгэх, айлган сүрдүүлэх, шахалт үзүүлэх зорилгоор хүний бие махбодь, сэтгэл санааг хүчтэй шаналган зовоох аливаа санаатай үйлдлийг эрүү шүүлт гэж тодорхойлсон байдаг. Олон улсын түгээмэл болон бүс нутгийн хүний эрхийн гэрээ, конвенцид эрүү шүүлт, хэрцгий, хүнлэг бус, нэр төрийг доромжилсон харьцаа, хэрцгий, хүнлэг бус, нэр төрийг доромжилсон шийтгэл гэсэн долоон төрлийн үйлдлийг тодорхойлж, хориглосон байдаг. Эдгээр үйлдлийн алийг ч нийтийг хамарсан онц байдал зарласан болон аливаа тохиолдолд, алан хядлага, төрлөөр устгах, хүмүүнлэгийн, дайны гэмт хэрэг үйлдсэн этгээдэд ч гаргахыг олон улсын гэрээ, конвенциор хориглосон. Өөрөөр, хэлбэл эрүү шүүлтээс ангид байх эрх ямар нэг хязгаарлалтгүй, “туйлын эрх” юм. Конвенцийн 15 дугаар зүйлд хөгжлийн бэрхшээлтэй хүмүүсийн хувьд баталгаажуулахыг конвенци зорьжээ. Хөгжлийн бэрхшээлтэй хүмүүст тохиолддог хамгийн түгээмэл хэрцгий, хүнлэг бус харьцаа бол тэдний сайн дураараа өгсөн зөвшөөрөлгүйгээр эмнэлгийн буюу шинжлэх ухааны туршилтад оруулах явдал байдаг. Тиймээс Конвенцид ийм төрлийн хэрцгий, хүнлэг бус үйлдлийг тусгайлан авч үзсэн байна.

☺ Аливаа хэлбэрийн мөлжлөг, хүчирхийлэл, доромжлолоос ангид байх эрх чөлөө (16 дугаар зүйл)

Мөлжлөг, хүчирхийлэл, доромжлол нь хүний эрхэм зэргийг үгүйсгэдэг, эрх чөлөө, халдашгүй байдал, нэр төрд бүдүүлгээр халддаг хүний эрхийн ноцтой зөрчил мөн. Хэн нэгний бүрэн хараат байдалд хөдөлмөр эрхэлж, ашиг орлого олдог боловч хөдөлмөрийнх нь үр шим тухайн хүнд хүртээлгүй нөхцөл байдлыг мөлжлөг гэх бол хэн нэгний давуу хүч чадалд автаж, бие махбодь, сэтгэл санаа, бэлгийн хувьд өөрөө хүсээгүй байдалд орсон, энэ байдлынхаа үндсэн дээр зовж шаналсан байхыг хүчирхийлэл гэнэ. Хүнийг ямар нэг шинж байдлаар нь дорд үзэж, нэр төрийг нь гутаах нь доромжлол юм. Мөлжлөг, хүчирхийлэл, доромжлол нь ихэнх тохиолдолд хамтдаа үйлдэгддэг. Тухайлбал, хүн худалдаалах гэмт хэргийн хохирогч бараа таваарын үүрэг гүйцэтгэж, ашиг орлого олж байгаагаар мөлжлөгт өртөж, өөрийнхөө хүсээгүй үйлдлийг хүчинд автаж хийх болдгоороо хүчирхийлэлд орж, гэмт этгээдүүд хохирогчийн “хүн” хэмээх эрхэм чанарыг үгүйсгэн харьцаж байгаа нь доромжлол болдог. Хөгжлийн бэрхшээлтэй хүмүүсийн эрхийн тухай конвенцид мөлжлөг, хүчирхийлэл, доромжлолын бүх хэлбэрийг хориглож, энэ талаар хууль тогтоох, мэдээлэн

таниулах, дэмжлэг үзүүлэх, мөлжлөг, хүчилхийлэл, доромжлолоос урьдчилан сэргийлэх үүднээс асрамжийн газрууд, нөхөн сэргээх төв, тусгай эмнэлгүүдэд хараат бус байгууллага хяналт тавих боломжийг бий болгох, ийм гэмт хэргийн хохирогч болсон хөгжлийн бэрхшээлтэй хүмүүсийг бие махбодь, танин мэдэхүй, сэтгэлзүйн хувьд сэргээх, нөхөн сэргээх, нийгмийн амьдралд дахин оролцуулах арга хэмжээ авахаар заасан байна. Эдгээр арга хэмжээ нь хөгжлийн бэрхшээлтэй хүмүүсийн нас, хүйсийн онцлог болон хөгжлийн бэрхшээлийн төрөл хэлбэрийг харгалзан үзсэн байх ёстой.

Чөлөөтэй зорчих болон иргэний харъяаллаа чөлөөтэй сонгох эрх чөлөө (18 дугаар зүйл)

Эртний Грекийн сэтгэгч Сократ, Критотой хувь хүний эрх чөлөөний тухай ярилцахдаа хүн нутгаа орхин явах эрхтэй байх нь эрх чөлөөтэй байдлын шинж мөн гэж үздэгээ илэрхийлсэн байдаг. Тэрээр “Бид цаашид Афины иргэдэд олгосон эрх чөлөөний хүрээнд өөрийн эд зүйлс, өмч хөрөнгийг авч, эх нутгаа орхин явах эрхийг баталгаажуулах ёстой. Ямар ч хууль цааз хувь хүний энэ эрхийг хязгаарлаж болохгүй” гэж өгүүлсэн нь эх сурвалжид тэмдэглэгдэн үлджээ¹. Сократын энэ санаа, үзэл баримтлал орчин үеийн олон улсын эрх зүйгээр баталгаажсан байна. Чөлөөтэй зорчих эрх нь улсынхаа нутаг дэвсгэрт чөлөөтэй зорчих, оршин суух газраа чөлөөтэй сонгох, өөрийн орныг оролцуулан аливаа улсыг орхин явах, өөрийн улсдаа буцаж ирэх гэсэн дөрвөн үндсэн агуулгаас бүрддэг. Гэхдээ аливаа улсад хууль ёсоор оршин сууж байгаа хүн бүрийн хувьд энэ эрх хэрэгжих бололцоотой. Мэдээж тухайн улсын иргэд эх орондоо хууль ёсоор оршин сууж байгаа учир чөлөөтэй зөрчих эрхээ баталгаатай эдэлнэ. Харин гадаадын иргэний хувьд тухайн улсын нутаг дэвсгэрт “хууль ёсоор” оршин сууж байгаа эсэхийг дотоодын хууль тогтоомжоороо тодорхойлно. НҮБ-ын Хүний эрхийн хорооны 27 дугаар ерөнхий зөвлөмжид аливаа улсын нутаг дэвсгэрт хуулийн дагуу нэвтэрсэн, эрх зүйн байдал нь тухайн улсын хуулиар тогтоогдсон этгээдийг хууль ёсоор оршин суугч гэнэ гэж тайлбарлажээ. Чөлөөтэй зорчих эрхийг үндэсний аюулгүй байдал, нийгмийн хэв журам, эрүүл мэнд, ёс суртахуун болон бусдын эрх, эрх чөлөөнд хохирол учруулахгүйн тулд хязгаарлаж болдог. Иргэний харъяаллаа чөлөөтэй сонгох эрх чөлөө бол чөлөөтэй зорчих эрх чөлөөний дээд хэлбэр юм. Хүн төрмөгцөө аливаа улсын харъя алалд багтах бөгөөд өөрийн хүсэл сонирхол, хууль тогтоомжид заасан журмын дагуу иргэний харъяаллаа солих, сонгох эрхийг хүний эрхийн талаарх гэрээнүүдэд баталгаажуулсан. Хувь хүний иргэний харъяалал нь аливаа улсын иргэний бүртгэлд бүртгэгдсэнээр баталгааждаг. Хөгжлийн бэрхшээлтэй хүмүүсийн чөлөөтэй зорчих, иргэний харъяаллаа сонгох, ялангуяа хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийн төрмөгцөө улсын бүртгэлд бүртгүүлэх эрхийг конвенцоор баталгаажуулсан байна.

Бие даан амьдрах болон оршин суугаа орчиндоо байх эрх (19 дүгээр зүйл)

Бие эрхтнийхээ согог гэмтлийн улмаас хөгжлийн бэрхшээлтэй хүмүүс хэн нэгний асрамжид буюу тусгай эмнэлэг, сэргээн засах төвүүд, асрамжийн газруудад амьдрах нь элбэг байдаг. Гэхдээ зарим тохиолдолд эдгээр халамж, үйлчилгээ нь тэдний хүсэл зоригоос гадуур, эрхийн нь зөрчсөн

Платоны “Хэлэлцээ” (Dialogues) зохиол.

байх тохиолдол гардаг. Ийм учраас бие даан амьдрах болон оршин суугаа орчиндоо байх асуудлыг Конвенцид тусгайлан авч үзжээ. Бие даан амьдрах гэдэг нь хүсэл зоригоосоо гадуур хэн нэгний оролцоо, тусламжгүйгээр амьдрахыг хэлж байгаа бөгөөд хөгжлийн бэрхшээлтэй хүн бие даан амьдрах эрх хангагдсанаас хувийн нууцаа хүндэтгүүлэх, нийгмийн амьдралд бүрэн дүүрэн оролцох боломжтой болно. Оршин суугаа орчин гэдэг нь тухайн хүний амьдарч дассан орон гэр, гэр бүлийн орчныг хэлж байгаа бөгөөд хөгжлийн бэрхшээлтэй хүний зөвшөөрөл, хүсэл зоригоор гадуур түүнийг оршин сууж дассан орчин нөхцөлөөс нь хөндийрүүлэх, тусгаарлах нь хүний эрхийн зөрчил болно.

☺ Үзэл бодол, итгэл үнэмшлээ илэрхийлэх, мэдээлэл хүртэх эрх чөлөө (21 дүгээр зүйл)

Үзэл бодол, итгэл үнэмшлээ илэрхийлэх, мэдээлэл хүртэх эрх чөлөө нь харилцан нягт шүтэлцээтэй бүлэг эрхийн нэг хэсэг юм. Хувь хүн зөвхөн үзэл бодол, итгэл үнэмшлээ илэрхийлээд зогсохгүй, мэдээлэл хайх, хүлээн авах, түгээх эрхтэй. Тиймээс хувь хүний үзэл бодлоо илэрхийлэх эрх чөлөө зөрчигдсөн тохиолдолд бусад хүмүүсийн мэдээлэл хүлээн авах эрх зөрчигдөхөд хүрдэг. Хувь хүн үзэл бодлоо тайван жагсаал цуглаан зохион байгуулах, үг хэлэх, хэвлэн нийтлэх болон өөрийн сонгосон бусад арга замаар илэрхийлж болно. Тухайлбал, 2003 онд Монгол Улсын иргэн Э Туулын голын ус бохирдож байгааг эсэргүүцэж, Төв бассейнд бүтэн өдрийн турш сэлсэн нь үзэл бодлоо илэрхийлэх өвөрмөц арга байсан юм. Үзэл бодлоо илэрхийлэх, мэдээлэх хүлээн авах эрх чөлөөг улсын буюу нийгмийн аюулгүй байдал, нийгмийн хэв журам, хүн амын эрүүл мэнд, амгалан тайван байдал, бусдын эрх чөлөөг хамгаалах ашиг сонирхлын үүднээс зөвхөн хуульд заасан журмаар хязгаарладаг. Конвенцид хөгжлийн бэрхшээлтэй хүмүүс өөрсдийн сонгосон харилцааны хэрэглүүрээр дамжуулан үзэл бодлоо илэрхийлэх, мэдээлэл хүлээн авах нөхцөл бүрдүүлэхийг улс орнуудад үүрэг болгожээ. Харилцааны хэрэглүүр гэдэг нь мөн конвенцийн 2 дугаар зүйлд зааснаар хэл яриа, эх бичвэрийн үзүүлэн, брайль болон тактил хэл, том үсгээр хэвлэгдсэн хэвлэмэл материал, аудио тоног төхөөрөмж, ярьдаг ном зэрэг хялбар ойлгогдох мультимедиа төхөөрөмж мэдээлэл харилцааны бусад технологийг хэлж байна. Дээрх арга замаар түгээж буй мэдээ, мэдээлэл ямар нэг нэмэлт өртөггүйн дээр цаг хугацааны хувьд хоцрогдоогүй, шинэлэг байх ёстой. Түүнчлэн, конвенцид интернэт, мэдээллийн технологийг хөгжлийн бэрхшээлтэй хүмүүст хүртээмжтэй болгох явдлыг чухалчилж, ийм нөхцөл бүрдүүлэхийг улс орнуудад үүрэг болгосон байна.

☺ Хувийн нууцаа хүндэтгүүлэх эрх (22 дугаар зүйл)

Орон байр, захидал харилцаа, хувийн байдал (хөрөнгө чинээ, эрүүл мэнд, албан тушаал гэх мэт.) зэрэг нь аливаа хүний хувийн асуудал бөгөөд эдгээр хувийн зүйлсийг нууцад хамруулж, олон улсын эрх зүй, үндэсний хууль тогтоомжоор хамгаалсан. Конвенцид хөгжлийн бэрхшээлтэй хүмүүс хаана амьдарч байгаагаасаа үл шалтгаалан хувийн нууцаа хамгаалуулах эрхтэй гэж заасан. Энэ нь тэдгээр хүмүүс өвчин эмгэгийнхээ улмаас эмнэлэг, нөхөн сэргээх эмчилгээний төвүүд, асрамжийн газруудад удаан хугацаагаар, бусдын асрамжид амьдрах явцдаа хувийн амьдралын халдашгүй байдал нь хөндөгдөх, нийтэд дэлгэхийг хүсээгүй нууц нь задрах тохиолдол түгээмэл гардагтай холбоотой. Түүнчлэн, эрүүл мэндийн байдал, нөхөн сэргээлтийн талаарх мэдээллийн нууцлал

алдагдсанаас хөгжлийн бэрхшээлтэй хүмүүсийн эрх, эрх чөлөө зөрчигдөхөд хүрдэг тул эрүүл мэнд, нөхөн сэргээлттэй холбоотой мэдээллийг нууцлах асуудлыг Конвенцид тухайлан заажээ.

☺ Орон гэр, гэр бүлээ хүндэтгүүлэх эрх (23 дугаар зүйл)

Хүний эрхийн гэрээ, конвенцид нийгмийн үндсэн нэгж болох гэр бүл төрийн хамгаалалтад байх, гэрлэлт тэгш эрх, сайн дурын харилцаанд үндэслэх тухай заасан. Монгол Улсын Гэр бүлийн тухай хуульд “гэрлэлт” гэж хуулиар тогтоосон насанд хүрсэн эрэгтэй, эмэгтэй хоёр, сайн дурын, чөлөөтэй, тэгш эрхийн үндсэн дээр гэр бүл болох зорилгоор хуульд заасны дагуу төрийн эрх бүхий байгууллагад бүртгүүлэхийг, “гэр бүл” гэж гэрлэлтийн үр дүнд буй болсон, эд хөрөнгийн бус амины болон эд хөрөнгийн эрх, үүргээр холбогдсон хамтын амьдрал бүхий гэр бүлийн гишүүдийг, “гэрлэгчид” гэж гэрлэлтээр холбогдсон харилцан тэгш эрх эдэлж, адил үүрэг хүлээх нөхөр, эхнэрийг хэлнэ гэж тус тус тодорхойлсон. Гэрлэлт нь үр хүүхэд төрүүлэх, өсгөх, тэжээн тэтгэх зэрэг нийгмийн бусад харилцаа үүсэх эхлэл цэг болно. Гэрлэлт, гэрлэлтээс үүссэн бусад харилцаанд хөгжлийн бэрхшээлтэй хүмүүс ялгаварлан гадуурхалтад өртөх тохиолдол түгээмэл гардаг. Иймээс хөгжлийн бэрхшээлтэй хүмүүс гэр бүл болох эрхээ бусдын нэгэн адил эдлэх явдлыг конвенцоор баталгаажуулсан. Хөгжлийн бэрхшээлтэй хүмүүсийн хувьд анхаарах асуудал бол үр удмаа үлдээх, ялангуяа тэднийг албадан үргүй болгох явдал байдаг. Конвенцид хөгжлийн бэрхшээлтэй хүүхэд болон насанд хүрсэн хүний үр удмаа үлдээх чадвараа хадгалах эрхийг баталгаажуулсны зэрэгцээ төр хөгжлийн бэрхшээлтэй хүмүүсийг нөхөн үржхүй гэр бүл төлөвлөлтийн мэдээллээр хангах, эрхийг нь хуулиар баталгаажуулах, үр хүүхдээ өсгөхөд нь зохих тусламж үзүүлэх үүрэгтэй. Түүнчлэн, хөгжлийн бэрхшээлтэй хүүхдүүдийг нууцлах, орхих, үл тоомсорлох, эцэг эхээс нь тусгаарлахыг хориглож, ийм нөхцөл бүрдүүлэх, шаардлагатай тусламж үзүүлэх үүргийг төрд хүлээлгэжээ.

☺ Сурч боловсрох эрх (24 дүгээр зүйл)

Боловсрол нь өөрөө бие даасан эрх төдийгүй бусад эрх хэрэгжих баталгаа юм. Сурч боловсрох эрх нь өргөн агуулгатай эрх бөгөөд олон улсын гэрээ, *Конвенцид* тодорхойлсноор дараах асуудлууд хамаардаг. Үүнд:

- ✓ Бага боловсролыг хүн бүрт үнэ төлбөргүй, заавал эзэмшүүлэх;
- ✓ Дунд боловсрол хүн бүрт хүртээмжтэй, эзэмших боломжтой байх; (дунд боловсролыг аажмаар үнэ төлбөргүй болгох буюу шаардлагатай тохиолдолд суралцагчдад санхүүгийн дэмжлэг үзүүлэх)
- ✓ Хүн бүр дээд боловсрол эзэмших боломжтой байх; (аажмаар үнэ төлбөргүй болгох асуудал мөн хамаарна)
- ✓ Анхан шатны боловсрол эзэмшээгүй хүмүүст зориулсан суурь боловсрол олгох тогтолцоо бий болгох;
- ✓ Хөгжлийн бэрхшээлтэй хүмүүст зориулсан боловсролын тусгай хөтөлбөрийг бий болгох;

- ✓ Стандартад нийцсэн хувийн боловсрол олгох байгууллага байгуулах, ийм байгууллагад боловсрол эзэмших боломжтой байх;
- ✓ Эцэг эх нь өөрийн шашин, ёс суртахуун, гүн ухааны үзэл итгэл үнэмшлийнхээ дагуу үр хүүхдийнхээ боловсрол эзэмших байгууллагыг сонгох
- ✓ Эрдэм шинжилгээний ажил эрхлэх эрх чөлөөг боогдуулахгүй байх
- ✓ Суралцагчидтай хүнлэг бус, харгис, хэрцгий байдлаар хандахгүй, бие махбодийн шийтгэл үзүүлэхгүй байх.

Сурч боловсрох эрхийн дээрх агуулга хөгжлийн бэрхшээлтэй хүмүүсийн эрхийн тухай Конвенцид ч хамааралтай хэрэгжинэ. Гэхдээ конвенцид хөгжлийн бэрхшээлтэй хүмүүст зориулсан сургалтын зорилго, тэдгээрийг хэрэгжүүлэх арга замыг тодорхойлсноороо онцлогтой. Тухайлбал, хөгжлийн бэрхшээлтэй хүмүүст зориулсан сургалт нь тухайн хүний өөрийгөө үнэлэх, хүндэтгэх хандлагыг хөгжүүлж, хүний ялгаатай байдлыг хүндэтгэх үзлийг төлөвшүүлэх, хөгжлийн бэрхшээлтэй хүний авьяас чадварыг дээд хэмжээнд хөгжүүлэх, нийгмийн амьдралд үр дүнтэй оролцох боломжийг бий болгоход чиглэгдэх ёстой гэж заасан.

☺ Эрүүл мэндээ хамгаалуулах эрх (25 дугаар зүйл)

Эрүүл мэндээ хамгаалуулах, эмнэлгийн тусламж авах эрхийг хангах гэдэг нь төр хүн бүрийг цоо эрүүл байлгахыг ёстой гэсэн хэрэг биш юм. Харин иргэдийн эрүүл мэндийг хамгаалах, эрүүл байх боломжийг дээшлүүлэх нь энэ эрхийг хангахад төрийн гүйцэтгэх үүрэг болно. Олон улсын эрх зүйд тодорхойлсноор иргэдийнхээ эрүүл мэндээ хамгаалах талаар төрийн гүйцэтгэх үүрэг дараах агуулгатай байна. Үүнд:

- ✓ Бүх хүн амд хүрэлцэхүйц эрүүл мэндийн үйлчилгээг бий болгох;
- ✓ Эрүүл мэндийн үйлчилгээ үнийн хувьд боломжийн байх бөгөөд үйлчилгээний төлбөр төлөх боломжгүй хүмүүст зориулсан тусгай хөнгөлөлттэй байх;
- ✓ Эрүүл мэндийн үйлчилгээ газар зүйн хувьд хүрч очиход бэрхшээлгүй, тухайн хүн амын соёл уламжлалыг хүндэтгэсэн байх;
- ✓ Эрүүл мэндийн үйлчилгээ чанартай байх;
- ✓ Хүн бүр тэгш үйлчлүүлэх боломжтой, хэн нэгнийг, нийгмийн аль нэг хэсгийг алагчлахгүй нөхцөлийг хангасан байх ёстой байдаг.

Хөгжлийн бэрхшээлээс шалтгаалсан ямар нэг алагчлалгүйгээр эрүүл мэндийн үйлчилгээ үзүүлэх төрийн үүргийг Конвенцид тодорхойлсон. Тухайлбал, төр бусад хүмүүст хүргэдэгтэй адил түвшинд, ижил чанартай эрүүл мэндийн тусламж, үйлчилгээгээр хөгжлийн бэрхшээлтэй хүмүүсийг хангах бөгөөд үйлчилгээ нь хөгжлийн бэрхшээлтэй хүмүүсийн амьдарч буй орчинд аль болох ойр байхын зэрэгцээ хөгжлийн бэрхшээлийн онцлогт нийцсэн байх тухай Конвенцид заасан байна.

☺ Хөдөлмөрлөх эрх (27 дугаар зүйл)

Хөдөлмөрлөх эрхийн үндсэн агуулгад ажил мэргэжлээ чөлөөтэй сонгох, ажилгүйдлээс хамгаалуулах, адил хөдөлмөрт ижил цалин хөлс авах, амьжиргааны зохистой түвшинд амьдархуйц хүрэлцээтэй цалин хөлс авах, эрүүл, аюулгүй хөдөлмөрийн нөхцөлөөр хангагдах, албан тушаал ахих тэгш боломжтой байх, амрах, хуулиар тогтоосон амралтын хугацаандаа цалин хөлс авах эрхүүд багтдаг. Түүнчлэн эвлэлдэн нэгдэх, үйлдвэрчний эвлэл байгуулах, хамтын гэрээ, хэлэлцээр хийх болон ажил хаялт зарлаж эсэргүүцлээ илэрхийлэх зэрэг эрх хөдөлмөрлөх эрхээ хамгаалах зорилгоор урган гардаг салбар эрхүүд юм. Эдгээр салбар эрхийг тухайн хүний эрхэлж буй албан тушаалаас нь хамаарч хязгаарлаж болохоор олон улсын гэрээ, Конвенцид заасан байдаг. Хөгжлийн бэрхшээлтэй хүмүүсийн эрхийн тухай Конвенцид тэдгээр хүмүүсийн бусадтай адил тэгш эрхийн үндсэн дээр хөдөлмөрлөх эрхийг баталгаажуулж, энэ эрхийг хангах үүднээс ажлын байрыг тохирох хэрэглэгдэхүүнээр тоноглох, төрийн алба, хувийн хэвшлийн байгууллагад хөгжлийн бэрхшээлтэй хүн хөдөлмөр эрхлэх болон хувиараа хөдөлмөр эрхлэхийг дэмжих, тэдэнд мэргэжлийн чиг баримжаа олгох сургалтад хамруулах арга хэмжээ авахаар заасан.

☺ Хүрэлцэхүйц амьжиргаатай байх эрх (28 дугаар зүйл)

Амьдралын хүрэлцээтэй төвшинд амьдрах гэдэг нь аливаа хүн харъяалагдан буй улсынхаа амьжиргааны баталгаажих доод төвшингөөс дээгүүр амьдрах боломжтой байхыг хэлнэ. Гуйлга гуйх, биеэ үнэлэх, барьцааны хөдөлмөр эрхлэх зэргээр амьжиргааныхаа наад захын хэрэгцээг хангах нь хүний эрхэм зэрэг хөсөрдөхөд хүргэдэг. Иймээс төр иргэдээ хангалттай хоол хүнс, хувцас хунар, зохистой орон байр, шаардлагатай халамж үйлчилгээгээр хангах, үүнд шаардагдах эрх зүй, удирдлага, зохион байгуулалт, хөрөнгө нөөцийг бий болгох үүрэгтэй. Зохистой амьжиргаатай байх эрхийг хангах өөр нэг чухал арга зам бол амьжиргааны баталгаа нь алдагдах эрсдэлтэй зарим бүлгийн эрхийг хангах үүднээс авч буй нийгмийн хамгааллын үйлчилгээ байдаг. Монгол Улсын Үндсэн хуульд зааснаар өндөр наслах, хөдөлмөрийн чадвар алдах, хүүхэд төрүүлэх, асрах болон бусад тохиолдолд иргэд эд мөнгөний тусламж авах эрхтэй. Нийгмийн хамгааллын үйлчилгээг хэрэгжүүлэх үүднээс улс орнууд эдийн засгийн идэвхтэй хүн амаа даатгалд хамруулах, эдийн засгийн идэвхгүй хүн амдаа тусламж, дэмжлэг үзүүлэх үйл ажиллагаа явуулдаг. Дэлхийн аль улс оронд ялгаагүй нийгмийн хамгааллын үйлчилгээг тогтвортой хүртэгч бүлэг бол хөгжлийн бэрхшээлтэй иргэд байдаг. Иймээс Конвенцид хөгжлийн бэрхшээлтэй хүмүүс, тэдний гэр бүлийн хүрэлцэхүйц амьжиргаатай байх эрхийг баталгаажуулж, цэвэр усны үйлчилгээ, нийгмийн хамгааллын, ядуурлыг бууруулах, бүх нийтийг орон сууцжуулах хөтөлбөрүүдэд тэгш хамрагдах, хөгжлийн бэрхшээлийг нөхөх тусгай хэрэглэгдэхүүний зардлуудад төрөөс дэмжлэг авахаар заасан.

☺ Улс төр, нийгмийн амьдралд оролцох эрх (29 дүгээр зүйл)

Улс төр, нийгмийн амьдралд оролцох эрх хүмүүст эрх ашгаа хамгаалах төдийгүй амьдарч буй нийгмийнхээ байгууламж, үнэт зүйлсийг тодорхойлох боломж олгодог чухал эрх юм. Олон улсын гэрээ, Конвенцид тодорхойлсноор улс төр нийгмийн амьдралд оролцох эрх нь дараах гурван үндсэн хэсгээс бүрддэг. Үүнд:

- ✓ Төрийн хэрэгт шууд буюу чөлөөтэй сонгосон төлөөлөгчдөөрөө дамжуулан оролцох
- ✓ Бүх нийтээрээ тэгш эрхтэй оролцон, хүсэл зориггоо чөлөөтэй илэрхийлэх, саналаа нууцаар гаргах боломж хангасан, тогтмол сонгуульд сонгох буюу сонгогдох;
- ✓ Тэгш эрхийн үндсэн дээр улсдаа төрийн алба хаших.

Хөгжлийн бэрхшээлтэй хүмүүсийн улс төр, нийгмийн амьдралд оролцох эрхийг баталгаажуулах үүднээс сонгууль өгөх журам, байр, саналын хуудсыг хүртээмжтэй болгох, төр, засгийн байгууллагын аль ч түвшинд төрийн алба хашихыг дэмжих, улс төрийн намууд, төрийн бус байгууллага байгуулах, үйл ажиллагаанд нь оролцох явдлыг хангах нь Конвенцид оролцогч улс орнуудын үүрэг юм.

Соёлын амьдралд оролцох эрх (30 дугаар зүйл)

Конвенцид соёлын амьдралд оролцох эрхийг соёлын, телевизийн хөтөлбөр, кино, театр, номын сан, аялал жуулчлалын үйлчилгээнд хамрагдах, хөшөө дурсгал, соёлын ач холбогдол бүхий газруудад хүрэх боломжтой байх, оюуны өмчөө хамгаалуулах, амралт, чөлөөт цагаа спортын арга хэмжээнд оролцох зэрэг өргөн хүрээнд авч үзжээ. Дурдсан бүхий л үйлчилгээ, соёл урлаг, спортын салбар хөгжлийн бэрхшээлтэй хүмүүст хүртээмжтэй байх бөгөөд төрөөс энэ эрхийг хангах бүх төрлийн арга хэмжээ авах үүрэгтэй. Түүнчлэн, дохионы хэл зэрэг хэл ярианы онцлог байдлыг хөгжлийн бэрхшээлтэй хүмүүс соёлын тусгай хэлбэр болохыг нь хүлээн зөвшөөрч баталгаажуулсан нь конвенцийн онцлог юм.

2.3 Гэрээг дагаж мөрдөх зөвшөөрлөө илэрхийлэх арга зам ба конвенци хүчин төгөлдөр болох нь

Улс орнууд олон улсын гэрээг дагаж мөрдөх зөвшөөрлөө илэрхийлэх арга замаа үндэсний хууль тогтоомжоороо тодорхойлох боловч олон улсын хэмжээнд мөрдөгддөг нийтлэг хэм хэмжээ бий. Ийм нийтлэг хэм хэмжээг 1969 онд батлагдсан Олон улсын гэрээний эрх зүйн тухай (Венийн) конвенцоор тогтоосон. Тус конвенцийн 11 дүгээр зүйлд зааснаар олон улсын гэрээг дагаж мөрдөх зөвшөөрлөө улс орнууд гэрээнд гарын үсэг зурах, гэрээг бүрдүүлэгч баримт бичгийг солилцох, соёрхон батлах, хүлээн зөвшөөрөх, нэгдэн орох зэрэг аргаар илэрхийлж болно. Харин гарын авлагын энэ хэсэгт Хөгжлийн бэрхшээлтэй хүмүүсийн эрхийн тухай конвенцийг дагаж мөрдөх зөвшөөрөл илэрхийлэх аргуудыг авч үзлээ.

Конвенцийн 44 дүгээр зүйлд “Энэхүү конвенцид гарын үсэг зурсан улсуулын хувьд түүнийг соёрхон батлах бөгөөд, гарын үсэг зурсан бүс нутгийн хамтын ажиллагааны байгууллагуудын хувьд албан ёсоор батламжилна. Энэхүү конвенцид гарын үсэн зураагүй аливаа улс болон бүс нутгийн хамтын ажиллагааны байгууллагуудын хувьд энэхүү конвенци нь нэгдэн ороход нээлттэй байна” гэж заасан. Иймээс гарын үсэг зурах, нэгдэн орох, соёрхон батлах үйл явц, тэдгээрийн үр дагаврыг тодорхой мэдэх нь сонирхогч хэн бүхэнд ач холбогдолтой юм.

Гарын үсэг зурах:

Гарын үсэг зурах нь олон улсын гэрээг дагаж мөрдөх зөвшөөрөл илэрхийлэх арга замын нэг юм. Гарын үсэг зурснаар хүчин төгөлдөр болохыг тухайн гэрээнд заасан, гэрээ байгуулагч талууд тийнхүү тохиролцсон, гарын үсэг зурснаар гэрээ хүчин төгөлдөр болох нь улс орнуудын санаа зориг, хэлэлцээнд оролцогч төрийн албан хаагчийн бүрэн эрхийн байдлаас харагдаж байвал энэ арга замаар гэрээний оролцогч болж болно. Харин гэрээнд нэгдэн орох, батлах, соёрхон батлах аргаар дагаж мөрдөх зөвшөөрлөө илэрхийлэхийг тухайн гэрээнд заасан бол улс орнуудын төлөөлөгч урьдчилан гарын үсэг зурдаг. Энэ нь гэрээний эх бичвэрийг хүлээн зөвшөөрч, хожмын өдөр уг гэрээг дагаж мөрдөх зөвшөөрлөө албан ёсоор илэрхийлж байгаа хэрэг юм. Ерөнхийдөө олон улсын олон талт гэрээг соёрхон батлах замаар дагаж мөрдөх зөвшөөрлөө илэрхийлэх нь түгээмэл байдаг.

Хөгжлийн бэрхшээлтэй хүмүүсийн эрхийн тухай конвенцийн 44 дүгээр зүйлд заасны дагуу улс орнууд болон Европын холбоо зэрэг бүс нутгийн хамтын ажиллагааны байгууллагууд тус конвенцид гарын үсэг зурж болно. Түүнчлэн конвенцид гарын үсэг зурсан аливаа улс орон, бүс нутгийн хамтын ажиллагааны байгууллагууд нэмэлт протоколд гарын үсэг зурж болно. Харин аливаа олон улсын эрх зүйн этгээд гэрээнд нэгдэн орох бол ийнхүү гарын үсэг зурах шаардлагагүй юм.

**УЛСЫН ТӨЛӨӨЛЖ ОЛОН УЛСЫН ОЛОН ТАЛТ ГЭРЭЭНД ХЭН ГАРЫН ҮСЭГ
ЗУРАХ ВЭ?**

🇺🇳 Улсыг төлөөлж тухайн улсын төрийн тэргүүн, засгийн газрын тэргүүн, гадаад хэргийн сайд нар бүрэн эрхийг нь батламжилсан итгэмжлэхгүйгээр гэрээнд гарын үсэг зурах бүрэн эрхтэй.

🇺🇳 Харин улсыг төлөөлж дээрх дурдсан албан тушаалтнуудаас өөр төлөөлөгч гарын үсэг зурах бол бүрэн эрхийг нь илэрхийлсэн батламж шаардлагатай.

🇺🇳 Төлөөлөгчөөр дамжуулан Хөгжлийн бэрхшээлтэй хүмүүсийн эрхийн тухай конвенцид гарын үсэг зурах улс орнууд төлөөлөгчийн бүрэн эрхийн батламжийг дараах хаягаар урьдчилан НҮБ-д хүргүүлсэн байх ёстой.

Treaty Section
Office of Legal Affairs
United Nation's Headquarters
New York,
United States of America

Tel: 1 212 963 5047
Fax: 1 212 963 3693
Email: treaty@un.org

Олон улсын олон талт гэрээнд гарын үсэг зурсан даруйд тухайн улсын хувьд гэрээг дагаж мөрдөх хууль зүйн үүрэг үүсэхгүй бөгөөд харин энэ үйл явц хожмын нэг өдөр конвенци, түүний нэмэлт протоколыг дагаж мөрдөх болохоо илэрхийлж буй хэрэг юм. Гэхдээ гарын үсэг зурсан олон улсын эрх зүйн этгээд (Улс орон, олон улсын байгууллага, тусгаар тогтнолынхоо төлөө тэмцэж буй үндэстнүүдийг олон улсын эрх зүйн этгээдүүд гэж үздэг. Олон улсын эрх зүйн хөгжил, хүний эрхийг асуудалтай холбоотой хувь хүнийг олон улсын эрх зүйн этгээд гэж үзэх хандлага бий.) тийнхүү гарын үсэг зурснаас дагаж мөрдөх зөвшөөрлөө илэрхийлэх хүртэлх хугацаанд тухайн гэрээний объект, зорилгод үл нийцэх үйлдэл гаргахгүй байх үүрэгтэй.

Дагах мөрдөх зөвшөөрлөө илэрхийлэх:

Хөгжлийн бэрхшээлтэй хүмүүсийн эрхийн тухай конвенци болон түүний нэмэлт протоколын оролцогч болохын тулд улс орнууд тодорхой эрх зүйн акт гаргаж, дагаж мөрдөх зөвшөөрлөө илэрхийлэх ёстой. Олон улсын эрх зүйн этгээдүүд конвенци болон түүний нэмэлт протоколыг дагаж мөрдөх зөвшөөрлөө дараах арга замаар илэрхийлж болно. Үүнд:

☺ Соёрхон батлах (Улс орнуудын хувьд)

☺ Нэгдэн орох (Улс орнуудын болон бүс нутгийн хамтын ажиллагааны байгууллагуудын хувьд)

☺ Албан ёсоор батламжлах (Бүс нутгийн хамтын ажиллагааны байгууллагуудын хувьд)

Олон улсын гэрээний тухай Монгол Улсын хуулийн 10 дугаар зүйлийн 10.1-т заасны дагуу хүний салшгүй эрхтэй холбогдсон олон улсын гэрээ нь заавал соёрхон батлах гэрээ байдаг. Хуульд зааснаар олон улсын гэрээг соёрхон батлуулах саналыг гадаад хэргийн асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүн дангаар, эсхүл тухайн гэрээгээр зохицуулж буй асуудлыг эрхэлсэн Засгийн газрын гишүүн буюу тусгай газрын дарга гадаад хэргийн асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүнтэй зөвшилцөн Засгийн газарт өргөн мэдүүлэх бөгөөд Засгийн газар олон улсын гэрээг соёрхон батлуулах саналыг хэлэлцээд зохих шийдвэр гарган Улсын Их Хуралд өргөн мэдүүлдэг. Засгийн газраас соёрхон батлуулахаар өргөн мэдүүлсэн олон улсын гэрээг Улсын Их Хурал хэлэлцэж соёрхон батлах эсэх асуудлыг шийдвэрлэнэ. Улсын Их Хурлаас олон улсын гэрээг соёрхон баталбал хууль, соёрхон батлаагүй тохиолдолд тогтоол гаргана.

ГАРЫН ҮСЭГ ЗУРАХ, СОЁРХОН БАТЛАХ, НЭГДЭЖ ОРОХ, АЛБАН ЁСООР БАТЛАМЖЛАХ ЯМАР ЯЛГААТАЙ ВЭ?

☞ **Гарын үсэг зурснаар** олон улсын эрх зүйн этгээд тухайн гэрээг дагаж мөрдөх зөвшөөрлөө илэрхийлэх талаар арга хэмжээ авах болохоо нотолж байгаа хэрэг бөгөөд дагаж мөрдөх зөвшөөрлөө илэрхийлэх хүртэл гэрээний объект, зорилгод үл нийцэх үйлдлээс татгалзах ёстой.

🕯 **Соёрхон баталснаар** улс орнууд тухайн гэрээний дагуу хууль зүйн үүрэг хүлээх бөгөөд гэрээнд тайлбар хийх (гэрээний зарим заалтыг үл дагаж мөрдөх буюу өөрийн орны онцлогт тохируулан ялгаатай хэрэгжүүлэх тухай мэдэгдэл) эрхтэй.

🕯 **Нэгдэн орсноор** олон улсын эрх зүйн этгээдэд тухайн гэрээг дагаж мөрдөх хууль зүйн үүрэг үүснэ.

🕯 **Албан ёсоор** батламжилснаар бүс нутгийн хамтын ажиллагааны байгууллагад гэрээг дагаж мөрдөх хууль зүйн үүрэг үүснэ.

Хөгжлийн бэрхшээлтэй хүмүүсийн эрхийн тухай конвенцийн 45 дугаар зүйлд зааснаар хорь дахь соёрхон баталсан батламж жуух, эсхүл нэгдэн орсон тухай баримт бичгийг хадгалуулахаар хүргүүлснээс хойш гуч хоногийн дараа хүчин төгөлдөр болохоос заасан. 2008 оны 4 дүгээр сарын 3-ны өдөр Эквадор улс конвенцийг, нэмэлт протоколын хамт соёрхон баталснаар 2008 оны 5 дугаар сарын 3-ны өдрөөс эхлэн Хөгжлийн бэрхшээлтэй хүмүүсийн эрхийн тухай конвенци болон түүний нэмэлт протокол хүчин төгөлдөр үйлчилж байна.

КОНВЕНЦИЙГ СОЁРХОН БАТЛУУЛАХЫН ТУЛД ШИЙДВЭР ГАРГАГЧ ЮУ ХИЙЖ БОЛОХ ВЭ?

🕯 Улсын Их Хурал, Засгийн газрын гишүүдэд *конвенци*, нэмэлт протоколыг соёрхон батлах санаа зорилго байгаа эсэхийг нягтлах

🕯 Хэрвээ байхгүй бол хуульд заасан горимын дагуу соёрхон батлуулах ажлыг шуурхайлахад чиглэгдсэн *санаачилга* гаргах

🕯 Энэ асуудлаар нэгдсэн шийдвэр гаргуулахыг тулд өөрийн бүрэн эрхийнхээ хүрээнд үйл ажиллагаа явуулах

🕯 Албан ба албан бус байдлаар бусад хамтран зүтгэгчидтэйгээр хэлэлцүүлэг өрнүүлэх

🕯 Энэ талаарх иргэний нийгмийн болон хүний эрхийн байгууллагуудын үйл ажиллагаанд оролцох, үзэл бодлоо илэрхийлэх, тэдний дэмжлэгийг авах, хамтарч ажиллах

🕯 Конвенцийг, нэмэлт протоколын хамт соёрхон батлахад анхаарал хандуулах

🕯 Конвенцид тайлбар хийх санаа, зорилго байгаа эрх бүхий албан тушаалтнуудад бий эсэхийг нягталж, хэрвээ байгаа бол тайлбар үнэхээр шаардлагатай эсэхэд дүн шинжилгээ хийх; Тайлбар төдийлөн ач холбогдолгүй бол эрх бүхий этгээдүүдийг энэ байр сууринаасаа ухрахад чиглэгдсэн арга хэмжээ авах

ГУРАВДУГААР ХЭСЭГ: ХӨГЖЛИЙН БЭРХШЭЭЛТЭЙ ХҮМҮҮСИЙН ЭРХИЙН ХОРОО

3.1 Хөгжлийн бэрхшээлтэй хүмүүсийн эрхийн хороо

Конвенци хүчин төгөлдөр болсноор НҮБ-ын бүтцэд Хөгжлийн бэрхшээлтэй хүмүүсийн эрхийн хороо (цаашид хороо гэх) байгуулагдах бөгөөд хороо нь дараах бүрэн эрхийг хэрэгжүүлнэ. Үүнд:

- ☺ Конвенцийн хэрэгжилтийн талаарх улс орнуудын тайлан илтгэлийг хүлээн авч, хэлэлцэх
- ☺ Конвенцийг талаар ерөнхий тайлбар, зөвлөмж гаргах
- ☺ Хувь хүмүүсийн гомдлыг хүлээн авч, шийдвэрлэх
- ☺ Хяналт шалгалт явуулах

Конвенцийн 34 дүгээр зүйлээр хороо байгуулах болон хорооны үйл ажиллагааг явуулах журмыг тодорхойлжээ. Уг зүйлд конвенци хүчин төгөлдөр болмогц 12 шинжээчийн бүрэлдэхүүнтэйгээр хороог байгуулах бөгөөд конвенци хүчин төгөлдөр болсноос нь хойш 60 улс нэгдэн орсон, соёрхон баталсан нөхцөлд гишүүдийн тоог 18 болгож нэмэгдүүлэхээр заасан байна. Хорооны гишүүн нь аливаа нэг улс орныг төлөөлж биш, гагцхүү шинжээчийнхээ хувиар, өөрийн нэрийн өмнөөс ажиллах ёстой. Ёс суртахууны эрхэм чанарыг эзэмшсэн, хөгжлийн бэрхшээлтэй хүмүүсийн эрхийн асуудлаарх хүлээн зөвшөөрөгдсөн мэдлэг чадвартай байх шаардлагууд хорооны гишүүдэд тавигддаг. Түүнээс гадна хорооны гишүүнийг сонгохдоо газар зүй, нутаг дэвсгэр, хүйсийн тэгш төлөөлөл, соёл иргэншлийн янз бүрийн хэлбэр, эрх зүйн тогтолцооны ялгаатай байдлыг харгалзаж үзэхээр конвенцид заасан. Хорооны гишүүдийн бүрэн эрхийн хугацаа дөрвөн жил байх бөгөөд нэг удаа улиран сонгогдох боломжтой.

Хорооны гишүүнд нэр дэвшигчийг тодруулах буюу нэр дэвшүүлэхдээ гэрээнд оролцогч улсууд уг конвенцийн 4 дүгээр зүйлийн 4.3 дахь хэсэгт зааснаар хөгжлийн бэрхшээлтэй хүмүүс, тэдний төлөөллийн байгууллагатай зөвшилцөн шийдвэрлэнэ. Хороо нь үйл ажиллагаагаа НҮБ-ын Ерөнхий ассамблей болон Эдийн засаг, нийгмийн зөвлөлд хариуцан тайлагнах бөгөөд үйл ажиллагааныхаа тайланг хоёр жил тутамд хүргүүлэх үүрэгтэй.

3.2 Конвенцийн хэрэгжилтийн талаарх Засгийн газрын тайлан

Конвенцийн 35-36 дугаар зүйлүүдэд оролцогч улс орнууд конвенцийг хэрэгжүүлсэн тухай тайлан илтгэлээ Хөгжлийн бэрхшээлтэй хүмүүсийн эрхийн хороонд хүргүүлэх нөхцөл, журмыг

тодорхойлсон. Гэрээ, конвенцийн хэрэгжилтийн талаар оролцогч улсуудаас хороонд тайлан ирүүлэх ижил журам НҮБ-ын хүний эрхийн суурь гэрээнүүдэд бий. Засгийн газраас тайлан илтгэл гаргах журам нь нэг талаас гэрээнд оролцогч улсуудаас конвенциор хүлээсэн үүргээ биелүүлэхэд түлхэц үзүүлэх, нөгөө талаас, Засгийн газар, хүний эрхийн үндэсний байгууллага, иргэний нийгмийн байгууллагуудаас улс орныхоо хүний эрхийн хэрэгжилтэд үнэлгээ хийх цаашид авах арга замаа тодорхойлох боломж олгох зорилготой.

ТАЙЛАН ИЛТГЭЛ ЯМАР АЧ ХОЛБОГДОЛТОЙ ВЭ?

🔗 Оролцогч улсын Засгийн газар, хүний эрхийн үндэсний байгууллага, иргэний нийгмийн байгууллагуудад конвенцийн зорилго, түүгээр баталгаажуулсан эрх, эрх чөлөөний агуулгыг бүрэн гүйцэд ойлгоход дөхөм үзүүлнэ.

🔗 Конвенци, түүгээр баталгаажуулсан эрхийн хэрэгжилтийн талаарх олон нийтийн мэдлэг, ойлголтыг нэмэгдүүлнэ.

🔗 Засгийн газарт улс орныхоо нөхцөл байдлыг сайжруулах арга замаа мэргэшсэн шинжээчдийн тусламжтай тодорхойлох боломж олгоно.

🔗 Конвенцийг хэрэгжүүлэх талаар гаргасан тэргүүн туршлага, ололт амжилтаа олон улсын түвшинд мэдээлж, гадаад нэр хүндээ өсгөх боломжийг бий болгоно.

🔗 Бусад улсын туршлагаас суралцаж, амжилттай авч хэрэгжүүлсэн арга хэмжээг өөрийн улсад нэвтрүүлэх боломж олгоно.

🔗 Конвенцийг хэрэгжилтийг дээшлүүлэхийн тулд Засгийн газар, хүний эрхийн үндэсний байгууллага, иргэний нийгмийн байгууллагуудын зүгээс авах цаашдын арга хэмжээний чиглэлийг тодорхойлно.

🔗 Конвенцийг хэрэгжүүлэхэд олон улсын хамтын нийгэмлэгийн дэмжлэгийг авах боломжийг олгоно.

Гэрээнд оролцогч улс конвенцийн хэрэгжилтийн талаарх анхдугаар тайлан илтгэлээ тухайн улсын хувьд конвенци хүчин төгөлдөр болсноос хойш хоёр жилийн дотор Хөгжлийн бэрхшээлтэй хүмүүсийн эрхийн хороонд хүргүүлэх ёстой. Анхдугаар илтгэлд тайлагнаж буй асуудлыг дэлгэрэнгүй тусгах бөгөөд дараах агуулгатай байна.

😊 Конвенциор баталгаажуулсан хүний эрх, эрх чөлөөг хэрэгжүүлэхэд чиглэгдсэн Үндсэн хууль, бусад хууль тогтоомжийн заалт, энэ талаар авч хэрэгжүүлж буй захиргааны арга хэмжээг тодорхойлсон;

☺ Хөгжлийн бэрхшээлтэй хүмүүсийн эрхийг хангах талаарх төрийн бодлого, хэрэгжүүлж буй хөтөлбөрүүдийг тайлбарласан;

☺ Конвенцийг соёрхон баталж, хэрэгжүүлсний дүнд гарсан ахиц дэвшил, өөрчлөлтийг харуулсан байх.

Харин удаах илтгэлүүд нэлээд товч байх бөгөөд Хороонд урьд нь ирүүлсэн мэдээллээ давтах шаардлагагүй. Гэрээнд оролцогч улсууд конвенцийн хэрэгжилтийн талаарх удаах илтгэлүүдийг дөрвөн жил тутамд, эсхүл Хорооноос хүссэн тухай бүр хүргүүлэх ёстой. Тэдгээр илтгэлүүд дараах мэдээллийг багтаасан байна.

☺ Өмнөх илтгэлийг хэлэлцээд Хорооноос гаргасан дүгнэлт, зөвлөмжийн мөрөөр авсан арга хэмжээ;

☺ Илтгэл боловсруулах хугацаанд гарсан өөрчлөлт, ахиц, дэвшил;

☺ Илтгэл боловсруулах хугацаанд гэрээний үүргээ биелүүлэхэд гарсан саад бэрхшээл зэрэг болно.

Оролцогч улсын Засгийн газар тайлан илтгэлээ боловсруулахдаа аль болох нээлттэй, олон талын оролцоог хангаж, ялангуяа, хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн байгууллагуудтай хамтран ажиллах үүрэгтэй.

Гэрээний хэрэгжилтийн талаар тайлан боловсруулах ажиллагаа нь улс орнуудад дараах ач холбогдолтой. Үүнд:

☺ Хүний эрх, хөгжлийн бэрхшээлтэй хүмүүсийн талаарх хууль тогтоомж, бодлого, хөтөлбөрөө цогц байдлаар нь хянан үзэх боломжийг Засгийн газарт олгоно.

☺ Хөгжлийн бэрхшээлтэй хүмүүст эрхээ эдлэх боломж, нөхцөл бий болгоход чиглэгдсэн Засгийн газрын үйл ажиллагаанд үнэлгээ хийгдэнэ.

☺ Хөгжлийн бэрхшээлтэй хүмүүсийн эрхийг хангахын тулд нэн түрүүнд авч хэрэгжүүлэх арга хэмжээгээ тодорхойлох боломжийг олгоно.

☺ Хөгжлийн бэрхшээлтэй хүмүүсийн талаар Засгийн газраас авч хэрэгжүүлсэн арга хэмжээний талаарх мэдээллийг иргэдэд түгээнэ.

☺ Хөгжлийн бэрхшээлтэй хүмүүст тулгамдсан хэдий ч төдийлөн анзаарагдаж, арга хэмжээ авагдаж байгаагүй асуудлуудыг тодорхойлох, тэдгээрийг шийдвэрлэх бололцоо бий болно.

Илтгэлийг хэлэлцээд гаргасан Хорооны зөвлөмжийг хэрэгжүүлэхэд дэмжлэг үзүүлэх, илтгэгч улсын нөхцөл байдалд олон улсын байгууллагуудын анхаарлыг хандуулах зорилгоор Хороо дүгнэлт,

зөвлөмжөө НҮБ-ын тусгай байгууллага, сан, хөтөлбөрүүдэд (НҮБ-ын Боловсрол, соёл, шинжлэх ухааны байгууллага /ЮНЕСКО/, НҮБ-ын Хөгжлийн Хөтөлбөр, НҮБ-ын Хүүхдийн сан, Олон улсын хөдөлмөрийн байгууллага, Дэлхийн эрүүл мэндийн байгууллага, Дэлхийн банк зэрэг) хүргүүлнэ. Конвенцид заасны дагуу тэдгээр олон улсын байгууллагууд хөгжлийн бэрхшээлтэй хүмүүсийн эрхийг хангах, хамгаалахад хувь нэмрээ оруулах үүрэгтэй бөгөөд хөгжиж буй орнуудын асуудалд нэн түрүүнд анхаарал хандуулах учиртай.

3.3 Хөгжлийн бэрхшээлтэй хүмүүсийн эрхийн тухай конвенцийн нэмэлт протокол

Хүний эрхийн гэрээний нэмэлт протокол нь гэрээний хэрэгжилтэд хяналт тавих өнөөгийн тогтолцооны үр нөлөөг үлэмж нэмэгдүүлдэг. Гэхдээ нэмэлт протоколын үр дүнд улс орнуудын гэрээгээр хүлээсэн үүргээ бүрэн дүүрэн ойлгох боломжийг бий болгож байгаа нь хувь хүмүүсийн гомдлыг шийдвэрлэх ажиллагаанаас ч илүү чухал ач холбогдол юм.

*Луиз Арбор, НҮБ-ын
Хүний эрхийн дээд комиссар*

түвшинд хүрсэн улс орнуудын хэлэлцээний үр дүнд бий болдог учраас зарим асуудлын талаар тэдгээр улс орнуудын төлөөлөгчдийн санал эрс зөрөх, нэгдсэн шийдэлд хүрэхэд төвөгтэй байдал үүсэх тохиолдол цөөнгүй гардаг. Энэ тохиолдолд гэрээний объект, зорилгыг биелүүлэхэд чухал ач холбогдолтой боловч цөөнгүй улс орны эсэргүүцэлтэй тулгарсан зарим асуудлыг тусад нь боловсруулж, тухайн гэрээний нэмэлт протокол болгон батлах шийдэлд хүрдэг. Энэ мэт нөхцөлийн улмаас олон улсын гэрээний нэмэлт протокол бий болдог юм.

Нэмэлт протокол нь эх гэрээний зохицуулаагүй буюу хангалттай хэмжээнд зохицуулж чадаагүй асуудлыг тусгасан хууль зүйн нэмэлт баримт бичиг юм. Нэмэлт протоколыг дагаж мөрдөх явдал ихэвчлэн эх гэрээг соёрхон баталсан буюу нэгдэн орсон улс оронд нээлттэй байдаг. Англи хэл дээр нэмэлт протоколыг “optional protocol” буюу үгчлэн орчуулбал “сонголтот протокол” гэж нэрлэдэг нь улс орнууд түүнийг дагаж мөрдөх эсэхээ сонгох боломжтой байдагтай холбоотой.

Нөгөө талаас, олон улсын гэрээний эх бичвэр харилцан адилгүй соёл уламжлал, зан заншил, ашиг сонирхол, улс төрийн хүсэл эрмэлзлэл, хөгжлийн

Хөгжлийн бэрхшээлтэй хүмүүсийн эрхийн тухай конвенцийн нэмэлт протоколоор конвенцийн хэрэгжилтийг хангахад чиглэгдсэн дараах хоёр төрлийн тусгай ажиллагааны журмыг тодорхойлсон байна. Үүнд:

☺ Хувь хүний гомдол, мэдээллийг хүлээн авах

☺ Хяналт, шалгалт зохион байгуулах

Хувь хүний гомдол, мэдээллийг шийдвэрлэх журам:

НҮБ-ын гэрээний хэрэгжилтийг хангах хороодод гэрээнд оролцогч улс орнуудын иргэн, хувь этгээдүүдээс гаргасан гомдлыг “мэдээлэл” (“communication”) гэж нэрлэдэг.

Нэмэлт протоколд нэгдсэнээрээ улс орнууд конвенциор баталгаажуулсан хөгжлийн бэрхшээлтэй хүний эрх, эрх чөлөөг оролцогч улс зөрчиж байгаа тухай хувь хүний гомдлыг хүлээн авч, хянан хэлэлцэх бүрэн эрхийг Хороонд олгож байгаа хэрэг юм. Хувь хүний гомдлыг шийдвэрлэх ажиллагаа нь баримт бичиг, бичгээр ирүүлсэн гомдол тайлбарт үндэслэн явагддаг. Өөрөөр хэлбэл, гомдол гаргаж буй хувь хүн ч, хөгжлийн бэрхшээлтэй хүний эрхийг зөрчсөн гэх улс орны төр, засгийн төлөөлөгч ч энэ асуудлаар биечлэн Хорооны хуралдаан оролцож, тайлбар, мэдүүлэг гаргадаггүй. Хороо гомдлыг хүлээн авч зохих шалгалт явуулсны эцэст дүгнэлт, зөвлөмжөө гаргаж, гомдолд холбогдогч талуудад хүргүүлдэг. Эдгээр дүгнэлт, зөвлөмж нь Хорооны тайланд тусгагдах бөгөөд НҮБ-ын Ерөнхий Ассамблейгаар хэлэлцэгдэнэ.

Хөгжлийн бэрхшээлтэй хүмүүсийн эрхийн хороонд гаргах гомдолд тавигдах шаардлагуудыг нэмэлт протоколын 2 дугаар зүйлд тодорхойлсон. Тэдгээр тусгай шаардлагыг хангаагүй гомдлыг хороо хүлээн авдаггүй бөгөөд шаардлага хангаагүй гэдэгт дараах нөхцөлүүд хамаарагдана. Үүнд:

- ☹ Нэр хаяггүй;
- ☹ Гомдол гаргах эрхээ урвуугаар ашигласан буюу гаргаж буй асуудал нь конвенцийн зүйл, заалттай нийцээгүй;
- ☹ Асуудлыг НҮБ-ын гэрээний хэрэгжилтийг хянах өөр Хороогоор урьд өмнө нь хэлэлцсэн;
- ☹ Асуудлыг олон улсын мөрдөн шалгах өөр журмаар хэлэлцсэн;
- ☹ Дотоодын эрх зүйн хамгаалалтын бүхий л арга хэрэгслийг барагдуулаагүй;
- ☹ Тавьж буй асуудал үндэслэлгүй буюу хангалттай нотлогдож чадаагүй;
- ☹ Тавьж буй асуудал нэмэлт протоколд оролцогч улсын хувьд түүнийг хүчин төгөлдөр болохоос өмнө эцэслэн шийдвэрлэгдсэн;

ХУВЬ ХҮНИЙ ГОМДЛЫГ ШИЙДВЭРЛЭХ ҮЕ ШАТ

Хөгжлийн бэрхшээлтэй хүмүүсийн эрхийн хороо дараах журмын дагуу хувь хүний гомдлыг хүлээн авч, шийдвэрлэнэ.

🕒 Гомдлыг хүлээн авна.

🕒 Гомдол хорооны бүрэн эрхэд хамаарч байгаа эсэхийг хянаана. Зарим тохиолдол энэ шатанд гомдолд холбогдогч улс хүний эрхийг зөрчөөгүй нь тогтоогдож, гомдлыг эцэслэн шийдвэрлэх нь бий.

🕒 Хороо гомдолд дурдсан асуудлыг холбогдогч улсад мэдээлнэ.

Гомдолд холбогдогч улс мэдээлэл хүлээн авснаас хойш зургаан сарын хугацаанд багтаан гомдлын талаарх тайлбараа Хороонд бичгээр ирүүлнэ. Тайлбартаа тухайн асуудлын талаарх байр сууриа тодорхойлж, хүний эрхийн зөрчлийг таслан зогсоох үүднээс авах арга хэмжээ, хохирол барагдуулах арга замыг тусгасан байна.

Гомдолд холбогдогч улсаас тухайн асуудлаар гаргасан тайлбарыг гомдол гаргагч хувь хүн мэдэх боломжтой болно.

Хороо гомдол гаргагч хувь хүний эрхийг хамгаалах түр тусгай арга хэмжээ авах хүсэлтийг гомдолд холбогдогч улсад тавьж болно.

Хороо гомдлыг хаалттай хуралдаанаараа хэлэлцэнэ.

Хороо дүгнэлт, зөвлөмжөө гаргана.

Хороо гомдлыг шийдвэрлэсэн тухай дүгнэлт, зөвлөмжийг тайландаа тусгаж, НҮБ-ын Ерөнхий ассамблейгаар хэлэлцүүлнэ.

Хяналт, шалгалт зохион байгуулах журам:

Конвенциор баталгаажуулсан эрхийг гэрээнд оролцогч улс ноцтойгоор, удаа дараа зөрчиж байгаа тухай баттай мэдээллийг Хороо хүлээн авсан бол оролцогч улсад мэдээллийн талаар байр сууриа илэрхийлж, хүний эрхийн зөрчлийг шалгахад хамтран ажиллах хүсэлт тавьж болохыг нэмэлт протоколын 6 дугаар зүйлд заасан. Оролцогч улсын дүгнэлт, саналыг хүлээн авч, хэлэлцээд хороо зөрчлийг газар дээр шалгах шаардлагатай гэж үзвэл нэг буюу хэд хэдэн гишүүнээ энэ ажилд томилдог. Томилогдсон гишүүд оролцогч улсын зөвшөөрлөөр нөхцөл байдлыг газар дээр нь шалгаж тогтоох үүрэг гүйцэтгэнэ.

Хяналт шалгалт явуулснаас хойш зургаан сарын хугацаанд багтаан хороо дүгнэлтээ гаргаж, зөвлөмжийн хамт холбогдох улсад хүргүүлэх ёстой. Түүнчлэн энэ үе шатанд Хороо холбогдох улсаас хүний эрхийн зөрчлийн талаар нэмэлт мэдээлэл хүсэх боломжтой. Хяналт шалгалтынхаа үр дүнг хороо Ерөнхий Ассамблейгаар хэлэлцүүлэх бөгөөд хэрвээ гомдолд холбогдогч улс зөвшөөрвөл хяналт шалгалтын үр дүнг бүхэлд нь нийтэд мэдээлж болно.

Нэмэлт протоколыг хүлээн зөвшөөрсөн улс орнууд хяналт шалгалт явуулах хорооны энэхүү бүрэн эрхээс татгалзаж болохыг нэмэлт протоколын 8 дугаар зүйлд заасан. Гэхдээ тэдгээр улс хувь хүний гомдол гаргах журмаас татгалзаж болохгүй юм.

НҮБ-аас батлагдсан хүний эрхийн суурь гэрээ, конвенцийн ихэнхэд нь хувь хүний гомдлыг шийдвэрлэх болон хяналт шалгалт явуулах журмыг тодорхойлсон нэмэлт протоколууд байдаг. Тухайлбал, дараах гэрээ, нэмэлт протоколд хувь хүний гомдол гаргах эрхийг хүлээн зөвшөөрсөн байна:

☺ Иргэний болон улс төрийн эрхийн тухай олон улсын *пактын* нэмэлт протокол

☺ Арьс үндсээр алагчлах үзлийн бүх хэлбэрийг устгах тухай конвенци

☺ Эрүүдэн шүүх болон бусад хэлбэрээр хэрцгий, хүнлэг бусаар буюу хүний нэр төрийг доромжлон харьцаж, шийтгэхийн эсрэг конвенци

☺ Эмэгтэйчүүдийг алагчлах бүх хэлбэрийг устгах тухай конвенцийн нэмэлт протокол

☺ Бүх цагаач ажилчид, тэдгээрийн гэр бүлийн гишүүдийг хамгаалах тухай конвенци

☺ Бүх хүнийг хүчээр сураггүй алга болохоос хамгаалах тухай конвенци (Одоогоор хүчин төгөлдөр болоогүй.)

Харин доор дурдсан конвенци, протоколд тэдгээр гэрээний хэрэгжилтэд хяналт тавих хорооноос оролцогч улсын нутаг дэвсгэрт хяналт, шалгалт явуулах бүрэн эрхийг олгожээ. Үүнд:

☺ Эрүүдэн шүүх болон бусад хэлбэрээр хэрцгий, хүнлэг бусаар буюу хүний нэр төрийг доромжлон харьцаж, шийтгэхийн эсрэг конвенци

☺ Эмэгтэйчүүдийг алагчлах бүх хэлбэрийг устгах тухай конвенцийн нэмэлт протокол

☺ Бүх хүнийг хүчээр сураггүй алга болохоос хамгаалах тухай конвенци (Одоогоор хүчин төгөлдөр болоогүй.)

Хувь хүний гомдлыг шийдвэрлэх болон хяналт шалгалт явуулах журмууд тус тусын давуу талтай.

Хувь хүний гомдлыг шийдвэрлэх журам

☺ Үндэсний эрх зүйн тогтолцооны хүрээнд эрхээ сэргээлгэж чадаагүй хохирогчдод нэмэлт боломж олгодог.

☺ Хөгжлийн бэрхшээлтэй хүний зөрчигдсөн эрхийг сэргээх үр дүнтэй арга замыг тодорхойлж, гомдолд холбогдох улсад санал болгох замаар үндэсний эрх зүйн тогтолцоог боловсронгуй болгоход нөлөөлдөг.

☺ Оролцогч улсуудад гэрээгээр хүлээсэн үүргийнхээ агуулгыг бүрэн гүйцэд танин мэдэх болон үүргээ биелүүлэхэд нь тус дөхөм үзүүлдэг.

Хяналт, шалгалт явуулах журам

☺ Хороонд хүний эрхийн тогтолцооны шинжтэй, ноцтой зөрчлийн талаар арга хэмжээ авах боломж олгоно.

☺ Ийм зөрчлийг шийдвэрлэх арга замаа тодорхойлох боломжийг улс орнуудад олгоно.

☺ Хороо болон оролцогч улсын хамтран асуудлыг шийдвэрлэх боломжийг бий болгоно.

ДӨРӨВДҮГЭЭР ХЭСЭГ: КОНВЕНЦИЙГ ХЭРЭГЖҮҮЛЭХ НЬ

4.1 Конвенцийн хэрэгжилтийг хангах тусгай арга хэмжээ

Конвенциор хөгжлийн бэрхшээлтэй хүмүүсийн бусадтай адил тэгш эрхийн үндсэн дээр эдлэх эрх, эрх чөлөөний төрлийг баталгаажуулахын зэрэгцээ тэдгээрийг хэрэгжүүлэх зарим арга хэмжээг тодорхойлсон. Тухайлбал, конвенцид дараах арга хэмжээг чухалчлан заажээ. Үүнд:

☺ Мэдлэг ойлголтыг нэмэгдүүлэх (8 дугаар зүйл)

Нийт иргэддээ хөгжлийн бэрхшээлтэй хүмүүсийн эрх, эрх чөлөөний талаар мэдээлэл түгээж, хөгжлийн бэрхшээлтэй хүмүүст тулгардаг тэгш бус харьцаа, сөрөг хандлагын талаарх тэдний ойлголтыг нэмэгдүүлэх нь аливаа улс оронд конвенцийг хэрэгжүүлэхэд үр дүнгээ өгнө. Иймд конвенцид гэр бүлийг оролцуулан нийгмийн бүх хүрээнд хөгжлийн бэрхшээлтэй хүмүүсийн талаарх ойлголтыг нэмэгдүүлэх, хөгжлийн бэрхшээлтэй хүмүүст хор, хохирол учруулхуйц дадал зуршлыг бий болгоход хүргэж буй нийгэмд тогтсон үзэл хандлагатай тэмцэх, хөгжлийн бэрхшээлтэй хүний *чадавх*, тэдний нийгэмд оруулж буй хувь нэмрийн талаарх ойлголтыг нэмэгдүүлэхэд оролцогч улсууд анхаарахыг заасан.

☺ Статистик, мэдээлэл цуглуулах (31 дүгээр зүйл)

Тодорхой тоон мэдээлэл, баримт нь төрийн бодлого зөв, үр дүнтэй байхын үндэс суурь юм. Иймээс конвенцид улс орнууд хөгжлийн бэрхшээлтэй иргэдийнхээ талаар нарийн статистик мэдээллийг бий болгож, тэдгээрийг конвенциор хүлээсэн үүргийнхээ хэрэгжилтэд үнэлэлт өгөх, хөгжлийн бэрхшээлтэй хүмүүс эрхээ эдлэхэд учирч буй бэрхшээлийг тодорхойлоход эх сурвалж болгож хэрэглэхийг заасан байна. Монгол Улсын хэмжээнд хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн талаар тодорхой тоон мэдээлэл өнөөг хүртэл байхгүй байгаа юм. Энэ байдал нь тэдгээр хүмүүст чиглэсэн төрийн бодлого “цоорхойтой” байхад хүргэж байна.

☺ Олон улсын хамтын ажиллагаа (32 дугаар зүйл)

Хөгжлийн бэрхшээлтэй хүмүүсийг эрхийг хангахад олон улсын хамтын ажиллагаа чухал болохыг хүлээн зөвшөөрч, энэ талаар конвенцид тухайлан заасан байна. Хэдийгээр бүх нийтийн сайн сайханд чиглэсэн, олон улсын төсөл, хөтөлбөрүүд дэлхийн бүхий л улс оронд хэрэгждэг ч хөгжлийн бэрхшээлтэй хүмүүст тэр бүр хүртээлтэй байж чадахгүй байна. Иймээс конвенцид олон улсын хамтын ажиллагааны үр дүнг хөгжлийн бэрхшээлтэй хүмүүст хүргэх асуудлыг тухайлан авч үзжээ. Нөгөө талаас, олон улсын хамтын ажиллагааны үр дүнд улс орнууд мэдээлэл, туршлагаа солилцох замаар конвенцийг хэрэгжүүлэх үндэсний чадавхаа бэхжүүлэх, хөгжлийн бэрхшээлтэй

хүмүүст туслах хэрэгслийг солилцох, шинэ технологи нэвтрүүлэх боломжтой болно. Түүнчлэн, энэхүү заалт НҮБ, Дэлхийн банк, Европын холбоо зэрэг олон улсын хамтын ажиллагааны байгууллагуудад үйл ажиллагаагаа хөгжлийн бэрхшээлтэй хүмүүст хандуулахыг сануулах, шаардах зорилготой юм.

4.2 Үндэсний хууль тогтоомжийг конвенцид нийцүүлэх тухай

Олон улсын эрх зүйн дагуу аливаа улс орон үндэсний хууль тогтоомжоо нэгдэн орсон, соёрхон баталсан олон улсын гэрээндээ нийцүүлэх ёстой. Үндэсний хууль тогтоомжийг олон улсын гэрээнд хэрхэн нийцүүлснээс гэрээний хэрэгжилт ихээхэн хамаарах тул Хөгжлийн бэрхшээлтэй хүмүүсийн эрхийн тухай конвенцид Монгол Улсын хууль тогтоомжийг нийцүүлэхэд анхаарах асуудлыг гарын авлагад тухайлан авч үзлээ.

Олон улсын эрх зүйн практикт улс орны үндэсний хууль тогтоомжийг олон улсын гэрээнд нийцүүлэхэд дараах аргууд байдаг. Үүнд:

☺ Гэрээгээр зохицуулсан асуудлын талаар шинэ хууль гаргах;

☺ Гэрээний оролцогч болох үед хэрэгжиж байгаа, ижил төстэй харилцааг зохицуулсан хууль тогтоомждоо нэмэлт өөрчлөлт оруулах;

☺ Олон улсын гэрээний заалтаас дотоодын хууль тогтоомждоо иш татах (Тухайлбал, “Хөгжлийн бэрхшээлтэй хүмүүст мэдээллийг хүртээмжтэй болгох талаар Хөгжлийн бэрхшээлтэй хүмүүсийн эрхийн тухай конвенцийн 9 дүгээр зүйлийн 2.f, 2.h, 2.g хэсэгт заасан арга хэмжээ авна” гэх зэргээр олон улсын гэрээний заалтыг хууль тогтоомждоо тусгаж, уялдаа холбоог хангадаг.йм хариуулах) зэрэг болно.

Хууль тогтоогч олон улсын гэрээнд үндэсний хууль тогтоомжийг нийцүүлэхдээ дээр дурдсан аргын аль алианаар нь гэрээ, хууль тогтоомжийн уялдааг хангаж болох боловч манай улсын хувьд хууль тогтоомждоо өөрчлөлт оруулах аргыг ихэвчлэн хэрэглэж байна.

Монгол Улсын Үндсэн хуулийн 10 дугаар зүйлийн 10.4-т “Монгол Улс Үндсэн хуульдаа харшилсан олон улсын гэрээг дагаж мөрдөхгүй” гэж заасан. Хөгжлийн бэрхшээлтэй хүмүүсийн эрхийн тухай конвенцид манай улсын Үндсэн хуульд харшилсан зүйл заалт байхгүй тул энэхүү гэрээний оролцогч болоход татгалзах шалтгаан хууль зүйн талаасаа байхгүй.

Зохицуулж буй харилцааны шинж байдал, хэлэлцээнд оролцогч талуудын хүсэл зоригоос хамаарч олон улсын гэрээний заалт томъёолол, агуулгын хувьд харилцан адилгүй байдаг. Тухайлбал, гэрээний зарим заалтад оролцогч улсаас авах арга хэмжээний ерөнхий чиглэлийг тодорхойлсон байхад зарим нь үндэсний хууль тогтоомжид шууд тусгаж болохуйц нарийвчилсан зохицуулалтыг агуулсан байх нь бий. Хөгжлийн бэрхшээлтэй хүмүүсийн эрхийн тухай конвенцийн заалтууд

дээрх хоёр шинжийн аль алиныг нь агуулсан. Иймээс, конвенцийн нарийвчилсан зохицуулалтыг хууль тогтоомжид бүхэлд нь тусгаж ч болох юм.

Нийгмийн олон талт харилцааг дан ганц хууль тогтоомжоор зохицуулах боломжгүй учраас гэрээнд заасан зарим асуудлын талаар тусгай бодлого, хөтөлбөр боловсруулж хэрэгжүүлэх шаардлагатай болдог, энэ нь ч үр дүнгээ өгдөг. Хөгжлийн бэрхшээлтэй хүмүүсийн асуудлаар төрийн тусгай хөтөлбөр боловсруулж, хэрэгжүүлэх талаар конвенцид ч заасан байна. Манай улсад хөгжлийн бэрхшээлтэй иргэдийг дэмжих зорилготой хоёр үндсэн хөтөлбөр (Засгийн газрын 2006 оны 283 дугаар тогтоолоор “Хөгжлийн бэрхшээлтэй иргэдийг дэмжих үндэсний хөтөлбөр”, “Хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийн оролцоог дэмжих дэд хөтөлбөр”-үүдийг хавсралтаас үзнэ үү.) батлагдан хэрэгжиж байгаа юм.

Аливаа гэрээнд хууль тогтоомжийг нийцүүлэхдээ гэрээний үндсэн утга санаа, зорилгыг ойлгож, тэдгээрийг бүрэн дүүрэн хуульчлах шаардлагатай юм. Хөгжлийн бэрхшээлтэй хүмүүсийн эрхийн тухай конвенцид үндэсний хууль тогтоомжийг нийцүүлэхэд дараах зарчмыг харгалзан үзэх ёстой.

✎ Конвенцид “хөгжлийн бэрхшээлтэй хүн” гэсэн туйлын тодорхойлолт байхгүй бөгөөд зөвхөн хөгжлийн бэрхшээлтэйд тооцогдох, конвенцийн зохицуулах хүрээнд хамаарах хүмүүсийн наад захын шинж байдлыг тодорхойлсон юм. Өөрөөр хэлбэл, улс орнууд үндэсний хууль тогтоомждоо бие эрхтний хэвийн үйл ажиллагаагаа нь түр зуур алдагдсан хүмүүсийг хөгжлийн бэрхшээлтэйд тооцож, эрхийг нь хамгаалах, давуу боломж олгох явдлыг хязгаарлахгүй.

✎ Үндэсний хууль тогтоомжид “хөгжлийн бэрхшээлээс нь шалтгаалан алагчлах”, “тохирох хэрэглэгдэхүүн”, “төгс хэв маяг” зэрэг конвенцийн тодорхойлолтуудыг бүрэн гүйцэд тусгах нь гэрээ, хууль тогтоомжийн нэг мөр байдлыг хангахад ач холбогдолтой.

✎ Хөгжлийн бэрхшээлээс нь шалтгаалан алагчлах явдлыг нийгмийн амьдралын бүхий л салбар, хүрээнд хориглох ёстой.

✎ Хөгжлийн бэрхшээлтэй хүмүүс конвенциор баталгаажуулсан эрх, эрх чөлөөгөө эдлэх нөхцөлийг бий болгох үүргийг төрийн бүх шатны байгууллага, хувийн хэвшлийн байгууллагуудад хүлээлгэнэ.

✎ Конвенци, хууль тогтоомжид заасан эрх нь зөрчигдсөн гэж үзсэн хувь хүн, хэсэг бүлэг хүмүүст дараах эрх олгох, эрхээ хэрэгжүүлэх арга замыг хуульчлах. Үүнд:

- Хөгжлийн бэрхшээлийнх нь улмаас алагчилсан тухай гомдлыг шүүх болон бусад байгууллагад гаргах, эрхээ сэргээлгэх боломжтой байх;
- Гомдол гаргаж буй асуудлыг шалгаж тогтоох журмыг хуульчлах;
- Эрх зөрчигдсөн нь тогтоогдсон тохиолдолд хохирлоо барагдуулах, нөхөн төлбөр авах асуудал хуулиар зохицуулагдсан байх;

🔗 Шүүх, хүний эрхийн үндэсний байгууллага зэрэг хүний эрхийг хамгаалах чиг үүрэг бүхий хараат бус байгууллагуудад дараах бүрэн эрх олгогдсон байх явдлыг *хуульчлах*:

- Хөгжлийн бэрхшээлийнх нь улмаас алагчилж, эрхийг нь зөрчсөн хувь хүний буюу бүлэг этгээдийн гомдлыг хүлээн авах
- Гомдлын дагуу шалгалт хийх, дүгнэлт гаргах
- Олон хүний эрх ашгийг хөндсөн асуудлаар нэхэмжлэл гаргах, тийм нэхэмжлэлийг шийдвэрлэх бүрэн эрх олгогдсон байх, хохирлыг барагдуулах

Ихэнх улс орнууд дотоодын хууль тогтоомждоо хөгжлийн бэрхшээлтэй хүмүүст зориулсан байнгын (Хөгжлийн бэрхшээлтэй иргэний нийгмийн хамгааллын тухай хуулийн 5 дугаар зүйлд заасан унааны, эмчилгээний, утсан холбоо, орон байрны, амралт сувилал, түлээ, нүүрсний тусламж, хөнгөлөлтүүд нь хөгжлийн бэрхшээлтэй хүмүүст чиглэсэн байнгын тусгай арга хэмжээ юм.) болон түр тусгай арга хэмжээг (Хөдөлмөрийн тухай хуулийн 111 дүгээр зүйлд заасан ажлын байрны тодорхой хувьд хөгжлийн бэрхшээлтэй ажилтан ажиллуулах квот нь түр тусгай арга хэмжээ болно.) тусгасан байдаг. Олон улсын эрх зүйд урьд өмнө нь зарим бүлгийн хүмүүсийн эрхийг хангахад төрийн зүгээс ялгавартай хандаж байсны үр дагаврыг арилгах үүднээс нийгмийн бодлого, хууль тогтоомжийн хүрээнд тухайн бүлгийн хүмүүст тусгайлан анхаарал тавьж, үүссэн уршгийг багасгах зорилгоор авч хэрэгжүүлж байгаа арга хэмжээг дэмждэг бөгөөд ийм арга хэмжээ нь бусад хүмүүсийг алагчилж байгаа хэрэг биш болохыг хууль тогтоогч анхаарах нь зүйтэй.

ҮНДЭСНИЙ ХУУЛЬ ТОГТООМЖИД ТУСГАХ ГОЛ АСУУДЛУУД...

🔗 Хууль тогтоомж дараах үзэл санаанд тулгуурлах ёстой.

- Хөгжлийн бэрхшээл нь согог гэмтэл болон орчны хязгаарлалтаас үүдэн бий болдог.
- Хөгжлийн бэрхшээлтэй хүмүүс бусадтай адил тэгш байдлаар иргэний, улс төрийн, эдийн засгийн, нийгмийн болон соёлын бүх эрх, эрх чөлөөгөө эдлэх эрхтэй.

🔗 Төрийн, төрийн бус, хувийн хэвшлийн байгууллагууд хөгжлийн бэрхшээлтэй хүмүүст нийцэх орчин бүрдүүлээгүй нь тэднийг алагчилж, эрхийг нь зөрчиж байгаа хэлбэр мөн.

🔗 Хөгжлийн бэрхшээлтэй хүмүүс нийгмийн амьдралын бүхий л хүрээнд бүрэн дүүрэн оролцох явдлыг баталгаажуулах бөгөөд ялангуяа, дараах салбаруудад анхаарал хандуулна:

- Улс төр, олон нийтийн амьдралд (Конвенцийг хэрэгжүүлэх болон хөгжлийн бэрхшээлтэй хүмүүст хамааралтай хууль тогтоомж, бодлого, хөтөлбөр боловсруулахдаа тэдэнтэй зөвшилцөж байх)
- Соёлын амьдралд (Бүтээн туурвих, чөлөөт цагаа өнгөрүүлэхэд, спортын арга хэмжээнд оролцох)
- Бүх шатны боловсролд

🦿 Нийгмийн орчин, нийтийн тээврийн хэрэгсэл, технологи, мэдээлэл, харилцаа холбоо, нийтэд зориулсан байгууламж, үйлчилгээ хөгжлийн бэрхшээлтэй хүнд хүртээмжтэй байх явдлыг баталгаажуулна.

🦿 Хөгжлийн бэрхшээлтэй хүмүүсийн тэгш байдлыг бий болгоход чиглэгдсэн түр зуурын болон байнгын тусгай арга хэмжээнүүдийг тодорхойлох;

🦿 Хувь хүн, бүлэг этгээдүүд хөгжлийн бэрхшээлийнх нь улмаас алагчилсан гэж үзвэл эрхээ сэргээлгэхээр эрүү, иргэн, захиргааны хэрэг үүсгэх, хохирлоо нөхөн төлүүлэх боломжтой байх

🦿 Үндэсний хууль тогтоомжийн “Хөгжлийн бэрхшээлтэй хүн” гэсэн тодорхойлолт конвенцийн 2 дугаар зүйлд заасантай нийцэж байх;

🦿 Дэмжих арга замыг нь тодорхойлох, шаардлагатай хамгаалалт бий болгох замаар хөгжлийн бэрхшээлтэй хүний эрх зүйн этгээд байх, эрх зүйн чадамжаа хүлээн зөвшөөрүүлэх эрхийг баталгаажуулах;

🦿 Шүүх ажиллагааны бүхий л шатыг хөгжлийн бэрхшээлтэй хүний байдалд нийцүүлэх замаар хэргээ шударгаар шүүлгэх, хуулийн өмнө тэгш байх боломжийг бий болгох;

🦿 Конвенцийн хэрэгжилтийг хангах үндэсний тогтолцоог бий болгосон байх;

4.3 Конвенцийн хэрэгжилтийг хангах байгууллагууд

Конвенцийн хэрэгжилтэд хууль тогтоомжийн арга хэмжээ, хөрөнгө санхүүгийн хүчин зүйлээс гадна түүний хэрэгжилтийг хангах тогтолцоог бүрдүүлсэн байдал чухал. Конвенцийн 33 дугаар зүйлд заасны дагуу гэрээнд оролцогч улсууд конвенцийг хэрэгжүүлэх, хэрэгжилтэд нь хяналт тавих үүргийг дотоодын байгууллагууддаа хүлээлгэнэ. Тодруулбал, оролцогч улсууд нь:

🗣️ Засгийн газрынхаа бүтцэд конвенцийг хэрэгжүүлэх үүрэгтэй нэгж бий болгох буюу томилох

🗣️ Конвенцийг хэрэгжүүлэх үүднээс нийгмийн бүх салбарт, бүх түвшинд авч хэрэгжүүлж байгаа арга хэмжээг уялдуулан зохицуулах үүрэг бүхий нэгжийг Засгийн газрынхаа бүтцэд бий болгох буюу томилох

☺ Конвенцийн хэрэгжилтийг дэмжих, хяналт тавих үүрэг бүхий бие даасан, хараат бус байгууллагыг бий болгох буюу томилох. Гэхдээ конвенцид дээр дурдсан чиг үүргийг гүйцэтгэх байгууллагуудыг шууд нэрлэхээс зайлсхийж, зөвхөн тэдгээр байгууллагуудын хүрээг тодорхойлсон болохыг анхаарах нь зүйтэй.

Түүнчлэн, оролцогч улс орнууд иргэний нийгэм, ялангуяа хөгжлийн бэрхшээлтэй хүмүүсийн байгууллагад конвенцийн хэрэгжилтэд хяналт тавихад боломжийг бүрдүүлэх үүрэгтэй.

Улс орнууд конвенцийн хэрэгжилтэд хяналт тавих хараат бус байгууллагыг бий болгох буюу томилохдоо хүний эрхийг хамгаалах, хөхиүлэн дэмжих үндэсний байгууллагуудын үйл ажиллагаа, эрх зүйн байдлын талаарх зарчмуудыг анхааралдаа авах тухай конвенцийн 33 дугаар зүйлд заасан. “Хүний эрхийг хамгаалах, хөхиүлэн дэмжих үндэсний байгууллагуудын үйл ажиллагаа, эрх зүйн байдлын талаарх зарчмууд” 1991 онд Франц улсын Парис хотноо зохион байгуулагдсан хүний эрхийн үндэсний байгууллагуудын уулзалтаас батлагдсан тул олон улсын хэмжээнд эдгээр зарчмуудыг “Парисын” хэмээн нэрлэж заншжээ. 1993 онд Парисын зарчмуудыг НҮБ-ын Ерөнхий Ассамблейгаар хэлэлцэж хүлээн зөвшөөрчээ. Парисын зарчмаар хүний эрхийн хэрэгжилтэд хяналт тавих, хөхиүлэн дэмжих, хамгаалах чиг үүрэг бүхий хараат бус байгууллагуудын үйл ажиллагааны цар хүрээ, зарчмыг тодорхойлсон байдаг.

2000 онд Улсын Их Хурлаас Монгол Улсын Хүний эрхийн үндэсний комиссын тухай хуулийг батлан гаргасан бөгөөд энэ хууль нь дээр дурдсан Парисын зарчимд тулгуурласан юм. Конвенцид заасны дагуу хараат бус байгууллага нь конвенцийн хэрэгжилтийг хөхиүлэн дэмжих (конвенцийн талаарх олон нийтийн мэдлэг ойлголтыг нэмэгдүүлэх), хамгаалах (конвенциор баталгаажуулсан эрх, эрх чөлөө зөрчигдсөн тухай хувь хүмүүсийн гомдлыг хүлээн авах, шийдвэрлэх, тэднийг төлөөлж шүүхэд хандах), хяналт тавих (хөгжлийн бэрхшээлтэй хүмүүсийн талаарх хууль тогтоомж, нөхцөл байдалд дүн шинжилгээ хийх) ёстой. Хараат бус байгууллагын талаарх конвенцид заасан шаардлага Монгол Улсын Хүний эрхийн үндэсний комиссын тухай хуулиар тус байгууллагад олгогдсон бүрэн эрхтэй нийцэж байгаа юм.

Үүний зэрэгцээ, хөгжлийн бэрхшээлтэй хүмүүсийн эрхийн хамгаалахад шүүхийн үүргийг конвенцид чухалчлан авч үзсэн. Үндсэн хуулийн 10 дугаар зүйлийн 10.3-т “Монгол Улсын олон улсын гэрээ нь соёрхон баталсан буюу нэгдэн орсон тухай хууль хүчин төгөлдөр болмогц дотоодын хууль тогтоомжийн нэгэн адил үйлчилнэ” гэж заасан тул Хөгжлийн бэрхшээлтэй хүмүүсийн эрхийн тухай конвенцийг Улсын Их Хурлаас соёрхон баталсан тохиолдолд шүүх түүнийг дотоодын хууль тогтоомжийн нэгэн адил хэрэглэх боломжтой болно. Үүний зэрэгцээ, шүүх хөгжлийн бэрхшээлтэй хүмүүсийн эрхийн талаарх дотоодын хууль тогтоомжийг тайлбарлах, хэрэглэхэд Хөгжлийн бэрхшээлтэй хүмүүсийн эрхийн тухай конвенцийн зорилго, зарчмын үүднээс хандах ёстой болох юм.

КОНВЕНЦИЙГ ХЭРЭГЖҮҮЛЭХ ҮҮРЭГТЭЙ БАЙГУУЛЛАГА ЯМАР АРГА ХЭМЖЭЭ АВАХ ВЭ?

᠘ Төр, засгийн газрын тэргүүн, шийдвэр гаргагчдад хөгжлийн бэрхшээлтэй хүмүүсийн талаар хууль тогтоох, бодлого, хөтөлбөр боловсруулахад нь мэргэжил, арга зүйн дэмжлэг үзүүлэх;

᠘ Яам, агентлагууд, төрийн бусад байгууллагуудаас хөгжлийн бэрхшээлтэй хүний талаар явуулж буй үйл ажиллагааг нь уялдуулан зохицуулах;

᠘ Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгжийн түвшинд зохион байгуулагдаж байгаа ажлуудыг уялдуулан зохицуулах;

᠘ Хөгжлийн бэрхшээлтэй хүмүүсийн эрхийн талаарх бодлого, хөтөлбөрүүдийн хэрэгжилтэд хяналт тавих;

᠘ Шинэ хуулийн төсөл, хуульд оруулах нэмэлт өөрчлөлтийн төслийг боловсруулах;

᠘ Засгийн газрын хэмжээнд конвенци болон нэмэлт протоколыг сурталчлах;

᠘ Конвенци болон нэмэлт протоколыг эх хэл дээрээ орчуулж, хөгжлийн бэрхшээлтэй хүнд хүртээмжтэй хэв маягаар хэвлүүлэн, нийтийн хүртээл болгох, энэ ажилд тогтмол хяналт тавих;

᠘ Конвенцийг соёрхон батлах үйл ажиллагааны төлөвлөгөө боловсруулж, хэрэгжүүлэх;

᠘ Конвенцийг хэрэгжүүлэх үйл ажиллагааны төлөвлөгөө боловсруулж, хэрэгжүүлэх;

᠘ Хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн талаарх төрийн бусад бодлого, хөтөлбөрийн хэрэгжилтэд хяналт тавих;

᠘ Засгийн газрын тайлан илтгэлийг боловсруулах ажлыг уялдуулан зохицуулах;

᠘ Хөгжлийн бэрхшээлтэй хүний эрхийн талаарх олон нийтийн мэдлэг ойлголтыг нэмэгдүүлэхэд чиглэсэн арга хэмжээ авах;

᠘ Засгийн газрын түвшинд хөгжлийн бэрхшээлийн асуудал хариуцах чадавхыг дээшлүүлэх;

᠘ Конвенцийн хэрэгжилтийг үнэлэхэд шаардлагатай тоон мэдээлэл, баримтыг цуглуулах;

᠘ Хөгжлийн бэрхшээлтэй хүмүүст хамаарах бодлого, хууль тогтоомжийг боловсруулахад тэдгээр хүмүүсийн оролцоог дэмжих;

᠘ Хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн чиглэлээр ажилладаг иргэний нийгмийн байгууллагуудыг дэмжих;

ХӨГЖЛИЙН БЭРХШЭЭЛТЭЙ ХҮМҮҮСИЙН ЭРХИЙН ТУХАЙ КОНВЕНЦ

Удиртгал

Энэхүү конвенцид оролцогч улсууд,

(а) Нэгдсэн үндэсний Байгууллагын дүрэмд тунхагласан зарчмын дагуу хүн төрөлхтний ам бүлийн гишүүн бүхэнд угаас заяасан нэр төр болон тэдний адил тэгш, салшгүй эрхийг хүлээн зөвшөөрөх нь эрх чөлөө, шударга ёс, бүх нийтийн энх тайвны иш үндэс мөн болохыг эргэн санаж,

(b) Хүний эрхийн түгээмэл тунхаглал болон Хүний эрхийн олон улсын пактуудад заасан бүх эрх, эрх чөлөөг хүн бүр ямар нэг ялгаваргүй эдлэх эрхтэй гэдгийг Нэгдсэн үндэсний Байгууллага тэдгээр баримт бичигт тунхаглан баталгаажуулсныг эргэн санаж,

(c) хүний бүх эрх, үндсэн эрх чөлөө нь түгээмэл, хуваагдашгүй, биеэ даасан, өөр хоорондоо харилцан хамааралтай болон хөгжлийн бэрхшээлтэй хүн эдгээрийг ямар нэг алагчилалгүй, бүрэн дүүрэн эдлэх явдлыг баталгаажуулах шаардлагатай байгааг дахин нотолж,

(d) Эдийн засаг, нийгэм, соёлын эрхийн тухай олон улсын пакт, Иргэний болон улс төрийн эрхийн тухай олон улсын пакт, Арьс үндсээр алагчилах үзлийн бүх хэлбэрийг устгах тухай олон улсын конвенц, Эмэгтэйчүүдийг алагчилах бүх хэлбэрийг устгах тухай олон улсын конвенц, Эрүүдэн шүүх болон бусад хэлбэрээр хэрцгий, хүнлэг бусаар буюу хүний нэр төрийг доромжлон харьцаж, шийтгэхийн эсрэг конвенц, Хүүхдийн эрхийн тухай конвенц, Бүх цагаач ажилчин, тэдний гэр бүлийн гишүүдийг хамгаалах тухай олон улсын конвенцийг эргэн санаж,

(e) хөгжлийн бэрхшээл гэдэг нь өөрчлөгдөн хувьсаж байдаг ойлголт бөгөөд нийгмийн амьдралд бусдын нэгэн адил бүрэн дүүрэн чөлөөтэй оролцоход саад тотгор учруулахуйц бие эрхтний согог, нийгмийн хандлагын болон орчны хязгаарлалтаас үүдэн бий болж байгаа гэдгийг хүлээн зөвшөөрч,

(f) хөгжлийн бэрхшээлтэй хүмүүст тэгш боломж олгох явдлыг дээшлүүлэхэд чиглэсэн үндэсний, бүс нутгийн болон олон улсын хэмжээний бодлого, хөтөлбөр, төлөвлөгөөг боловсруулах, тодорхойлох, үнэлэлт дүгнэлт өгөхөд Хөгжлийн бэрхшээлтэй хүмүүсийн тухайд хэрэгжүүлэх үйл ажиллагааны дэлхийн хөтөлбөр болон Хөгжлийн бэрхшээлтэй хүнд тэгш боломж олгох стандарт, дүрэм журамд заасан зарчим, бодлогын удирдамжийн ач холбогдлыг хүлээн зөвшөөрч,

g) хөгжлийн бэрхшээлтэй хүмүүсийн асуудлыг тогтвортой хөгжлийн зохих стратегийн бүрэлдэхүүн хэсэг болгох зайлшгүй шаардлагатайг онцлон тэмдэглэж,

(h) хүнийг хөгжлийн бэрхшээлээс нь шалтгаалан алагчилах нь угаас заяасан хувь хүний нэр төр болон нандин чанарыг үгүйсгэж буй явдал гэдгийг мөн хүлээн зөвшөөрч,

(i) түүнчлэн хөгжлийн бэрхшээлтэй хүмүүсийн ялгаатай байдлыг хүлээн зөвшөөрч,

(j) нэн түрүүн дэмжлэг үзүүлэх шаардлагатай байгаа хүмүүсийг оролцуулан хөгжлийн бэрхшээлтэй бүх хүний эрхийг хамгаалах, хөхиүлэн дэмжих хэрэгцээ байгааг хүлээн зөвшөөрч,

(k) төрөл бүрийн баримт бичиг баталж, үүрэг хүлээлгэсэн хэдий ч дэлхийн аль ч өнцөг буланд тэдгээр хүний эрх зөрчигдөж, нийгмийн амьдралд бусадтай адил тэгш оролцоход саад учирсаар байгаад сэтгэл гүнээ зовниж,

(l) орон бүрд, ялангуяа хөгжиж буй орнуудын хувьд хөгжлийн бэрхшээлтэй хүмүүсийн амьдралын нөхцөлийг дээшлүүлэхэд олон улсын хамтын ажиллагаа чухал болохыг хүлээн зөвшөөрч,

(m) бүх нийтийн сайн сайхан хийгээд тухайн хүрээн дэх ялгаатай байдалд хүний эрх, эрх чөлөөг бүрэн дүүрэн эдлүүлэх явдлыг дэмжих нөхцөлд хөгжлийн бэрхшээлтэй хүмүүсийн зүгээс өнөө үед оруулж буй үнэт, зохих хувь нэмэр, түүнчлэн хөгжлийн бэрхшээлтэй хүмүүсийг бүрэн дүүрэн оролцуулснаар тэдний нийгмийн оролцооны мэдрэмжийг дээшлүүлж хүний, нийгмийн, эдийн засгийн хөгжил дэвшилд мэдэгдэхүйц амжилт олон ядуурлыг бууруулах боломжтой гэдгийг хүлээн зөвшөөрч,

(n) хөгжлийн бэрхшээлтэй хүмүүсийн хувьд сонголтоо чөлөөтэй хийх эрхийг оролцуулан хувийн бие даасан, хараат бус байдал чухал гэдгийг хүлээн зөвшөөрч,

(o) хөгжлийн бэрхшээлтэй хүмүүс тэднийг шууд хамаарах болон бусад төрлийн хөгжлийн бодлого, хөтөлбөр боловсруулах, шийдвэр гаргах түвшинд хүрч ажиллах боломжоор хангагдсан байх ёстойг харгалзан үзэж,

(p) хөгжлийн бэрхшээлтэй хүмүүс нь арьс үндэс, арьсны өнгө, хүйс, хэл, шашин шүтлэг, улс төрийн болон бусад үзэл бодол, үндэс угсаа, гарал үүсэл, нийгмийн гарал, өмч хөрөнгө, төрсөн байдал, нас болон бусад байдлаараа давхар болон хүнд хэлбэрийн алагчилалд өртөх хэцүү нөхцөл байсаар байгаад сэтгэл гүнээ зовниж,

(q) хөгжлийн бэрхшээлтэй эмэгтэйчүүд, охид нь хүчирхийлэл, осол гэмтэл, доромжлол, үл тоомсорлол, хайхрамжгүй харьцаа, хэрцгийлэл, мөлжлөгт өрх гэрийнхээ дотор, гадна хаана ч өртөж болзошгүй туйлын эрсдэлтэй байдалд амьдарч байгааг хүлээн зөвшөөрч,

(r) Хүүхдийн эрхийн тухай конвенцид оролцогч улсуудын хүлээсэн үүргийг эргэн санахын хамт хөгжлийн бэрхшээлтэй хүүхдүүд нь бусад хүүхдийн нэгэн адил хүний эрх, үндсэн эрх чөлөөгөө бүрэн дүүрэн эдлэх учиртайг хүлээн зөвшөөрч,

(s) хөгжлийн бэрхшээлтэй хүмүүст хүний эрх, үндсэн эрх чөлөөг бүрэн дүүрэн эдлүүлэх явдлыг хөхиүлэн дэмжихдээ жендэрийн асуудлыг бүх талаар харгалзан үзэх шаардлагатайг цохон тэмдэглэж,

(t) хөгжлийн бэрхшээлтэй ихэнх хүн ядуу нөхцөлд амьдарч байгааг тэмдэглэж, үүнтэй холбоотойгоор хөгжлийн бэрхшээлтэй хүмүүст сөрөг нөлөө үзүүлж буй ядуурлын асуудлыг шийдвэрлэх нэн шаардлагатай гэдгийг хүлээн зөвшөөрч,

(u) Нэгдсэн үндэсний Байгууллагын дүрэмд заасан зорилго, зарчмыг бүрнээ хүндэтгэх сахиж, хөгжлийн бэрхшээлтэй хүмүүсийг бүрэн дүүрэн хамгаалахад нэн чухал хүний эрхийн баримт бичгүүдийг бүхий л нөхцөл байдалд, ялангуяа зэвсэгт мөргөлдөөн болон гадаад улсын түрэмгийллийн үед ч дагаж мөрдөх нь энх тайван, аюулгүй байдлын гол нөхцөл мөн болохыг анхааралдаа авч,

(v) хөгжлийн бэрхшээлтэй хүмүүс биеийн, нийгмийн, эдийн засгийн, соёлын орчинд, эрүүл мэнд, боловсрол, мэдээлэл, харилцаа холбооны үйлчилгээг хүртсэнээр хүний бүхий л эрх, үндсэн эрх чөлөөг бүрэн дүүрэн эдлэхэд чухал болохыг хүлээн зөвшөөрч,

(w) аливаа хувь хүн өөрийг нь харьяалах нийгэмлэг болон бусад хүний өмнө үүрэг хүлээснээр Хүний эрхийн тухай олон улсын биллд заасан хүний эрхийг хөхиүлэн дэмжиж сахин биелүүлнэ гэдгийг анхааралдаа авч,

(x) гэр бүл бол хүний мөн чанараас урган гарсан, нийгмийн үндсэн нэгж бөгөөд нийгэм, төрийн хамгаалалтанд байх эрхтэй хийгээд хөгжлийн бэрхшээлтэй хүмүүс эрхээ бүрэн дүүрэн, тэгш эдлэх нөхцөлийг бий болгох үүднээс хөгжлийн бэрхшээлтэй хүмүүс, тэдний гэр бүлийн гишүүд тусламж дэмжлэг хүртэх, шаардлагатай хамгаалалтад байх ёстойд итгэл төгс байж,

(y) хөгжлийн бэрхшээлтэй хүний эрх, эрх чөлөө, нэр төрийг хамгаалах, хөхиүлэн дэмжих өргөн хүрээтэй бөгөөд суурь олон улсын конвенцийг батлан гаргах нь хөгжлийн бэрхшээлтэй хүмүүсийн өмнө тулгарч буй нийгмийн сөрөг нөлөөллийг арилгах болон хөгжингүй, хөгжиж байгаа аль ч оронд тэдгээр хүмүүс бусдын нэгэн адил иргэний, улс төрийн, эдийн засгийн бүхий л хүрээнд оролцох явдлыг дэмжихэд чухал хувь нэмэр оруулна гэдэгт итгэл төгс байж, дараахь зүйлийг хэлэлцэн тохиров:

1 дүгээр зүйл

Зорилго

Энэхүү конвенцийн зорилго нь хөгжлийн бэрхшээлтэй бүх хүн хүний бүх эрх, үндсэн эрх чөлөөг бүрэн дүүрэн эдлэх явдлыг хангах, хамгаалах, хөхиүлэн дэмжих, түүнчлэн тэдний нэр төр, нандин чанарыг хүндэтгэн дэмжихэд оршино.

Хөгжлийн бэрхшээлтэй хүн гэдэгт бие махбодь, оюун санаа, сэтгэл мэдрэл, мэдрэхүйн байнгын согогтой бөгөөд уг согог нь бусад төрлийн бэрхшээлтэй нэгдэн нийлсний улмаас бусдын нэгэн адил нийгмийн амьдралд бүрэн дүүрэн, үр дүнтэй оролцоход нь саад учруулахуйц болсон этгээдийг хэлнэ.

2 дугаар зүйл

Тодорхойлолт

Энэхүү конвенцийн зорилгод:

“Харилцаа” гэж хэл яриа, эх бичвэрийн үзүүлэн, брайль болон тактил хэл, том үсгээр хэвлэгдсэн ойлгоход хялбар мультимедиа хэлбэртэй тоног төхөөрөмж, тухайлбал хэвлэмэл төхөөрөмж, аудио тоног төхөөрөмж, ердийн хэл яриа, ярьдаг ном, түүнчлэн эдгээрийг томруулсан болон орлуулсан аргачлал, харилцаа, түүний дотор мэдээлэл харилцааны технологид нэвтрэх бусад хэрэгслийг хэлнэ;

“Хэл яриа” гэдэгт ярианы болон бичгийн хэл, түүнчлэн ярианы бус бусад төрлийн хэлийг хэлнэ;

“Хөгжлийн бэрхшээлийн улмаас алагчилах” гэж улс төр, эдийн засаг, нийгэм, соёл, иргэний болон бусад салбарт хүний эрх, үндсэн эрх чөлөөг бусадтай адил тэгш байх үндсэн дээр эдлэх явдлыг хөгжлийн бэрхшээлээс нь шалтгаалан сулруулах буюу ийм эрхийг хүлээн зөвшөөрөхийг үгүйсгэх зорилго агуулсан, эсхүл тийм үр дүнд хүргэсэн бүх төрлийн алагчилал, гадуурхалт, хязгаарлалтыг хэлнэ. Энэ нь алагчиллын бүх хэлбэр, түүний дотор тохирох хэрэглэгдэхүүнээс татгалзах явдал мөн хамаарна;

“Боломжит хэрэглэгдэхүүн” гэж тодорхой тохиолдолд хөгжлийн бэрхшээлтэй хүн бусдын нэгэн адил хүний бүх эрх, үндсэн эрх чөлөөг эдлэх явдлыг хангах үүднээс зохицоогүй, эсхүл үндэслэлгүй саад тотгорыг арилгах, багасгахад чиглэгдсэн нэн хэрэгцээтэй бөгөөд шаардлагатай тохируулга хийх болон өөрчилж засварлахыг хэлнэ;

“Түгээмэл загвар” гэж ямарваа нэгэн нэмэлт тохиргоо, тусгай загвар шаардагдахгүйгээр бүх хүн ашиглахад хамгийн дээд зэргээр тохиромжтой байж болох бүтээгдэхүүн, байрлал, програм болон үйлчилгээний хэв маягийг хэлнэ. Түгээмэл загварт хөгжлийн бэрхшээлтэй хүмүүс шаардлагатай тохиолдолд хэрэглэх туслах хэрэгслүүдийг орхигдуулахгүй.

3 дугаар зүйл

Нийтлэг зарчмууд

Энэхүү конвенцийн зарчмууд нь:

а) сонголт хийх эрх чөлөө болон хүний бие даасан байдлыг оролцуулан хүний нэр төр, нандин чанар, хувийн хараат бус байдлыг хүндэтгэх;

b) алагчилахгүй байх;

c) нийгэмд бүрэн дүүрэн, үр дүнтэй оролцох болон хамрагдах;

d) хөгжлийн бэрхшээлтэй хүмүүсийн онцлог байдлыг хүндэтгэх, тэднийг хүний ялгаатай байдал, хүн төрөлхтний нэг хэсэг гэж хүлээн авах;

e) тэгш боломж олгох;

f) хүртээмжтэй байх;

g) эрэгтэй, эмэгтэйчүүдийн тэгш эрхтэй байх;

h) хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийн хувьсаж өөрчлөгдөх чадамжийг хүндэтгэх болон хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийн өөрийн онцлог байдлаа хадгалах эрхийг хүндэтгэх хандах.

4 дүгээр зүйл

Нийтлэг үүргүүд

1. Хөгжлийн бэрхшээлтэй хүмүүст хөгжлийн бэрхшээлээс нь шалтгаалан алагчлалгүйгээр хүний бүх эрх, үндсэн эрх чөлөөг бүрэн дүүрэн эдлүүлэх явдлыг оролцогч улсууд хангаж, хөхиүлэн дэмжих үүрэг хүлээнэ. Эл зорилгоор оролцогч улсууд дараахь үүрэг хүлээнэ:

a) энэхүү конвенцид заасан эрхийг эдлүүлэхийн тулд хууль тогтоох, захиргааны болон холбогдох бусад арга хэмжээ авна;

b) хөгжлийн бэрхшээлтэй хүмүүсийг алагчилах явдлыг үүсгэж байгаа бүхий л хууль тогтоомж, дүрэм журам, зан заншил, уламжлалыг арилгах, өөрчлөх бүхий л зохистой арга хэмжээг авна;

c) төрийн бүх бодлого, хөтөлбөрт хөгжлийн бэрхшээлтэй хүний эрхийг хамгаалах, хөхиүлэн дэмжих явдлыг тусгана;

d) энэхүү конвенцид үл нийцэх үйлдэл, эсхүл дадал зуршил гаргахаас татгалзаж, төрийн эрх бүхий албан тушаалтан, байгууллагыг энэхүү конвенцид нийцсэн үйл ажиллагаа хэрэгжүүлэх явдлыг хангана;

e) аливаа этгээд, байгууллага, хувийн хэвшлийн аж ахуйн нэгжийн зүгээс хүнийг хөгжлийн бэрхшээлийн улмаас алагчилах явдлыг устгахад чиглэгдсэн шаардлагатай бүхий л арга хэмжээг авна;

f) хөгжлийн бэрхшээлтэй хүмүүсийн тусгай хэрэгцээг хангахад чиглэсэн аль болох хамгийн бага тохируулга шаардагдах бөгөөд хамгийн бага үнэ өртөгтэй энэхүү конвенцийн 2 дугаар зүйлд тодорхойлсон түгээмэл загвар бүхий бараа, үйлчилгээ, тоног төхөөрөмж болон хэрэгслийг зохион бүтээх, боловсруулах, энэ талаар судалгаа шинжилгээ хийхийг хөхиүлэн дэмжих, тэдгээрийг ашиглахад дэмжлэг үзүүлэх, түүнчлэн стандарт, гарын авлагыг боловсруулахдаа түгээмэл загварыг тусгуулах явдлыг дэмжинэ;

g) хөгжлийн бэрхшээлтэй хүнд тохирсон, юуны өмнө өртгийн хувьд хямд шинэ технологи, түүний дотор мэдээлэл харилцааны технологи, хөдөлгөөн хөнгөвчлөх хэрэгсэл, тоног төхөөрөмж болон туслах технологийг боловсруулах, энэ талаар судалгаа шинжилгээ хийхийг хөхиүлэн дэмжих;

h) хөдөлгөөн хөнгөвчлөх хэрэгсэл, тоног төхөөрөмж болон туслах технологи, ялангуяа шинэ технологи, тусламж үзүүлэх бусад хэлбэр, нэмэлт үйлчилгээ болон объектын талаархи мэдээллийг хөгжлийн бэрхшээлтэй хүнд хүртээмжтэй болгох;

i) туслалцаа, үйлчилгээг сайжруулах үүднээс энэхүү конвенцид заасан эрхийг эдлэхэд нь хөгжлийн бэрхшээлтэй хүмүүстэй харьцаж ажилладаг мэргэжилтнүүд, ажилтнуудыг сургах ажлыг дэмжих.

2. Эдийн засаг, нийгэм, соёлын эрхийн тухайд эдгээр эрхийг бүрэн дүүрэн эдлүүлэх нөхцөл байдлыг аажмаар бий болгох үүднээс оролцогч улс бүр олон улсын эрх зүйн дагуу нэн даруй үүсэх энэхүү конвенцоор хүлээлгэсэн үүрэгтэй үл харшлах байдлаар өөрийн боломжит нөөцийг дээд хэмжээгээр ашиглах бөгөөд шаардлагатай тохиолдолд олон улсын хамтын ажиллагаанд түшиглэнэ.

3. Энэхүү конвенцийг хэрэгжүүлэхэд чиглэсэн хууль тогтоомж, бодлого хөтөлбөрийг боловсруулж мөрдөх, хөгжлийн бэрхшээлтэй хүмүүстэй холбоотой бусад шийдвэрийг гаргахдаа оролцогч улсууд хөгжлийн бэрхшээлтэй хүмүүс, түүний дотор хөгжлийн бэрхшээлтэй хүүхдүүдтэй зөвлөлдөх бөгөөд тэднийг төлөөлөх байгууллагаар дамжуулан тэднийг идэвхтэй оролцуулна.

4. Энэхүү конвенцийн аль ч заалт нь хөгжлийн бэрхшээлтэй хүнд эрхээ элдэх давуу боломж олгосон аливаа улсын дотоодын хууль тогтоомж, эсхүл тухайн улсын хувьд хүчин төгөлдөр олон улсын эрх зүйн хэм хэмжээг хэрэгжүүлэх явдалд нөлөө үзүүлэхгүй. Энэхүү конвенцид оролцогч аливаа улсын хууль тогтоомж, конвенц, дүрэм журам, зан заншлаар хүлээн зөвшөөрсөн буюу хэрэгжүүлж байгаа хүний аливаа эрх, үндсэн эрх чөлөөг энэхүү конвенцид тэдгээр эрх, эрх чөлөөг хүлээн зөвшөөрөөгүй буюу доогуур хэмжээгээр хүлээн зөвшөөрсөн гэх шалтгаанаар хязгаарлах буюу бууруулж болохгүй.

5. Энэхүү конвенцийн заалт бүхэн холбооны улсын хувьд бүх нутаг дэвсгэрт ямарваа нэгэн ялгаа, хязгаарлалтгүй үйлчилнэ.

5 дугаар зүйл

Адил тэгш байдал, үл алагчилал

1. Хүн бүр хуулийн өмнө адил тэгш бөгөөд хуулиар ямарваа нэгэн алагчилалгүйгээр тэгш хамгаалуулж, адил ашиг хүртэх эрхтэй болохыг оролцогч улсууд хүлээн зөвшөөрнө.

2. Оролцогч улсууд нь хүнийг хөгжлийн бэрхшээлийн улмаас бүх хэлбэрээр алагчилах явдлыг хориглох бөгөөд хөгжлийн бэрхшээлтэй хүмүүсийг ямарваа хэлбэрийн алагчилалд өртөхөөс хамгаалах адил тэгш, үр дүнтэй хууль зүйн хамгаалалтыг бий болгоно.

3. Тэгш байдлыг хөхиүлэн дэмжих, алагчиллыг устгах үүднээс оролцогч улсууд нь боломжит зохицлыг хангах бүхий л алхмыг хийнэ.

4. Хөгжлийн бэрхшээлтэй хүний тэгш байдлыг *de facto* хангах, ийм байдлыг бий болгоход чиглэсэн зайлшгүй шаардлагатай тусгай арга хэмжээнүүдийг энэхүү конвенцийн агуулгад алагчилал гэж үзэхгүй.

6 дугаар зүйл

Хөгжлийн бэрхшээлтэй эмэгтэйчүүд

1. Оролцогч улсууд хөгжлийн бэрхшээлтэй эмэгтэйчүүд, хөгжлийн бэрхшээлтэй охид нь давхар алагчилалд өртөж болзошгүй гэдгийг хүлээн зөвшөөрч, үүнтэй холбогдуулан тэдэнд хүний бүх эрх, үндсэн эрх чөлөөг бүрэн дүүрэн, адил тэгш эдлүүлэхэд чиглэсэн арга хэмжээ авна.

2. Оролцогч улсууд нь энэхүү конвенцид заасан хүний эрх, үндсэн эрх чөлөөг эдлүүлэх явдлыг баталгаажуулах зорилгоор эмэгтэйчүүдийг бүх талаар хөгжүүлэх, аж байдлыг нь дээшлүүлэх болон эмэгтэйчүүдийн эрх боломжийг нэмэгдүүлэхэд чиглэсэн зохих бүхий л арга хэмжээг авна.

7 дугаар зүйл

Хөгжлийн бэрхшээлтэй хүүхдүүд

1. Оролцогч улсууд нь хөгжлийн бэрхшээлтэй хүүхдүүдэд бусад хүүхдийн нэгэн адил хүний бүх эрх, үндсэн эрх чөлөөг бүрэн дүүрэн эдлүүлэх явдлыг хангах бүхий л шаардлагатай арга хэмжээ авна.

2. Хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийн талаар арга хэмжээ авч хэрэгжүүлэхдээ хүүхдийн ашиг сонирхлыг нэн түрүүн харгалзан үзнэ.

3. Оролцогч улсууд хөгжлийн бэрхшээлтэй хүүхдүүдэд бусад хүүхдийн нэгэн адил нь өөрсдийн нас болон биеийн онцлогт тохирсон байдлаар өөрт нь хамаарах аливаа асуудлаар үзэл бодлоо чөлөөтэй илэрхийлэх эрхийг эдлүүлэх бөгөөд энэхүү эрхээ эдлэхэд нь хөгжлийн бэрхшээл болон насны онцлогт тохирсон туслалцаа үзүүлэх явдлыг хангана.

8 дугаар зүйл

Мэдлэг, ойлголтыг дээшлүүлэх

1. Оролцогч улсууд нь дараахь үр дүнтэй, холбогдох арга хэмжээг нэн түрүүн авах үүрэгтэй:

а) хөгжлийн бэрхшээлтэй хүмүүсийн талаархи мэдлэг ойлголтыг нийгмийн бүх хүрээ, ялангуяа гэр бүлийн хүрээнд нэмэгдүүлэх, хөгжлийн бэрхшээлтэй хүний нэр төр, нандин чанарыг хүндэтгэх явдлыг бэхжүүлэх;

б) амьдралын бүх үе шатанд хөгжлийн бэрхшээлтэй хүний хувьд хор уршигтай, хохирол учруулахуйц, ялангуяа нас, хүйс зэрэгт үндэслэсэн дадал зуршлыг бий болгохуйц нийгэмд тогтсон хэв маягтай тэмцэх;

с) хөгжлийн бэрхшээлтэй хүний чадавхи, тэдний оруулж буй хувь нэмрийн талаархи мэдлэг ойлголтыг нэмэгдүүлэх.

2. Эдгээр арга хэмжээ нь дараахь төрөлтэй байж болно:

а) дараахь төрлийн үр нөлөөтэй олон нийтэд чиглэгдсэн мэдлэг ойлголтыг нэмэгдүүлэх олныг хамарсан ажлыг санаачилж, зохион байгуулах:

(i) хөгжлийн бэрхшээлтэй хүний эрхийг хүлээн зөвшөөрөх байдлыг бий болгох;

(ii) хөгжлийн бэрхшээлтэй хүний талаар эерэг ойлголт, нийгмийн зөв хандлагыг тогтоохыг дэмжих;

(iii) хөгжлийн бэрхшээлтэй хүний ур чадвар, авьяас билиг, чадавхи, түүнчлэн ажлын байр болон хөдөлмөрийн зах зээл дээр тэдний оруулж буй хувь нэмрийг хүлээн зөвшөөрүүлэх явдалд дэмжлэг үзүүлэх.

б) боловсролын тогтолцооны бүхий л түвшин, ялангуяа бүх хүүхдэд бага наснаас эхэлж хөгжлийн бэрхшээлтэй хүний эрхийг хүндэтгэх хандлагыг төлөвшүүлэх;

с) бүх төрлийн хэвлэл мэдээллийн байгууллагууд хөгжлийн бэрхшээлтэй хүнийг энэхүү конвенцийн зорилгод нийцүүлэн дүрслэн харуулахыг дэмжих;

д) хөгжлийн бэрхшээлтэй хүмүүс болон хөгжлийн бэрхшээлтэй хүмүүсийн эрхийн талаархи танин мэдэхүй, сурталчилгааны ажлыг хөхиүлэн дэмжих.

9 дүгээр зүйл

Хүртээмж

1. Хөгжлийн бэрхшээлтэй хүмүүс бие даан амьдрах, амьдралын бүхий л хүрээнд бүрэн дүүрэн оролцох боломжийг бий болгох зорилгоор оролцогч улсууд нь хөдөө орон нутаг, хот суурин газрын хаана ч хөгжлийн бэрхшээлтэй хүмүүсийг бусдын нэгэн адил өөрийг нь хүрээлэн буй орчин, тээвэр, мэдээлэл, харилцаа холбоо тухайлбал, мэдээлэл харилцаа холбооны технологи, систем болон нийтэд нээлттэй үйлчлэх буюу зориулагдсан бусад төрлийн объект, үйлчилгээг хүртэх явдлыг хангахад чиглэсэн зохих арга хэмжээ авна. Хүртээмжтэй байх явдалд учруулж буй саад, тотгорыг илрүүлэх, устгахад чиглэсэн эдгээр арга хэмжээг *inter alia* дараахь газарт авна:

а) барилга байшин, зам, тээвэр болон сургууль, орон сууцны байр, эмнэлгийн газар, ажлын байр зэрэг бүх төрлийн доторхи болон гаднах байгууламж;

б) мэдээлэл, харилцаа холбооны болон бусад төрлийн үйлчилгээ тухайлбал, түргэн тусламжийн болон цахим үйлчилгээ.

2. Түүнчлэн оролцогч улсууд нь дараахь шаардлагатай арга хэмжээг авна:

а) нийтэд нээлттэй үйлчлэх буюу зориулагдсан объект, үйлчилгээг хүртээмжтэй байлгахад чиглэсэн наад захын стандарт, гарын авлагыг боловсруулж мөрдүүлэх, хэрэгжилтэд нь хяналт тавих;

б) нийтэд нээлттэй үйлчлэх буюу зориулагдсан объект, үйлчилгээг эрхэлдэг хувийн хэвшлийн байгууллагууд хөгжлийн бэрхшээлтэй хүмүүст хүртээмжтэй байдлыг бий болгох бүхий л хүчин зүйлийг харгалзан үзэх явдлыг хангах ;

с) хөгжлийн бэрхшээлтэй хүмүүсийн өмнө тулгарч буй хүртээмжийн асуудлаар холбогдох талуудад зориулсан сургалт зохион байгуулах;

д) нийтэд нээлттэй үйлчлэх байшин барилга, бусад байгууламжид брайль үсгээр буюу хялбар уншигдах, ойлгогдохуйц байдлаар тэмдэг, тэмдэглэгээ хийх;

е) нийтэд нээлттэй үйлчлэх байшин барилга, бусад байгууламжийн хүртээмжтэй байдлыг дээшлүүлэх үүднээс хүний туслалцаа, зуучлалын хэлбэрүүд, тухайлбал, хөтөч, уншигч, дохионы хэлний мэргэжлийн орчуулагчийг бий болгох;

f) хөгжлийн бэрхшээлтэй хүмүүст мэдээлэл хүлээн авах хүртээмжийг нэмэгдүүлэхэд чиглэсэн дэмжлэг, туслалцаа үзүүлэх зохих хэлбэрийг хөхиүлэн дэмжих;

g) хөгжлийн бэрхшээлтэй хүмүүс мэдээлэл, харилцаа холбооны шинэ технологи, систем, үүний дотор интернэтийг хэрэглэх боломжийг нэмэгдүүлэх;

h) хүртээмжтэй мэдээлэл, харилцаа холбооны технологи, системийн загварыг зохиох, сайжруулах, үйлдвэрлэх, түгээн борлуулахдаа эхний ээлжинд эдгээр технологи, системийг байж болох хамгийн хямд өртөгтэй байх явдлыг хангах.

10 дугаар зүйл

Амьд явах эрх

Оролцогч улсууд нь хүн бүр амьд явах салшгүй эрхтэй гэдгийг дахин нотолж, хөгжлийн бэрхшээлтэй хүмүүс бусдын нэгэн адил энэ эрхээ бүрэн дүүрэн эдлэх явдлыг хангах талаар шаардлагатай бүх арга хэмжээ авна.

11 дүгээр зүйл

Хүмүүнлэгийн гамшиг болон эрсдэл бүхий нөхцөл байдал

Оролцогч улсууд олон улсын хүмүүнлэгийн эрх зүй, олон улсын хүний эрхийн хэм хэмжээг оролцуулан олон улсын эрх зүйгээр хүлээлгэсэн үүрэгтэй нийцүүлэн эрсдэл бүхий байдал, тухайлбал зэвсэгт мөргөлдөөн, хүмүүнлэгийн гамшиг, байгалийн аюул гамшиг тохиолдсон үед хөгжлийн бэрхшээлтэй хүмүүсийг хамгаалах, аюулгүй байдлыг нь хангахад чиглэсэн шаардлагатай бүхий л арга хэмжээг авна.

12 дугаар зүйл

Хуулийн өмнө тэгш байх эрх

1. Оролцогч улсууд нь хөгжлийн бэрхшээлтэй хүмүүс нь бусад хүний нэгэн адил хуулийн өмнө адил тэгш байх эрхтэйг дахин нотолж байна.

2. Оролцогч улсууд нь хөгжлийн бэрхшээлтэй хүмүүс нь амьдралын бүхий л хүрээнд бусадтай адил тэгш байх үндсэн дээр эрх зүйн чадамжтай байх явдлыг хүлээн зөвшөөрнө.

3. Оролцогч улсууд нь хөгжлийн бэрхшээлтэй хүмүүс эрх зүйн чадамжаа хэрэгжүүлэхэд нь шаардагдах дэмжлэг тусалцааг хүртээмжтэй байлгах үүднээс шаардлагатай арга хэмжээ авна.

4. Оролцогч улсууд нь эрх нь зөрчигдөхөөс урьдчилан сэргийлэх үр нөлөөтэй, зохистой хамгаалалтыг бий болгохуйц эрх зүйн чадамжаа хэрэгжүүлэхтэй холбогдсон бүх арга хэмжээг олон улсын хүний эрхийн хэм хэмжээний дагуу авна. Эрх зүйн чадамжийг хэрэгжүүлэхтэй холбогдсон ийм хамгаалалт нь тухайн хүний сонголт, хүсэл зоригт нийцсэн, эрхийг хүндэтгэсэн, сонирхлын зөрчилгүй, сөрөг нөлөөгүй, хувийн нөхцөл байдалд нь тохирсон, байж болох хамгийн богино хугацаанд байх бөгөөд бүрэн эрхт, хараат бус, бие даасан байгууллага, эсхүл шүүхийн зохих шатны байгууллага түүнийг тогтмол хянаж байна. Эдгээр хамгаалалт нь тухайн хүний эрх, ашиг сонирхол аль хэр хөндөгдөнө төдийчинээний хэмжээтэй байна.

5. Энэ зүйлийн заалтуудын дагуу оролцогч улсууд нь хөгжлийн бэрхшээлтэй хүмүүсийн эд хөрөнгө эзэмших, түүнийг өвлөх, санхүүгийн үйл ажиллагаа эрхлэх болон банкны зээл, үл хөдлөх хөрөнгийн барьцаат зээл болон бусад төрлийн санхүүгийн үйлчилгээг тэгш хүртэх эрхийг баталгаажуулах зорилгоор шаардлагатай, үр дүнтэй арга хэмжээ авах бөгөөд хөгжлийн бэрхшээлтэй хүний эд хөрөнгийг хүсэл зоригийг нь үл хамааран хураахгүй байх явдлыг баталгаажуулна.

13 дугаар зүйл

Шүүх ажиллагаанд хүртээмжтэй оролцох

1. Хөгжлийн бэрхшээлтэй хүмүүс бусадтай адил тэгш байх үндсэн дээр шүүхийн шатны бүх үйл ажиллагаа, түүний дотор мөрдөн байцаалт болон шүүхийн өмнөх шатны бусад ажиллагаа зэрэг хууль эрх зүйн бүх ажиллагаанд шууд болон шууд бус оролцох үүрэг, тухайлбал гэрчийн хувьд үр нөлөөтэй оролцох явдлыг байцаан шийтгэх ажиллагааны хэм хэмжээ болон насны онцлогт нийцсэн хэрэглэгдэхүүн ашиглах замаар шүүх ажиллагаанд хүртээмжтэй, үр дүнтэй оролцох эрхийг оролцогч улсууд хангана.

2. Хөгжлийн бэрхшээлтэй хүмүүсийг шүүх ажиллагаанд үр дүнтэй, хүртээмжтэй оролцох нөхцөлийг хангах үүднээс оролцогч улсууд шүүхийн байгууллагуудад тухайлбал, цагдаа болон хорих ангийн албан хаагчдыг зохих сургалтад хамруулах явдлыг дэмжинэ.

14 дүгээр зүйл

Эрх чөлөө, хувийн халдашгүй эрх

1. Оролцогч улсууд нь бусадтай адил тэгш байх эрхийг хангах үүднээс хөгжлийн бэрхшээлтэй хүний дараахь эрхийг хангана:

а) эрх чөлөөтэй байх, хувийн халдашгүй эрхээ эдлэх;

б) хуульд заасан үндэслэл, журмаас гадуур тэдгээр хүний эрх чөлөөг үл хасах, эсхүл зөвхөн хуульд нийцсэн журмын дагуу эрх чөлөөг хасах болон аль ч тохиолдолд хөгжлийн бэрхшээл нь эрх чөлөөг нь хасах үндэслэл болохгүй байх.

2. Хэрэв хөгжлийн бэрхшээлтэй хүний эрх чөлөөг аливаа журмын дагуу хассан бол уг тохиолдолд оролцогч улсууд нь бусадтай адил тэгш нөхцөлийн үндсэн дээр боломжит хэрэглэгдэхүүнээр хангахыг оролцуулан энэхүү конвенцийн зорилго, зарчим болон олон улсын хүний эрхийн хэм хэмжээнд нийцсэн байдлаар тэдэнд хандах явдлыг хангана.

15 дугаар зүйл

Эрүүдэн шүүлт, хэрцгий, хүнлэг бус, нэр төрийг доромжлон харьцаж шийтгэхээс ангид байх эрх

1. Хэнд ч эрүү шүүлт тулгах, хэрцгий, хүнлэг бусаар нэр төрийг нь доромжлон харьцах буюу шийтгэхийг хориглоно. Ялангуяа, өөрийнх нь чөлөөтэй өгсөн зөвшөөрөлгүйгээр хэнийг ч эмнэлгийн буюу шинжлэх ухааны туршилтад оруулж болохгүй.

2. Оролцогч улсууд нь хөгжлийн бэрхшээлтэй хүмүүсийг бусадтай адил тэгш байх эрхийн үндсэн дээр эрүү шүүлт тулгах, хэрцгий, хүнлэг бусаар нэр төрийг нь доромжлон харьцах буюу шийтгэхээс урьдчилан сэргийлэх бүхий л үр дүнтэй хууль тогтоох, захиргааны, шүүхийн буюу бусад арга хэмжээг авна.

16 дугаар зүйл

Аливаа хэлбэрийн мөлжлөг, хүчирхийлэл, доромжлолоос ангид байх эрх

1. Оролцогч улсууд нь хөгжлийн бэрхшээлтэй хүмүүс нь орон гэрийнхээ дотор, гадна хаана ч жендерт үндэслэсэн байдлыг оролцуулан аливаа хэлбэрийн мөлжлөг, хүчирхийлэл, доромжлолоос ангид байх явдлыг хангах үүднээс бүхий л зохистой хууль тогтоох, захиргааны, боловсролын болон бусад арга хэмжээг авна.

2. Оролцогч улсууд нь хөгжлийн бэрхшээлтэй хүмүүсийн нас, хүйсийн онцлогт тохирсон тусламж, туслалцаа үзүүлэх болон хөгжлийн бэрхшээлтэй хүмүүсийн гэр бүл, асран халамжлагчдад нь аливаа хэлбэрийн мөлжлөг, хүчирхийлэл, доромжлолтой холбоотой бодит явдлын талаар мэдээлэх, таниулах болон эдгээрээс хэрхэн сэргийлэх талаар мэдээлэл түгээх боловсрол олгох зэргээр дэмжлэг үзүүлэх явдлыг хангах замаар аливаа хэлбэрийн мөлжлөг, хүчирхийлэл, доромжлолоос урьдчилан сэргийлэх зохистой бүхий л арга хэмжээ авна. Оролцогч улсууд ийнхүү үзүүлж буй хамгаалалтын арга хэмжээ нь нас, хүйсийн онцлог болон хөгжлийн бэрхшээлийг харгалзан үзсэн байх явдлыг хангана.

3. Аливаа хэлбэрийн мөлжлөг, хүчирхийлэл, доромжлол гарахаас урьдчилан сэргийлэхийн тулд оролцогч улсууд нь хөгжлийн бэрхшээлтэй хүмүүст зориулагдсан байгууллага, хөтөлбөрийг хараат бус эрх бүхий байгууллагаар үр нөлөөтэй хянуулах явдлыг хангана.

4. Оролцогч улсууд аливаа хэлбэрийн мөлжлөг, хүчирхийлэл, доромжлолын хохирогч болсон хөгжлийн бэрхшээлтэй хүмүүсийг бие махбодь, танин мэдэхүй, сэтгэлзүйн хувьд сэргээх, нөхөн сэргээх, нийгмийн амьдралд дахин оролцуулах, ялангуяа хамгаалах үйлчилгээ үзүүлэх зэрэг зохистой бүхий л арга хэмжээг авна. Тийнхүү сэргээх, нийгэмд оролцуулах арга хэмжээг тухайн хүний эрүүл мэнд, нийгмийн хамгаалал, өөрийгөө хүндэтгэх байдал, нандин чанар, хувь хүний хараат бус байдлыг хангасан орчин нөхцөлд л авахын зэрэгцээ тухайн хүний нас, хүйсийн онцлогийг харгалзан үзсэний үндсэн дээр хэрэгжүүлнэ.

5. Хөгжлийн бэрхшээлтэй хүнийг мөлжсөн, хүчирхийлсэн, доромжилсон тохиолдол гарсан бол түүнийг илрүүлэх, мөрдөн шалгах болон мөрдөн байцаах хууль тогтоох болон бусад үр дүнтэй арга хэмжээ, ялангуяа хүүхэд, эмэгтэйчүүдэд чиглэсэн хууль тогтоох болон бусад арга хэмжээг оролцогч улсууд авна.

17 дугаар зүйл

Хувийн нэгдмэл байдлыг хамгаалах

Хөгжлийн бэрхшээлтэй хүн бүр бусдын нэгэн адил өөрийнхөө бие махбодь болон сэтгэхүйн нэгдмэл байдлаа хүндэтгүүлэх эрхтэй.

18 дугаар зүйл

Чөлөөтэй зорчих болон иргэний харьяаллаа чөлөөтэй сонгох эрх

1. Оролцогч улсууд нь хөгжлийн бэрхшээлтэй хүний бусадтай адил чөлөөтэй зорчих, оршин суух газраа чөлөөтэй сонгох болон иргэний харьяаллаа чөлөөтэй сонгох эрхийг хүлээн зөвшөөрч, хөгжлийн бэрхшээлтэй хүмүүсийн дараахь эрхийг хангана:

а) иргэний харьяалал олж авах болон өөрчлөх эрх болон иргэний харьяаллыг хүсэл зоригоос нь гадуур буюу хөгжлийн бэрхшээлээс нь шалтгаан хасахыг хориглох;

б) иргэншлийг нь нотолсон бичиг баримт, эсхүл өөрийг нь тодорхойлох бусад төрлийн биеийн байцаалтыг олж авах, эзэмших, ашиглах, эсхүл чөлөөтэй зорчих эрхээ хэрэгжүүлэхэд нь зайлшгүй шаардлагатай цагаачлалын журам зэрэг холбогдох дүрэм журмыг ашиглах эрхийг хөгжлийн бэрхшээлээс нь шалтгаалан хасахыг хориглох;

с) төрөлх улсыг нь оролцуулан аливаа улсыг орхин явах;

д) өөрийн эх орондоо эргэн ирэх эрхийг хөгжлийн бэрхшээлийн улмаас, эсхүл хүсэл зоригоос гадуур хязгаарлаж болохгүй.

2. Хөгжлийн бэрхшээлтэй хүүхдүүд төрөхөөс, эсхүл төрсөн даруй улсын бүртгэлд бүртгэгдэх, нэртэй болох, иргэний харьяалал олж авах болон боломжийн хэрээр эцэг эхээ мэдэх, тэднээрээ асран тэтгүүлэх эрхтэй.

19 дүгээр зүйл

Бие даан амьдрах болон тухайн оршин суугаа орчиндоо байх эрх

Оролцогч улсууд нь хөгжлийн бэрхшээлтэй бүх хүний бусдын нэгэн адил ердийн оршин суугаа газартаа амьдрах тэгш эрхийг хүлээн зөвшөөрч, хөгжлийн бэрхшээлтэй хүмүүс энэхүү эрхээ эдлэх явдлыг хангах, тухайн оршин суугаа орчиндоо бүрэн дүүрэн хамрагдаж оролцохыг дэмжих үүднээс дараахь нөхцөлийг хангах замаар зохистой, үр дүнтэй арга хэмжээ авна:

а) хөгжлийн бэрхшээлтэй хүмүүс нь бусдын нэгэн адил оршин суух газар болон хаана, хэнтэй амьдрах эсэхээ чөлөөтэй сонгох боломжтой байх ёстой бөгөөд тусгай нөхцөл байдалд амьдрахыг шаардахгүй;

б) хөгжлийн бэрхшээлтэй хүмүүст гэрийн, оршин суугаа газрын болон тухайн оршин суугаа бусад орчны үйлчилгээ, түүний дотор амьдрахад нь дэмжлэг болохуйц болон тухайн оршин суугаа орчиндоо оролцоход нь хувийн туслалцаа хүртэх боломжтой байх бөгөөд нийгмээс тусгаарлах, хөндийрүүлэхээс хамгаалагдана;

с) нийт хүн амд үйлчлэх зориулалттай нийтийн үйлчилгээ, объект нь бусадтай адил тэгш байх үндсэн дээр хөгжлийн бэрхшээлтэй хүмүүсийн хувьд хэрэглэх боломжтой байх бөгөөд хэрэгцээнд нь нийцсэн байна.

20 дугаар зүйл

Хувийн хөдөлгөөн

Оролцогч улсууд нь хөгжлийн бэрхшээлтэй хүмүүсийн бие даасан байдлыг байж болох хамгийн дээд түвшинд хангах замаар хувийн хөдөлгөөнийг хангах үүднээс дараахь хэлбэрээр үр дүнтэй бүх арга хэмжээг авна:

а) хөгжлийн бэрхшээлтэй хүмүүсийн хувийн хөдөлгөөнийг тэдний сонгосон аргаар, сонгосон цаг хугацаанд нь аль болох хамгийн бага зардлаар хангах явдлыг дэмжих;

б) чанарын шаардлага хангасан хөдөлгөөн дэмжих хэрэгсэл, тоног төхөөрөмж, туслах технологи болон туслагчид болон дэмжлэг үзүүлэгчдийн үйлчилгээг хөгжлийн бэрхшээлтэй хүмүүс аль болох хамгийн хямд өртгөөр хүртэх явдлыг дэмжих;

с) хөгжлийг бэрхшээлтэй хүмүүс болон тэдэнтэй ажилладаг мэргэшсэн ажилтнуудыг хөдөлгөөн дэмжих ур чадвар эзэмшүүлэх сургалтад хамруулах;

д) хөдөлгөөн дэмжих хэрэгсэл, тоног төхөөрөмж, туслах технологиудыг үйлдвэрлэж боловсруулахдаа аж ахуйн нэгжүүд хөгжлийн бэрхшээлтэй хүний хөдөлгөөний бүхий л тал, хэрэгцээг харгалзаж байх явдлыг хангах.

21 дүгээр зүйл

Үзэл бодол, итгэл үнэмшлээ илэрхийлэх, мэдээлэл хүртэх эрх чөлөө

Оролцогч улсууд нь хөгжлийн бэрхшээлтэй хүмүүс бусадтай адил тэгш байх үндсэн дээр энэхүү конвенцийн 2 дугаар зүйлд заасан өөрсдийн сонгосон харилцааны бүх төрлийн хэрэглэгдэхүүнээр дамжуулан үзэл бодлоо илэрхийлэх, мэдээлэл хүртэх, тухайлбал, төрөл бүрийн мэдээлэл, үзэл бодлыг хайх, олж авах, түгээх эрхээ эдлэх нөхцөл байдлыг бий болгох үүднээс зохих бүхий л арга хэмжээ авах бөгөөд ялангуяа:

а) нийгмийн бүх гишүүнд зориулсан мэдээллийг түгээхдээ хөгжлийн бэрхшээлтэй хүн ашиглахад хүртээлтэй байхад зориулж хөгжлийн бэрхшээлийн янз бүрийн хэлбэрт нийцсэн арга замаар, тухайн цаг хугацаанд нь, ямар нэг нэмэлт өртөг зардалгүйгээр түгээх;

б) албан харилцаанд дохионы хэл, брайль үсэг, харилцааны нэмэлт болон сонголтот хэлбэр болон хөгжлийн бэрхшээлтэй хүмүүсийн сонгосон мэдээлэл хүртэх харилцааны бусад арга зам, хэлбэр, хэв маягийг ашиглах явдлыг хүлээн авч дэмжлэг үзүүлэх;

с) интернэтийг оролцуулан нийгмийн бүх гишүүнд зориулсан үйлчилгээ үзүүлдэг хувийн хэвшлийн аж ахуйн нэгжүүдийг мэдээлэл түгээх, үйлчилгээ үзүүлэхдээ хөгжлийн бэрхшээлтэй хүмүүс ашиглаж болохуйц хэлбэрээр түгээх нөхцөл бололцоо бий болгохыг уриалах;

д) интернэтээр мэдээлэл түгээдэг байгууллагуудыг оролцуулан олон нийтийн мэдээллийн хэрэгслүүдийн үзүүлдэг үйлчилгээг хөгжлийн бэрхшээлтэй хүмүүст хүртээмжтэй байлгахад дэмжлэг үзүүлэх;

е) дохионы хэлнүүдийг хэрэглэх явдлыг хүлээн зөвшөөрч, хөхиүлэн дэмжих.

22 дугаар зүйл

Хувийн нууцыг хүндэтгэх

1. Амьдран буй газар, орон байрны нөхцөл байдлаас нь үл шалтгаалан хөгжлийн бэрхшээлтэй хүмүүсийн хувийн болон гэр бүлийн амьдралд хөндлөнгөөс дур мэдэн буюу хууль бусаар оролцох, орон байр буюу захидал харилцааных нь нууцад дур мэдэн буюу хууль бусаар халдах, эсхүл нэр төр, алдар хүндэд нь хууль бусаар халдахыг хориглоно. Хөгжлийн бэрхшээлтэй иргэд уг халдага буюу өртөлтөөс хуулийн дагуу хамгаалагдана.

2. Оролцогч улсууд нь бусадтай адил тэгш байх эрхийн үндсэн дээр хөгжлийн бэрхшээлтэй хүмүүсийн хувийн, эрүүл мэндийн болон нөхөн сэргээлтийн талаархи мэдээллийн нууцлалыг хамгаална.

23 дугаар зүйл

Орон байр болон гэр бүлийг хүндэтгэх

1. Оролцогч улсууд нь хөгжлийн бэрхшээлтэй хүмүүсийг гэрлэлт, гэр бүл, эцэг эх, төрөл садангийн харьцаанд бусадтай адил тэгш эрхийн үндсэн дээр алагчилах явдлыг устгах үр дүнтэй, шаардлагатай дараахь арга хэмжээг авна:

а) гэрлэх насанд хүрсэн хөгжлийн бэрхшээлтэй хүний гэр бүл болох эрхийг гэрлэх хүнийх нь бүрэн, чөлөөтэй өгсөн зөвшөөрлийн үндсэн дээр хүлээн зөвшөөрөх;

б) хөгжлийн бэрхшээлтэй хүн нь хүүхдийн тоо, хүүхэд төрүүлэх хоорондын зайг чөлөөтэй шийдвэрлэх, хариуцах эрхтэй бөгөөд насныхаа онцлогт тохирсон мэдээлэл, нөхөн үржхүй, гэр бүл төлөвлөлтийн боловсрол эзэмшиж, эдгээр эрхээ эдлэхэд нь шаардлагатай нөхцөл бололцоо болон үр удмаа үлдээх тэгш боломжоор хангагдах;

с) хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийг оролцуулан хөгжлийн бэрхшээлтэй бүх хүнийг бусадтай адил тэгш эрхийн үндсэн дээр үр удмаа үлдээх эрхээр хангах.

2. Оролцогч улсууд нь хөгжлийн бэрхшээлтэй хүнийг асран хамгаалах, харгалзан дэмжих, итгэмжлэх, хүүхэд үрчлэх, эсхүл эдгээртэй ижил төрлийн арга хэмжээ хэрэв үндэсний хууль тогтоомжид тусгагдсан бол эдгээр арга хэмжээний хувьд эрх, үүргээр хангах бөгөөд ямар ч тохиолдолд хүүхдийн ашиг сонирхлыг нэн тэргүүнд тавина. Оролцогч улсууд нь хөгжлийн бэрхшээлтэй хүмүүсийг хүүхэд өсгөхтэй холбогдсон үүргээ биелүүлэхэд нь зохих тусламжийг үзүүлнэ.

3. Оролцогч улсууд нь гэр бүлийн харилцаанд хөгжлийн бэрхшээлтэй хүүхдүүдийн тэгш эрхийг хангана. Энэхүү эрхийг хэрэгжүүлэх болон хөгжлийн бэрхшээлтэй хүүхдүүдийг нууцлах,

орхих, үл тоомсорлох, хөндийрүүлэхээс урьдчилан сэргийлэхийн тулд оролцогч улсууд хөгжлийн бэрхшээлтэй хүүхдүүд болон тэдний гэр бүлийн гишгүүдийг эхнээсээ л бүх талын мэдээллээр хангаж, үйлчилгээ болон туслалцаа үзүүлнэ.

4. Оролцогч улсууд нь холбогдох хууль тогтоомж, журмын дагуу тийнхүү хөндийрүүлэх нь хүүхдийн эрх ашигт хамгийн ихээр нийцэх тухай шүүхээр шийдвэрлэсний дагуу эрх бүхий зохих байгууллагаас тодорхойлохоос бусад тохиолдолд хүүхдийг өөрийнхөө хүсэл зоригоос гадуур эцэг эхээсээ тусгаарлагдахгүй байх эрхээр хангана. Ямар ч тохиолдолд эцэг эхийн аль нэг нь, эсхүл хоёулаа, эсхүл хүүхэд нь хөгжлийн бэрхшээлтэй гэх шалтгаанаар хүүхдийг эцэг эхээс нь тусгаарлаж болохгүй.

5. Оролцогч улсууд нь хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийг үндсэн гэр бүл нь асран халамжлах боломжгүй тохиолдолд төрөл садангийн гэр бүлийн хүрээнд асран хамгаалуулах бүх төрлийн арга хэмжээг авах бөгөөд ийм арга хэмжээ үр дүнгүй болсон тохиолдолд тухайн оршин суугаа орчинд нь гэр бүлийн нөхцөлийг бий болгож асран хамгаална.

24 дүгээр зүйл

Боловсрол

1. Оролцогч улсууд хөгжлийн бэрхшээлтэй хүний сурч боловсрох эрхийг хүлээн зөвшөөрнө. Энэхүү эрхийг ямар нэг алагчилалгүй, тэгш боломжийн үндсэн дээр эдлүүлэх үүднээс оролцогч улсууд нь дараахь зорилгод чиглэсэн бүх түвшний болон насан туршийн сургалтын боловсролын тогтолцоог бий болгоно:

а) хүний чадвар, нандин чанарын мэдрэмж болон өөрийгөө үнэлэх үнэлэмжийг бүрэн дүүрэн хөгжүүлж, хүний эрх, үндсэн эрх чөлөө болон хүний ялгаатай байдлыг хүндэтгэх явдлыг бэхжүүлэх;

б) хөгжлийн бэрхшээлтэй хүний хувийн шинж чанар, авъяас чадвар, бүтээлч чанар болон тэдний оюуны болон бие махбодийн чадварыг байж болох хамгийн бүрэн дүүрэн хэмжээгээр хөгжүүлэх;

с) хөгжлийн бэрхшээлтэй хүмүүсийг чөлөөт нийгэмд үр дүнтэйгээр оролцох боломжийг олгох.

2. Эдгээр эрхийг хэрэгжүүлэх үүднээс оролцогч улсууд нь дараахь зүйлээр хангана:

а) хөгжлийн бэрхшээлтэй хүмүүс нь хөгжлийн бэрхшээлийн улмаас ерөнхий боловсролын тогтолцооны гадна, мөн хөгжлийн бэрхшээлтэй хүүхдүүд хөгжлийн бэрхшээлийн улмаас үнэ төлбөргүй, заавал эзэмших ёстой бага боловсрол болон дунд боловсрол олгох үйл ажиллагааны гадна үлдэхгүй;

б) хөгжлийн бэрхшээлтэй хүмүүс нь өөрсдийн амьдарч буй орчиндоо бусадтай адил тэгш байх үндсэн дээр тусгай, үнэ төлбөргүй, чанартай, бага боловсрол болон дунд боловсролыг эзэмших боломжтой байх;

с) хувь хүний онцлог шаардлагад нийцсэн боломжит хэрэглэгдэхүүнээр хангагдах;

д) ерөнхий боловсролын тогтолцоонд хөгжлийн бэрхшээлтэй хүмүүс нь өөрсдийн үр дүнтэйгээр сурч боловсрох нөхцөл байдлыг хангуулах үүднээс шаардлагатай дэмжлэг туслалцаа авах;

е) түүнчлэн, мэдлэг олгох болон нийгмийн хөгжилд аль болох дэмжлэг үзүүлснээр хувь хүнд зориулж авах арга хэмжээг үр дүнтэй байлгаж, бүрэн дүүрэн оролцуулах зорилтыг хангах.

3. Оролцогч улсууд нь хөгжлийн бэрхшээлтэй хүмүүс нийгмийн гишүүний хувьд боловсролд бүрэн дүүрэн, тэгш оролцоход нь дэмжлэг үзүүлэх амьдралын болон нийгмийн хөгжлийн ур чадваруудыг эзэмших боломжийг олгоно. үүний тул оролцогч улсууд нь дараахь зүйлийг оролцуулан шаардлагатай бусад арга хэмжээ авна:

а) брайл үсэг болон түүнтэй төстэй өөр үсэг, нэмэлт болон сонголтот арга, төрөл хэлбэр, харилцаанд хэрэглэх бусад хэв маяг, түүнчлэн орон зайн чигийг баримжаалах болон хөдөлгөөн дэмжих ур чадвар эзэмшүүлэх, үе тэнгийнхэн болон сургагч нараас үзүүлэх туслалцаанд дэмжлэг үзүүлэх;

б) дохионы хэл сургахад туслалцаа үзүүлэх болон дүлий хүмүүсийн хоорондын хэл ярианы өвөрмөгц онцлогийг хөхиүлэн дэмжих;

с) мэдлэг олгох болон нийгмийн хөгжилд аль болох дэмжлэг үзүүлснээр хүмүүс, ялангуяа хараагүй, дүлий, хараагүй-дүлий хүүхдүүдэд олгох боловсролыг тухайн хүний онцлогт нийцсэн хамгийн зохистой хэл яриа, арга хэлбэр, харилцаанд хэрэглэх бусад хэв маягаар олгох явдлыг хангах.

4. Эдгээр эрхийг хэрэгжүүлэхэд дэмжлэг үзүүлэх зорилгоор оролцогч улсууд нь багш нар, ялангуяа брайль үсэг болон/эсхүл дохионы хэл эзэмшсэн хөгжлийн бэрхшээлтэй багш нарыг ажиллуулах талаар зохих арга хэмжээ авч, боловсролын бүх түвшинд ажилладаг ажилтан, мэргэжилтнүүдийг сургах зохистой арга хэмжээ авна. Ийм сургалт нь хөгжлийн бэрхшээлтэй хүний талаархи мэдлэг ойлголтыг нэмэгдүүлэх болон зохистой нэмэлт болон сонголтот арга зам, төрөл хэлбэр, харилцаанд хэрэглэх бусад хэв маяг, хөгжлийн бэрхшээлтэй хүнд туслах боловсролын заах арга зүй, сургалтын материал хэрэглэх явдлыг хамарвал зохино.

5. Оролцогч улсууд нь хөгжлийн бэрхшээлтэй хүмүүсийн бусадтай адил тэгш, үл алагчилах үндсэн дээр дээд боловсрол эзэмших, мэргэжлийн сургалтад хамрагдах, насанд хүрэгсдийн болон насан туршийн сургалтад хамрагдах явдлыг хангана. Эл зорилгоор оролцогч улсууд хөгжлийн бэрхшээлтэй хүмүүсийг боломжит хэрэглэгдэхүүнээр хангах явдлыг баталгаажуулна.

25 дугаар зүйл

Эрүүл мэнд

Оролцогч улсууд нь хөгжлийн бэрхшээлтэй хүмүүсийг хөгжлийн бэрхшээлийн улмаас алагчилалгүйгээр эрүүл мэндийн дээд түвшингийн стандартад хүрэх эрхийг хүлээн зөвшөөрнө. Оролцогч улсууд нь хөгжлийн бэрхшээлтэй хүмүүсийг эрүүл мэндтэй холбоотой нөхөн сэргээх эмчилгээг оролцуулан жендэрийн онцлогийг харгалзсан эрүүл мэндийн үйлчилгээгээр хангагдах боломжийг баталгаажуулах бүхий л зохистой дараахь арга хэмжээг авна. Тухайлбал, оролцогч улсууд нь:

а) хөгжлийн бэрхшээлтэй хүмүүсийг хүнд амд суурилсан нийтийн эрүүл мэндийн хөтөлбөр болон бэлгийн болон нөхөн үржхүйн эрүүл мэндийн салбарыг оролцуулан бусад хүнд хүргэдэгтэй ижил түвшин, чанар, стандарт бүхий үнэ төлбөргүй буюу худалдан авах чадавхид нийцсэн эрүүл мэндийн тусламж үйлчилгээ, хөтөлбөрүүдээр хангах;

б) хөгжлийн бэрхшээлтэй хүмүүсийг эрүүл мэнд, ялангуяа хөгжлийн бэрхшээлтэй нь холбоотойгоор шаардлагатай үйлчилгээнд хамруулах, эрт оношлох, зохих үед таслан зогсоох буюу багасгахад чиглэгдсэн болон хүүхдүүд, ахмадуудыг цаашид хөгжлийн бэрхшээлтэй болохоос урьдчилан сэргийлэх үйлчилгээнд хамруулах;

с) хөгжлийн бэрхшээлтэй хүнд зориулсан эмнэлгийн үйлчилгээг бүх газарт тухайлбал, хөдөө орон нутагт ч аль болох гэрт нь ойр газар үзүүлэх;

д) эмч, эмнэлгийн ажилтнуудыг хөгжлийн бэрхшээлтэй хүмүүст бусдад үзүүлдгийн нэгэн адил чанартай үйлчилгээ, тухайлбал хүний эрх, нандин чанар, хараат бус байдал болон хөгжлийн бэрхшээлтэй хүнд боловсрол олгох тусгай хэрэгцээ, төрийн эзэмшлийн болон хувийн эмнэлгийн байгууллагуудын ажилтнуудын баримтлах ёс зүйн хэм хэмжээний талаархи ойлголтыг нэмэгдүүлэх замаар *inter alia* чөлөөтэй олж авсан мэдээллийн үндсэн дээр үзүүлнэ;

е) эрүүл мэндийн даатгал, хэрэв дотоодын хууль тогтоомжоор зөвшөөрөгдсөн бол амь насны даатгалын хувьд хөгжлийн бэрхшээлтэй хүмүүсийг алагчилахыг хориглох бөгөөд эдгээрт шударга, боломжит үндэслэлээр даатгуулна;

ф) хөгжлийн бэрхшээлийн улмаас эмнэлгийн тусламж, эрүүл мэндийн үйлчилгээ, эсхүл хоол хүнс, ундны асуудалд алагчилж, үгүйсгэхээс урьдчилан сэргийлэх.

26 дугаар зүйл

Сэргээлт, нөхөн сэргээлт

1. Оролцогч улсууд нь хөгжлийн бэрхшээлтэй хүмүүсийн хараат бус байдлыг дээд зэргээр хангах, тэднийг бие махбодь, оюун санаа, нийгмийн болон мэргэжлийн бүрэн чадавхитай болгох, нийгмийн бүхий л хүрээнд бүрэн хамрагдах, оролцох боломжийг олгох, эзэмшүүлэх үүднээс бүхий л үр дүнтэй, зохистой арга хэмжээ авна. Эл зорилгоор оролцогч улсууд, ялангуяа эрүүл мэнд, хөдөлмөр эрхлэлт, боловсрол, нийгмийн үйлчилгээний салбарт өргөн хүрээтэй сэргээх, нөхөн сэргээх үйлчилгээ, хөтөлбөрүүдийг дараахь арга замаар зохион байгуулан бэхжүүлж, өргөжүүлнэ:

а) тухайн хувь хүний зүгээс нэн түрүүн шаардлагатай байгаа хэрэгцээг олон талаас нь үнэлж, дүгнэсний үндсэн дээр аль болох эрт үед хэрэгжүүлэх эхлэх;

б) хөгжлийн бэрхшээлтэй хүмүүсийг тухайн оршин суугаа орчинд нь болон нийгмийн амьдралын бүхий л салбарт сайн дурын үндсэн дээр оролцуулах болон хөгжлийн бэрхшээлтэй хүмүүсийг тэдний амьдарч буй, ялангуяа хөдөө, орон нутаг дахь орчинтой нь аль болох ойртуулахад дэмжлэг үзүүлэх.

2. Оролцогч улсууд нь сэргээх, нөхөн сэргээх үйлчилгээ үзүүлэх салбарт ажилладаг мэргэжилтнүүд, ажилтнуудад зориулсан анхан болон үргэлжилсэн шатны сургалт зохион байгуулах ажлыг хөхиүлэн дэмжинэ.

3. Оролцогч улсууд нь хөгжлийн бэрхшээлтэй хүмүүст зориулагдсан сэргээх, нөхөн сэргээх үйлчилгээнд хэрэглэх туслах тоног төхөөрөмж, технологиудыг хүртээлтэй байлгах, тэдгээрийг хэрэглэх зааварчилгаа, мэдлэг олгох явдлыг хөхиүлэн дэмжинэ.

27 дугаар зүйл

Ажил, хөдөлмөр эрхлэлт

1. Оролцогч улсууд нь хөгжлийн бэрхшээлтэй хүмүүсийн бусадтай адил тэгш байх үндсэн дээр хөдөлмөр эрхлэх, тухайлбал хөгжлийн бэрхшээлтэй хүмүүсийн хувьд хүртээлтэй, нээлттэй байгаа, оролцож болох хөдөлмөрийн зах зээл, хөдөлмөрлөх орчинд ажиллахаар чөлөөтэй сонгосон, эсхүл зөвшөөрлөө чөлөөтэй өгсөн нөхцөлд эрхэлж буй хөдөлмөрийнхөө үр шимээр амьжиргааны эх үүсвэрээ олох боломжтой байх хөгжлийн бэрхшээлтэй хүний эрхийг хүлээн зөвшөөрнө. Оролцогч улсууд нь хөдөлмөр эрхлэх явцдаа хөгжлийн бэрхшээлтэй болсон хүмүүсийг оролцуулан хөгжлийн бэрхшээлтэй бүх хүний ажил, хөдөлмөр эрхлэх эрхийг эдлүүлэх үүднээс зохистой арга хэмжээ, тухайлбал хууль тогтоох болон дараахь арга хэмжээ авах явдлыг хангаж, хөхиүлэн дэмжинэ:

а) ажилд авах нөхцөл, хөлсөөр ажиллуулах, ажил олгох, ажил хөдөлмөр эрхлэх, мэргэжлийн хувьд өсөн дэвжих, эрүүл, аюулгүй хөдөлмөрийн нөхцөлөөр хангагдах явдлыг оролцуулан хөдөлмөрийн бүх хэвшилтэй холбогдсон бүхий л асуудалд хөгжлийн бэрхшээлийн улмаас алагчилахыг хориглох;

б) хөгжлийн бэрхшээлтэй хүмүүсийн бусадтай адил тэгш байх үндсэн дээр адил хөдөлмөрт ижил тэгш боломж, адил цалин хөлс авах, эрүүл, аюулгүй хөдөлмөрийн нөхцөлөөр хангагдах, тухайлбал, дарамт шахалтад өртөхгүй байх, өргөдөл гомдлоо барагдуулах эрх;

с) хөгжлийн бэрхшээлтэй хүмүүсийг бусадтай адил тэгш байх үндсэн дээр хөдөлмөрлөх, үйлдвэрчний байгууллагатай холбогдсон эрхээр хангах;

д) хөгжлийн бэрхшээлтэй хүмүүсийг техникийн болон мэргэжлийн чиг баримжаа олгох ерөнхий хөтөлбөр, ажлын дадал олгох, мэргэжлийн болон гүнзгийрүүлсэн сургалтад үр дүнтэйгээр хамрагдах боломжийг бий болгох;

е) хөдөлмөрийн зах зээлд ажил хайх, ажилд орох, ажиллах болон ажилдаа буцаж орох боломж нөхцөл, мэргэжлийн хувьд дэвших боломжийг хөгжлийн бэрхшээлтэй хүмүүст олгох явдлыг хөхиүлэн дэмжих;

ф) хувиараа хөдөлмөр эрхлэх, аж ахуйн нэгж байгуулах, нөхөрлөл, хоршоо ажиллуулах, хувийн бизнесээ эрхлэх боломжийг дэмжих;

г) хөгжлийн бэрхшээлтэй хүмүүсийг төрийн албанд ажиллуулах;

h) зохих бодлого хэрэгжүүлэх, арга хэмжээ авах, түүний дотор тэдэнд зориулсан хөтөлбөр батлах, урамшуулал олгох зэрэг бусад арга хэмжээ авах замаар хөгжлийн бэрхшээлтэй хүмүүсийг хувийн хэвшлийн байгууллагад хөдөлмөр эрхлэх явдлыг хөхиүлэн дэмжих;

i) хөгжлийн бэрхшээлтэй хүмүүсийг ажлын байранд боломжит хэрэглэгдэхүүнээр хангах;

j) хөдөлмөрийн нээлттэй зах зээлд хөгжлийн бэрхшээлтэй хүмүүс ажлын туршлага хуримтлуулах явдлыг хөхиүлэн дэмжих;

к) хөгжлийн бэрхшээлтэй хүмүүст мэргэжлийн болон техник мэргэжлийн нөхөн сэргээлт, ажлын байрыг нь хадгалах болон ажилд нь буцааж оруулах хөтөлбөрийг хөхиүлэн дэмжих.

2. Оролцогч улсууд нь хөгжлийн бэрхшээлтэй хүмүүсийг мөлжлөг, боолын байдалд оруулахгүй байх, бусадтай адил тэгш байх үндсэн дээр албадан хөдөлмөрөөс хамгаалагдах явдлыг хангана.

28 дугаар зүйл

Амьжиргааны хүрэлцэхүйц түвшин, нийгмийн хамгаалал

1. Оролцогч улсууд нь хүрэлцэхүйц хоол хүнс, хувцас, орон байраар хангагдах эрх, амьдралын нөхцөлөө тасралтгүй сайжруулах явдлыг оролцуулан хөгжлийн бэрхшээлтэй хүмүүс, тэдний гэр бүл амьжиргааны хүрэлцэхүйц түвшинд байх эрхийг хүлээн зөвшөөрч, энэхүү эрхийг эдлэх явдлыг хөгжлийн бэрхшээлийн улмаас үл алагчилах үндсэн дээр хөхиүлэн дэмжих зохистой арга хэмжээ авна.

2. Оролцогч улсууд нь хөгжлийн бэрхшээлтэй хүмүүсийн нийгмийн хамгаалал хүртэх эрх, уг эрхийг хөгжлийн бэрхшээлээс шалтгаалан аливаа алагчилалгүйгээр эдлэх явдлыг хүлээн зөвшөөрч, эдгээр эрхийг эдлүүлэх явдлыг хөхиүлэн дэмжих, хамгаалах үүднээс дараахь зохистой арга хэмжээ авна:

а) хөгжлийн бэрхшээлтэй хүмүүсийг цэвэр усны үйлчилгээнд тэгш хамрагдах явдлыг хангах болон хөгжлийн бэрхшээлтэй нь холбоотойгоор шаардагдах, боломжийн өртөгтэй үйлчилгээ, тоног төхөөрөмж болон бусад туслалцааг хүртэх явдлыг хангах;

б) хөгжлийн бэрхшээлтэй хүмүүс, ялангуяа хөгжлийн бэрхшээлтэй эмэгтэйчүүд, охид болон хөгжлийн бэрхшээлтэй ахмад настнуудыг нийгмийн хамгаалал болон ядуурлыг бууруулах хөтөлбөрүүдэд хамрагдах явдлыг хангах;

с) ядуу нөхцөлд амьдарч буй хөгжлийн бэрхшээлтэй хүмүүс болон тэдний гэр бүлийн гишүүдийг хөгжлийн бэрхшээлтэй хүний тусгай хэрэгцээт зардал тухайлбал, шаардлагатай сургалт, зөвлөгөө, санхүүгийн туслалцаа болон түр хугацааны туслалцаа авахдаа төрөөс дэмжлэг авах боломжоор хангах;

д) бүх нийтийг орон сууцаар хангах хөтөлбөрт хөгжлийн бэрхшээлтэй хүмүүсийг хамруулах;

е) тэтгэвэр, түүнтэй холбоотой хөтөлбөрт хөгжлийн бэрхшээлтэй хүмүүсийг хамруулах.

29 дүгээр зүйл

Улс төр, нийгмийн амьдралд оролцох

Оролцогч улсууд нь хөгжлийн бэрхшээлтэй хүмүүсийн улс төрийн эрхийг баталгаажуулж, эдгээр эрхээ бусдын нэгэн адил эдлэх боломжийг бий болгох үүднээс дараахь үүрэг хүлээнэ:

а) бусадтай адил тэгш байх үндсэн дээр хөгжлийн бэрхшээлтэй хүмүүсийн сонгох, сонгогдох эрх, боломжийг оролцуулан шууд буюу чөлөөтэй сонгосон төлөөллийн байгууллагаараа дамжуулан улс төр, нийгмийн амьдралд үр дүнтэй, бүрэн дүүрэн оролцох байдлыг дараахь хэлбэрээр хангана:

(i) сонгууль өгөх журам, байр, сонгуулийн хуудас нь ашиглахад зохистой, хүртээмжтэй болон ойлгох, ашиглахад хялбар байх явдлыг хангах;

(ii) хөгжлийн бэрхшээлтэй хүмүүс сонгууль болон ард нийтийн санал асуулгад ямар нэг сүрдүүлэггүйгээр саналаа нууцаар өгөх, сонгуульд нэрээ дэвшүүлэх, болон шаардлагатай тохиолдолд туслах болон шинэ технологи ашиглах замаар албан тушаал хаших, төр, засгийн байгууллагын аль ч түвшинд төрийн алба хаах эрхийг дэмжиж хамгаалах;

(iii) хөгжлийн бэрхшээлтэй хүмүүс сонгогчийн хувьд өөрийн санал, бодлоо чөлөөтэй илэрхийлэх, үүний тул шаардлагатай тохиолдолд тэдгээр хүмүүсийн хүсэлтээр сонгосон хүний туслалцаатайгаар саналаа өгөх.

b) хөгжлийн бэрхшээлтэй хүмүүст бусадтай адил тэгш байх үндсэн дээр ямар нэг алагчилалгүйгээр төрийн удирдах хэрэгт бүрэн дүүрэн, үр нөлөөтэй оролцох орчин бүрдүүлэх явдлыг идэвхтэйгээр хөхиүлэн дэмжиж, тэдний нийгмийн үйл хэрэгт оролцох оролцоог дараахь хэлбэрээр дэмжих:

(i) улс орны улс төрийн болон төрийн хэрэг, ялангуяа улс төрийн намуудын үйл ажиллагаа болон удирдлагатай нь холбоотойгоор үйл ажиллагаа явуулдаг засгийн газрын бус байгууллагуудын үйл ажиллагаанд оролцох;

(ii) хөгжлийн бэрхшээлтэй хүмүүсийг олон улсын, үндэсний, бүс нутгийн болон орон нутгийн түвшинд төлөөлөх хөгжлийн бэрхшээлтэй хүмүүсийн байгууллага байгуулах, тийм байгууллагад элсэх.

30 дугаар зүйл

Соёлын амьдралд оролцох, чөлөөт цаг, амралтаа өнгөрүүлэх, спортоор хичээллэх

1. Оролцогч улсууд хөгжлийн бэрхшээлтэй хүмүүс бусадтай адил тэгш байх үндсэн дээр соёлын амьдралд оролцох эрхийг хүлээн зөвшөөрөх бөгөөд хөгжлийн бэрхшээлтэй хүмүүсийн дараахь эрхийг хангах зохистой бүхий л арга хэмжээг авна:

a) соёлын бүтээлийг хүртээмжтэй хэлбэрээр хүртэх;

b) телевизийн хөтөлбөр, кино, театр болон соёлын бусад арга хэмжээг хүртээмжтэй хэлбэрээр хүртэх;

c) театр, музей, кино театр, номын сан, аялал жуулчлалын үйлчилгээ зэрэг соёлын үзвэр, үйлчилгээ эрхэлдэг газруудад нэвтрэх боломжтой байх бөгөөд түүнчлэн хөшөө дурсгал болон үндэсний соёлын ач холбогдол бүхий газруудад ч мөн хүрэх боломжтой байх.

2. Хөгжлийн бэрхшээлтэй хүмүүс зөвхөн өөрийн сайн сайхны төдийгүй нийгмийн баялагт хувь оруулах үүднээс уран бүтээлийн, урлагийн болон оюуны чадавхиа ашиглах болон хөгжүүлэх боломжийг тэдэнд бий болгох зохистой бүхий л арга хэмжээг оролцогч улсууд нь авна.

3. Хөгжлийн бэрхшээлтэй хүмүүс урлагийн бүтээлийг хүртэхэд оюуны өмчийн эрхийг хамгаалсан хууль тогтоомж нь үндэслэлгүй, алагчилах шинжтэй саад тотгорыг үүсгэхгүй байх явдлыг хангах үүднээс оролцогч улсууд бүхий л зохистой арга хэмжээг олон улсын эрх зүйн дагуу авна.

4. Хөгжлийн бэрхшээлтэй хүмүүс өөрсдийн соёлын тусгай болон хэл ярианы онцлог байдал тухайлбал, дохионы хэл, дүлий хүмүүсийн өвөрмөц онцлогийг бусадтай адил тэгш байх үндсэн дээр хүлээн зөвшөөрүүлэх эрхтэй.

5. Бусадтай адил тэгш байх үндсэн дээр амралт, чөлөөт цагаа спортын арга хэмжээнд оролцох хэлбэрээр өнгөрүүлэх боломжийг хөгжлийн бэрхшээлтэй хүмүүст хангах үүднээс оролцогч улсууд нь дараахь зохистой арга хэмжээг авна:

a) нийтэд зориулсан спортын бүх төрлийн арга хэмжээнд хөгжлийн бэрхшээлтэй хүмүүсийг аль болох бүрэн хэмжээгээр оролцуулах явдлыг дэмжиж сурталчлах;

b) хөгжлийн бэрхшээлтэй хүмүүст тусгайлан зориулагдсан спорт, чөлөөт цагийн арга хэмжээг зохион байгуулах, хөгжүүлэх болон оролцох боломжтой байх явдлыг тэдгээр хүнд баталгаажуулах, үүний тулд бусадтай адил тэгш байх үндсэн дээр шаардлагатай сургалт, бэлтгэл, хэрэгслээр хангах;

c) хөгжлийн бэрхшээлтэй хүмүүс спорт, чөлөөт цагаа өнгөрүүлэх, аялал жуулчлалын байгууллагуудад хүрэх боломжтой байх явдлыг хангах;

d) хөгжлийн бэрхшээлтэй хүүхдүүд тоглоом наадгайд оролцох, амралт чөлөөт цагаа спортын арга хэмжээ, тухайлбал сургууль дээр зохион байгуулагдаж байгаа ийм төрлийн арга хэмжээнд бусад хүүхдийн адил оролцох тэгш боломжтой байх явдлыг хангах;

e) хөгжлийн бэрхшээлтэй хүмүүс чөлөөт цагаа өнгөрүүлэх, аялал жуулчлал, амралт, спортын үйл ажиллагааг зохион байгуулдаг байгууллагуудын үйлчилгээг хүртэх боломжтой байх явдлыг хангах.

31 дүгээр зүйл

Статистик болон мэдээлэл цуглуулах

1. Оролцогч улсууд энэхүү конвенцийг хэрэгжүүлэх зорилгоор бодлого, стратеги боловсруулах, статистик болон судалгааны мэдээллийг оролцуулан шаардлагатай бүхий л мэдээллийг цуглуулах,

тэдгээр мэдээллийг тухайн бодлогод ашиглах үүрэг хүлээнэ. Ийм мэдээллийг олж авах, цуглуулах ажиллагаа нь:

а) мэдээллийн нууцлал, хөгжлийн бэрхшээлтэй хүмүүсийн хувийн халдашгүй байдлыг хангахын тулд мэдээллийг хамгаалах тухай хууль тогтоомжийг оролцуулан бусад хууль тогтоомжоор олгосон хамгаалалтыг чанд сахих;

б) статистик мэдээллийг цуглуулах, ашиглахдаа хүний эрх, үндсэн эрх чөлөөний талаархи олон улсын нийтээр хүлээн зөвшөөрөгдсөн хэм хэмжээ болон ёс зүйн хэм хэмжээг чанд сахих.

2. Энэ зүйлийн дагуу цуглуулсан мэдээлэл нь зохих түвшинд тодорхой байх бөгөөд оролцогч улсууд энэхүү конвенцийн дагуу хүлээсэн үүргээ хэрэгжүүлж байгаа эсэхэд үнэлэлт өгөх болон хөгжлийн бэрхшээлтэй хүмүүс эрхээ эдлэх явцад учирч буй саад бэрхшээлүүдийг тогтоох, арилгахад түүнийг мөн хэрэглэнэ.

3. Оролцогч улсууд статистик эдгээр мэдээллийг түгээх үүрэг хүлээх бөгөөд хөгжлийн бэрхшээлтэй хүмүүс болон бусад хүнд эдгээр мэдээлэл нь хүртээлтэй байх явдлыг хангана.

32 дугаар зүйл

Олон улсын хамтын ажиллагаа

1. Оролцогч улсууд нь энэхүү конвенцийн зорилт, зорилгыг хэрэгжүүлэх өөрийн үндэсний хүчин чармайлтад дэмжлэг үзүүлэхэд олон улсын хамтын ажиллагаа чухал болохыг хүлээн зөвшөөрөх бөгөөд үүнтэй холбогдуулан улс хооронд үр дүнтэй арга хэмжээ авах, шаардлагатай тохиолдолд олон улсын, бүс нутгийн болон иргэний нийгмийн байгууллагууд ялангуяа, хөгжлийн бэрхшээлтэй хүмүүсийн байгууллагуудтай хамтран ажиллах бүхий л зохистой арга хэмжээг авна. Тухайн арга хэмжээ нь дараахь байдалтай байж болно:

а) олон улсын хөгжлийн хөтөлбөрүүдийг оролцуулан олон улсын хамтын ажиллагаа нь хөгжлийн бэрхшээлтэй хүмүүсийг хамарсан, хүртээмжтэй байх явдлыг хангах;

б) байгаа нөөц бололцоондоо тулгуурлан, түүний дотор мэдээлэл, туршлага, хөтөлбөр болон тэргүүний туршлагуудаа солилцох замаар чадавхийг бэхжүүлэх явдлыг дэмжих;

с) шинжлэх ухаан, техникийн мэдлэг болон судалгаа шинжилгээний салбар дахь хамтын ажиллагаанд дэмжлэг үзүүлэх;

д) шаардлагатай тохиолдолд техник, эдийн засгийн туслалцаа, түүний дотор хүртээмжтэй болон туслах технологийг хүртэх явдлыг хөнгөвчлөх, тэдгээрийг өөр хоорондоо харилцан солилцох, түүнчлэн технологийг шилжүүлэх замаар үзүүлэх.

2. Оролцогч аливаа улс энэхүү конвенцийн дагуу хүлээсэн үүргээ биелүүлэхэд энэ зүйлийн заалт аливаа байдлаар нөлөөлөхгүй.

33 дугаар зүйл

Үндэсний түвшинд хэрэгжүүлэх болон хяналт тавих

1. Оролцогч улсууд нь төрийн байгууллагын тогтолцоондоо нийцүүлэн засгийн газартаа нэг буюу хэд хэдэн шатны байгууллагыг энэхүү конвенцийг хэрэгжүүлэхтэй холбогдсон үүрэг гүйцэтгүүлэхээр томилох бөгөөд төрөл бүрийн салбарын төрөл бүрийн түвшинд тухайн асуудлыг зохицуулах механизмыг засгийн газрын бүрэлдэхүүнд бий болгох, томилох боломжийг судалж үзнэ.

2. Оролцогч улсууд нь өөрсдийн эрх зүйн болон засаг захиргааны тогтолцоондоо нийцүүлэн өөрийн улсын хувьд шаардлагатай нэг буюу хэд хэдэн бие даасан механизмыг оролцуулан энэхүү конвенцийн хэрэгжилтэд хяналт тавих, дэмжлэг үзүүлэх, хамгаалах ажиллагааг эрхэлсэн бүтцийг шаардлагатай тохиолдолд байгуулах, томилох, бэхжүүлэх, тогтвортойгоор ажиллуулна. Ийм механизмыг байгуулахдаа оролцогч улсууд нь хүний эрхийг хамгаалах, хөхиүлэн дэмжих үндэсний байгууллагуудын үйл ажиллагаа, эрх зүйн байдлын талаархи зарчмуудыг анхааралдаа авна.

3. Иргэний нийгмийн байгууллагууд, ялангуяа хөгжлийн бэрхшээлтэй хүмүүс болон тэднийг төлөөлөх байгууллагууд ийнхүү хяналт тавих ажиллагаанд бүрэн дүүрэн оролцох, хамрагдах ёстой.

34 дүгээр зүйл

Хөгжлийн бэрхшээлтэй хүний эрхийн хороо

1. үүгээр дор заасан чиг үүргийг гүйцэтгэх Хөгжлийн бэрхшээлтэй хүний эрхийн хороог (цаашид “Хороо” гэх) байгуулав.

2. Энэхүү конвенцийг хүчин төгөлдөр болох үед Хороо нь арван хоёр гишүүний бүрэлдэхүүнтэй байгуулна. Энэхүү конвенцийг жаран улс соёрхон батласан, эсхүл нэгдэн орсон бол Хороог хамгийн дээд хязгаар арван найман гишүүн хүртэл зургаан гишүүнээр нэмэгдүүлнэ.

3. Хорооны гишүүд нь өөрийн нэрийн өмнөөс ажиллах бөгөөд өндөр ёс суртахуунтай, энэхүү конвенцид заасан салбарт хүлээн зөвшөөрөгдсөн мэдлэг чадвар, туршлагатай этгээд байна. Хорооны гишүүнд нэр дэвшүүлэхдээ оролцогч улсууд энэхүү конвенцийн 4 дүгээр зүйлийн 3 дахь хэсэгт заасан нөхцөлийг зайлшгүй харгалзан үзнэ.

4. Хорооны гишүүд нь оролцогч улсуудаас сонгогдох бөгөөд ийнхүү сонгохдоо улсууд нь газар зүйн шударга хуваарилалт, соёл иргэншил болон эрх зүйн тогтолцооны олон хэлбэрийн төлөөлөл болон хүйсийн тэгш төлөөлөл, хөгжлийн бэрхшээлийн талаар мэргэшсэн байдлыг харгалзан үзнэ.

5. Өөрсдийн улсаас нэр дэвшүүлсэн оролцогч улсуудын нэр дэвшигчдээс бүрдсэн жагсаалтаас оролцогч улсуудын Бага хурал нууцаар санал хурааж Хорооны гишүүдийг сонгоно. Оролцогч улсуудын гуравны хоёр нь оролцсон санал хураалтыг хүчин төгөлдөр гэж үзэх бөгөөд хуралдаанд байлцаж санал өгсөн оролцогч улсын төлөөлөгчдийн хамгийн олонхи буюу дийлэнх олонхийн саналыг авсан нэр дэвшигчийг Хорооны гишүүнд сонгогдсонд тооцно.

6. Анхны сонгуулийг энэхүү конвенц хүчин төгөлдөр болсноос хойш зургаан сараас илүүгүй хугацааны дотор явуулна. Ээлжит сонгууль явуулахаас наад зах нь дөрвөн сарын өмнө Нэгдсэн үндэсний Байгууллагын Ерөнхий нарийн бичгийн дарга оролцогч улсуудад захидал илгээж хоёр сарын дотор нэр дэвшүүлэхийг санал болгоно. Ерөнхий нарийн бичгийн дарга ийнхүү нэр дэвшсэн хүмүүсийн нэрсийн жагсаалтыг үсгийн дарааллаар нь дэвшүүлсэн улсын хамт гаргаж оролцогч улсуудад хүргүүлнэ.

7. Хорооны гишүүд нь дөрвөн жилийн бүрэн эрхийн хугацаатайгаар сонгогдох бөгөөд нэг удаа улиран сонгогдох эрхтэй. Гэхдээ анхны сонгуулиар сонгогдсон зургаан гишүүний бүрэн эрхийн хугацаа хоёр жил байх бөгөөд анхны сонгуулийг явуулж дуусмагц эдгээр зургаан гишүүний нэрийг энэ зүйлийн 5 дахь хэсэгт заасан хуралдааныг даргалагч шодож тогтооно.

8. Нэмж сонгогдох зургаан гишүүнийг энэ зүйлийн холбогдох заалтын дагуу ердийн сонгууль явуулах замаар сонгоно.

9. Хорооны гишүүн нас барах, огцрох буюу бусад шалтгаанаар үүргээ гүйцэтгэх боломжгүй гэж зарласан тохиолдолд түүний нэрийг дэвшүүлсэн оролцогч улс энэ зүйлийн холбогдох заалтыг шаардлагад нийцсэн мэргэшил бүхий өөр шинжээчийн нэрийг дэвшүүлж үлдсэн хугацаанд томилуулж ажиллуулна.

10. Хороо нь үйл ажиллагааныхаа горим, дэгийг өөрөө тогтооно.

11. Энэхүү конвенцийн дагуу Хорооны ажил үүргийг үр дүнтэй гүйцэтгэхэд шаардлагатай боловсон хүчин, материаллаг хэрэгслээр Нэгдсэн үндэсний Байгууллагын Ерөнхий нарийн бичгийн дарга Хороог хангах бөгөөд түүний анхны хуралдааныг мөн зарлаж хуралдуулна.

12. Энэхүү конвенцийн дагуу байгуулагдсан Хорооны гишүүн нь Хорооны хүлээсэн үүрэг, хариуцлагын ач холбогдлыг харгалзан Нэгдсэн үндэсний Байгууллагын Ерөнхий Ассамблейн тогтоосон журам, нөхцөлийн дагуу Нэгдсэн үндэсний Байгууллагын хөрөнгөөс Ерөнхий Ассамблейн батласан хөлсийг авна.

13. Нэгдсэн үндэсний Байгууллагын дархан эрх, эрх ямбын тухай конвенцийн холбогдох заалтын дагуу Нэгдсэн үндэсний Байгууллагын томилолтоор ажиллахдаа Хорооны гишүүд нь шинжээчийн эрх ямба, дархан эрх, хөнгөлөлтийг эдэлнэ.

35 дугаар зүйл

Оролцогч улсуудын тайлан илтгэл

1. Оролцогч улс бүр энэхүү конвенцийн дагуу хүлээсэн үүргээ биелүүлэх зорилгоор авсан арга хэмжээ, үүнтэй холбоотойгоор гарсан дэвшлийн талаархи дэлгэрэнгүй тайлан илтгэлээ энэхүү конвенц хүчин төгөлдөр болсноос хойш хоёр жилийн дотор Нэгдсэн үндэсний Байгууллагын Ерөнхий нарийн бичгийн даргаар уламжлан Хороонд хүргүүлнэ.

2. Оролцогч улс цаашид шинээр авсан арга хэмжээнийхээ тухай нэмэлт тайлан илтгэлийг дөрвөн жилд нэгээс доошгүй удаа, түүнчлэн Хорооны хүссэн үед бусад тайлан илтгэлийг гарган өгч байна.

3. Хороо нь тайлан илтгэлийн агуулгыг тодорхойлох аргачлал зааварчилгаагаар хангана.

4. Анхны дэлгэрэнгүй тайлан илтгэлээ Хороонд хүргүүлсэн оролцогч улсын хувьд дараагийн тайлан илтгэлийн өмнө нь дурдсан мэдээллийг давтах шаардлагагүй. Хороонд хүргүүлэх тайлан илтгэлийг бэлтгэхдээ оролцогч улсууд нь нээлттэй, ил тод зарчмыг баримтлах бөгөөд энэхүү конвенцийн 4 дүгээр зүйлийн 3 дахь хэсэгт заасан нөхцөлийн харгалзан үзнэ.

5. Тайлан илтгэлдээ энэхүү конвенцоор хүлээсэн үүргээ биелүүлэхэд саад учруулж буй хүндрэл, нөхцөл байдлын талаар дурдаж болно.

36 дугаар зүйл

Тайлан илтгэлийг хэлэлцэх

1. Хороо нь тайлан илтгэл бүрийг авч хэлэлцээд шаардлагатай гэж үзвэл ерөнхий зөвлөмж, саналыг оролцогч улсад хүргүүлнэ. Оролцогч улс аливаа мэдээллийг хариулт болгон өөрийн сонголтоор Хороонд хүргүүлж болно. Түүнчлэн Хороо нь энэхүү конвенцийг хэрэгжүүлэхтэй холбоотой нэмэлт мэдээллийг оролцогч холбогдох улсаас хүсч болно.

2. Оролцогч улсууд нь тайлан илтгэлээ хүргүүлэх хугацааг нэлээд хугацаагаар хожимдуулсан тохиолдолд Хороо оролцогч холбогдох улсад мэдэгдэл өгснөөс хойш гурван сарын дотор зохих тайлан илтгэлийг хүлээж аваагүй тохиолдолд нь оролцогч тухайн улсын хувьд энэхүү конвенцийн хэрэгжилтийг өөрт байгаа бодит мэдээлэлд тулгуурлан хэлэлцэх талаар мэдэгдэнэ. Ийнхүү хэлэлцэхэд

оролцогч тухайн улсыг оролцуулах талаар Хороо санал гаргана. Оролцогч улсын зүгээс мэдэгдлийг дагуу тайлан илтгэлийг хүргүүлсэн тохиолдолд энэ зүйлийн 1 дэх хэсгийн заалтыг удирдлага болгоно.

3. Нэгдсэн үндэсний Байгууллагын Ерөнхий нарийн бичгийн дарга нь тайлан илтгэлийг оролцогч бүх улсад хүргүүлнэ.

4. Оролцогч улсууд нь өөрийн орондоо тайлан илтгэлийг олон нийтэд өргөн хэмжээгээр танилцуулах бөгөөд тайлан илтгэлтэй холбогдуулан гаргасан ерөнхий зөвлөмж, саналыг олон нийт танилцахад хүртээмжтэй байлгана.

5. Хороо нь шаардлагатай гэж үзвэл техникийн зөвлөгөө, дэмжлэг туслалцаа хүсэх зорилгоор оролцогч улсуудын тайланг Нэгдсэн үндэсний Байгууллагын төрөлжсөн байгууллагууд, сангууд, хөтөлбөрүүдэд анхаарлыг нь хандуулах үүднээс хүргүүлэх бөгөөд хэрэв байгаа бол тухайн тайлан илтгэлтэй холбогдуулж Хорооноос гаргасан санал, зөвлөмжийг хавсарган хүргүүлнэ.

37 дугаар зүйл

Оролцогч улсууд болон Хорооны хамтын ажиллагаа

1. Оролцогч улс бүр Хороотой хамтран ажиллах бөгөөд Хорооны гишүүд өөрийн мандатаа хэрэгжүүлэхэд нь тэдэнд туслалцаа үзүүлнэ.

2. Оролцогч улсуудтай хамтран ажиллахдаа Хороо нь олон улсын хамтын ажиллагаанаас үзүүлэх туслалцааг оролцуулан энэхүү конвенцийг хэрэгжүүлэх үндэсний чадавхийг дээшлүүлэх арга зам, хэлбэрийг харгалзан үзнэ.

38 дугаар зүйл

Хорооноос бусад байгууллагатай харилцах

Энэхүү конвенцийг үр дүнтэй хэрэгжүүлэхэд тус дөхөм үзүүлэх болон түүний хамарсан салбарт олон улсын хамтын ажиллагааг өргөжүүлэх үүднээс:

а) Нэгдсэн үндэсний Байгууллагын төрөлжсөн байгууллагууд болон бусад байгууллага өөрийн бүрэн эрхийн хүрээнд хамаарах асуудлаархи энэхүү конвенцийн холбогдох зүйл заалтын хэрэгжилттэй холбоотой асуудлыг хэлэлцэхэд төлөөллөө байлцуулж болно. Хороо нь шаардлагатай гэж үзвэл төрөлжсөн байгууллага болон бусад эрх бүхий байгууллагыг тэдгээрийн бүрэн эрхийн хүрээнд хамаарах асуудлаар энэхүү конвенцийн хэрэгжилтийн тухайд шинжээчийн зөвлөгөө өгөхийг хүсч болно. Түүнчлэн Хороо нь Нэгдсэн үндэсний Байгууллагын төрөлжсөн байгууллагууд болон

бусад байгууллагыг үйл ажиллагааных нь хүрээний асуудлаар энэхүү конвенцийн хэрэгжилтийн талаархи тайлан илтгэл ирүүлэхийг хүсч болно.

b) тухайн асуудал Хорооны бүрэн эрхийн хүрээнд үл хамаарах тохиолдолд шаардлагатай гэж үзвэл олон улсын хүний эрхийн гэрээний үндсэн дээр байгуулагдсан бусад холбогдох байгууллагатай өөрсдийн тайлан илтгэлийг хэлэлцэх аргачлал, санал, ерөнхий зөвлөмж гаргах журмын нийцлийг хангах үүднээс зөвлөлдөх бөгөөд үйл ажиллагааны давхцал, хийдэл гаргахаас сэргийлнэ.

39 дүгээр зүйл

Хорооны тайлан илтгэл

Хороо нь хоёр жил тутамд өөрийн үйл ажиллагааны талаархи тайлан илтгэлийг Ерөнхий Ассамблей болон Эдийн засаг, нийгмийн зөвлөлд хүргүүлэх бөгөөд оролцогч улсуудаас хүлээн авсан мэдээлэл, тайлан илтгэлийг хэлэлцсэний үр дүнд үндэслэн ерөнхий зөвлөмж, санал гаргаж болно. Ийнхүү гаргасан ерөнхий зөвлөмж, санал нь Хорооны тайлан илтгэлд хавсаргагдах бөгөөд хэрэв оролцогч улсуудаас тайлбар ирүүлсэн бол түүнийг мөн хамтад нь хүргүүлнэ.

40 дүгээр зүйл

Оролцогч улсуудын бага хурал

1. Энэхүү конвенцийн хэрэгжилттэй холбоотой аль ч асуудлыг хэлэлцэх зорилгоор оролцогч улсууд нь Оролцогч улсуудын бага хурлыг тогтмол хуралдуулна.

2. Энэхүү конвенц хүчин төгөлдөр болсноос хойш зургаан сараас илүүгүй хугацаанд Оролцогч улсуудын бага хурлыг Нэгдсэн үндэсний Байгууллагын Ерөнхий нарийн бичгийн дарга зарлан хуралдуулна. Дараагийн Бага хурлуудыг Нэгдсэн үндэсний Байгууллагын Ерөнхий нарийн бичгийн даргын зарлан хуралдуулснаар хоёр жил тутамд нэг удаа, эсхүл оролцогч улсуудын Бага хурлаас шийдвэрлэсэн тухай бүр хуралдана.

41 дүгээр зүйл

Эх хадгалагч

Энэхүү конвенцийн эх хадгалагч нь Нэгдсэн үндэсний Байгууллагын Ерөнхий нарийн бичгийн дарга байна.

42 дугаар зүйл

Гарын үсэг зурах

Энэхүү конвенц нь Нэгдсэн үндэсний Байгууллагын Нью-Йорк хот дахь төв байранд 2007 оны 3 дугаар сарын 30-ны өдрөөс эхлэн гарын үсэг зурахад бүх улс болон бүс нутгийн хамтын ажиллагааны байгууллагуудын хувьд нээлттэй байна.

43 дугаар зүйл

Дагаж мөрдөх зөвшөөрөл

Энэхүү конвенцид гарын үсэг зурсан улсуудын хувьд түүнийг соёрхон батлах бөгөөд, гарын үсэг зурсан бүс нутгийн хамтын ажиллагааны байгууллагуудын хувьд албан ёсоор батламжилна. Энэхүү конвенцид гарын үсэг зураагүй аливаа улс болон бүс нутгийн хамтын ажиллагааны байгууллагуудын хувьд энэхүү конвенц нь нэгдэн ороход нээлттэй байна.

44 дүгээр зүйл

Бүс нутгийн хамтын ажиллагааны байгууллагууд

1. “Бүс нутгийн хамтын ажиллагааны байгууллагууд” гэж тодорхой бүс нутгийн тусгаар тогтносон улсуудаас бүрдсэн, гишүүн улсууд нь энэхүү конвенцоор зохицуулсан асуудлаар шийдвэр гаргах өөрийн эрх мэдлээ шилжүүлсэн байгууллагыг хэлнэ. Тийм байгууллагууд нь албан ёсоор батламжилсан, эсхүл нэгдэн орох тухай баримт бичигт энэхүү конвенцоор зохицуулсан асуудлын хувьд ямар эрх мэдэлтэй болох талаар тусгана. Түүний дараа эдгээр байгууллага нь өөрийн бүрэн эрхийн хүрээнд гарсан аливаа өөрчлөлтийн талаар эх хадгалагчид мэдээлж байна.

2. Энэхүү конвенцид “Оролцогч улс” гэсэн ишлэл нь эдгээр байгууллагын хувьд түүнд олгосон бүрэн эрхийн хүрээнд үйлчилнэ.

3. Энэхүү конвенцийн 45 дугаар зүйлийн 1 дэх хэсэг, 47 дугаар зүйлийн 2 болон 3 дахь хэсгийн зорилгын хүрээнд бүс нутгийн хамтын ажиллагааны байгууллагаас хадгалуулсан аль ч баримт бичгийг тооцохгүй.

4. Өөрийн эрх мэдлийн хүрээнд хамаарах асуудлаар бүс нутгийн хамтын ажиллагааны байгууллага нь Оролцогч улсуудын бага хуралд энэхүү конвенцийн оролцогч болж буй өөрийн гишүүн улсуудынхаа тоотой тэнцүү хэмжээний саналын эрхтэй оролцож болно. чингэхдээ гишүүн улсуудынх нь аль нэг нь санал өгөх эрхээ эдлэсэн тохиолдолд хамтын ажиллагааны байгууллагууд эсрэгээр санал өгөх эрхээ эдлэхгүй.

45 дугаар зүйл

Хүчин төгөлдөр болох

1. Энэхүү конвенц нь хорь дахь соёрхон батласан батламж жуух, эсхүл нэгдэн орсон тухай баримт бичгийг хадгалуулахаар хүргүүлснээс хойш гуч хоногийн дараа хүчин төгөлдөр болно.

2. Хорь дахь баримт бичгийг хадгалуулахаар өгснөөс хойш энэхүү конвенцийг соёрхон батласан буюу нэгдэн орсон улс, эсхүл албан ёсоор батламжилсан бүс нутгийн хамтын ажиллагааны байгууллагын хувьд ижил төрлийн баримт бичгээ хадгалуулахаар өгснөөс хойш гуч дахь өдрөөс эхлэн энэхүү конвенц хүчин төгөлдөр болно.

46 дугаар зүйл

Тайлбар хийх

1. Энэхүү конвенцийн зорилго, зорилттой үл нийцэх тайлбарыг хүлээн авахгүй.

2. Тайлбарыг ямар ч үед буцааж авч болно.

47 дугаар зүйл

Нэмэлт өөрчлөлт оруулах

1. Энэхүү конвенцид оролцогч аль ч улс нэмэлт өөрчлөлт хийх саналаа Нэгдсэн үндэстний Байгууллагын Ерөнхий нарийн бичгийн даргад хүргүүлж болно. Ерөнхий нарийн бичгийн дарга уг саналыг оролцогч улсуудад мэдээлж, тухайн саналыг хэлэлцэж санал хураах Оролцогч улсуудын бага хурал хуралдуулах саналтай эсэхээ хариу мэдэгдэхийг хүснэ. Ийнхүү мэдээлснээс хойш дөрвөн сарын дотор оролцогч улсын гуравны нэгээс багагүй нь Бага хурлыг хуралдуулах саналтай байвал Ерөнхий нарийн бичгийн дарга түүнийг Нэгдсэн үндэстний Байгууллагын ивээл дор зарлан хуралдуулна. Нэмэлт өөрчлөлт нь хуралд оролцогч улсуудын гуравны хоёроос доошгүйн саналаар дэмжигдэх бөгөөд ийнхүү дэмжигдсэн нэмэлт өөрчлөлийг Ерөнхий нарийн бичгийн дарга Ерөнхий Ассамблейгаар батлуулахаар хүргүүлэх бөгөөд дараа нь оролцогч улсуудаар хүлээн зөвшөөрүүлэхээр хүргүүлнэ.

2. 1 дэх хэсгийн заалтын дагуу дэмжигдэж, батлагдсан нэмэлт өөрчлөлт нь тухайн нэмэлт өөрчлөлтийг дэмжих үед байлцсан оролцогч улсуудын гуравны хоёрын тоотой тэнцүү тооны улс түүнийг хүлээн зөвшөөрсөн тухай баримт бичгийг хадгалуулахаар хүргүүлснээс хойш гуч хоногийн дараа хүчин төгөлдөр болно. Түүнээс хойш нэмэлт өөрчлөлтийг хүлээн зөвшөөрсөн оролцогч аливаа улсын хувьд хүлээн зөвшөөрсөн тухай баримт бичгээ хадгалуулахаар хүргүүлснээс хойш гуч хоногийн

дараа нэмэлт өөрчлөлт нь хүчин төгөлдөр болно. Хүчин төгөлдөр болсон нэмэлт өөрчлөлт нь зөвхөн түүнийг батласан оролцогч улсуудын хувьд заавал дагаж мөрдөх хүчинтэй байна.

3. Хэрвээ Оролцогч улсуудын бага хурлаас нийтийн тохиролцооны үндсэн дээр шийдвэрээ гаргасан бол энэхүү конвенцийн 34, 38, 39 болон 40 дүгээр зүйлийн заалтад хамаарах энэ зүйлийн 1 хэсгийн заалтын дагуу дэмжигдэж, батлагдсан нэмэлт өөрчлөлт нь түүнийг дэмжих үед байлцсан оролцогч улсуудын гуравны хоёртой тэнцүү тооны хүлээн зөвшөөрсөн тухай баримт бичгийг хадгалуулахаар хүргүүлсэн өдрөөс хойш гуч хоногийн дараа оролцогч бүх улсын хувьд хүчин төгөлдөр болно.

48 дугаар зүйл

Цуцлах

Оролцогч аливаа улс Нэгдсэн үндэсний Байгууллагын Ерөнхий нарийн бичгийн даргад бичгээр мэдэгдэх замаар энэхүү конвенцийг цуцалж болно. Цуцлалт нь Ерөнхий нарийн бичгийн дарга мэдэгдлийг хүлээн авснаас хойш нэг жилийн дараа хүчин төгөлдөр болно.

49 дүгээр зүйл

Боломжит хувилбар

Энэхүү конвенцийн эх бичвэр нь хүртээмжтэй хэлбэрээр үйлдэгдэнэ.

50 дугаар зүйл

Ижил хүчинтэй эх бичвэр

Энэхүү конвенцийн англи, араб, испани, орос, хятад, франц хэлээрх эх бичвэр нь ижил хүчинтэй байна.

Үүнийг нотолж, засгийн газраасаа зохих ёсоор бүрэн эрх олгогдсон бүрэн эрх төлөөлөгчид энэхүү конвенцид гарын үсэг зурав.

—oOo—

ХӨГЖЛИЙН БЭРХШЭЭЛТЭЙ ХҮМҮҮСИЙН ЭРХИЙН ТУХАЙ КОНВЕНЦИЙН НЭМЭЛТ ПРОТОКОЛ

Энэхүү протоколд оролцогч улсууд нь дараахь зүйлийн талаар хэлэлцэн тохиров:

1 дүгээр зүйл

1. Энэхүү протоколд оролцогч улсууд (цаашид “Оролцогч улсууд” гэх) нь Конвенцид тусгасан аль нэг эрхийг оролцогч тухайн улс зөрчсөний улмаас хохирсон хэмээн мэдүүлж буй харьяат этгээдийнх нь мэдээллийг хүлээн авч, хянан хэлэлцэх Хөгжлийн бэрхшээлтэй хүний эрхийн Хорооны (“Хороо”) хэргийн харьяаллыг хүлээн зөвшөөрнө.

2 Конвенцийн оролцогч улс хэдий ч энэхүү протоколд нэгдэн ороогүй улстай холбоотой аливаа мэдээллийг Хороо хүлээн авахгүй.

2 дугаар зүйл

Хороо нь дараахь тохиолдолд мэдээллийг хүлээн авах боломжгүй гэж үзнэ:

а) мэдээлэл нь нэр хаяггүй;

б) мэдээлэл нь тийнхүү мэдээлэх эрхээ урвуулан ашигласан буюу энэхүү конвенцийн зүйл заалттай нийцээгүй;

с) тухайн асуудал олон улсын мөрдөн шалгах буюу зохицуулах өөр журмын дагуу шалгагдсан, эсхүл өөр хороогоор хэлэлцэгдсэн;

д) дотоодын эрх зүйн хамгаалалтын бүхий л арга хэрэгслийг барагдуулаагүй. Эдгээр арга хэрэгслийг ашиглах явдал хүндэтгэх шалтгаангүйгээр удааширсан бол энэ журмыг мөрдөхгүй;

е) мэдээлэл нь үндэслэлгүй буюу хангалттай нотлогдож чадахгүй;

ф) мэдээлэлд дурдагдсан баримт нь оролцогч тухайн улсын хувьд энэхүү протокол хүчин төгөлдөр болохоос өмнө бий болсон бөгөөд тухайн мэдээлэл хүргэгдэх өдрийг хүртэл үргэлжлээгүй.

3 дугаар зүйл

2 дугаар зүйлийн заалтын дагуу Хороо энэхүү протоколын дагуу ирүүлсэн аливаа мэдээллийг нууцалж оролцогч улсын сонорт хүргэнэ. Мэдээлэл хүлээн авсан улс дурдагдсан асуудлын талаар,

түүнчлэн тухайн улсаас авсан байж болох аливаа арга хэмжээ байгаа бол тэр тухайгаа тодруулсан тайлбар буюу мэдэгдэл бичгээр гаргаж зургаан сарын дотор Хороонд ирүүлнэ.

4 дүгээр зүйл

1. Хороо мэдээллийг хүлээн авсны дараа аль ч үед болон түүний талаар зарчмын шийдвэр гаргахаасаа өмнө оролцогч холбогдогч улсад хандаж, эрх нь зөрчигдсөн байж болзошгүй хохирогч буюу хохирогчдод нөхөж баршгүй хохирол учрахаас урьдчилан сэргийлэх үүднээс оролцогч тухайн улс зайлшгүй шинжтэй түр арга хэмжээ авахыг хүсч болно.

2. Энэ зүйлийн 1 дэх хэсгийн заалтын дагуу Хорооны өөрийн эрх мэдлийн бүрээнд хамаарах эрхээ хэрэгжүүлж байгаа нь энэ мэдээллийг хүлээн авч болох эсэх буюу түүний талаар зарчмын шийдвэр гаргаж байгаа хэрэг биш юм.

5 дугаар зүйл

Энэхүү протоколд дурдагдсан мэдээллийг Хороо нь хаалттай хуралдаанаар хэлэлцэнэ. Мэдээллийг шалгаж тогтоосныхоо дараа Хороо нь хэрэв холбогдох зөвлөмж, санал гаргасан бол тэдгээрийг оролцогч улс болон гомдол гаргагчид мэдээлнэ.

6 дугаар зүйл

1. Конвенцид заасан эрхийг оролцогч улс ноцтойгоор удаа дараа зөрчиж байгаа тухай баттай мэдээллийг Хороо хүлээн авсан бол мэдээллийг шалгахад хамтран оролцож, мэдээллийн талаархи саналаа ирүүлэхийг оролцогч улсаас хүсч болно.

2. Оролцогч холбогдох улсаас ирүүлж болох аливаа санал, түүнчлэн Хороонд байгаа баталгаатай бусад мэдээллийг харгалзан Хороо мөрдөн шалгах ажиллагаа явуулж, дүнг яаралтай илтгүүлэх зорилгоор нэг буюу хэд хэдэн гишүүнээ томилж болно. Шаардлагатай гэж үзсэн бөгөөд оролцогч тухайн улс зөвшөөрсөн тохиолдолд тухайн улсын нутаг дэвсгэрт очиж мөрдөн шалгах ажиллагаа явуулж болно.

3. Тэрхүү мөрдөн шалгах ажиллагааны дүнг судалж үзсэний дараа Хороо нь үр дүнг санал, зөвлөмжийнхөө хамт оролцогч холбогдох улсад хүргүүлнэ.

4. Хорооноос ирүүлсэн үр дүн, санал, зөвлөмжийг хүлээн авснаас хойш зургаан сарын дотор оролцогч холбогдогч улс Хороонд хариу илгээнэ.

5. Мөрдөн шалгах тухайн ажиллагааг нууцлалыг хадгалсан байдлаар явуулах бөгөөд энэ ажлын бүхий л үе шатанд оролцогч улсын зүгээс хамтын ажиллагааг хангах бүх арга хэмжээг авна.

7 дугаар зүйл

1. Энэхүү протоколын 6 дугаар зүйлийн дагуу явуулсан мөрдөн шалгалтын ажиллагаатай холбогдуулан авсан аливаа арга хэмжээний тухай дэлгэрэнгүй мэдээллийг Конвенцийн 35 дугаар зүйлийн дагуу ирүүлэх тайлан илтгэлдээ тусгахыг Хороо оролцогч холбогдогч улсаас хүсч болно.

2. Шаардлагатай тохиолдолд 6 дугаар зүйлийн 4 дэх хэсэгт заасан зургаан сарын хугацаа дууссаны дараа мөрдөн шалгалтын ажиллагаатай холбогдуулан авсан аливаа арга хэмжээний тухай мэдээлэхийг Хороо оролцогч холбогдогч улсаас хүсч болно.

8 дугаар зүйл

Оролцогч аливаа улс энэхүү протоколд гарын үсэг зурах, түүнийг соёрхон батлах, эсхүл нэгдэж орохдоо 6 болон 7 дугаар зүйлд заасан Хорооны эрх мэдлийг зөвшөөрөхгүй байгаагаа мэдэгдэж болно.

9 дүгээр зүйл

Энэхүү протоколын эх хадгалагч нь Нэгдсэн үндэсний Байгууллагын Ерөнхий нарийн бичгийн дарга байна.

10 дугаар зүйл

Энэхүү протокол нь Нэгдсэн үндэсний Байгууллагын Нью-Йорк хот дахь төв байранд 2007 оны 3 дугаар 30-ны өдрөөс гарын үсэг зурахад бүх улсууд болон бүс нутгийн хамтын ажиллагааны байгууллагуудад нээлттэй болно.

11 дүгээр зүйл

Энэхүү протокол нь Конвенцийг соёрхон батласан, эсхүл нэгдэн орж энэхүү протоколд гарын үсэг зурсан оролцогч улсуудын хувьд соёрхон батлавал зохино. Түүнчлэн Конвенцийг албан ёсоор батламжилсан, эсхүл нэгдэн орсон бүс нутгийн хамтын ажиллагааны байгууллагуудын хувьд энэхүү протоколыг албан ёсоор батламжилна. Конвенцийг соёрхон батласан, эсхүл нэгдэн орсон буюу албан ёсоор батламжилсан боловч Протоколд гарын үсэг зураагүй оролцогч улсууд болон бүс нутгийн хамтын ажиллагааны байгууллагуудын хувьд энэхүү протокол нэгдэн ороход нээлттэй байна.

12 дугаар зүйл

1. “Бүс нутгийн хамтын ажиллагааны байгууллагууд” гэж тодорхой бүс нутгийн тусгаар тогтносон улсуудаас бүрдсэн гишүүн улсууд нь Конвенц болон энэхүү протоколоор зохицуулсан

асуудлаар шийдвэр гаргах өөрийн эрх мэдлээ шилжүүлсэн байгууллагыг хэлнэ. Тийм байгууллагууд нь албан ёсоор батламжилсан, эсхүл нэгдэн орох тухай баримт бичигт Конвенц болон энэхүү протоколоор зохицуулсан асуудлын хувьд ямар эрх мэдэлтэй болох талаар тусгана. Түүний дараа эдгээр байгууллага нь өөрийн бүрэн эрхийн хүрээнд гарсан аливаа өөрчлөлтийн талаар эх хадгалагчид мэдээлж байна.

2. Энэхүү протоколд “Оролцогч улс” гэсэн ишлэл нь эдгээр байгууллагын хувьд түүнд олгосон бүрэн эрхийн хүрээнд үйлчилнэ.

3. Энэхүү протоколын 13 зүйлийн 1 дэх хэсэг, 15 дугаар зүйлийн 2 дахь хэсгийн зорилгын хүрээнд бүс нутгийн хамтын ажиллагааны байгууллагаас хадгалуулсан аль ч баримт бичгийг тооцохгүй.

4. өөрийн эрх мэдлийн хүрээнд хамаарах асуудлаар бүс нутгийн хамтын ажиллагааны байгууллага нь оролцогч улсуудын зөвлөлдөөнд энэхүү протоколын оролцогч болж буй өөрийн гишүүн улсуудынхаа тоотой тэнцүү хэмжээний саналын эрхтэй оролцож болно. чингэхдээ гишүүн улсуудынх нь аль нэг нь санал өгөх эрхээ эдлэсэн тохиолдолд хамтын ажиллагааны байгууллагууд эсрэгээр санал өгөх эрхээ эдлэхгүй.

13 дугаар зүйл

1. Конвенцийг хүчин төгөлдөр болсон нөхцөлд энэхүү протокол нь арав дахь соёрхон батласан батламж жуух, эсхүл нэгдэн орсон тухай баримт бичгийг хадгалуулахаар хүргүүлснээс хойш гуч хоногийн дараа хүчин төгөлдөр болно.

2. Арав дахь баримт бичгийг хадгалуулахаар өгснөөс хойш энэхүү протоколыг соёрхон батласан буюу нэгдэн орсон, эсхүл албан ёсоор батламжилсан улс, эсхүл бүс нутгийн хамтын ажиллагааны байгууллагын хувьд ижил төрлийн баримт бичгээ хадгалуулахаар өгснөөс хойш гуч дахь өдрөөс эхлэн энэхүү протокол хүчин төгөлдөр болно.

14 дүгээр зүйл

1. Энэхүү протоколын зорилго, зорилттой үл нийцэх тайлбарыг хүлээн авахгүй.

2. Тайлбарыг аль ч үед буцааж авч болно.

15 дугаар зүйл

1. Энэхүү протоколд оролцогч аливаа улс түүнд нэмэлт өөрчлөлт хийх саналаа Нэгдсэн үндэстний Байгууллагын Ерөнхий нарийн бичгийн даргад хүргүүлж болно. Ерөнхий нарийн бичгийн дарга нь уг саналыг оролцогч улсуудад уламжилж, уг саналыг хэлэлцэж, санал хураахаар оролцогч улсуудын зөвлөлдөөн хийх эсэхээ хариу мэдэгдэхийг хүснэ. Ийнхүү мэдээлснээс хойш дөрвөн сарын дотор оролцогч улсын гуравны нэгээс багагүй зөвлөлдөөн хийх саналтай байвал Ерөнхий

нарийн бичгийн дарга түүнийг Нэгдсэн үндэстний Байгууллагын ивээл дор хийлгэнэ. Нэмэлт өөрчлөлт нь зөвлөлдөөнд оролцогч улсуудын гуравны хоёроос доошгүйн саналаар дэмжигдэх бөгөөд ийнхүү дэмжигдсэн нэмэлт өөрчлөлийг Ерөнхий нарийн бичгийн дарга Ерөнхий Ассамблейгаар батлуулахаар хүргүүлэх бөгөөд дараа нь оролцогч улсуудаар хүлээн зөвшөөрүүлэхээр хүргүүлнэ.

2. 1 дэх хэсгийн заалтын дагуу дэмжигдэж, батлагдсан нэмэлт өөрчлөлт нь тухайн нэмэлт өөрчлөлтийг дэмжих үед байсан оролцогч улсуудын гуравны хоёрын тоотой тэнцүү тооны улс түүнийг хүлээн зөвшөөрсөн тухай баримт бичгийг хадгалуулахаар хүргүүлснээс хойш гуч хоногийн дараа хүчин төгөлдөр болно. Түүнээс хойш нэмэлт өөрчлөлтийг хүлээн зөвшөөрсөн оролцогч аливаа улсын хувьд хүлээн зөвшөөрсөн тухай баримт бичгээ хадгалуулахаар хүргүүлснээс хойш гуч хоногийн дараа нэмэлт өөрчлөлт нь хүчин төгөлдөр болно. Хүчин төгөлдөр болсон нэмэлт өөрчлөлт нь зөвхөн түүнийг батласан оролцогч улсуудын хувьд заавал дагаж мөрдөх хүчинтэй байна.

16 дугаар зүйл

Оролцогч аливаа улс Нэгдсэн үндэсний Байгууллагын Ерөнхий нарийн бичгийн даргад бичгээр мэдэгдэж энэхүү протоколыг цуцалж болно. Цуцлалт нь Ерөнхий нарийн бичгийн дарга мэдэгдлийг хүлээн авснаас хойш нэг жилийн дараа хүчин төгөлдөр болно.

17 дугаар зүйл

Энэхүү протоколын эх бичвэр нь хүртээмжтэй хэлбэрээр үйлдэгдэнэ.

18 дугаар зүйл

Энэхүү протоколын англи, араб, испани, орос, хятад, франц хэлээрх эх бичвэр нь ижил хүчинтэй байна.

үүнийг нотолж, засгийн газраасаа зохих ёсоор бүрэн эрх олгогдсон бүрэн эрх төлөөлөгчид энэхүү протоколд гарын үсэг зурав.

—oOo—

ХӨГЖЛИЙН БЭРХШЭЭЛТЭЙ ИРГЭНИЙ НИЙГМИЙН ХАМГААЛЛЫН ТУХАЙ

/шинэчилсэн найруулга/

НЭГДҮГЭЭР БҮЛЭГ

Нийтлэг үндэслэл

1 дүгээр зүйл. Хуулийн зорилт

1.1.Энэ хуулийн зорилт нь хөгжлийн бэрхшээлтэй иргэнийг нийгмийн харилцаанд аливаа ялгаваргүйгээр тэгш оролцуулах нөхцлийг бүрдүүлэх, тэдний өвөрмөц хэрэгцээнд түшиглэсэн нийгмийн хамгааллын үйлчилгээ үзүүлэх, энэ талаар иргэн, хуулийн этгээдийн хүлээх үүрэг хариуцлагыг тодорхойлохтой холбогдсон харилцааг зохицуулахад оршино.

/Энэ хэсгийг 2008 оны 1 дүгээр сарын 15-ны өдрийн хуулиар өөрчлөн найруулсан/

2 дугаар зүйл. Хөгжлийн бэрхшээлтэй иргэний нийгмийн хамгааллын тухай хууль тогтоомж

2.1.Хөгжлийн бэрхшээлтэй иргэний нийгмийн хамгааллын тухай хууль тогтоомж нь Үндсэн хууль¹, Нийгмийн халамжийн тухай хууль, энэ хууль болон тэдгээртэй нийцүүлэн гаргасан хууль тогтоомжийн бусад актаас бүрдэнэ.

2.2.Монгол Улсын олон улсын гэрээнд энэ хуульд зааснаас өөрөөр заасан бол олон улсын гэрээний заалтыг дагаж мөрдөнө.

3 дугаар зүйл. Хуулийн нэр томъёо

3.1.Бие махбодь, оюун санаа, сэтгэл мэдрэл, мэдрэхүйн согогийн улмаас бусдын адил нийгмийн харилцаанд оролцох чадвар нь эн болон 12 сараас дээш хугацаагаар хязгаарлагдсан хүнийг “хөгжлийн бэрхшээлтэй” гэж ойлгоно.

/Энэ хэсгийг 2008 оны 1 дүгээр сарын 15-ны өдрийн хуулиар өөрчлөн найруулсан/

—oOo—

¹ Монгол Улсын Үндсэн хууль-”Төрийн мэдээлэл” эмхтгэлийн 1992 оны 1 дүгээрт нийтлэгдсэн.

ХОЁРДУГААР БҮЛЭГ

Хөгжлийн бэрхшээлтэй иргэний нийгмийн хамгаалал

4 дүгээр зүйл. Нийгмийн хамгааллын арга хэмжээ

4.1.Энэ хуулийн 3 дугаар зүйлд заасан иргэн нийгмийн хамгааллын дараахь үйлчилгээнд хамрагдах эрхтэй:

- 4.1.1. нийгмийн даатгалын тэтгэвэр, тэтгэмж;
- 4.1.2. нийгмийн халамжийн тэтгэвэр;
- 4.1.3. нөхцөлт мөнгөн тэтгэмж;
- 4.1.4. тусламж, хөнгөлөлт;
- 4.1.5. төрөлжсөн асрамжийн үйлчилгээ;
- 4.1.6. олон нийтийн оролцоонд түшиглэсэн халамжийн үйлчилгээ;
- 4.1.7. хөдөлмөр эрхлэлтийг дэмжих үйлчилгээ;
- 4.1.8. эрүүл мэндийн үйлчилгээ;
- 4.1.9. боловсрол, соёл, урлагийн үйлчилгээ.

5 дугаар зүйл. Нийгмийн халамжийн сангаас хөгжлийн бэрхшээлтэй иргэнд үзүүлэх тусламж, хөнгөлөлт

5.1.Энэ хуулийн 3 дугаар зүйлд заасан иргэнд нийгмийн халамжийн сангаас дор дурдсан тусламж, хөнгөлөлтийг үзүүлнэ:

5.1.1. бүрэн хараагүй, бүрэн хэлгүй дүлий, одой иргэн болон байнгын асаргаа шаардлагатай хөдөлмөрийн чадвараа бүрэн алдсан хөгжлийн бэрхшээлтэй иргэнд орон сууцны хөлс төлөхөд, хэрэв нийтийн халаалтгүй сууц, гэрт амьдардаг бол түлш худалдан авахад нь жилд нэг удаа мөнгөн тусламж олгох;

/Энэ заалтыг 2008 оны 1 дүгээр сарын 15-ны өдрийн хуулиар өөрчлөн найруулсан/

5.1.2. 18 хүртэлх насны хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийн дотоодод хийлгэсэн протезийн үнийг 3 жил тутам нэг удаа 100 хувь нөхөн олгох;

/Энэ заалтад 2008 оны 1 дүгээр сарын 15-ны өдрийн хуулиар өөрчлөлт орсон/

5.1.3. үйлдвэрлэлийн осол, мэргэжлээс шалтгаалсан өвчний даатгалын сангаас протез хийлгэх, сэргээн засалттай холбогдсон хөнгөлөлт авах эрх үүсээгүй хөгжлийн бэрхшээлтэй иргэний дотоодод хийлгэсэн протезийн үнийг 5 жил тутам нэг удаа 100 хувь нөхөн олгох;

/Энэ заалтад 2008 оны 1 дүгээр сарын 15-ны өдрийн хуулиар өөрчлөлт орсон/

5.1.4. 18 хүртэлх насны хөгжлийн бэрхшээлтэй хүүхэд, түүнчлэн үйлдвэрлэлийн осол, мэргэжлээс шалтгаалсан өвчний даатгалын сангаас протез хийлгэх, сэргээн засалттай холбогдсон хөнгөлөлт авах эрх үүсээгүй, ядуу амьдралтай эрхийн хөгжлийн бэрхшээлтэй иргэний дотоодод хийлгэсэн болон худалдан авсан ортопед, тэргэнцэр зэрэг тусгай хэрэгслийн үнийг 5 жил тутам нэг удаа 100 хувь нөхөн олгох;

/Энэ заалтад 2008 оны 1 дүгээр сарын 15-ны өдрийн хуулиар нэмэлт, өөрчлөлт орсон/

5.1.5. хөгжлийн бэрхшээлтэй хүүхэд болон түүний асран хамгаалагч, харгалзан дэмжигчийн тусгай сургуульд ирж, очих унааны зардлыг жилд нэг удаа хөнгөлөх;

/Энэ заалтад 2008 оны 1 дүгээр сарын 15-ны өдрийн хуулиар өөрчлөлт грсгн/

5.1.6. эмчилгээ, сувилгаа шаардлагатай хөгжлийн бэрхшээлтэй хүүхэд болон үйлдвэрлэлийн осол, мэргэжлээс шалтгаалсан өвчний даатгалын сангаас протез хийлгэх, сэргээн засалттай хгльгдсгн хөнгөлөлт авах эрх үүсээгүй хөдөлмөрийн чадвараа бүрэн алдсан иргэн дгтггдын рашаан сувилалд сувилуулбал нэг талын унааны зардал, эрхийн бичгийн үнийн 50 хувийг жилд нэг удаа нөхөн олгох;

/Энэ заалтад 2008 оны 1 дүгээр сарын 15-ны өдрийн хуулиар нэмэлт, өөрчлөлт орсон/

5.1.7. хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийн болон хөдөлмөрийн чадвараа бүрэн алдсан иргэний нэг хүүхдийн цэцэрлэгийн хоолны зардлын төлбөрт хөнгөлөлт үзүүлэх;

/Энэ заалтад 2008 оны 1 дүгээр сарын 15-ны өдрийн хуулиар өөрчлөлт орсон/

5.1.8. насанд хүрсэн бүрэн хараагүй иргэний харилцаа холбооны зардалд хөнгөлөлт үзүүлэх;

/Энэ заалтад 2008 оны 1 дүгээр сарын 15-ны өдрийн хуулиар өөрчлөлт орсон/

5.1.9. нийслэлээс 1000 ба түүнээс дээш км алслагдсан газарт байнга оршин суудаг хөгжлийн бэрхшээлтэй хүн аймгийн нэгдсэн эмнэлгийн нарийн мэргэжлийн эмч нарын хяналтын комиссын шийдвэрээр нийслэлд ирж эмчлүүлэх, шинжилгээ хийлгэх тохиолдолд нэг талын унааны зардлыг жилд нэг удаа нөхөн олгох;

5.1.10. хараагүй хүний брайлын үсгээр бичсэн захидал, ил захидал, брайль хэвлэл 10 кг хүртэлх илгээмжийг дотоодод үнэ төлбөргүй явуулж, хараагүй хүний згриулалттай техник, тоног төхөөрөмж, материал хэрэгслийг дгтггдгд үнэ төлбөргүй хүргүүлэх;

5.1.11. бүрэн хараагүй хүн эмнэлэгийн байгууллагын дүгнэлтээр эмчлүүлэх, рашаан сувилалд сувилуулахаар аймгаас нийслэлд, нийслэлээс аймагт згрчих шаардлагатай болвол ирж буцах унааны зардлын 75 хувийг жилд нэг удаа нөхөн олгох;

5.1.12. хөгжлийн бэрхшээлтэй хүүхэд нь хүүхдийн зусланд амарвал эрхийн бичгийн үнийн 50 хувийг жилд нэг удаа олгох;

5.1.13. нийгмийн даатгалын тухай хууль тогтоомжид заасан оршуулгын тэтгэмж авах эрх үүсээгүй, хөгжлийн бэрхшээлтэй ганц бие иргэн нас барвал түүний оршуулгын зардалд нийгмийн даатгалын сангаас олгох оршуулгын тэтгэмжийн 75 хувьтай тэнцэх хэмжээний мөнгөн тусламж олгох.

/Дээрх 5.1.9-5.1.13 дахь заалтыг 2008 оны 1 дүгээр сарын 15-ны өдрийн хуулиар нэмсэн/

5.2. Энэ хуулийн 3 дугаар зүйлд заасан иргэн нийслэл, аймгийн төвийн нийтийн тээврийн хэрэгсэл /таксинаас бусад/-ээр орон нутгийн харъяалал харгалзахгүйгээр үнэ төлбөргүй зорчино.

/Энэ хэсэгт 2008 оны 1 дүгээр сарын 15-ны өдрийн хуулиар өөрчлөлт орсон/

5.3. Худалдаа, тээвэр, холбоо, эрүүл мэнд, нийтийн үйлчилгээний байгууллага хөгжлийн бэрхшээлтэй иргэнд тэргүүн ээлжинд үйлчилнэ.

5.4. Энэ хуулийн 5.1-д заасан тусламж, хөнгөлөлтийн хэмжээ, олгох журмыг Засгийн газар батална.

5.5. Энэ хуулийн 3 дугаар зүйлд заасан иргэнийг Нийгмийн халамжийн тухай хуульд заасны дагуу төрөлжсөн асрамжийн, эсхүл олон нийтийн оролцоонд түшиглэсэн халамжийн үйлчилгээнд хамруулж болно.

5.6. Орон гэргүй бүрэн хараагүй, бүрэн хэлгүй дүлий, одой иргэн бглгн байнгын асаргаа шаардлагатай хөдөлмөрийн чадвараа бүрэн алдсан хөгжлийн бэрхшээлтэй иргэнд гэр олгох, орон сууцны нөхцөл сайжруулах арга хэмжээнд зарцуулах хөрөнгийг Засгийн газар тухайн жилийн улсын төсөвт тусгана.

/Энэ хэсгийг 2008 оны 1 дүгээр сарын 15-ны өдрийн хуулиар нэмсэн/

6 дугаар зүйл. Хөгжлийн бэрхшээлтэй иргэний сэргээн засалт

6.1. Энэ хуулийн 3 дугаар зүйлд заасан хүн нийгмийн харилцаанд оролцох, өөрөө өөртөө үйлчилж сурах, бие даан хөгжих чадвар эзэмших згрилггтр сэргээн засах үйлчилгээнд хамрагдах эрхтэй. Сэргээн засах үйлчилгээ нь эрүүл мэнд, мэргэжил, боловсрол, хөдөлмөр, нийгмийн болон сэтгэл зүйн гэсэн төрөлтэй байна.

6.2. Энэ хуулийн 6.1-д заасан үйлчилгээг сэргээн засах үйлчилгээ үзүүлдэг эмчилгээ, сувилгааны, сургалтын байгууллага болон протез, ортопедийн хэрэгслийн үйлдвэрлэл эрхэлдэг аж ахуйн нэгж үзүүлнэ.

6.3. Хөгжлийн бэрхшээлтэй хүний сэргээн засах үйлчилгээг иргэн, хувийн хэвшлийн аж ахуйн нэгж, төрийн бус байгууллагаар гэрээний үндсэн дээр гүйцэтгүүлж, зардлыг хэсэгчлэн буюу бүрэн санхүүжүүлж болно.

/Дээрх 6 дугаар зүйлийг 2008 оны 1 дүгээр сарын 15-ны өдрийн хуулиар өөрчлөн найруулсан/

**7 дугаар зүйл. Хөгжлийн бэрхшээлтэй иргэний сурах,
боловсрол эзэмших эрх**

7.1. Сүрьеэ зэрэг архаг халдварт өвчний халдвартай үед байгаагаас бусад тохиолдолд энэ хуулийн 3 дугаар зүйлд заасан иргэн эрүүл иргэдтэй хамт сурч, боловсрох, мэргэжил эзэмших эрхтэй бөгөөд тэдгээрийг бүх шатны боловсрол эзэмшихэд төрөөс дэмжлэг үзүүлнэ..

/Энэ хэсэгт 2008 оны 1 дүгээр сарын 15-ны өдрийн хуулиар нэмэлт орсон/

7.2. Бүх шатны боловсролын болон мэргэжил олгох байгууллага нь сурч, боловсрох, мэргэжил эзэмших чадвартай энэ хуулийн 3 дугаар зүйлд заасан иргэнийг энэ хуулийн 7.1-д зааснаас бусад үндэслэлээр элсүүлэхээс, элсэлтийн шалгалтад оруулахаас татгалзахыг хориглоно.

7.3. Энэ хуулийн 3 дугаар зүйлд заасан хүүхэд энэ хуулийн 7.1-д заасан шалтгаангүй бгл сургуулийн өмнөх боловсролын сургалтын байгууллагад эрүүл хүүхэдтэй хамт хүмүүжих эрхтэй.

7.4. Дотоодын их, дээд сургууль, коллеж, мэргэжлийн боловсролын сургалтын байгууллага нь энэ хуулийн 3 дугаар зүйлд заасан иргэнийг элсүүлэх хөнгөлөлттэй нөхцөл бүрдүүлж, тэнцсэн тохиолдолд тухайн иргэний, түүнчлэн хөдөлмөрийн чадвараа бүрэн алдсан гишүүнтэй өрхийн нэг сурагч буюу оюутны сургалтын зардлыг сургалтын төрийн сан хариуцна.

7.5. Тусгай хэрэгцээт боловсрол олгох ясли, цэцэрлэг, бүх шатны сургууль, мэргэжлийн сургалт-үйлдвэрлэлийн төвд суралцах хүүхэд ба иргэнийг эрүүл мэндийн байгууллагын нарийн мэргэжлийн эмч нарын хяналтын комисс тодорхойлно.

/Энэ хэсэгт 2008 оны 1 дүгээр сарын 15-ны өдрийн хуулиар өөрчлөлт орсон/

7.6. Тусгай хэрэгцээт боловсрол олгох сургалтын байгууллага нь энэ хуулийн 3 дугаар зүйлд заасан иргэний боломжид үндэслэн стандартын дагуу болгосрол эзэмшүүлнэ.

7.7. Тусгай хэрэгцээт боловсрол олгох сургалтын стандартыг боловсролын болон нийгмийн хамгааллын асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага хамтран боловсруулж, стандартчиллын төв байгууллагаар батлуулна.

7.8. Тусгай хэрэгцээт боловсрол олгох сургалтын байгууллагын удирдах болон гүйцэтгэх албан тушаалтанд үндсэн цалингийн 10-30 хувьтай тэнцэх хэмжээний нэмэгдэл хөлс олгоно.

/Энэ хэсэгт 2008 оны 1 дүгээр сарын 15-ны өдрийн хуулиар нэмэлт орсон/

7.9. Хөгжлийн бэрхшээлтэй иргэн тусгай хэрэгцээт боловсролд үнэ төлбөргүй хамрагдахыг төрөөс дэмжинэ.

7.10. Энэ хуулийн 7.4, 7.9-д заасан сургалтын зардлын хэмжээ, 7.8-д заасан нэмэгдэл хөлс олгох журмыг Засгийн газар батална.

8 дугаар зүйл. Хөгжлийн бэрхшээлтэй иргэний хөдөлмөр эрхлэлт

8.1. Энэ хуулийн 3 дугаар зүйлд заасан иргэн ажил, хөдөлмөр эрхлэхэд нь дэмжлэг үзүүлж түүний ажилладаг аж ахуйн нэгж, байгууллагад хууль тогтоомжид заасан хөнгөлөлт эдлүүлнэ.

8.2. Аж ахуйн нэгж, байгууллагын эрх баригчид хөгжлийн бэрхшээлтэй иргэнийг хүндэтгэн үзэх шалтгаангүйгээр ажлаас халах, энэ хуулийн 7.1-д зааснаас бусад тохиолдолд боломжтой ажил, албан тушаалд авч ажиллуулахаас татгалзахыг хориглоно.

8.3. Энэ хуулийн 3 дугаар зүйлд заасан иргэний ажлын цагийг Хөдөлмөрийн тухай² хуулийн 71.5-д заасны дагуу богинсгож болно.

8.4. Аж ахуйн нэгж, байгууллагад хараагүй хүнийг ажиллуулах ажлын байрны жагсаалтыг Засгийн газар батална.

/Энэ хэсгийг 2008 оны 1 дүгээр сарын 15-ны өдрийн хуулиар нэмсэн/

9 дүгээр зүйл. Хөгжлийн бэрхшээлтэй иргэний соёл, урлаг, биеийн тамир, олон нийтийн арга хэмжээ

9.1. Энэ хуулийн 3 дугаар зүйлд заасан иргэнийг олон улсын бглгн өөрийн оронд згхиггддгг соёл, урлаг, биеийн тамир, олон нийтийн арга хэмжээнд идэвхтэй оролцоход нь төрөөс дэмжинэ.

9.2. Энэ хуулийн 3 дугаар зүйлд заасан иргэнд зориулсан соёл, урлаг, биеийн тамир, олон нийтийн арга хэмжээ нь түүний чадавхид зохицсон байна.

9.3. Энэ хуулийн 3 дугаар зүйлд заасан иргэнд зориулсан дор дурдсан арга хэмжээг төрийн зохих байгууллага зохион байгуулна:

9.3.1.ажил, амьдралынх нь талаар олон нийтийн мэдээллийн хэрэгслээр сурталчлах;

9.3.2.телевизийн нэвтрүүлгийг дохионы хэлний орчуулгатай гаргах, урсгал мэдээлэл явуулах, бичгэн мэдээллийг хараагүй хүнд зориулж нэвтрүүлэгч унших;

/Энэ заалтад 2008 оны 1 дүгээр сарын 15-ны өдрийн хуулиар нэмэлт, өөрчлөлт орсон/

9.3.3. нийтийн тээврийн хэрэгсэл, төмөр зам, орон сууц, албан байгууллага, нийтийн үйлчилгээний газрын орц, гарц, гэрэлтүүлэг, бие засах газрын зорчих хэсгийг эдгээр иргэдийн хязгаарлагдмал боломжид тохируулан хийх;

9.3.4. гэрлэн дохио, нийтийн үзвэр, үйлчилгээний газрын талбай, зам, харилцаа, холбооны хэрэгсэл эдгээр иргэдийн хэрэгцээ, шаардлагад зохицсон байх;

² Хөдөлмөрийн тухай хууль-"Төрийн мэдээлэл" эмхтгэлийн 1999 оны 25 дугаарт нийтлэгдсэн

9.3.5. аж ахуйн нэгж, байгууллагын эрх баригчид эдгээр иргэдийн соёл, урлаг, биеийн тамир, олон нийтийн арга хэмжээнд санхүүгийн туслалцаа үзүүлэх;

9.3.6. нийгмийн амьдралд идэвхтэй оролцож, дорвитгй хувь нэмэр оруулсан хөгжлийн бэрхшээлтэй иргэн болон эдгээр иргэдийн нийгмийн хамгааллын талаар хүлээсэн үүргээ сайн биелүүлсэн аж ахуйн нэгж, байгууллагыг дэмжих;

9.3.7. хараагүй хүнд зориулсан брайль болон томруулсан үсэгтэй ном, сурах бичиг, сонин, сэтгүүл хэвлэх зардлыг нийгмийн халамжийн сангаас гаргах.

/Энэ заалтыг 2008 оны 1 дүгээр сарын 15-ны өдрийн хуулиар нэмсэн/

**10 дугаар зүйл. Иргэн хөгжлийн бэрхшээлтэй болохыг тогтоох,
үнэмлэх олгох, статистик мэдээлэл гаргах**

10.1. 16 насанд хүрээгүй хүүхдийн хөгжлийн бэрхшээлийг эрүүл мэндийн байгууллагын мэргэжлийн эмч нарын хяналтын комисс, 16 насанд хүрсэн иргэний хөдөлмөрийн чадвар алдалтын хувь хэмжээг эмнэлэг хөдөлмөрийн магадлах комисс тус тус тогтооно.

/Энэ хэсгийг 2008 оны 1 дүгээр сарын 15-ны өдрийн хуулиар өөрчлөн найруулсан/

10.2. Энэ хуулийн 10.1-д заасан комиссын дүгнэлтийг үндэслэн хөгжлийн бэрхшээлтэй хүүхэд болон иргэнийг бүртгэн үнэмлэх олгох үүргийг аймаг, дүүргийн Засаг даргын Тамгын газар хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн эрх ашгийг хамгаалах байгууллагын оролцоотойгоор хэрэгжүүлнэ.

/Энэ хэсгийг 2008 оны 1 дүгээр сарын 15-ны өдрийн хуулиар өөрчлөн найруулсан/

10.3. Аймаг, дүүргийн эмнэлэг хөдөлмөрийн магадлах комисс нь нарийн мэргэжлийн /дотор, мэдрэл, мэс засал, ерөнхий эмч/, нийгмийн даатгалын магадлагч эмч, аймаг, дүүргийн нийгмийн халамжийн байгууллагын болон ажил олгогчид, хөгжлийн бэрхшээлтэй иргэний эрх ашгийг хамгаалах байгууллагын төлөөллөөс бүрдэнэ.

/Энэ хэсгийг 2008 оны 1 дүгээр сарын 15-ны өдрийн хуулиар нэмсэн/

/Энэ хэсгийн дугаарт 2008 оны 1 дүгээр сарын 15-ны өдрийн хуулиар өөрчлөлт орсон/

10.4. Энэ хуулийн 10.2-т заасан үнэмлэх нь хөгжлийн бэрхшээлтэй хүүхэд ба иргэн хууль тогтоомжид заасан эрхээ эдлэх, нийгмийн халамжийн үйлчилгээнд хамрагдах үндсэн баримт болно.

/Энэ хэсэгт 2008 оны 1 дүгээр сарын 15-ны өдрийн хуулиар нэмэлт орсон/

/Энэ хэсгийн дугаарт 2008 оны 1 дүгээр сарын 15-ны өдрийн хуулиар өөрчлөлт орсон/

10.5. Хөгжлийн бэрхшээлтэй иргэний талаархи статистик мэдээллийг сум, дүүрэг, аймаг, нийслэлийн Засаг даргын Тамгын газар гаргаж, Үндэсний статистикийн газарт өгнө.

/Энэ хэсгийн дугаарт 2008 оны 1 дүгээр сарын 15-ны өдрийн хуулиар өөрчлөлт орсон/

10.6. Хөгжлийн бэрхшээлтэй иргэний үнэмлэхийн загвар, түүнийг олгох журмыг нийгмийн халамжийн асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүн, албан ёсны статистик мэдээллийн маягтыг Үндэсний статистикийн газрын дарга батална.

/Энэ хэсгийн дугаарт 2008 оны 1 дүгээр сарын 15-ны өдрийн хуулиар өөрчлөлт орсон/

ГУРАВДУГААР БҮЛЭГ

Хөгжлийн бэрхшээлтэй иргэний нийгмийн хамгааллын талаархи аж ахуйн нэгж, байгууллага, албан тушаалтны гүйцэтгэх үүрэг

11 дүгээр зүйл. Хөгжлийн бэрхшээлтэй иргэний нийгмийн хамгааллын талаархи аж ахуйн нэгж, байгууллага, албан тушаалтны гүйцэтгэх үүрэг

11.1. Нийгмийн хамгааллын асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага нь хөгжлийн бэрхшээлтэй иргэний нийгмийн хамгааллын талаархи төрийн бодлогт боловсруулах холбогдох хууль тогтоомжийн хэрэгжилтийг зохион байгуулж, биелэлтэд хяналт тавина.

11.2. Нийгмийн халамжийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллага нь хөгжлийн бэрхшээлтэй иргэний талаархи хууль тогтоомжийн биелэлтийг хангаж тэтгэвэр, тэтгэмж, тусламж, хөнгөлөлт, үйлчилгээ үзүүлэх арга хэлбэрийг боловсронгуй болгох талаар судалгаа хийх, санал боловсруулж шийдвэрлэх буюу эрх бүхий байгууллагад уламжлах, нийгмийн халамжийн үйл ажиллагаа явуулж байгаа төрийн болон төрийн бус байгууллагыг мэргэжил, арга зүйн удирдлагаар хангах, үйл ажиллагааг нь уялдуулан зохицуулах, тэдгээрт дэмжлэг, туслалцаа үзүүлэх арга хэмжээ авна.

11.3. Засаг дарга хөгжлийн бэрхшээлтэй иргэний нийгмийн хамгааллын талаар тус тусын эрх хэмжээний хүрээнд дор дурдсан үүрэг хүлээнэ:

11.3.1. сум, дүүрэг, хорооны Засаг дарга хөгжлийн бэрхшээлтэй иргэний нийгмийн хамгааллын тухай хууль тогтоомжийн хэрэгжилтийг тухайн шатны иргэдийн Төлөөлөгчдийн Хуралтай хамтран зохион байгуулах, энэ хуулийн 3 дугаар зүйлд заасан иргэнийг нийгмийн хамгааллын үйлчилгээнд хамруулах асуудлаар холбогдох байгууллагад санал тавьж шийдвэрлүүлэх, сургалтад хамруулах, урлаг соёл, биеийн тамир, олон нийтийн арга хэмжээнд оролцуулах;

/Энэ заалтад 2008 гны 1 дүгээр сарын 15-ны өдрийн хуулиар өөрчлөлт орсон/

11.3.2. аймаг, нийслэлийн Засаг дарга хөгжлийн бэрхшээлтэй иргэний нийгмийн хамгааллын асуудлаар орон нутгийн хэмжээнд авах арга хэмжээний санал боловсруулж, иргэдийн Төлөөлөгчдийн Хуралд оруулах, энэ талаар баримтлах хууль тогтоомжийн хэрэгжилтэд хяналт тавьж, биелэлтийг хангуулах арга хэмжээ авах.

11.4. Аж ахуйн нэгж, байгууллагад ажиллаж байгаад хөгжлийн бэрхшээлтэй болсон иргэнд тухайн байгууллага тусламж, дэмжлэг үзүүлнэ.

11.5. Хөгжлийн бэрхшээлтэй иргэний ажиллаж байсан аж ахуйн нэгж, байгууллага нь өөрчлөн зохион байгуулагдсан буюу татан буугдсан бол түүний эрх, үүргийг хүлээж авсан этгээд энэ хуулийн 11.4-т заасан үүргийг хэрэгжүүлнэ.

**12 дугаар зүйл. Төрийн зохих байгууллагын зарим чиг үүргийг
төрийн бус байгууллагаар гүйцэтгүүлэх**

12.1. Энэ хуульд заасан төрийн болон нутгийн захиргааны байгууллагын зарим чиг үүргийг хөгжлийн бэрхшээлтэй иргэний эрх ашгийг хамгаалах төрийн бус байгууллагаар гүйцэтгүүлж, зардлыг гэрээний үндсэн дээр санхүүжүүлж болно.

ДӨРӨВДҮГЭЭР БҮЛЭГ

Бусад асуудал

13 дугаар зүйл. Хууль тогтоомж зөрчигчид хүлээлгэх хариуцлага

13.1. Энэ хуулийн 3 дугаар зүйлд заасан иргэний нийгмийн хамгааллын тухай хууль тогтоомж зөрчсөн гэм буруутай этгээдэд хуульд заасны дагуу хариуцлага хүлээлгэнэ.

13.2. Иргэний хөдөлмөрийн чадвар алдалтыг буруу тогтоож тэтгэвэр, тэтгэмж авах эрх үүсгэсэн албан тушаалтанд Нийгмийн халамжийн тухай хуулийн 35.2-т заасны дагуу хариуцлага хүлээлгэж, олгогдсон тэтгэвэр, тэтгэмжийг нөхөн төлүүлнэ.

——oOo——

*Монгол Улсын Засгийн газрын 2006 оны
283 дугаар тогтоолын нэгдүгээр
хавсралтаар батлагдав.*

ХӨГЖЛИЙН БЭРХШЭЭЛТЭЙ ИРГЭДИЙГ ДЭМЖИХ ҮНДЭСНИЙ ХӨТӨЛБӨР

Нэг. Нийтлэг үндэслэл

Хөгжлийн бэрхшээлтэй иргэдэд өөрсдийн нөөц бололцоогоо хөгжүүлэн амьдралын чанараа дээшлүүлэх, тэдэнд тэгш боломж олгох, нийгмийн ээлтэй орчныг бүрдүүлэхэд дэлхий нийт онцгой анхаарч байна.

НҮБ-аас 1993-2002 оныг Ази, Номхон далайн бүсийн хөгжлийн бэрхшээлтэй иргэдийг дэмжих 10 жил болгон зарлаж энэ ажлын хүрээнд Монгол Улсын Засгийн газар 1998 оноос Тахир дутуу иргэдийн аж байдлыг сайжруулах үндэсний хөтөлбөрийг хэрэгжүүлж ирсэн.

Тахир дутуу иргэдийн аж байдлыг сайжруулах үндэсний хөтөлбөр /1998-2003/-ийг хэрэгжүүлэх хугацаанд хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн нийгмийн амьдралд оролцох оролцоо дээшилж тэдний эрхийг хангах талаар нийгмийн сэтгэл зүйд эерэг хандлага бүрэлдсэн гэж Засгийн газар дүгнэсэн.

2003-2012 онд Ази, Номхон далайн бүсийн хөгжлийн бэрхшээлтэй иргэдийг дэмжих хоёр дахь 10 жилийн ажлын хүрээнд хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн бүрэн оролцоог хангасан, ая тухтай, хүний эрхэд тулгуурласан нийгмийг цогцлон бүрдүүлэх талаархи үйл ажиллагааны “Бивакогийн мянганы хөтөлбөр”-ийг НҮБ-ын Ази, Номхон далайн бүсийн эдийн засаг, нийгмийн комиссоос баталсан.

“Бивакогийн мянганы хөтөлбөр”-ийг хэрэгжүүлэхийн тулд хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн тэгш боломжийг хангах, эрхийг нь хүндэтгэх, боломж, чадавхийг нь нэмэгдүүлэх, тэднийг хөгжүүлэхэд чиглэсэн хууль тогтоомж, үндэсний хөтөлбөр, төлөвлөгөөг боловсруулан хэрэгжүүлэхийг НҮБ-аас бүсийн улс орнуудын Засгийн газарт зөвлөсөн билээ.

Монгол Улс 2005 оны байдлаар 2562.4 мянган хүн амтай байгаагийн 2.8 хувь буюу 69263 нь хөгжлийн бэрхшээлтэй иргэн байна.

Хөгжлийн бэрхшээлтэй нийт иргэдийн 55.2 хувийг эрэгтэйчүүд, 44.8 хувийг эмэгтэйчүүд эзэлж байна. Тэдний 35.5 хувь нь төрөлхийн, 64.5 хувь нь олдмол шалтгааны улмаас хөгжлийн бэрхшээлтэй болсон иргэд байна.

2004 оны байдлаар хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн дөнгөж 26.4 хувь хөдөлмөр эрхэлж байгаа нь тэдний амьжиргааны түвшинд сөргөөр нөлөөлж байна.

Хөгжлийн бэрхшээлтэй иргэдэд халамжийн үйлчилгээнд хамрагдах сонирхол, бэлэнчлэх сэтгэлгээ их байгаагаас тэдэнд өөрсдийн нөөц бололцоогоо дайчлан хөгжүүлж амьдрах идэвх, чармайлт хангалтгүй байна.

Хөгжлийн бэрхшээлтэй иргэний хязгаарлагдмал чадавхи боломжийг ойлгож хүндэтгэх, онцлог хэрэгцээнд нь тулгуурласан үйлчилгээг сайжруулах замаар тэднийг дэмжин хөгжүүлэх, үүнд нийгмийн сэтгэл зүйг төлөвшүүлэх шаардлагатай байна.

Энэхүү хөтөлбөр нь хөгжлийн бэрхшээлтэй иргэдэд ээлтэй орчинг бүрдүүлэх замаар нийгмийн амьдралд идэвхтэй оролцох оролцоог нь нэмэгдүүлэхэд чиглэгдэж байгаагаараа нийгмийн хамгаалал, аж байдалд нь түлхүү анхаарсан өмнөх хөтөлбөрөөс ялгаатай юм.

Хөтөлбөрийг НҮБ-аас баталсан Хөгжлийн бэрхшээлтэй иргэдэд адил тэгш боломж олгох тухай үлгэрчилсэн журам, Олон Улсын Хөдөлмөрийн Байгууллагын 159 дүгээр тогтоолоор батлагдсан Тахир дутуу иргэдийн хөдөлмөр эрхлэлт, нөхөн сэргээлтийн талаархи конвенц, Бивакогийн мянганы хөтөлбөрийн үзэл санаанд нийцүүлэн боловсруулсан болно.

Хоёр. Хөтөлбөрийн зорилго

Хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн ая тухтай амьдрах, хөгжих боломжийг нэмэгдүүлэх, эрхийг нь хүндэтгэсэн нийгмийн орчинг бүрдүүлэхэд төр, иргэний нийгэм болон хөгжлийн бэрхшээлтэй иргэдийг оролцуулахад чиглэгдэнэ.

Гурав. Хөтөлбөрийн зарчим

Тэгш байдлын зарчим

Хөгжлийн бэрхшээлтэй иргэдийг жирийн иргэдийн нэгэн адилаар нийгмийн амьдралд эрх тэгш оролцуулах боломжийг тусгасан байна.

Боломж олгох зарчим

Хөгжлийн бэрхшээлтэй иргэдэд өөрсдийгөө хөгжүүлэх боломжийг олгосон байна.

Дэмжлэг үзүүлэх зарчим

Нийгмийн зүгээс хөгжлийн бэрхшээлтэй иргэдийг дэмжих ээлтэй орчинг бүрдүүлэхэд чиглэгдсэн байна.

Бодлогыг уялдуулах зарчим

Хөгжлийн бэрхшээлтэй иргэдийг дэмжих төрийн бодлогыг эдийн засаг, нийгмийн хөгжлийн чиг хандлага, салбарын хөгжлийн бодлоготой уялдуулсан байна.

Хүртээмжтэй байх зарчим

Хөгжлийн бэрхшээлтэй иргэдийг нийгмийн хөгжлийн аливаа үйл явцад бүрэн хамруулж, түүний үр шимийг хүртэх нөхцөлийг бүрдүүлсэн байна.

Дөрөв. Хөтөлбөрийн хугацаа, санхүүжилт

Хөтөлбөрийг 2 үе шаттайгаар хэрэгжүүлнэ:

Нэгдүгээр үе шат 2006-2008 он;
Хоёрдугаар үе шат 2009-2012 он.

Хөтөлбөрийн санхүүжилтийг дараахь эх үүсвэрээс бүрдүүлнэ:

- 1) улсын болон орон нутгийн төсвөөс хуваарилсан хөрөнгө;
- 2) хандивлагч орон, олон улсын байгууллагын тусламж, хандив, зээл;
- 3) төрийн болон төрийн бус байгууллага, аж ахуйн нэгж, иргэдийн тусламж, хандив
- 4) гадаад, дотоодын хөрөнгө оруулалт;
- 5) бусад эх үүсвэр.

Тав. Хөтөлбөрийн зорилт

1. Хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн улс орны хөгжилд оруулах хувь нэмрийг үнэлж төрийн болон төрийн бус байгууллага, аж ахуйн нэгж, байгууллага, хамт олон, гэр бүл, иргэдийн санал санаачилгыг дэмжих замаар нийгэмд хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн талаархи эерэг хандлагыг төлөвшүүлэх.

2. Хөгжлийн бэрхшээлтэй иргэдэд ээлтэй дэд бүтцийг сайжруулан мэдээлэл харилцааны технологийг хөгжүүлэх.

3. Хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн хөдөлмөр эрхлэлтийг нэмэгдүүлэх арга хэмжээг өргөжүүлэх.

4. Хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн сурч боловсрох, мэдээллээр хангагдах орчинг сайжруулах.

5. Хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн чадавхийг нэмэгдүүлэх замаар тэдний нийгмийн хамгааллыг сайжруулах.

6. Хөгжлийн бэрхшээлтэй болохоос урьдчилан сэргийлэх үйл ажиллагааг нэмэгдүүлж, тэдний бие бялдар, мэдрэхүй, сэтгэц, оюун санаа, эрүүл мэндийн сэргээн засалтын үйлчилгээг сайжруулах.

Зургаа. Хөтөлбөрийн үйл ажиллагааны үндсэн чиглэл

Зорилт 1. Хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн улс орны хөгжилд оруулах хувь нэмрийг үнэлж төрийн болон төрийн бус байгууллага, аж ахуйн нэгж, байгууллага, хамт олон, гэр бүл, иргэдийн санал санаачилгыг дэмжих замаар нийгэмд хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн талаархи эерэг хандлагыг төлөвшүүлэх.

Үр дүн 1.1. Хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн улс орны хөгжилд оруулах хувь нэмрийг үнэлж, тэдэнд хандах нийгмийн эерэг орчин бүрдсэн байна.

Үйл ажиллагаа

1.1.1. Хөгжлийн бэрхшээлтэй иргэнтэй зохистой харьцах, түүнчлэн тэднийг ялгаварлах, хүчирхийлэх аливаа хэлбэрийг устгахад чиглэсэн сурталчилгааны ажил хийх, нийгмийн ажилтан болон сургалтын байгууллагын ажилтныг үе шаттайгаар энэ чиглэлийн сургалтад хамруулах;

1.1.2. Бодлого боловсруулагч, шийдвэр гаргагчдад хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн онцлог байдлын талаар мэдлэг олгох чиглэлээр сурталчилгаа хийх;

1.1.3. Хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн талаар авах гэж буй арга хэмжээний тухай хэлэлцүүлгийг нийгмийн бүх түвшинд өрнүүлэх;

1.1.4. Хөгжлийн бэрхшээлтэй иргэдэд тулгамдаж байгаа шийдвэрлэвэл зохих асуудал, эрхийн талаар судалгаа хийх;

1.1.5. Хөгжлийн бэрхшээлтэй иргэдтэй зүй бусаар харьцах, үл хайхрах, тоомсорлохгүй байх, гадуурхах явдлыг таслан зогсооход чиглэсэн сурталчилгаа хийх.

Үр дүн 1.2. Хөгжлийн бэрхшээлтэй иргэний үүсгэл санаачилгын байгууллагын чадавхийг бэхжүүлэх замаар тэдний нийгмийн амьдралд оролцох оролцоо нэмэгдсэн байна.

Үйл ажиллагаа

1.2.1. Хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн үүсгэн санаачилсан төрийн бус байгууллагын чадавхийг бэхжүүлэхэд төрөөс арга зүй, мэдээллээр дэмжлэг үзүүлэх;

1.2.2. Төрийн болон төрийн бус байгууллагын хамтын ажиллагааг сайжруулах, хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн талаар баримтлах бодлогын баримт бичиг боловсруулах, түүнийг хэрэгжүүлэх үйл ажиллагаанд иргэний нийгэм хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн оролцоог хангах;

1.2.3. Хөгжлийн бэрхшээлтэй иргэнийг хөгжүүлэх, тэдний нийгмийн хамгааллыг сайжруулах чиглэлээр олон улсын болон бүсийн байгууллагатай хамтран ажиллах;

1.2.4. Хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн талаар Засгийн газраас хэрэгжүүлэх зарим арга хэмжээг гэрээний үндсэн дээр гүйцэтгүүлэх асуудлыг судлан хэрэгжүүлэх;

1.2.5. Хөгжлийн бэрхшээлтэй иргэний эрх ашгийг хамгаалах, хөгжүүлэх чиглэлээр зохион байгуулагдах олон улсын болон бүсийн уралдаан тэмцээн, хурал зөвлөлгөөнд тэдгээрийг төлөөлөн оролцох иргэний нийгмийн байгууллагад дэмжлэг үзүүлэх.

Зорилт 2. Хөгжлийн бэрхшээлтэй иргэдэд ээлтэй дэд бүтцийг сайжруулан, мэдээлэл харилцааны технологийг хөгжүүлэх.

Үр дүн 2.1. Хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн чөлөөтэй саадгүй зорчих боломжийг бүрдүүлсэн барилга байгууламж, зам талбайг томоохон хотуудад бий болгоно.

Үйл ажиллагаа

2.1.1. Нийтээр цуглардаг гудамж, талбайд хөгжлийн бэрхшээлтэй иргэд саадгүй зорчиход зориулсан зам, замын тэмдэг, дуут дохиог бий болгох;

2.1.2. Шинээр баригдаж байгаа барилга байгууламж болон эмнэлэг, үзвэр, үйлчилгээ, худалдаа, олон нийтийн байгууламжид хөгжлийн бэрхшээлтэй иргэд чөлөөтэй зорчих нөхцөлийг бүрдүүлсэн дэд бүтцийг бий болгох;

2.1.3. Хөгжлийн бэрхшээлтэй хүүхэд олноор сурдаг сургуулийн барилгыг тусгай тоноглолоор хангах;

2.1.4. Сэргээн засалтын чиглэлээр ажилладаг төрийн үйлчилгээний байгууллагад хөгжлийн бэрхшээлтэй иргэд чөлөөтэй саадгүй зорчих дэд бүтцийг жишиг байдлаар бий болгох.

Үр дүн 2.2. Хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн мэдээлэл хүртэх боломж сайжирч, мэдээлэл, харилцаа холбооны тоног төхөөрөмжийн хангамжийг нэмэгдүүлнэ.

Үйл ажиллагаа

2.2.1. Хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн мэдээлэл хүртэх боломжийг сайжруулах, ном, сонин, сэтгүүл, интернетийн хэрэглээг нэмэгдүүлэх;

2.2.2. Хөгжлийн бэрхшээлтэй иргэнд зориулсан мэдээлэл, харилцаа холбооны тусгай техник, компьютерийн хангамжийг нэмэгдүүлэх;

2.2.3. Хөгжлийн бэрхшээлтэй иргэдэд зориулсан компьютерийн программ хангамжийн нийлүүлэлт, хэрэглээг сайжруулах;

2.2.4. Хөгжлийн бэрхшээлтэй иргэнд зориулсан телевизийн нэвтрүүлэг бэлтгэх, кино бүтээх, сурталчилгааны үйл ажиллагааг өргөжүүлэх асуудлыг судлан хэрэгжүүлэх.

Зорилт 3. Хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн хөдөлмөр эрхлэлтийг нэмэгдүүлэх арга хэмжээг өргөжүүлэх.

Үр дүн 3.1. Хөгжлийн бэрхшээлтэй иргэдийг хөдөлмөрийн зах зээлд эрэлт хэрэгцээтэй мэргэжил эзэмших, ур чадвараа дээшлүүлэхэд чиглэсэн мэргэжлийн сургалтын чанар, хүртээмж сайжирсан байна.

Үйл ажиллагаа

3.1.1. Хөгжлийн бэрхшээлтэй хүний хэрэгцээ шаардлагад үндэслэн тэднийг мэргэжлийн сургалтад хамруулах, шинээр мэргэших, хос мэргэжил эзэмших сургалтыг зохион байгуулах;

3.1.2. Онцлог хэрэгцээ шаардлагад нийцсэн тоног төхөөрөмж бүхий сургалтын төвийг бүсийн төвийг түшиглэн байгуулах;

3.1.3. Хөгжлийн бэрхшээлтэй иргэдийг ажлын байран дээр сургах сургалтыг ажил олгогчдын дэмжлэгтэйгээр зохион байгуулах;

3.1.4. Хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн дунд бизнес эрхлэх, удирдах ур чадвар эзэмшүүлэхэд чиглэсэн сургалт явуулах, уг чиглэлээр зөвлөгөө өгөх үйлчилгээг хөгжүүлэх;

3.1.5. Хөгжлийн бэрхшээлтэй иргэдийг бизнес инкубаторт хамрагдах боломжийг өргөжүүлэх;

3.1.6. Хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн авьяас, ур чадварыг нээн илрүүлэх, нийгэмшүүлэхэд чиглэсэн богино хугацааны сургалт, семинар зохион байгуулж байх.

Үр дүн 3.2. Хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн хөдөлмөр эрхлэлт нэмэгдэж, тэдний хөдөлмөр эрхлэх таатай нөхцөл бий болсон байна.

Үйл ажиллагаа

3.2.1. өмчийн бүх хэлбэрийн байгууллага, аж ахуйн нэгжид хөгжлийн бэрхшээлтэй иргэдийг хуульд заасан хувь хэмжээгээр ажиллуулах асуудлыг хамтын хэлэлцээр, байгууллагын дотоод журамд тусгах, хэрэгжилтэд хяналт тавих;

3.2.2. Хөгжлийн бэрхшээлтэй иргэдэд зориулсан үйлдвэрлэл, тусгай ажлын байр бий болгоход дэмжлэг үзүүлэх эрх зүйн орчинг боловсронгуй болгох;

3.2.3. Хөгжлийн бэрхшээлтэй иргэдэд зориулж ажлын байр гаргасан, үйлдвэрлэл зохион байгуулалтад өөрчлөлт хийж, хөгжлийн бэрхшээлтэй хүн ажиллах боломжийг бүрдүүлсэн, ажлын байран дээрх сургалт, ганцаарчилсан тусламж, орчуулагчийн үйлчилгээ үзүүлсэн зэрэг ажлын байранд таатай уур амьсгал бүрдүүлэн ажиллаж байгаа ажил олгогчийг дэмжих;

3.2.4. Хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн хөдөлмөр эрхлэлтийг нэмэгдүүлэх үйл ажиллагаанд хөдөлмөр, нийгмийн зөвшилцлийн гурван талт байгууллагын оролцоог нэмэгдүүлэх;

3.2.5. Богиносгосон цагаар болон гэрээр ажиллах боломжийг бүрдүүлж цалин хөлс, ажлын цагийн уян хатан зохицуулалтыг бий болгох талаар хөдөлмөрийн хууль тогтоомжид тусгах.

Үр дүн 3.3. Хөгжлийн бэрхшээлтэй иргэдийг хувиараа хөдөлмөр эрхэлж орлогоо нэмэгдүүлэхэд нь дэмжлэг үзүүлэх орчинг бүрдүүлнэ.

Үйл ажиллагаа

3.3.1. Хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн үйлдвэрлэсэн бүтээгдэхүүнийг борлуулахад дэмжлэг үзүүлэх үзэсгэлэн, яармаг худалдаа зохион байгуулах санал санаачилгыг дэмжих;

3.3.2. Хөгжлийн бэрхшээлтэй иргэдийг хувиараа хөдөлмөр эрхлэхэд дэмжлэг үзүүлэх үйлчилгээг өргөжүүлэх;

3.3.3. Хөгжлийн бэрхшээлтэй иргэд сайн дураараа нэгдэн орлогоо нэмэгдүүлэх санал санаачилгыг дэмжиж зээл олгох, зөвлөгөө үзүүлэх үйлчилгээг бий болгох асуудлыг судлан хэрэгжүүлэх.

Зорилт 4. Хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн сурч боловсрох, мэдээллээр хангагдах орчинг сайжруулах.

Үр дүн 4.1. Хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн хэрэгцээнд тулгуурласан боловсролын тогтолцоо бүрдсэн байна.

Үйл ажиллагаа

4.1.1. Хөнгөн хэлбэрийн хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийг ердийн сургуульд сурч хөгжих нөхцөл боломжоор хангах замаар тэдний боловсролын түвшинг нэмэгдүүлэх;

4.1.2. Хөгжлийн бэрхшээлтэй хүүхдүүдэд зориулсан тусгай анги бүлэгт багшлах согог зүйч, хэл засалч багш бэлтгэх, тэдгээрийг урамшуулах тогтолцоог шинэчлэх;

4.1.3. Хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийн онцлог хэрэгцээнд нийцүүлэн анги, танхим, бүлэг, дотуур байрыг тусгай тоног төхөөрөмж, хүүхдийн бие бялдрын болон сэтгэцийн хөгжлийг идэвхжүүлэх тоглоом, хэрэгслээр хангах;

4.1.4. Хөгжлийн бэрхшээлийн хүнд хэлбэр /оюун ухааны болон бие эрхтэн/-ийн согогтой хүүхдийг тусгай цэцэрлэг, анги, бүлэгт хамруулан тэдний согогийг засах, сэргээхэд чиглэгдсэн сургалтын хөтөлбөрийг боловсруулж хэрэгжүүлэх;

4.1.5. Хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийн онцлог хэрэгцээнд нийцсэн сурах бичиг, ном, сургалтын хэрэглэгдэхүүний хангамж, хүрэлцээг нэмэгдүүлэх;

4.1.6. Тусгай анги, бүлэгт хамрагдаж байгаа хүүхдийн тасралтгүй суралцах боломжийг бүрдүүлэх зорилгоор тусгай тоног төхөөрөмж бүхий тээврийн хэрэгсэлтэй болгох асуудлыг судлан шийдвэрлэх;

4.1.7. Хөгжлийн бэрхшээлтэй хүүхдүүдийн боловсролын хэрэгцээг тодорхойлох болон амьдралын нөхцөл байдлыг үнэлэх судалгаа хийх, албан сургалтад хамрагдаж байгаа хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийн сурлагын амжилт, хөгжлийн үнэлгээг тогтмол хийж байх;

4.1.8. Хөгжлийн бэрхшээлтэй иргэн тэтгэлэгт болон хөнгөлөлттэй нөхцөлөөр сурах, сурах бичгээр үнэ төлбөргүй хангагдах зэргээр тасралтгүй суралцах нөхцөлийг бүрдүүлэх.

Үр дүн 4.2. Хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн талаархи статистик мэдээ, мэдээлэл, судалгаа сайжирч, тэдний мэдээллийн хүртээмж нэмэгдсэн байна.

Үйл ажиллагаа

4.2.1. Нас, хүйс, амьжиргааны түвшин болон хөдөлмөрийн чадвар алдалтын төрөл, хэлбэр зэргээр ангилсан хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн талаархи мэдээллийг цуглуулах;

4.2.2. Хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн талаар үйл ажиллагаа явуулдаг байгууллагууд нэгдсэн мэдээллийн сүлжээ байгуулахыг дэмжих;

4.2.3. Хөгжлийн бэрхшээлтэй иргэнд зориулсан мэдээлэл, харилцаа холбооны шинэ техник, технологийг эзэмшүүлэх чиглэлээр мэргэжлийн боловсон хүчнийг бэлтгэх;

4.2.4. Хөгжлийн бэрхшээлтэй иргэнийг боловсролын үйлчилгээнд тэгш хамруулах, ялангуяа хөдөө орон нутагт бичиг үсэг сургах албан бус болон зайны сургалт зохион байгуулж байгаа иргэний нийгмийн байгууллагын үйл ажиллагаанд дэмжлэг үзүүлэх;

4.2.5. Олон улсын хэл ярианы стандарт, кодчилал, загварыг ашиглан хөгжлийн бэрхшээлтэй иргэний дохионы хэлийг сайжруулах, боловсронгуй болгох;

4.2.6. Хөгжлийн бэрхшээлтэй иргэдэд нөхөн үржихүйн талаархи мэдээлэл, сургалт, сурталчилгааг тэдний хэрэгцээнд тулгуурлан хийх, түүнд гэр бүлийн гишүүд, ойр дотны хүмүүсийг нь хамруулах;

4.2.7. Хэвлэл мэдээллийн хэрэгслээр хөгжлийн бэрхшээлтэй иргэдэд зориулж дохионы хэлний орчуулгатайгаар мэдээлэл олгох асуудлыг шийдвэрлэх, шаардлагатай боловсон хүчнийг бэлтгэх.

Зорилт 5. Хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн чадавхийг нэмэгдүүлэх замаар тэдний нийгмийн хамгааллыг сайжруулах.

Үр дүн 5.1. Хөгжлийн бэрхшээлтэй иргэний хэрэгцээнд тохирсон, чанартай, хүртээмж бүхий нийгмийн хамгааллын тогтолцоо бүрдсэн байна.

Үйл ажиллагаа

5.1.1. Хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн тэтгэвэр, тэтгэмжийн хэмжээг амьжиргааны доод түвшинтэй уялдуулан нэмэгдүүлэх арга хэмжээг авах;

5.1.2. Хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн хэрэгцээ болон судалгаанд үндэслэн тэдэнд үзүүлэх олон нийтийн оролцоонд түшиглэсэн халамжийн үйлчилгээний нэр төрлийг боловсронгуй болгож хөгжүүлэх;

5.1.3. Хөгжлийн бэрхшээлтэй иргэнийг асарч байгаа хүнд олгож байгаа нөхцөлт мөнгөн тэтгэмжийн хэмжээг үе шаттай нэмэгдүүлэх;

5.1.4. Хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн өөртөө туслах бүлгийн үйл ажиллагааг дэмжих чиглэлээр нийгмийн хамгааллын үйлчилгээг өргөжүүлэх;

5.1.5. Хөгжлийн бэрхшээлтэй иргэдэд зориулсан төрөлжсөн асрамжийн газрыг бүсийн төвүүдэд байгуулах;

5.1.6. Хөгжлийн бэрхшээлтэй иргэдтэй ажилладаг нийгмийн ажилтны чадавгийг сайжруулах;

5.1.7. Хөгжлийн бэрхшээлтэй иргэдэд төрөөс үзүүлж байгаа нийгмийн хамгааллын үйлчилгээний чанарыг үнэлэх тогтолцоог бий болгох.

Үр дүн 5.2. Хөгжлийн бэрхшээлтэй иргэнийг чадваржуулах, ядууралд өртөж байгаа хүчин зүйлсийг бууруулах үйл ажиллагаа идэвхжсэн байна.

Үйл ажиллагаа

2.1. Хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн ядууралд өртөж байгаа шалтгаан, түүнд нөлөөлөх хүчин зүйлсийг судалж, ядуурлыг бууруулах, амьжиргааны чадавхийг дээшлүүлэх төсөл, хөтөлбөрт зуучлан хамруулах үйл ажиллагааг хэрэгжүүлэх;

5.2.2. Хөгжлийн бэрхшээлтэй иргэний ажлын дадал, авъяасыг дэмжих, зөвлөх, үйлчилгээ үзүүлэх, тэдгээрийг оролцуулан урлаг, спортын арга хэмжээ зохион байгуулах;

5.2.3. Насжилтын асуудлыг хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн нийгмийн хамгааллын үйлчилгээний асуудалтай уялдуулан авч үзэх;

5.2.4. Хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн өөртөө туслах бүлгийн үйл ажиллагааг дэмжих.

Зорилт 6. Хөгжлийн бэрхшээлтэй болохоос урьдчилан сэргийлэх үйл ажиллагааг нэмэгдүүлж, тэдний бие бялдар, мэдрэхүй, сэтгэц, оюун санаа, эрцүл мэндийн сэргээн засалтын үйлчилгээг сайжруулах.

Үр дүн 6.1. Бие махбодь, оюун ухаан, сэтгэл зүй, мэдрэлийн гэмтэл согог үүсэхээс урьдчилан сэргийлэх цогц арга хэмжээг авч хэрэгжүүлсэн байна.

Үйл ажиллагаа

6.1.1. Эмийн зохистой хэрэглээ, түүнчлэн хүнсний болон хүрээлэн буй орчны аюулгүй байдлын талаар мэдээлэл, сургалт, сурталчилгааг өргөжүүлэх;

6.1.2. Осол гэмтэл болон байгалийн аюулаас өөрийгөө болон бусдыг хамгаалах ур чадварыг эзэмшүүлэхэд чиглэсэн үйл ажиллагааг өргөжүүлэн, анхааруулга, санамжийг түгээх;

6.1.3. Эрүүл аж төрөх ёсонд сургах, халдварт болон халдварт бус өвчнөөс сэргийлэх зан үйлийг төлөвшүүлэхэд чиглэсэн ухуулга, сурталчилгааг иргэний нийгмийн дэмжлэгтэйгээр зохион байгуулах;

6.1.4. Хөдөлмөр хамгаалал, аюулгүй ажиллагааны горимыг ханган ажиллах талаар ажил олгогчийн хүлээх үүрэг, хариуцлагыг өндөржүүлэх, түүнд тавих хяналтыг сайжруулах;

6.1.5. Удамшлын өвчний шалтгааныг тогтоон дараагийн үе удамд дамжихаас хамгаалах арга хэмжээг эрүүл мэндийн байгууллагын дэмжлэгтэйгээр хэрэгжүүлэх;

6.1.6. Эрүүл мэндийн талаархи залуу эцэг, эхийн ойлголт мэдлэгийг дээшлүүлж эмгэг согогтой хүүхэд төрөхөөс урьдчилан сэргийлэх.

Үр дүн 6.2. Хөгжлийн бэрхшээлтэй хүмүүс бие махбодь, оюун ухаан, сэтгэл зүйн чадварыг нөхөн сэргээх, хэвийн түвшинд хүрэхэд нь туслах, амьдралаа өөрчлөхөд дэмжлэг үзүүлэх үйлчилгээ сайжирсан байна.

Үйл ажиллагаа

6.2.1. Хөгжлийн бэрхшээлтэй иргэний алдагдсан чадварыг нөхөн сэргээх, орлуулах протез, ортопедийн техник, технологийг нэвтрүүлэн ажиллаж байгаа хувийн хэвшлийн байгууллагын үйл ажиллагааг дэмжих;

6.2.2. Хүнд зэргийн буюу олон хэлбэрийн хөгжлийн бэрхшээлд өртсөн хүмүүст ганцаарчилсан тусламж, үйлчилгээг үзүүлэх сайн дурын ажилтныг иргэний нийгмийн дэмжлэгтэйгээр ажиллуулах;

6.2.3. Хөгжлийн бэрхшээлтэй иргэдэд сэтгэл зүйн сэргээн засах үйлчилгээг үзүүлэх кабинет, төвийг байгуулан ажиллуулах;

6.2.4. Сэргээн засалч бэлтгэх, эмч, эмнэлгийн ажилтнуудын дунд сэргээн засах чиглэлээр тогтмол сургалт зохион байгуулах;

Долоо. Хөтөлбөрийн хэрэгжилтэд хяналт тавих, үнэлгээ хийх

1. Хөтөлбөрийн хэрэгжилтийн байдалд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийх ажлыг аймаг, нийслэлийн Засаг дарга эрхлэн гүйцэтгэнэ. Хөтөлбөрийн хяналт-шинжилгээ, үнэлгээ хийхдээ төрийн бус байгууллага, иргэдийн оролцоог хангана.

2. Хөтөлбөрийн үр дүнг 2008, 2012 онд дараахь шалгуурыг баримтлан дүгнэнэ:

1) хүүхэд, өсвөр үеийнхнээс замын хөдөлгөөний осолд орсны улмаас гэмтсэн, нас барсан хүний тоо, нийт хүүхдийн дунд эзлэх хувь;

2) хөгжлийн бэрхшээлтэй иргэдэд зориулж дэд бүтэц бий болгоход зарцуулсан хөрөнгийн хэмжээ;

3) нөхөн сэргээлтийн үйлчилгээнд хамрагдсан хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн тоо, хөгжлийн бэрхшээлтэй нийт иргэдийн дунд эзлэх хувь;

4) мэргэжлийн чиг баримжаа эзэмшсэн хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн тоо, хөгжлийн бэрхшээлтэй нийт иргэдийн дунд эзлэх хувь;

5) нийгмийн халамж, асрамжийн үйлчилгээнд хамрагдсан хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн тоо, хөгжлийн бэрхшээлтэй нийт иргэдийн дунд эзлэх хувь;

6) цэцэрлэг, ясли, сургуульд хамрагдаж байгаа хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийн тоо, хөгжлийн бэрхшээлтэй нийт хүүхдийн дунд эзлэх хувь;

7) протез, ортопедийн үйлчилгээний төрөл, чанарын өсөлтийн байдал;

8) нийгмийн халамжийн сангаас халамжийн тэтгэвэр, тэтгэмж авч байгаа хөгжлийн бэрхшээлтэй хүний тоо, зарцуулж байгаа хөрөнгө;

9) хөгжлийн бэрхшээлтэй иргэдэд зориулсан тусгай мэдээлэл, харилцаа холбооны техник, технологид зарцуулсан хөрөнгийн хэмжээ.

*Моноол Улсын Засгийн оазрын 2006 оны
283 дуоаар тоотголын хоёрдуоаар
хавсралтаар батлаодав.*

ХӨГЖЛИЙН БЭРХШЭЭЛТЭЙ ХҮҮХДИЙН ОРОЛЦООГ ДЭМЖИХ ДЭД ХӨТӨЛБӨР

Нэг. Нийтлэг үндэслэл

2001–2006 онд улсын хэмжээнд хийсэн судалгаанаас үзэхэд хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийн талаар олон улсын жишиг ангиллын дагуу нарийвчилан гаргасан бүртгэл, төрөлжүүлсэн мэдээллийн сан Монгол Улсад одоог хүртэл байхгүй байна.

Хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийн эрүүл мэнд нь эмзэг асуудлын нэг юм. Хүүхдийн хөгжлийн бэрхшээл гол төлөв бага насанд илэрдэг боловч зөв оношлох, эмчлэх үйл ажиллагаа чанартай хийгдээгүйн улмаас олон хүүхэд эдгэрэх боломжоо алддаг байна. Орон нутагт хүүхдийн эмчилгээ, эмийн хангамж муу байгаагаас хөгжлийн бэрхшээлтэй хүүхэд зайлшгүй шаардлагатай эм, тариаг удаан хугацаагаар хэрэглэж чадалгүй өвчин нь хүндрэх явдал ажиглагдаж байна.

Хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийн 50 гаруй хувь нь бага насандаа сургуульд суралцдаг боловч анги дэвших тутам энэ үзүүлэлт 14 хувь болтлоо буурч байгаа нь тэднийг суралцахад шаардлагатай нийгэм-сэтгэл зүйн тааламжтай орчин сургалтын байгууллагад бүрдэж чадаагүй байгаатай холбоотой юм. Орон нутагт хөгжлийн бэрхшээлтэй хүүхэд суурь боловсрол эзэмших боломж хязгаарлагдмал хэвээр байна.

Хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийн 66.4 хувь нь орлогын эх үүсвэргүй буюу ам бүлийн нэг гишүүнд ногдох орлогын хэмжээ нь амьжиргааны баталгаажих доод түвшингээс бага байгаа өрхөд амьдардаг.

Хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийн хэдэн хувь нь нийгмийн халамж, үйлчилгээнд хамрагддаг, энэхүү хэмжээ нь хэрхэн өөрчлөгдөж байгааг улсын хэмжээнд тодорхойлдоггүй байна.

Нийгэм-эдийн засгийн олон шалтгааны улмаас хөгжлийн бэрхшээлтэй хүүхэдтэй өрх, гэр бүлийн орлого доогуур түвшинд байгааг судалгааны дүн харуулсан бөгөөд энэ нь хүүхдийн эрх, эрэлт хэрэгцээг хангахад саад учруулж улмаар хүчирхийллийн хэлбэр болдог байна.

Эрүүл мэнд, боловсрол, нийгмийн халамж, хамгаалал, эрх зүй болон сэргээн засах үйлчилгээний нэр төрөл, хүртээмж, чанар хангалтгүйн улмаас хүүхэд өөртөө тохиолддог хүндрэл, бэрхшээл, зарим талаар бусдаас дутуу дулимаг байгаа байдлаа мэдэрч, өөрийгөө нийгмийн орчноос тусгаарлах, нөгөөтэйгүүр тохирсон тохироогүй дэмжлэг, туслалцааг хэт бэлэнчлэх, мэдлэг, мэдээллийн зөрүүг

ухаарахын оронд тулган шаардах, өлсгөлөн зарлах зэрэг үзэл бодлоо илэрхийлэх оновчтой бус арга хэлбэрийг сонгож байна. Энэ нь тэдэнд хандах хандлага, харилцаа, үйлчилгээнд гарсан зөрчлийг шуурхай, шударга шийдвэрлэдэг арга зам болон түүнд суралцах арга зүй үгүйлэгдсэний илрэл мөн.

Хөгжлийн бэрхшээлтэй хүүхэд сэтгэл санааны хувьд өөрийгөө жолоодох, ирээдүйд итгэх, тэднийг гадуурхан хайхрамжгүй ханддаг байдлыг арилгах, хүн хүнээ хүндэтгэх зэрэг ёс зүйн зөв чиг хандлагыг төлөвшүүлэхэд биечлэн оролцох шаардлага байсаар байна.

2006 оны 4 дүгээр сард Улаанбаатар хотноо зохион байгуулсан хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийн асуудлаархи “Хамтдаа хөгжицгөө” хүүхдийн үндэсний чуулганаас хөгжлийн бэрхшээлтэй хүүхдэд тулгамдаж байгаа асуудал нь нийгмийн хөгжлийн асуудлын хавсарга болсноос шийдвэрлэх явцад эзэнгүйдэх явдал ердийн үзэгдэл боллоо гэж үзсэн байна.

Нийгмийн хөгжлийн явцад хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийн аж байдлыг сайжруулах үйл хэрэгт тэдний оролцоо, эцэг эх, нийгэм, хамт олны хандлага, хариуцлагыг нэмэгдүүлэх цогц, тогтвортой ажиллагаа, зохицуулалтыг хангасан хөтөлбөр хэрэгжүүлэх шаардлагатай байгаа нь харагдаж байна.

Хоёр. Дэд хөтөлбөрийн зорилго, зарчим

2.1. Хөгжлийн бэрхшээлтэй хүүхэд хувь хүн, нийгмийн гишүүний хувьд өөрийн сонголт, үзэл бодол, үнэт зүйлстэй байх, бие даасан аливаа үйлдлийнхээ төлөө хариуцлага хүлээх тэдгээрийн чадамж, чадварыг хөгжүүлэх, нийгмийн амьдралд оролцох оролцоог хөхиүлэн дэмжих орчин, нөхцөлийг бүрдүүлэхэд энэхүү хөтөлбөрийн зорилго оршино.

2.2. Дэд хөтөлбөрийг хэрэгжүүлэхдээ дараахь зарчмыг баримтална:

а) хөгжлийн бэрхшээлтэй хүүхдэд амьдрах, эсэн мэнд хөгжих, эрхээ хамгаалуулах, нийгмийн амьдралд оролцоход шаардлагатай мэдээлэл хүртээмжтэй байх;

б) хөгжлийн бэрхшээлтэй хүүхэд санаа бодлоо илэрхийлэх боломжтой байх;

в) хөгжлийн бэрхшээлтэй хүүхэд ялгаваргүйгээр гэр бүл, сургууль, хамт олны дунд шийдвэр гаргахад оролцохыг хүлээн зөвшөөрдөг байх;

г) хөгжлийн бэрхшээлтэй хүүхэд өөрийн болон нийгмийн сайн сайхан хөгжлийн төлөө үйл ажиллагаа явуулдаг байгууллагад эвлэлдэн нэгдэх, үүсгэн байгуулахад насанд хүрэгчдийн туслалцаа, дэмжлэгийг авдаг байх.

Гурав. Дэд хөтөлбөрийн зорилт, үр дүн, үйл ажиллагаа

Зорилт 1. Улс болон орон нутгийн нийгэм, эдийн засгийн хөгжлийн бодлого, хөтөлбөрийн хэрэгжилтэд хүүхдийн оролцох чадварыг нэмэгдүүлнэ.

Үр дүн. Хөгжлийн бэрхшээлтэй хүүхэд санал бодлоо илэрхийлэх боломж бүрдсэн байна.

Үйл ажиллагаа

3.1.1. Хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийн онцлогт нийцсэн хэлбэрээр мэдээлэл өгөх, санал бодлыг нь хүлээн авах зорилгоор хүүхдийн эрхийн тухай болон нийгмийн амьдралын талаархи танин мэдэхүйн ном, гарын авлага, хялбаршуулсан сонин, сэтгүүл гарган харилцан мэдээлэх ажлыг зохион байгуулах;

3.1.2. Улсын болон орон нутгийн статистикийн мэдээ, судалгаанд тулгуурлан хүүхдийн аж байдлыг хянах, үнэлэх үйл ажиллагаанд хүүхэд оролцох хүрээ тогтоох;

3.1.3. Хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийн эрхийн хэрэгжилт, тэдэнд үзүүлж байгаа тусламж, үйлчилгээний хүртээмж, эрэлт хэрэгцээний талаар судалгаа, хяналт-шинжилгээ, үнэлгээг тогтмол явуулж цаашид авах арга хэмжээг тодорхойлох;

3.1.4. Хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийн онцлогийг олон нийтэд таниулах, уг асуудлаар “Хүүхдийн хөрөг” нэвтрүүлэг, нийтлэлийг нэмэгдүүлэх, телевизийн хүүхдийн нэвтрүүлэгт дохионы хэлний орчуулга оруулах арга хэмжээ авах;

3.1.5. Жил бүр ижил төрлийн хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийн, 5 жил тутамд хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийн асуудлаархи хүүхдийн чуулга уулзалт зохион байгуулж хүүхдийг шийдвэр гаргах түвшинд оролцох болон шийдвэрт үнэлгээ, дүгнэлт өгөх, санал дэвшүүлэх соёлд сургах.

Үр дүн. Хөгжлийн бэрхшээлтэй хүүхэд аливаа үйл ажиллагаанд оролцох ээлтэй орчин, дэд бүтэц байгуулах эхлэл тавигдсан байна.

Үйл ажиллагаа

3.1.6. Хөгжлийн бэрхшээлтэй хүүхэд аюулгүй зорчих хаалга, шат, бие засах газрыг нэн тэргүүнд хүүхдийн байгууллагын орчинд бий болгох ажлыг үе шаттай төлөвлөн зохион байгуулах;

3.1.7. Хүүхдийн хөгжлийн бэрхшээлийн төрөл, хэлбэрийн ангиллаар өсөлт, хөгжлийн онцлог, эрүүл ахуйн стандартад нийцсэн ширээ, сандал, ор, сурах бичиг, тавилгын хангамжийг нэмэгдүүлэх чиглэлээр үндэсний үйлдвэрлэлийг дэмжих бодлого явуулах;

3.1.8. Хүүхдийн хөгжлийн бэрхшээлийн онцлогт нийцсэн урлаг, спортын уралдаан, тэмцээний хүрээг өргөжүүлэх замаар оролцоог нэмэгдүүлэх;

3.1.9. Хүүхдийн сургалт, урлаг, спорт, хөдөлмөр-дадлын уралдаан, тоглоом, наадамд шаардлагатай тусгай хэрэглэлийг хүүхдэд хуваарилах, хүргэх, тэдгээрийн ашиглалтад хяналт тавих ажлыг хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн төрийн бус байгууллагаар гүйцэтгүүлэх;

3.1.10. Хөгжлийн бэрхшээлтэй хүүхэд гэр бүл, хамт олноороо амрах, сувилуулах, зугаалах, тоглох бололцоотой зуслан, амралт, сувиллын газар ажиллуулах иргэд, байгууллагын санаачилгад дэмжлэг үзүүлэх;

Зорилт 2. Хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийн оролцоог хангах бүтцийг бэхжүүлж үйл ажиллагааг тогтворжуулна.

Үр дүн Хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийн оролцоог хангах олон нийтийн түншлэл, хамтын ажиллагаа өргөжсөн байна.

Үйл ажиллагаа

3.2.1. Хүүхдийн хөгжлийн бэрхшээлийн төрөл, хэлбэрийн ангилалд нийцсэн үйл ажиллагаа явуулдаг амьдрах чадварын клуб, хөдөлмөр-сургалтын төв, бэлгийн боловсрол олгох кабинет, урлаг, спортын секц, дугуйлан байгуулан ажиллах санаачилгыг идэвхжүүлэх;

3.2.2. Сэтгэл зүйч, нийгмийн ажилтан, багш, эмч, сувилагч бэлтгэдэг их, дээд сургуулийн оюутны зуны дадлагыг “Оюутны сайн дурынхны (Хөдөлгөөн-Хэрэглээ-Хөгжилд туслагч) баг”-ийн хэлбэрээр явуулахад дэмжлэг үзүүлэх;

3.2.3. Хөгжлийн бэрхшээлтэй хүүхэд нийгэм, хамт олны дунд орох, эвлэлдэн нэгдэх боломжийг нэмэгдүүлэх зорилгоор оюутны “Сайн дурынхны баг”-ийг хүүхэд хамгааллын болон хүүхдийн өөрийн удирдлагын байгууллагад ажиллуулах асуудлыг дэмжих;

3.2.4. Сум, дүүрэг, баг, хороонд хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийн эрхийг хамгаалах, шийдвэр гаргах түвшинд тэдний саналыг хүргэх “Хүүхдийн элч” ажиллуулах.

Зорилт 3. Хөгжлийн бэрхшээлтэй хүүхэдтэй эцэг, эх, асран хамгаалагч болон хүүхдийн төлөө ажил, үйлчилгээ эрхэлдэг ажилтны чадавхийг бэхжүүлнэ.

Үр дүн. Хөгжлийн бэрхшээлтэй хүүхдэд хандах хандлага, тэдний өмнө хүлээх хариуцлага бүх түвшинд нэмэгдэж хүүхдийн төлөө байгууллагын үйл ажиллагааны үр нөлөө дээшилнэ.

Үйл ажиллагаа

3.3.1. Хөгжлийн бэрхшээлтэй хүүхэдтэй эцэг, эхийн холбоодын үйл ажиллагааг идэвхжүүлэх чиглэлээр зөвлөх үйлчилгээг бий болгох;

3.3.2. Хөгжлийн бэрхшээлтэй хүүхэдтэй зүй бусаар харьцах, үл хайхрах, залхаах, зодож шийтгэх, хүчирхийлэхийг хориглосон, үл тэвчсэн нийгмийн сэтгэл зүйг төлөвшүүлэн сурталчлах;

3.3.3. Хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийн эрхийн талаар нийгмийн болон хүүхдийн эрхийн ажилтан, багш нарт сургалт зохион байгуулж мэдээллээр хангах;

3.3.4. Хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийн хөгжил, хамгааллын чиглэлээр ажилладаг ажилтны ур чадварыг нэмэгдүүлэх, тодорхой асуудлаар мэргэшүүлэх;

3.3.5. Хөгжлийн бэрхшээлтэй хүүхдэд олгодог протез, ортопедийн туслах хэрэглэлийг засах, сэлбэх, шинэчлэх, ашиглах сургалт зохион байгуулдаг сургагч бэлтгэх;

3.3.6. Хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийн эцэг, эх, асран хамгаалагчдыг нөхөн сэргээх эмчилгээний арга барилд сургах сургалт, сурталчилгааг өргөжүүлэх;

3.3.7. Нийгэм хамт олонд тулгуурласан сэргээн засах хөтөлбөрийн ажилтан, хөгжлийн бэрхшээлтэй хүүхэдтэй ажилладаг хүмүүст зориулан мэдээлэл, туршлага солилцох уулзалт, зөвлөлгөөн, семинарыг тогтмол зохион байгуулах;

3.3.8. Олон улсын чиг хандлагад нийцүүлэн аймаг, нийслэлийн эрүүл мэндийн төв, нэгдлийг түшиглэн хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийн “хөдөлгөөн засалч, ахуйн хэрэглээний сургагч, нийгмийн ажилтан, хэл засалч-сэтгэл зүйч, сурган хүмүүжүүлэгч”-дийг багаар ажиллуулах менежментийг нэвтрүүлэх.

Зорилт 4. Хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийн оролцоог хөхиүлэн дэмжсэн нийгэм, соёлын таатай орчин бүрдүүлнэ.

Үр дүн. Хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийн оролцооны эрхийг хэрэгжүүлэх таатай орчин бүрдүүлэгч байгууллага, хамт олон, иргэдийн санаачилга өрнөсөн байна.

А. Эрүүл мэндийн салбараас үзүүлэх дэмжлэг

3.4.1. Хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийн сэргээн засах эмчилгээнд ерөнхий болон тусгай аргачлал боловсруулан нэвтрүүлэх;

3.4.2. Хүүхдийн бэрхшээлийн өвөрмөц хэрэгцээнд шаардлагатай амин дэмээр баяжуулсан хоол тэжээлийг нэмэгдүүлэх, хоолны сувилал ажиллуулах санал, санаачилгыг дэлгэрүүлэх;

3.4.3. Хөгжлийн бэрхшээлтэй хүүхэд хэрэглэх зарим эмийг зайлшгүй шаардлагатай эмийн жагсаалтад оруулах;

3.4.4. Эмнэлэг, сувилал, биеийн тамир, чийрэгжилтийн тасаг, кабинетаас бүрдсэн “Сэргээн заслын цогцолбор”-ыг бүсийн оношилгоо, эмчилгээний төвийн дэргэд байгуулах санал боловсруулж улсын төсөв болон гадаад, дотоодын хандивлагчдын хөрөнгөөр санхүүжүүлэх асуудлыг судалж шийдвэрлэх;

3.4.5. Хүүхдэд хөгжлийн хоёрдогч, гуравдагч бэрхшээл үүсэхээс урьдчилан сэргийлэх зорилгоор орон нутагт эрүүл мэндийн урьдчилан сэргийлэх үзлэгийг тогтмол явуулах.

Б. Боловсролын салбараас үзүүлэх дэмжлэг

3.4.6. Хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийн сургалтад ногдох хувьсах зардлын норматив хэмжээг нэмэгдүүлэх, цэцэрлэг, сургуулийн багшийн ажлын үнэлгээний хэлбэрийг өөрчлөх, урамшууллыг боловсронгуй болгож шинэчлэх;

3.4.7. Ердийн сургуулиас тусгай сургуульд шилжүүлдэг тогтолцоог тусгай сургуульд 3 хүртэл жил суралцаж зохих чадамж, чадварын боломжид хүрсэн сурагч ерөнхий боловсролын сургуульд шилждэг болгон өөрчлөх;

3.4.8. Хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийг сургуульд тэгш хамруулан сургах бодлогыг хэрэгжүүлж, тэдгээрийн сургууль завсардалтыг бууруулах;

3.4.9. “Сурагчийн өдрийн цай” хөтөлбөрт хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийн витаминжуулалтын зардлыг нэмж тусгах асуудлыг судлах;

3.4.10. Хүнд хэлбэрийн эмгэгтэй хүүхдийн хэрэгцээнд тулгуурлан танхимын болон гэрийн сургалт хосолсон хөтөлбөр боловсруулах;

3.4.11. Хөгжлийн бэрхшээлтэй ахлах ангийн сурагчдыг гадаад хэл, компьютерийн сургалтад хамруулж, мэргэжлийн болон дээд боловсрол эзэмших боловсролын байгууллагад суралцахад нь бэлтгэх хөтөлбөр хэрэгжүүлэх;

3.4.12. Хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийн хэрэгцээнд зориулсан брайл, аудио, видео ном, сурах бичгийн хүртээмжийг нэмэгдүүлэх арга хэмжээ авах;

3.4.13. Хөгжлийн бэрхшээлтэй хүүхэд, залуучуудын онцлогт зориулсан бялдаржуулах буюу “Сэргээн засалт”-ын танхимыг орон нутагт байгуулах.

В. Нийгмийн хамгааллын салбараас үзүүлэх дэмжлэг

3.4.14. Хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийн халамжийн үйлчилгээний нэр төрлийг нэмэгдүүлэх чиглэлээр ажиллах;

3.4.15. Хөгжлийн бэрхшээлтэй хүүхэд нас барахад түүний оршуулгад зориулан оршуулгын тэтгэмж олгох асуудлыг судалж шийдвэрлэх;

3.4.16. Хөгжлийн бэрхшээлтэй хүүхэдтэй гэр бүлийн гишүүдэд зориулсан зайны сургалтад дэмжлэг үзүүлэх;

3.4.17. Хөгжлийн бэрхшээлтэй хүүхэдтэй эцэг, эх, асран хамгаалагчдад сэтгэл зүйн зөвлөгөө, дэмжлэг үзүүлэх үйлчилгээ бий болгох;

3.4.18. Хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийнхээ бэрхшээлийг сэргээн засах, авьяас, давуу талыг нь хөгжүүлэхийг дэмжсэн жижиг төслийг гэр бүлийн хүрээнд хэрэгжүүлэх асуудлыг дэмжих;

3.4.19. Асрамж, халамжийн төвд амьдардаг хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийн аж байдалд тавьдаг хөндлөнгийн хяналтын тогтолцоог бий болгох.

Г. Хууль зүйн салбараас үзцүлэх дэмжлэг

3.4.20. Хөгжлийн бэрхшээлтэй хүмүүсийн эрхийн тухай Тунхаглал, Хөгжлийн бэрхшээлтэй хүмүүст тэгш боломж олгох үндсэн зарчим, стандарт, дүрэмд нэгдэх асуудлаар судалгаа хийж, санал боловсруулах;

3.4.21. Ази, Номхон далайн бүсийн хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн аж байдлыг сайжруулах, тэдний оролцоог хангасан саад тотгоргүй, хүний эрхэд тулгуурласан нийгмийг цогцлон бүрдүүлэх талаархи 10 жилийн /2003-2012 он/ үйл ажиллагааны хөтөлбөрийн үзэл санаа, агуулгын тайлбарыг хүүхэд, залуучуудад сурталчлах арга хэмжээ авах;

3.4.22. Хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийн эрх, аж байдлыг сайжруулах чиглэлээр холбогдох хууль тогтоомжийг боловсронгуй болгох.

Дөрөв. Дэд хөтөлбөрийн хугацаа, санхүүжилт

4.1. Дэд хөтөлбөрийг хүүхдийн хөгжил, хамгааллыг сайжруулах үндэсний хөтөлбөрийн хэрэгжилттэй уялдуулан хэрэгжүүлэх бөгөөд үйл ажиллагааг дараахь үе шаттай төлөвлөнө:

1 дүгээр үе шат 2006-2009 он;

2 дугаар үе шат 2010-2012 он.

4.2. Дэд хөтөлбөрийн санхүүжилтийг дараахь эх үүсвэрээс бүрдүүлнэ:

- 1) улс, орон нутгийн төсвөөс олгох хөрөнгө;
- 2) олон улсын байгууллага, хандивлагч орны тусламж, хандив;
- 3) олон нийтийн санаачилгаар хуримтлагдсан хөрөнгө;
- 4) бусад эх үүсвэр.

Тав. Дэд хөтөлбөрийн удирдлага, зохион байгуулалт

5.1. Дэд хөтөлбөрийн үйл ажиллагаанд бүх салбарын оролцоог хангах, хамтын ажиллагааг зохицуулах үүргийг Хүүхдийн төлөө үндэсний зөвлөл хариуцна.

5.2. Дэд хөтөлбөрийг хэрэгжүүлэх ажлыг Хүүхдийн төлөө үндэсний газар гүйцэтгэнэ.

5.3. Орон нутагт дэд хөтөлбөрийг хэрэгжүүлэх, хэрэгжилтэд хяналт тавих ажлыг бүх шатны Засаг даргаар удирдуулсан Хүүхдийн төлөө зөвлөл мэргэжлийн байгууллагатай хамтран гүйцэтгэнэ. Орон нутгийн түвшинд зохион байгуулсан ажлын явц, үр дүнг Хүүхдийн төлөө үндэсний газарт жил бүрийн I улиралд багтаан тайлагнана.

5.4. Хүүхдийн төлөө үндэсний газар хөтөлбөрийн хүрээнд үндэсний болон орон нутгийн түвшинд зохион байгуулсан ажлын явц, үр дүнг нэгтгэн Хүүхдийн төлөө үндэсний зөвлөлд жил бүрийн II улиралд тайлагнаж байна.

Зургаа. Дэд хөтөлбөрийн хэрэгжилтийг үнэлэх шалгуур үзүүлэлт

6. Дэд хөтөлбөрийн хэрэгжилтийг дараахь үзүүлэлтээр үнэлнэ:

6.1. Хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийн санал, үнэлгээнд үндэслэн гарсан шийдвэр, эрх зүйн актын тоо;

6.2. Хөгжлийн бэрхшээлтэй хүүхэд санал, үзэл бодлоо илэрхийлэх, мэдээлэл солилцох арга, хэлбэрийн тоо;

6.3. Хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийн хөгжил, хамгаалал, оролцоог сайжруулах асуудлаар бодлогын баримт бичигтэй ажилладаг байгууллагын тоо;

6.4. Хөгжлийн бэрхшээлтэй хүүхдэд ээлтэй орчин, дэд бүтэц бий болгосон байгууллагын тоо, түүнд зарцуулсан хөрөнгийн хэмжээ;

6.5. Нийгмийн цогц суурь үйлчилгээнд хамрагдсан хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийн тоо.

ЭХ СУРВАЛЖИЙН ЖАГСААЛТ

Монгол хэл дээрх эх сурвалж

1. Хөгжлийн бэрхшээлтэй хүмүүсийн эрхийн тухай НҮБ-ын конвенци, Хөгжлийн бэрхшээлтэй хүмүүсийн эрхийн тухай конвенцийн нэмэлт протокол
2. “Төрийн мэдээлэл” сэтгүүлийн тусгай дугаар, 1 дүгээр боть, 2004 он
3. Г.Совд “Монгол Улсын Үндсэн хууль, хүний эрх” 1999 он
4. Жиампиеро Гриффо, Франческо Ортали, “Хөгжлийн бэрхшээлтэй хүмүүсийн эрхийн тухай гарын авлага”, 2007 он

Англи хэл дээрх эх сурвалж

5. United Nations, Office of the High Commissioner for Human Rights, Inter-Parliamentary Union “From Exclusion to Equality: Realizing the rights of persons with disabilities”, No14-2007
6. Nihal Jayawickrama, “The judicial application of human rights law: National, regional and international jurisprudence”, Cambridge University Press, 2002
7. Malcolm N.Shaw, International law: Fifth edition, Cambridge University Press, 2003
8. Mahidol University, Compilation of general comments and general recommendations adopted by Human rights treaty bodies
9. www.un.org/disability



АГУУЛГА

ӨМНӨХ ҮГ

НЭГДҮГЭЭР ХЭСЭГ: КОНВЕНЦ ХҮРТЭЛ...

1. Хөгжлийн бэрхшээлийн асуудалд хүний эрхийн үүднээс хандах нь
2. Хөгжлийн бэрхшээлтэй хүний эрхийн талаарх олон улсын эрх зүйн баримт бичгүүд
3. Хөгжлийн бэрхшээлтэй хүмүүсийн эрхийн тухай конвенцийн хэрэгцээ, шаардлага

ХОЁРДУГААР ХЭСЭГ: КОНВЕНЦИЙГ ОЙЛГОХ НЬ

1. Конвенцийн зорилго, зарчим, оролцогч улсын хүлээх нийтлэгүүрэг
2. Конвенциор баталгаажуулсан хүний эрх, эрх чөлөө
3. Гэрээг дагаж мөрдөх зөвшөөрөл илэрхийлэх арга зам ба конвенци хүчин төгөлдөр болох нь

ГУРАВДУГААР ХЭСЭГ: ХӨГЖЛИЙН БЭРХШЭЭЛТЭЙ ХҮМҮҮСИЙН ЭРХИЙН ХОРОО

1. Хөгжлийн бэрхшээлтэй хүмүүсийн эрхийн хороо
2. Конвенцийн хэрэгжилтийн талаарх Засгийн газрын тайлан
3. Хөгжлийн бэрхшээлтэй хүмүүсийн эрхийн тухай конвенцийн нэмэлт протокол

ДӨРӨВДҮГЭЭР ХЭСЭГ: КОНВЕНЦИЙГ ХЭРЭГЖҮҮЛЭХ НЬ

1. Конвенцийн хэрэгжилтийг хангах тусгай арга хэмжээ
2. Үндэсний хууль тогтоомжийг конвенцид нийцүүлэх тухай
3. Конвенцийн хэрэгжилтийг хангах байгууллагууд

ХАВСРАЛТ

1. Хөгжлийн бэрхшээлтэй хүмүүсийн эрхийн тухай НҮБ-ын конвенц
2. Хөгжлийн бэрхшээлтэй хүмүүсийн эрхийн тухай НҮБ-ын конвенцийн нэмэлт протокол
3. Хөгжлийн бэрхшээлтэй иргэний нийгмийн хамгааллын тухай хууль
4. Хөгжлийн бэрхшээлтэй иргэдийг дэмжих үндэсний хөтөлбөр
5. Хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийн оролцоог дэмжих дэд хөтөлбөр

ЭХ СУРВАЛЖИЙН ЖАГСААЛТ